

Миний мэдэх буриад нутаг

НОГООН ДЭВТЭР

Долоодугаар цуврал

Түвд судраас орчуулан эмхэтгэсэн
Монголын Бурханы Шашинтаны Төв Гандан хийдийн гавж
Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

Улаанбаатар, 2016 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Буриадын түүхэн тойм

- | | | |
|------|--|----|
| 1.1. | Түүхийн тавцанд гарч ирсэн ба тархац | 5 |
| 1.2. | Буриад хэмээх нэрийн тухай | 23 |

ХОЁРДУГААРБҮЛЭГ.

- | | |
|---|----|
| Буриадын хорин дөрвөн хамбын товч намтар | 26 |
| Буриадын хорин дөрвөн хамбын дэлгэрэнгүй намтар | 31 |

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Итгэлт хамбын амьдрал, түүхэн замнал

- | | | |
|------|---|-----|
| 3.1. | Хүүхэд болон өсвөр нас | 96 |
| 3.2. | Багш шавийн замнал | 105 |
| 3.5. | Итгэлт Хамба Санкт Петербургт | 145 |
| 3.6. | Итгэлт хамба дайны үед | 157 |
| 3.7. | Итгэлт хамба хувьсгалын үед | 164 |
| 3.8. | Итгэлт хамбын бумба оршоох ёслол | 180 |
| | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 215 |
| | Хамба Итгэлээс ард түмэндээ хандсан ИЛГЭЭЛТ | 256 |
| | XXIV Бандид Хамба Лам Дамба Аюшеев: | 271 |

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

- | | |
|---|-----|
| Буриадын сүм хийдүүд болон ариун дагшин газрууд | 287 |
| Ариун Байца | 290 |
| Алханы бэл дэх Намнан ламын суварга | 292 |
| Алхана-Тур | 293 |
| Иройскийн дацан | 294 |
| Бултумурын дацан | 295 |
| Гэгэтуйн дацан | 296 |
| Атаган-дырестүйн дацан | 297 |
| Сартуул-Булагийн дацан | 298 |
| Санагийн дацан | 300 |
| Цэжэ-Бургалтайн дацан | 301 |
| Шибертийн дацан | 302 |
| Манжушри ордон | 304 |

Иволгийн дацан	306
Тамчийн дацан	308
Агийн дацан	310
Цуголийн дацан	312
Читийн дацан	313
Зугалайн дацан	315
Угданийн дацан	316
Баргузины дацан	318
Курумканийн дацан	319
Усть-Ордын дацан	320
Якутын дацан	321
Ц.Отгонбаярын Итгэл хамбын хуралд тавьсан илтгэлүүд	325
Эзэн Чингис Богдын тахилга	342
Бурхан багш шинийн 1-15 дуустал тэрсүүдийг ялан зохиосон намтар	367
Заваа ламын зохиосон Нинжин сэтгэл магтаал Лам Ц.Отгонбаярын орчуулга	373

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУРИАДЫН ТҮҮХЭН ТОЙМ

1.1. Буриаддууд түүхийн тавцанд гарч ирсэн ба тархац

Буриад хэмээх нэр анх түүхэнд XIII зууны эхэн үед тэмдэглэгджээ. Монголын түүхийн тулгуур сурвалжуудад, Буриадын өвөг дээдэс байгаль нуурын орчимд ан гөрөөгөөр амьдардаг “Ойн иргэд”-ийн нэг бүрэлдэхүүн болж явсан тухай өгүүлжээ. “Судрын чуулган”-д дурьдсанаар Байгаль нуурын сав нутаг, Баргужин төхөм, Сэлэнгийн адгаар IX-XII зууны үед Булгачин, Хэрэмчин, Хори-Түмэд, Баргуд нэртэй ойн аймгууд ан гөрөөг гол болгон эрхлэн сууж байжээ. Булгачин, Хэрэмчин нь Енисей мөрний эхэнд, Хори-Түмэд Байгаль орчимд Баргуд Баргужин төхөмд тус тус нутаглаж байжээ.

Буриад гэдэг нэрийн тухай эрдэмтэн хуврага Балдан Базаров өгүүлэхдээ: Буриад гэдэг үг хохол буюу украин хэлэнд ихэрүүд гэдэг ба анх тааралдсан европчууд нүүр царай адилхан ихэр хүмүүс гэдэг байсан ба оросууд брада буюу ахан дүүс гэж нэр зүүн тэр нь сунжирсаар өнөөгийн буриад гэх нэр үүссэн гэж үздэг нь оновчтой тайлбар гэж бид үзэж байна. Түүнээс өмнө Байгалийн эргээс зүүн тийш Лена мөрний дээдэхээд, Ангарын сав нутагт “Гулигань” нэртэй аймаг нутаглаж байв. Хятадын сурвалжид энэ тухай “Гулигань нь байгалийн умар талаар нүүдэллэн амьдардаг. Тэд 5000 орчим хүчирхэг цэрэгтэй. Тэмээ мориор өдөрт хэдэн зуун газар явж чаддаг ба Гулиганчуудын нутаг нь хойшооих тэнгис хүртэл үргэлжилнэ” гэж тэмдэглэжээ.

Энэхүү гулиганыг эрдэмтэн Г.Н.Румянцев Орхоны түрэгийн хөшөөнд гардаг “уч курикан” мөн гэсэн бол А.П.Окландников тэргүүтэй эрдэмтэд Гулигань нь “хэрэмчин” аймгийн эртний нэр гэж үзжээ. Гулиганаас гадна байгалийн зүүн талд “Баегу” нэрт аймаг суудаг тухай Тан улсын түүхэнд тэмдэглэхдээ: “Тэдний улс

маш баян, 10000 орчим цэрэгтэй, цана хөлөглөн буга намнадаг, бас сайн морь, сайн зэвсэгтэй” гэжээ.

Манжийн халдан түрэмгийлэл, халх-ойродын дайн байлдааны улмаас халхын умард хэсгээр нутаглаж байсан зарим ард олон умар тийш нүүн, буриадад орж суух болжээ. Буриадын эрдэмтдийн судалгаанаас үзэхэд хамгийн анх 1630-аад оны үед Сэцэн хааны сартуулууд, 1665 онд атаганчууд 1684 онд Түшээт ханы цонгоол 1700 оны эхээр тавнангууд тус тусодоогийн буриадын нутагтанх оржээ. Сартуулууд нь Гэрсэнз Жалайр хун тайжийн хүү Далдан хөндлөнгийн мэдэлд арын долоон отгийг хуваахад очсон иргэд бөгөөд хожим Сэцэн хаанд инж болон очсон байжээ. Сэлэнгийн сартуулын бүрэлдэхүүнд Харчит, Кхирит, Хачинууд, Хатагин, Салджуд, Хөхүйд, Батуд, Атаган, Онхот, Цонгоол, Хэрдэг, Бунгут, Хатнул, Арбатан, Ашибагат, Булгад, Харнуд, Галзут, Хүлмэн, Алагууд, Хуркуд зэрэг овгууд байжээ. Сартуулууд нь Цонгоолуудтай нийлж Сэлэнгийн буриадуудын гол бүрэлдэхүүн болжээ. Цонгоол нь анх 1694 онд Түшээт хан аймгийн Гүршихийн хошуунаас Зая Сахул, Заяхан Онбол нарын хамт Сэлэнгэд ирснээс хоёр жилийн дараа 1696 онд зайсан Хонтогороор тэргүүлүүлсэн бөгөөд үүнд хэсэг хүн нэмэгдэн очжээ.Тэд Сэлэнгэ болон Хилго гол, Харалун, голын зүүн эргээр нутагласан юм. Цонгоол угсаатны бүрэлдэхүүнийг үзвэл Урианхай Найман цахар, Батуд, Хотогойд, Юншээбуу, Номхот, Илжигин, Аравтан, Сартуул, Харчиг, Оронгой зэрэг овгууд байв.

Сартуул, Цонгоолын умар тийш нүүх явдал нь бусад олон овог аймгуудад ихээхэн нөлөө болсон бололтой. Түшээт хан аймгаас 1690 онд Ариъяа багш Эрдэнэ даргаар тэргүүлүүлсэн үгзоон нар буриадад иржээ. 1735 оны “Сэлэнгийн мэдээ”-нд нийт 150 орчим үгзоон тоологдсон ба тэд Сэлэнгийн зүүн эргээр амьдардаг байжээ.

Сэлэнгийн буриадуудыг бүрдүүлэхэд оролцсон нэг бүлэг бол Сэлэнгэ Хиагтаар нутаглах болсон тавнангууд юм. 1690-ээд онд халхын Сэцэн ханы ээж гүнжийн албат болгож, түшээт ханаас өгсөн гурван тавнангын отог Онон голын Биндэрьяа нутгаасаа Хэнтий хөвчийг даван зугтаж, Хилго, Цөх, Сэлэнгийн сав нутагт суужээ. Тавнан хэмээн нэрийдэх болсон нь хааны хүргэнд өгдөг цолноос үүдэлтэй билээ. Тэднийг Турахай Тавнан гэгч захирч байв.

Хонгодорууд түүхийн тодорхой цаг үед буриадуудын нутагт сууж, буриадажсан хэдий боловч тэдний эдийн болон оюуны соёлд халхын эд өлгийн болон оюуны соёлын үлдэгдэл өдгөөг хүртэл байсаар байна.

Халдах дайснаас хамгаалах Халх түмнээс тодорхой шалтгаанаар буриадад орсон овог аймгууд нь ХҮII зууны эхэн үеээс ХҮIII зууны эхэн хүртэлх хугацаанд хэд хэдэн удаа нүүдэллэн очжээ. Тэд өөрсдийн нүүдлээ "БОШИГТ ХААНЫ БОСОЛГОН, САЙН ХААНЫ САМАЛГАН"- нар буриад нутагт ойн гарсан гэж өдгөөг хүртэл домоглон ярилцдаг. Эрдэмтэд үүнийг ойродын Бошигт хэмээх Галдан Хотгойдын Лувсан Сайн хан нарын үйл явдалтай холбон үздэг юм.

Ийнхүү халхчуудын зарим нь буриадуудтай угсаа соёлын хувьд нэгдэж улмаар Сэлэнгэ Түнхэн хиагт алайр зэрэг нутгийн буриадуудад нь Халх-ойрад-буриадын угсаатны ижилсэх үйл явц дүнд буй болсон байна. Буриадад орсон монголчууд нь эрдэмтэн В.С.Ханхалаевын үзсэнээр дунджаар тавин мянга орчим байсан бололтой.

Буриадад орсон монголчууд нь тэндээ нутаглан суух болсон гол шалтгаан нь 1689 онд Манж-Оросын хооронд хил тогтоох анхны гэрээ, 1727 оны Буурын хилийн гэрээнээс ихээхэн хамаарсан юм. Хаант орос өөрийн нөлөөг аажим аажмаар ахиулсаар 1648 онд Байгаль нуурын зүүн талд Баргузин шивээ, 1651 онд уг нуурын баруун талд эрхүү өвөлжөө, үд шивээг тус

тус байгуулж улмаар тэдгээр нь нутгийн иргэдийг баримтлан захирах цэрэг-засаг захиргааны төвүүд болон томорч байв. Энэ үе хүртэл халх, олон буриад монголчуудын газар нутгийн ерөнхий зааг байгаль нуурын урд бие ба сэлэнгэ мөрний адаг урсгал ,Хилго, Тэмнэг голуудын урсгалаар байжээ. Буриад халхчууд нь цаг улирлын байдлаас шалтгаалан нааш цааш бэлчээр даган нүүдэллэж байв. Энэ үед орос орон манж улстай хилийн гэрээ байгуулах нөхцөл бүрэлдсэн юм. Хэлэлцээр байгуулах нөхцөл байдалыг Ж.Гэрэлбадрах”Ойрадууд оросоос цэргийн тусламж авсан хэмээн цуурхаж байсан тул манж нар ойрад, оросын цэргийн холбоо байгуулагдахаас айн болгоомжилж оростой найрамдал тогтоохыг яаравчлах болжээ.

Жишээ нь Шодь Болтирогтой ойр төрөл нэгтэй занги хилийн гадна үлдсэн тул өөрийн язгуур нутгаас холдож салсандаа уйдаж харъяат бүл хүмүүстэйгээ хамт эдүүрийн мал гэр болон хөрөнгө хогшлоо тэмээнд ачаад нүүдлээрээ хааны шинэ тогтоосон хилийн овоог дарж нутагтаа орохоор хил гарахад нь харуулын монгол хасаг цэргүүд нэхэж заримыг нь алж заримыг нь баривчлан шилтэй заримийг нь манжийн хааны зарлигаар хил дээр цаазалсан байна. Харин зайсан Шодь Болтирогт тайш цол өгч хорийн арван нэгэн эцгийн хамт хилийн харуулыг мэдэн захирахыг зөвшөөрчээ.

Ийнхүү буриадад шурган орсон халхчууд тэндээ суух болж хилээр нааш цааш дураар явахыг цаазалснаар Байгаль нуурын хавьд нутаглах монгол хэлтэн нүүдэлчин аймгууд нь БУРИАД хэмээх нэрийн дор нэгдэн угсаа соёлын болон эд оюуны боловсролын нийтлэг төлөвших нэгэн үе эхэлсэн байна. Тухайн үеийн угсаатын үйл явцын гол хандлага нь хөгжлийн дотоод зүй тогтлын дагуу ижилсэн нэгдэж угсаатны шинэ хэлбэр бүхий нийтлэг бүрэлдэн үүсэх чиглэлээр явагдаж байсан юм. Энэ нь тус бүс нутгийн газарзүй байгаль орчны онцлог хүн амын эдийн засгийн үндэс нүүдлийн мал аж ахуй ан гөрөө нь нөхөн үйлдвэрлэл явуулах нөхцөл байдлын хувьд харьцангуй тайван

болсон явдал нь нийгмийн болон угсаатны хөгжлийн үйл явцад эерэг үйлчлэх хүчин зүйл болжээ. Буриадын аж ахуй соёлд оросын нөлөө тусч тэд газар тариалан тариалах болж талх барих сургууль эмнэлэг байгуулах зэрэг шинэлэг зүйлүүд 18-р зууны дунд үеээс бий болжээ. Буриадад талын дум хэмээх засаг захиргаанд нэгж байгуулж угсаатны бүлгүүд хэд хэдэн захиргаанд хуваагдан захирагдах болсон юм. 19 зууны байдлаар буриадын тойргуудын угсаатны нутагшилт хүн амын бүтэц нийгэм-эдийн засгийн байдал ямархан байсныг үзвэл

Хорийн буриад: Хори буриадууд нь байгалийн зүүн өмнө бие эргүнэ голын дээд эх Хилго гол Шилго голын дунд онон голын доод биеэр нутаглана. Хорийн буриадаас агийн болон Читийн талын дум байгуулагдсан. 1843 оны байдлаар нийт 32542 мянган хүн амтай 16000 га талбайг эзэмшиж байсан. Хорийн гол овгууд нь хөвдүүд хуацай харганууд шарнууд хамбигнууд батнайгучид худай зэргээс бүрдэж байжээ.

Агийн буриадуудын малын тоо толгойг хүснэгтээр сонирхуулбал: Хүснэгт 1

Он	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ	Гахай	Бүгд
1841	21138	18641	47135	6911	1535		95360
1850	19009	15485	41441	6217	1524		83676
1894	83762	15165	292278	77522	5812	73	611072
1900	90313	56725	221545	31756	6048	15	406402
1905	32214	50555	91197	14573	2385	14	190938

Кудрины болон Баргужины буриад: Эдгээр буриад нь одоогийн Улан-Үд хот орчим болон Байгаль нуурын зүүн өмнө эрэг, Кудрины талаар нутагладаг. 1808 оны байдлаар кудрины дөрвөн овгийн нийт 2892 хүн 1832онд 4308 хүн тус тус тоологджээ. Кудрин болон Баргужин буриадуудын үндсэн аж ахуй нь мал аж

ахуй мөн боловч ан агнуур загасчлал газар тариаланг бас эрхэлнэ. Тэд загасны аж ахуйг хамгийн өргөн ашигладаг угсаатны бүлэг юм. 1846 оны Кудрины думын мэдээнд хонь 6232, ямаа 1034, гахай 14, бод мал 5224, адуу 3944, нийт 16434 мал, гахай тоолуулжээ. Кудринчууд жилд өвөл зуны цагт 2 удаа нүүдэллэдэг. Тэд модон гэр орос загварын модон байшинд амьдарна. Ер нь тэдний аж ахуй амьдрал байдалыг ажиглахад оросын нөлөө туссан нь харагдаж байна. Тэд Сэлэнгэ болон байгаль далайд хавар 6 сараас намар 9 сар хүртэл загасчилдаг ажээ. Ангийн бүтээгдэхүүнээ Дээд үдийн худалдааны зах дээр борлуулдаг байжээ. Худалдаачид нь элдэв төрлийн хятад. Орос барааг зарах ба кудринчууд мал, малын өөх, тос, шир, хурганы арьс зэргээр арилжаа хийнэ.

Сэлэнгийн буриад: Сэлэнгийн буриадууд нь Сэлэнгэ мөрний доод бие Жаргалантай Хиагт хавиар нутаглана. Сэлэнгийн буриад нь халх ойрадын нүүдэлчдээс бүрэлдсэн ба энэ нь тэдний овгийн бүрэлдэхүүнийг сонирхон үзэхэд илэрхий.

Сэлэнгийн буриадын гол овгоос дурьдвал:Атаган, Ашигбат, Сартуул, Тавнан, Үгзоон,Хатагин, Андагай, Готол, Олзныхон зэрэг 40 орчим овог байна. 1822 онд Сэлэнгийн думыг байгуулахад дээрх овгуудын бүрэлдэхүүнтэйгээр 12 захиргааг байгуулсан. 1830 оны байдлаар 19787 хүн 1850 он 21302 нүүдэлчин ард, тэднээс 10960 эрэгтэй, 10342 эмэгтэй тоологджээ. 1850 оны байдлаар 4096 хүн модон гэрт 4220 хүн эсгий гэрт амьдарч байв.

Сэлэнгийн 22 захиргааны бүртгэлээс үзвэл: Хүснэгт-2

Д/д	Отгийн нэр	Эр	Эм	Нийт	Нутаглах газар
1.	Хатиган	517	494	1011	Жигд гол, Ерөө гол, Цагаан голын эхээр
2.	Харанут	321	329	650	Өрмөн гол, Идгэн гол
3.	1-рхвранут	599	620	1219	Доодоронтой, Гилбэр
4.	1-рхвранут	1553	1460	3013	Боргой гол
5.	Алагууд	341	353	694	Янзагатай, Хангайт
6.	Олзныхон	459	457	916	Галуут нуур, Загастай
7.	Сэлэнгийн харанут	1276	1368	2633	Иволгын гол, Оронгой
8.	2-р тавнангууд	12	127	259	Арсүүж, сүвэгттахам
9.	2-р харангут	259	258	517	Тэмнэг, Удган гол
10.	Бамбай хурамши	508	545	1051	Усть Иволго, Шивэрт
11.	1-р сартуул	760	772	1533	Бургалтай гол, баян гол
12.	2-р сартуул	1122	1159	2281	Үхэр чулуун, Хатголдон гол
13.	1-р тавнангууд	297	278	575	
14.	Подгородгой	434	449	883	
15.	Үзэн	118	11	229	Тэмнэг гол, Тамч
16.	Буумал готол	750	758	1508	Оронгой Бахан Жаргалант
17.	Цонгол	1684	1657	3341	Шаазгайт, Жиндо гол
18.	Ашигабат	1050	1092	2142	Кударин, Цайдам
19.	2-р втаган	378	388	766	Ацай, Тамч, Загастай
20.	2-р сэлэнгийн харанут	317	384	701	Сэлэнгэ, Ёнхор
21.	3-р тавнангууд	=	=	1196	Харат даваан, сувагтай
22.	Чихойн харанут	=	=	862	Дунд, доод шарилж

Баегуг гэдгийг эрдэмтэд барга буюу нэгэн дуугаар Баргуд аймаг гэж хүлээн зөвшөөрч байна. Тэд дээрх гулигантай эдийн соёлын хувьд онц ялгаваргүй байгаа нь угсаа соёлын холбоотой байсныг илэрхийлэх баримт юм. Тэдний эдийн соёлоос харахад нүүдлийн аж ахуй эрхэлдэг аймгууд байсан ба археологийн олдвороос үзэхэд, тэд Саян-Алтайн болон Байгалийн зүүн биеийн аль алины шинжийг илэрхийлсэн байдаг ажээ. Тэрхүү аймгууд нь Түрэгийн хант улсын бүрэлдэхүүнд орж, Тан улсын

эсрэг тэмцэж явсан ба энэ нь тэднийг монгол угсаатан биш гэсэн үг хараахан биш юм. Тэр үед Баегу хэмээх нэрийн дор байсан нүүдэлчин аймгууд нь цусан төрлийн холбоонд тулгуурласан биш, цэрэг улс төрийн зорилгоор нэгдсэн түрэг монгол гаралтай аймгууд байсан бололтой.

Харин Х зууны үеэс Байгаль нуурын сав газрын ойн иргэдийн дотор Хори түмэд, Баргуд, Буриад, Хабханас, Булгачин, Хэрэмчин, Урасут, Тэлэнгүт зэрэг аймгууд нутаглаж байв. Монголын нууц товчоонд: Хори түмэдийн зарим нь Х зууны үед байгаль нуур орчмын нутгаасаа нүүж Бурхан халдун /Хэнтий/ ууланд ирсэн тухай өгүүлэхдээ Дува сохор, Добу мэргэн ах дүү хоёр нэгэн өдөр Бурхан халдун ууланд гараад Түхнэлэг горхи нуруу уруу бүлэг иргэн нүүн айсууг харжээ. Тэр иргэний дотор нэгэн сайхан охин байгааг Дува сохор олж үзээд хэрэв тэр хүний гэргий болоогүй бол Добу мэргэн дүү чамд гуйж гэргий болгож өгье гээд очиж үзвэл тэр охины нэрийг Алунгуа гэх бөгөөд үнэхээр хадамд гараагүй гоо сайхан охин байж. Энэ охин Хори түмдийн ноён Хорилдай мэргэний гэргий Баргужин гуагаас Хори түмэдийн нутаг Ариг ус гэдэг газар төржээ. Түүний эх Баргужин гуа бол хол газрын Баргужин төхумийн эзэн Бургудай мэргэний охин бүлгээ. Тэр бүлэг иргэн бол Хорилдай мэргэнийх ажээ. Хорилдай мэргэн Хори түмдийн газарт булга хэрэм гэх мэт ан гөрөөс агнахаа хориглон булаалдаж харилцан муудалцаад салж хорилар овогтон болоод. Бурхан халдун ууланд ан гөрөөс элбэг гэж сонсож Бурхан халдуны эзэн бурхан босгосон Шинч баян урианхайтай уулзахаар нүүж ирсэн ажээ хэмээн өгүүлдэг. Үүнээс үзэхэд Хори түмэд Баргуд аймаг ургийн холбоотой байсан байна. Тодорхой нэгэн шалтгаанаар хоорондоо эв түнжин хагаран, Хорилдай мэргэн Бурхан халдунд хүрч ирж Добу мэргэн Алунгуаг гэргийгээ болгосноор тэд гурван голын монгол аймгуудтай ураг барилджээ. Оросын Бурханы шашинтны төв сангийн тэргүүн бандид хамба лам Дамба Аюшеев айлдахдаа гурван голын сав нутагт эзэн богд Чингис хаан мэндэлсэн нь үнэн гэж батлагдавал

Чингис хаан буриад гарвалтай гэдэг хамбын айлдвар яалтгүй үнэн болох нь батлагдаж байх шиг. Энэ үйл явцаас улбаалан зарим эрдэмтэд дундад зууны монголын түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсэн Горлос нарыг Хори түмэдтэй холбосон байна. Хорилдай мэргэн байгаль нуур хавьд нутаглаж байсан Хори Түмэдээс тасрахдаа үүсгэсэн Хорилар хэмээх овгийн нэр яваандаа Горлос хэмээгдсэн бололтой. Тэрхүү Горлос нь хожим Халхын арын долоон отгын нэг болж Гэрсэнзийн гутгаар хөвгүүн Онохуйн мэдэлд очсон ажээ.

Тэгэхээр өнөөгийн буриадын өвөг дээдэс нь эртнээс гурван голын язгуурын монголчуудтай харилцаж явсан нь дээр өгүүлсэн зүйлээс харагдаж байна. Их монгол улсыг байгуулсаны дараа жил буюу 1207 оны туулай жил Чингис хаан өөрийн ууган хөвгүүн Зүчийг их цэрэг авахуулан ойн иргэнийг дагуулан авахуулахаар илгээв. Энэ тухай МНТ-д Туулай жилд Зүчи баруун гарын цэргийг авч ойн иргэнээр эзлэхийг мордоход Буха газарчилж явав. Ойрд ойн ардын Худуга бэхи түмэн ойрдоо авч дагаар ирэв Худуга Бэхи ирээд Зүчийг газарчлан түмэн ойрадын нутгаар явж Шигшид голд хүрэв. Зүчи ойрд буриад барга урсууд хабханас ханхас туба аймгийг оруулаад түмэн хэргисийн нутагт хүрэв хэмээн ойн иргэдийг эзлэн авсан тухай дурджээ. Энд Зүчид газарчлан явсан Буха ноён бол буриадын тунка нутаг саяануулын домогт гардаг Бух ноён Будан хатан нь хори түмэдийн ноён Дайдухулын гэргий Бодохой мөн бололтой хэмээн зарим эрдэмтэд үздэг. Буриад хэмээх нэр энэ үеэс ойн иргэдийн олон аймгуудын доторх нэгэн угсаатны бүлгийн нэр болон түүхэнд тэмдэглэгдсэн байна. Түүхэн домогт өгүүлснээс үзэхэд буриад нь Барга аймгийн Баргудай мэргэний их хөвгүүн Баргудайгаас удамласан аймаг юм. Буриад нар нь тухайн цагт ойн иргэдэд багтан, голдуу ан гөрөө эрхэлж амьдарч байсан ба 12-р зууны эхээр Их монгол улсын бүрэлдэхүүнд багтжээ.

Буриадууд анх хаанаас гарсан, хаагуур нутаглаж байсан тухай зарим сонирхолтой мэдээг 19-р зууны үед зохиогдсон буриадын

сурвалжаас үзэж болно. Тухайлбал Шираб-нимбуу Хобитуевын Хорийн арван нэгэн эцгийн буриад зоны түүх гэдэг сурвалжид Буриад гэж гарсан язгууртан Байгаль нуурын урд талаар суусан Бэдэ улстай Бөртэ чонын язгууртай нийлж өнөржөв. Баргажин гэж нутагтаа Барга баатар, Буриад ба Хоридой гэж хоёр хөвүүнтэй байсан гэдэг. Буриад гэдэг нь байгалийн нөгөө талд гараад зүлэг голд нутаглаж загасны агнуураар амьдарч суув, гэсэн байна. Үүнд: 1/Хори түмэд 2/ Баргуд 3/Буриад гэж хувааж болно. Энэ гурван бүлэг нь хожмын буриад хэмээх угсаатны бүлгийн цөм болсон байна. Тэд тухайн үед бүгд монголоор ярьдаг ард түмэн байсан гэж судлаачид үздэг. Байгаль нуурын орчин тойронд нутагласан ойн иргэд Чингис хааны мэдэлд орсоноосоо хойш уугуул нутгаасаа зарим нь урагш зарим нь баруун тийш нүүдэллэсэн байна. Энэ хөдөлгөөн нь одоогийн буриадуудын өвөг дээдэст ч нөлөөлсөн байна. Тэдний зарим нь урагш Хянганы нурууны баруун бие одоогийн түмэдийн нутагт анхандаа очиж суужээ. Чингис хааны дараагаар тэд Тулуйн эзэмшлийн голын түмэнд багтан орсон бололтой байна.

XIII зууны эхээр Их монгол улс байгуулагдан бүх монгол туургатныг нэгэн төрийн жолоонд оруулснаар урьд нь тархай бутархай оршин байсан монгол аймгуудын улс төр газар нутгийн нэгдэл буй болж улмаар тэдний угсаа соёлын нийтлэг болон нэгэн аймаг бүрэлдэх аятай нөхцөл бололцоо бүрдсэн байна. Өдгөө ойрад буриадуудын дунд нийтлэг үзэгддэг хувцасны эсгүүр зах хормойн хиаз хуримын зарим зан үйл гэх мэт зүйлс нь XIII-XIV зууны үеэс улбаатай байж болох юм.

1368 онд монголын Юань улс унасны дараагаар буриадуудын зарим нь дөрвөн ойрадын бүрэлдэхүүнд багтан орсон байжээ. Сурвалжид тэдний тухай арын ганц модны отог хэмээх барга буриад аймгууд ойрадын нэгэн түмэн болон оролцож байсан гэжээ. XIII зуунд ойрадууд Эрчис мөрний хөвөөнд нутаглаж тэндээсээ аажмаар нүүн Алтай уулын бэлд хүрч суурьшжээ. Ийнхүү нүүх болсны шалтгаан нь хэдийгээр дотоод улс төрийн

үймээн самуунтай холбоотой боловч гол нь С.Пүрэвжавын үзлээр ойрадуудын үйлдвэрлэхүй хүчин урагшлан ахиж мал сүрэг олшрон өссөн явдалтай холбоотой байсан бололтой.

Хүн ам мал сүргийн тоо толгой олшрон өсч ойрадууд заримдаа анчин гөрөөчин заримдаа малчдын байдлаас бүрмөсөн талын малчин болцгоож олон толгой мал сүргийг Сибирийн цас их унадаг байнга зудархдаг нутагт цаашид найдвартайгаар өсгөн үржүүлэх боломжоор хязгаарлагдаж байсан тул ойрадууд нарлаг дулаан бэлчээр эрэн баруун зүг нүүн оджээ хэмээн дүгнэсэн байна. чухам л энэ үеэс ойрадын нийгэмд аж ахуй соёлын шинэ хэв маяг нүүдлийн мал аж ахуй зонхилох болсон нь ойрадуудын нийт монгол туургатантай эдийнзасгийн нэгдмэл хэвшлийн үндсэн дээр угсаатны нийтлэг угсаа соёлын хэлхээ холбоо хөгжих улмаар монгол угсаатны нэгдмэл ухамсар бүрэлдэх таатай нөхцөл буй болсон байна. Энэ нь ойрад буриадын мал аж ахуй эд өлгийн болон оюуны соёлын нийтлэгхэвшинж буй болоход түлхэц болжээ. 1437 онд Тогоон тайш дөрвөн ойрадын холбоог байгуулахад буриадууд баргатай нийлж дөрвөн ойрадын том аймгийн нэгийг бүрдүүлжээ Удалгүй 1487 онд дахин ойрадын шинэ холбоог байгуулахад буриад барга нар мөн л холбоотноор оролцсон байна. Зарим эрдэмтэд Ойрадын эхний холбоо байгуулагдсаны дараа барга буриад нь зүүн монголын бүрэлдэхүүнд үлдэж Батмөнх даян хааны эзэмшил урианхан түмний дотор багтаж явсан гэжээ. Бидний бодоход энэ нь цаг хугацааны хувьд арай эртдэх юм. Буриадууд ХҮI зууны үеэс л дөрвөн ойрадын холбооноос гарч халхын бүрэлдэхүүнд орсон байна.Энэ тухай хожим тод үсгээр зохиогдсон Гаван Шаравын Дөрвөн ойрадын гутгаар нь барга буриад хэмээх мөн. Барга буриад нь монгол орос хоёрт шингэвэй гэжээ. Энэ үед буриад барга нь халхын мэдэлд шилжээд байжээ. ХҮII зууны эхэн үе болоход Даян хааны дөтгөөр үеийн Буянт сэцэн хааны үед Солонгодын Бүүвэй баатар бэйлийн их хөвгүүн Дай хун тайжид түмэдийн Алтан ханы гүнж Балжиныг бэр болгон

өгөхөд барга болон хори түмэдийн нэг хэсэг нь Балжин хатны инж болж Хянганы тэндээс 1600-аад оны үед нь Эргүнэ мөрөнд очиж суусан гэдэг. Харин энэ үеэс Хори буриадууд өөрсдийн уугуул нутаг Сэлэнгэ Байгаль нуурын зүүн өмнө биеэр нутаглан Халхын түшээт хан, Сэцэн ханы харъяанд явах болжээ.

Солонгодын Бүүвэй баатар Баожин хатны тухай өгүүлдэг Балжин хатны домог, Бүүвэй бэйл ханы домог буриад зоны дунд өнөөг хүртэл өргөн тархаж ирсэн байна. Уг домогт зарим үйл явцыг өгүүлдэг юм. Тухайлбал хатан Бүүвэй бэйлийн хүү Дай хун тайжид хатан болон богтлогдож улмаар хадам эцгээс зугатан Хөхөлбий хөвч хэмээх нутагт нүүн ирсэн тухай өгүүлдэг. Мөн энэ үед Дай хун тайжийн арван отог албат улсуудаас Хорияхан гэгчийн арван нэгэн хөвүүд нь арван нэгэн аймаг отог байжээ. Тэд хойд зүгт чиглэн нүүж явсаар Онон гэж мөрнөөр нутаглан суугаад хамнигад хар улиядуудтай эв үгүй болж дайралдаад арван нэгэн отгуудын зон ихэд алуулав гэж домогт өгүүлдэг. Энэ үйл явц нь түүхэн үнэний ортой мэт байна. Буриадын домогт гардаг түүнийг Хөхөлбий гэж нэрлэдэг ажээ. Тэдний ямар зүг нүүсэн он цагийг Оросын эрдэмтэн К.В.Вяткина 1957 онд Хорийн арван нэгэн эцэг Балжин хатны хамт Байгалийн зүүн биед ирсэн гэдэг. Орсууд ангарын эхэнд бэхжихийн тулд 1657он Братскийн цайзаас урагш Балаганы бэхлэлтийг байгуулав. Түүнээс хоёр жилийн өмнө И.Похабов Ирхүү гол Ангарт цутгах газар өвөлжөө байгуулснаар Ангар-Окийн буриадуудыг оросууд эзлэх эхний үйл явц дуусч буриадууд дорнод зүг ихэд шахагдаж орсууд байгалийн өмнө нутгаар орж ирсэн. Улмаар 1650 онд Жимстийн нуруу, Яблоновын нуруу 1653 онд Сэлэнгийн дээд бие Хилго иргэн голын хөндийгөөр орсууд орж ирсэн байна. Ингэж орсууд хүч түрэн орох болсон нь 1641 онд Эхирэдийн Шэвшэй баатар тулалдаанд алагдаж Эхирэд Булгадыг бүрэн эзлэх боломж орсуудад олдсонтой холбоотой юм. Улмаар тэднээс орсууд үслэг эдлэлийн болон мөнгөн татвар авах болсон боловч 4 жилийн дараа Зүлэгийн Эхирэдүүд татвар төлөхөөс татгалзаж бослого

гаргасанд түүнийг даруулахаар А.Бедаревын 50 илүү хүнтэй зэвсэгт отряд илгээж тулалдаж байжээ. Энэ байдалд угсаа гарал нэгт халх, ойрадууд зүгээр гар хумхин суугаагүй байна. Тухайлбал 1667 онд Зүүнгарын Сэнгэ, 1669-1670 онд Дайхун тайж, 1674 онд Тавнангийн гэгээн тайж, 1684 онд Халхын түшээт хан Чахундорж, 1688 онд Баатар хун тайж зэрэг хүмүүс удаа дараа орсуудын түрэлтийн эсрэг эсэргүүцэл үзүүлж байсан боловч халх ойрадын дотоодын хямрал зөрчилдөөнөөс болж энэ байдал явцгүй болсон юм. Гэвч халхын хаад ноёд оросын газар нутгийн түрэмгийллийг дипломат болон цэргийн хүчээр эсэргүүцэн тэмцэж байв. Тэд оросуудаас хот бэхлэлтээ даруй нүүлгэхийг шаардан довтолход оросын талыг баримталдаг монгол буриад аймгуудыг уулгалан хүн малыг булаах зэргээр газар нутгаа хамгаалахад хүрч байжээ. Тухайлбал 1660 онд Халхын цэрэг Байгаль нуурын баруун бие, Ангар мөрний өмнөд эрэгт орших Балаганы шивээг довтолж Орост дагаар орсон буриад зоныг эгүүлэн авчээ. Гэвч халх буриадуудын нэг хэсэг нь оросуудын эсрэг тэмцэж байхад Байгалийн зүүн өмнө биеийн хорийн арван нэгэн эцгийн зон нь Оросын их хааны албат болох санал өгч 1642 онд Гачиг Буярков гэгчээр дамжуулан мэдүүлснээр зөвшөөрөгдөж 1648 онд өрх бүр хорин мөнгөний засаг албыг хааны санд жил бүхэн зоосоор өргөж байх болсноор албатын тоонд багтах болжээ.

Турахай тавнан бол халхын Сэцэн ханы хүргэн байсан. Тавнангуудыг С.А.Токарев Е.М.Залкинд тэргүүтэй олон эрдэмтэд 1718-1722 онуудад буриадад нүүдэллэн ирсэн гэж үздэг бол. И.Миллер И.Фишер нарын зарим хэсэг нь бүр 1646-1691 оны хооронд орж ирсэн гэж үздэг, Тавнангууд нь 1200 орчим өрх 6000 орчим хүн амтай нүүж очжээ. Ийнхүү Сэлэнгийн буриадуудын угсаатны бүрэлдэхүүн төлөвшилд халх ойрадын олон угсаатны бүлгүүдээс оролцжээ. Харин баруун болон баруун өмнөд буриадад орж суусан томоохон бүлгийн нэг нь хонгодорууд юм. Тэднийг хэдий үед буриадад орж нутаглах болсон тухай

тодорхой баримт үгүй бөгөөд ихэнх эрдэмтдийн судалгаанаас үзэхэд ХҮИ зууны дунд хагаст орсон гэсэн он цагийн баримжаа дийлэнх байна. Хонгодорын нэг хэсэг нь Алайр ,Тунханд, бас зарим хэсэг нь Енисэй мөрөн Ангарын сав газар Эрхүүгийн баруун өмнө бие Балаганы тойрогт багтжээ. Алайрын арван нэг, Балганы Хорин дөрөв,Идины хорин ёс, Ольхоны ёс Түнхэний арван дөрвөн овгуудаас бүрэлдсэн томоохон угсаатны бүлэг буй болжээ. Мөнхүү буриадууд зэргэлдээ орших өмнөд Сибирийн түрэг овог аймгуудтай холилдох үйл явц бас явагдсан бололтой.Буриадын эрдэмтэн С.П.Балдаев хонгодорыг бүрдүүлж буй хэдэн овгийг тэмдэглэсэн байна. Үүнд ашата, гуран ашхай, улаазай,тайбажан, хагт, найдар, шуранхай боолдой, буруутхан, боролзой, дүртэн зэрэг овгууд байна.Тэд мал аж ахуйг голлон эрхэлнэ. 1849 онд хорийн думаас гаргасан тайланд хорийн гол эрхлэх аж ахуй нь мал аж ахуй гэжээ. Мал аж ахуйн зэрэгцээ бага зэрэг тариалан гар урлалыг эрхэлдэг боловч тэдгээр нь хавсрагын төдий байлаа. Бараг ихэнхдээ эсгий гэрт суух ба 13-р зууны дунд үеээс модон байшинд суух явдал дэлгэрч хэдхэн жилийн дотор байшинд идэвхтэй суух болжээ. 1849 оны байдлаар эсгий гэрт суудаг ард 7533, модон байшинд 2412, орос байшинд 308 болсон ба модон байшинг нэгээс нөгөө нутагт нүүж явахад зориулж барьж байжээ. 293676 толгой малтай бөгөөд үүнээс хонь ямаа нь ойролцоогоор 50000 толгой,адуу нь 27562 тоологдож харин тэмээ үхрийн тоо нь тодорхой биш байна. Хорийн буриадууд нь малын мах сүү тос хүнсэндээ хэрэглэхээс гадна цай төмөр, тамхи,орос даавуу, зөгийн бал металл эдлэлийг худалдан авч хэрэглэдэг байсан аж. Энэ үед олон дацан сүмүүд байгуулагдаж Хорийн худанай дацангаас шанзодба Лхүндэв, унзад Чойндон,Галтайн дацангаас Чүлтэм зэрэг ном сайтай алдартай лам нар төрөн гарсан байна.

Агын буриад: Агын буриад нь Онон голын зүүн эрэг Ага Элийн голын хооронд нутаглана. Агын буриадыг бүрдүүлж буй овгууд нь цагаан галзууд бодонгууд, хөвдүүд,хуацай,харганууд,

шарайдууд, халбингууд, ага оргодой улаалзай, лэгдүүд зэрэг овог юм. 1840 оны байдлаар 7312 хүн тоологджээ. Агын буриадуудын ихэнх нь эсгий гэрт сууж байжээ. Жишээлбэл: тэр үед эсгий гэрт 5075 хүн, модон байшинд ердөө 49 хүн амьдарч байв. 1840 оны байдлаар нийт мал нь 79319 толгой үүнээс 19083 адуу, 16018 бод мал, 42864 хонь, 1354 тэмээ тоолуулсныг үзвэл энэ нь буриадын хамгийн олон малтай бүс байсан бөгөөд тэдний нутаг нь мал аж ахуйд ихээхэн тохиромжтой байсантай холбоотой. Хавар өвлийн цагт малдаа өвс бэлтгэж өгдөг. Малын мах сүүг хүнсэндээ хэрэглэж бас малын түүхий эдийг худалдаа гар урлалд өргөн хэрэглэж байв. Жил бүрийн 11 сарын 20-ноос 12 сарын 15-хүртэл яармаг худалдаа хийдэг байжээ. Худалдаа нь арилжааны шинжтэй байсан бөгөөд ихэнхдээ барааг бараагаар солилцдог ба нэг удаагийн яармагт ойролцоогоор 200-500 худалдаачид цугларч худалдааны томоохон үйл явдал болдог байжээ. Сэлэнгийн буриадын угсаатны бүрэлдэхүүний 80 орчим хувийг халхчууд эзэлж байгаа нь буриадын бусад угсаатны бүлгүүдээс ихээхэн өвөрмөц байна.

Иджин Алайр Балаганы буриад: Эдгээр буриадууд нь Эрхүүгийн тойрогт багтах ба тэд Ангар, үд, Оси, Унгэ зэрэг голын сав нутагт мал аж ахуй газар тариаланг хослуулан эрхэлж байв. Идиний буриадууд 1828 онд 12 овгоос бүрдсэн нийт 12631 хүн, Балаганы буриадууд 1853 онд 16346 хүн, Алайрын буриадууд 1855 оны байдлаар 107773 хүн тус тус тоологджээ. Тэд XIX зууны дунд үе болоход эсгий гэрт суухаа бүрэн болиж модон байшинд суух болсон байна. Жишээнх Балаганы буриадууд 1844 оны байдлаар 2207 айл байшинд амьдарч байжээ. Мөн өвөл зуны байшинтай бөгөөд өвлийн байшин нь 1855 онд 2207 байшинтай 3820 модон гэртэй байжээ. Овгийн бүрэлдэхүүний хувьд балаганы уриад нь кульмет, олзныхон, шарайт, бухат ноёд, зүүнгар, холтубай нараас тус тус бүрэлдэж байжээ.

XVIII зууны эцэс үе болоход баруун буриадууд жилд 2 удаа нүүдэллэдэг болсон. Тэд их төлөв төмс хүнсний ногоо тариалдаг.

Ан гөрөө хийж түүнийхээ түүхий эдийг борлуулж амьдарч байв. Жишээлбэл: Балаганы буриадууд 1858 онд нэг жилийн дотор 4520 хэрэм, 105 туулай, 95 янгир, 60 булга мөн баавгай, чоно, халиу, үмхий хүрэн зэргийн амьтан агнаж ашиглаж байжээ.

Кудин дээд Лены буриадууд: Кудины буриадууд нь Ангар мөрний баруун эрэг ордой Куйд Мөрөн зэрэг жижиг голын хөндий Лена голын дээд эх Манзурк голын савд нутаглацгаана. 1810 оны байдлаар дээд ленад 8930 хүн, Кудинд 1829 онд 12010 хүн байсан байна. Аж ахуйн хэв маягийн хувьд газар тариалан ан гөрөөг голлож мал аж ахуйг хавсарга болгон эрхэлдэг байв. 1829 онд Кудины буриадууд 39951 толгой малтай, 1840 онд 47415 малтай байжээ. Жилд дунджаар 5000-6000 ширхэг хэрэм агнаж тушаажээ. Кудины гол гурван овог ашигабат, харанут, алагуудууд голчлон загасчлах ажлыг гүйцэтгэж бүтээгдэхүүнээ яармаг дээр борлуулдаг байсан байна.

Хаант оросын хувьд Байгалийн өмнөд нутаг уруу хийж байсан халхын байнгын довтолгоон зогссон таатай боломжийг ашиглан Сибирь Хар мөрөн дэхь цэргийн хүчний харьцаа тэнцвэргүй байсан нөхцөлд Галдан бошигтын тэмцлийг далимдуулан эв зүйгээр санасныг бодоход хялбархнаар Манжтай хилийн гэрээ байгуулж авах ашигтай тохироо бүрджээ гэсэн байна.

Хэлэлцээр 1689 оны 8нсарын 12 нд оросын Нерчү хотын дэргэд Нэрчү Шилка голын бэлчир газар эхэлсэн агаад манжийн талыг гүн Сонгот оросын талыг гүн Ф.А.Головин нар тэргүүлж байв. Хэлэлцээрийн эцэст манж нар баруун, зүүн сибирь байгаль нуурын хавийн асар уудам нутгийн эзэн байх оросын эрхийг хүлээн зөвшөөрчээ. Ийнхүү оросууд буриад монголчуудыг эзлэн харъяалах эрхийг олон улсын хэмжээнд баталгаажуулжээ.

Энэ үед Хорийн Галзуд овгийн Бадан тухарханаар ахлуулсан хэсэг төлөөлөгчид оросын их цагаан хаан Петерт гомдол мэдүүлж татвар багасгах өөрсдийн дураар шашин шүтэх асуудлаар мориор явж Москва орж уулзсанд их хаанаас их албат

гэдэг буриад ардын төрөлх нутгаас Эрхүүд газар тасалж өгөхийг хориглох тэдний газар дээр дураар суусан орос хүмүүсийг өөр газарт суулгах байгаль нуурын өмнөөс монголын хил хүртэлх өөрийн элдэв газарт дураар нүүх эрх тэдэнд олгосон ба тэд өөрсдөө оросын хаант улсад үнэнч зүтгэхээ амласан билээ.

Удалгүй Манжийн Найралт төв хаанаас халхын оростой зах нийлсэн нутгийн хилийг зааглан тогтоох худалдааны харилцааг сэргээх саналыг тавьсанд хаант оросын тал хүлээн зөвшөөрчээ. Хил тогтоох хэлэлцээрийг халх оросын хил орчмын буур голын хөндийд 1727 оны 6 сараас 8 сар хүртэл хэлэлцэн гэрээ байгуулжээ. Гэрээгээр хиагт сэлэнгийн хавьд хилийг тодруулах зорилгоор 59 харуулын овоо босгожээ. Хил тавихад буриадаас Шодь болтирог гэгч хорийн арван нэгэн эцгийн ахлагч зайсан газарчилжээ. Шодь болтирог хиагтаас эхлэн зүүн тийш Эргүнэ гол хүртэл өөрийн харъяат арван нэгэн эцгийн зонтойгоор улаа болон хамаг хэрэгслийг өгч газарчлан хилийн овоотой танилцуулж өөрсдийн эртний нутагшиж байсан газруудаа баатар цагаан хааны мэдэл тийш оруулахын төлөө хүч тавин ажилласан бөгөөд тэрээр хилийн гадна орхигдсон угсаа гарал нэгт буриад барга зэргийг байгаа нутагт нь үлдээжээ.

Ольхоны буриад: Ольхон буриадууд Байгаль нуурын баруун хойд эрэг Ольхон арал дээр амьдарна. 1840 онд Ольхоны найман овгийн буриадууд 5324 хүн, харин 1856 онд 5946 хүн бүртгэгджээ. Ольхончууд байгаль газарзүйн эрс тэс уур амьсгалтай хүнд нөхцөлд амьдардаг зон олон юм. Тэд загас барих баавгай, чоно, янгир, хэрэм, халиу агнах зэрэг ан гөрөөг голлож мал аж ахуйг бага зэрэг эрхэлнэ. 1831 оны тооллогоор 22704 толгой малтай байжээ.

Түнхэний буриад: Түнхэний буриадууд нь Байгалийн баруун өмнө нутаг Саяан Закамен Түнхэний хойд талаар нутаглаж зүүн талаараа Сэлэнгийн буриадуудтай хиллэнэ. 1864 оны байдлаар 11519 хүн амтай, 29446 мянган толгой малтай байв. Тэд мал аж

ахуйг голлон эрхэлдэг зон байв. Түнхэний малын тооллогоос харахад тэд гахайг туслах аж ахуйн хэлбэрээр эрхэлж байжээ. Түнхэн буриадуудын овгуудыг үзвэл хонгодор, хүрхүүд,гэрт, хойхо шошоолог, сөөхөр, боолдой, уляад, галзуд, чоно, тангад, соёд, сартуул хамниган зэрэг овгууд бүрэлдэхүүнд нь байжээ. Тэдгээр овгуудад ХҮII зууны эхэн үеэс эхлэн буриад нутагт шилжин нүүгсдийн удам хойчоос ихээхэн оролцсон тул Түнхэний буриадын угсаатны бүрэлдэхүүний нэлээд хувийг халхчууд эзэлж байна.Буриадын угсаа түүх аж ахуйн байдал газар нутгийг тойм байдлаар үзэхэд XII зууны үеэс түүхэнд нэр гарах гөрөөчин аймгуудаас бүрэлдсэн монгол угсаатны томоохон бүлэг болон төлөвшжээ.

1.2. Буриад нэрийн тухай

Аливаа угсаатны угсаа түүхийн судалгаанд тухайн угсаатны нэр түүний гарал утга холбогдол хэрэглэж ирсэн байдал зэрэг асуудал чухал үүрэгтэй байдаг. Бид энд Буриад нэрийн гарал үүслийн тухай эрдэмтдийн дэвшүүлсэн судалгаа санал дүгнэлтийг харьцуулан үзэхийг оролдов. Эрдэмтэд буриад нэрийг түүх угсаатны судлал хэлний шинжлэх зэрэг ухааны хүрээнд судлан шинжлэх оролдлого хийжээ. Дээр дурдагдсан буриад гэх нэрийн талаар тайлбар хийсэн эрдэмтэн лам Балдан Базароваас гадна олон хүмүүс тайлбар хийснийг ишлэвэл: Буриад хэмээх нэрийг судлах оролдлогыг анх буриадын эрдэмтэн Базар Барадин хийж Баргут гэдэг нэрийг хожуу үеийн хувилбар мөн гэж бичсэнээс хойш оросын болон монголын зарим эрдэмтэд нилээд судалжээ. Б.Б.Бамбаев орос хэлний браты гэдэг албан ёсны нэрэнд буриадууд дасан өөрсдийгөө тийн нэрлэх болсон гэж санал гаргасныг нэлээд эрдэмтэд дэмжсэн. Түүнийхээр бол буриад хэлэнд нэг үгэнд хэд хэдэн гийгүүлэгч давхарлан ордоггүй тул б болон р гийгүүлэгчийн дунд ба у-гийн хоорондуур дуудагддаг эгшиг авиа жийрэглэгдсэнээр бырат юмуу бурят гэж нэрлэгдэх болсон аж. Энэ саналыг нэрт угсаатан зүйч С.А.Токарев дэмжиж өөрийн саналаа бичжээ.

Тэрээр ХҮII зуунд оросууд буриадуудыг брат брат хүмүүс гэж нэрлэж байсан гэж үзсэн Харин Г.Н.Румянцев лавшруулан судлаад Кан ба Енисейн мөрний саваар нутагладаг түрэг ба самоед овог аймгууд буриадуудыг Пырат гэж нэрлэж байсан бөгөөд П авиа нь П ба Б-гийн хоорондуур дуудагддаг байснаас орос хэлэнд б авиагаар сонсогддог юм. Иймээс ХҮII зуунд энэ үг орос хэлэнд орохдоо тэдний сонголт илүү нийцтэй брат гэж дуудагддаг болсон гэжээ. Харин Г.Д.Санжеев буриад нэрийн гарлыг монгол хэлний зүйн талаас тайлбарлах нь зүйтэй гээд буриад ардын дуу хэлэндгардаг Буриша ошохон бурьяадууд гэх үгийг үндэс болгоод энэ нэр нь бурийа-д buriya-d гэсэн бүтэцтэй

юм гэжээ. Бури гэсэн үйл үгний үндэс нь заасан зүгээс зориуд өөр тийш зүглэх чиглэх зугатах гэсэн утгатай гэж санал гаргасан. Энэ үзлийг дэмжсэн өгүүллийг 1990 онд В.Ц.Цыремпилов нийтлүүлжээ. Т.А.Бертагаев курыкан ба буриад нэрсийг холбон тайлбарласан боловч төдий л дэмжсэнгүй. Тэрээр *buriyat burian* иш курыкан хэмээх үгнээс гаралтай гэсэн байна.

Харин угсаатны зүйн үүднээс тотем шүтлэгтэй холбон үзсэн Ц.Б.Цыдендамбаевын дэвшүүлсэн нэгэн санал ихээхэн анхаарал татсан юм. Тэрээр чоно тотемтой монгол аймгуудын чинос нэр хожим түрэгийн ноёрхолд ороход түрэг хэлэнд орчуулагдан бурет буюу борят гэж нэрлэгдэх болсон ба чинос аймгийнхан бурят буюу борят хэмээн өөрсдийгөө нэрлэсэн ажээ. Сүүлийн үед ихээхэн хүчтэй гарч ирсэн нэгэн санал бол Буриадын Б.Р.Зориктуевын гаргалга юм. Тэрбээр 1980-аад оны эцсээс буриадын угсаа гарал угсаатны бүрэлдэхүүн нэрийн гарлыг нилээд сайн судлан олон сонирхолтой өгүүлэл ном гаргаад байна. Б.Р.Зориктуев Рашид-ад-дины зохиолд өгүүлэх Баргужин төхөм нутгаар амьдарч ан гөрөө эрхлэх ардыг ойн иргэн, тал нутагт мал маллан амьдрах ардыг талын нүүдэлчин хэмээн нэрлэсэнтэй өөрийн дэвшүүлсэн буй санаагаа холбон үзэхийг зорьжээ. Байгаль нуурын хавь нутагт суух иргэдийг нэлэнхүйд нь бураа-д гэж дуудаж байв. Энэхүү бураад гэх үг нь монгол хэлний өтгөн шигүү ой мод гэсэн утгатай гэж үзжээ. Энэ саналыг Ц.Төрбат дэмжиж бураа хэмээх нь модны нэр бөгөөд түүнд олон тооны дагавар залгаснаар бураад нэр үүссэн тэр нь бургас модыг тотемчлох үзэлтэй холбоотой гэжээ. Энэ бүгдийг бид харьцуулан судалж үзвэл Буриад нэрийн гарлын тухай гурван үндсэн чиглэл байна. Үүнд:

1. Буриад нэр нь орос хэлний брат эсвэл бырат гэсэн дуудлагаас үүсэлтэй.
2. Чоно шүтэх тотемийн түрэг нэртэй холбоотой.

3. Бургас мод өтгөн ой шугуйтай холбоотой гэсэн 3 үндсэн чиглэл байгаа юм. Бид эдгээрээс 3 дахь саналыг баримтлан дэмжиж байна. Үүний үндэслэл нь буриад зон өнөөг хүртэл бургас модыг эрхэмлэн шүтэж тэднийг бүрдүүлж буй олон овгуудын шүтээн уриа зэрэгт мод бут ойг шүтээн болгосон жишээ олон байна. Ер нь монголын нүүдэлчдийн дотор эрхлэх аж ахуй онгон шүтээнээр нь нэрийдэх явдал их байв. Түүнээс гадна дундад зууны үед тод үсгээр зохиогдсон хэдэн сурвалжид буриад хэмээх нэрийг буриад бураад хэмээн тэмдэглэжээ. Түүгээр ч үл барам өнөөгийн ойрад монголчуудын дунд тэднийг буриад гэлгүй харин бураад хэмээн дуудаж байна.

XVIII зууны өмнө байгаль нуур ба түүний өмнө этгээдээс Эрчис мөрөн хүртэлх өргөн уудам ой тайгад нүүдэллэн аж төрж байсан ба тэд нь барга бураад хорь түмэд зэрэг байгаль орчмын эртний монгол аймгуудтай ураг удын хэлхээ холбоотой явж ирсэнийг түүхэн баримт ардын домог баталж байна. Оросын эрдэмтэд монгол аймгуудтай ураг удмын хэлхээ холбоотой явж ирсэнийг түүхэн баримт ардын домог баталж буриад ардын гол төлөв байгаль хавийн ихэрэд булгад түүх ба эдийн боловсрол хийгээд домог хэв заншлыг судалж үзэхэд тэд нь ойрадуудтай тухайлбал баядтай өнө эртнээс нягт хэлхээ холбоотой явж иржээ хэмээх дүгнэлэд хүргэж байна гэж өгүүлсэн . Буриад нэр яагаад бураа буюу бургас модтой холбоотой үүссэн тухай аман домогт тусчээ. А.М.Позднеевын сурвалжлан хэвлүүлсэн Асухан удганы тухай домогт “Ойрад буриад удмын удган Асухан Байгаль нуурын эргээр явж байгаад амнаасаа хөөс гаргасан мөөрсөн нэгэн бухтай тохиолдон түүнийг тэнгэрийн элч хэмээн золгомогц нярай болж хоёр хөвгүүн төрүүлсний ахмад нь Буриадай, дүү нь Хоридай ажээ. Тэрхүү Буриадай ан гөрөө хийж яваад уулын оройд ургасан бургасны дээр сууж байсан охиныг олж түүнийг гэргийгээ болгожээ.” Гэх домогч байдаг. Гэвч би Балдан Базаровын буриад нэрийн талаархи тайлбарыг дээрхи эрдэмтэдийн тайлбараас илүүд үзэж байна.

ХОЁРДУГААРБҮЛЭГ. БУРИАДЫН ХОРИН ДӨРВӨН ХАМБЫН НАМТАР

1. Дамба Даржа Заяев (22 июня 1764-1777)
2. Содномпил Хэтырхеев (1777-1797)
3. Лубсан Жимба Ахалдаев (1783-1797)
4. Данзан Дэмчог Ешижамсуев (1797-1809)
5. Данзан Гыван Ешижамсуев (1809-1839)
6. Данзан Чойван Ешижамсуев (1839-1860)
7. Галсан Чойраб Ванчиков (1860-1872)
8. Чой Василин (1872-1873)
9. Чойдор Мархаев (1873-1876)
10. Дампиал Гомбоев (1876-1896)
11. Чойнзин Доржи Иролтүев (1896-1911)
12. Даши Доржи Этигэлов (1911-1917)
13. Намжил Лайдапов (1917- 1919)
14. Гуро Дарма Цыремпилов (1919-1922)
15. Цынгунжал Баниев (1922-1925)
16. Данжа Мункожапов (1925-1938)
17. Лубсан Нима Дармаев (1946-1956)
18. Еши Доржи Шарапов (1956-1963)
19. Жамбал Доржо Гомбоев (1963-1982)
20. Жимба Жамсо Эрдынеев (1982-1990)
21. Мунко Цыбиков (1990-1993)
22. Жамьян Шагдаров (1993-1994)
23. Чойдоржи Будаев (1994-1995)
24. Дамба Аюшеев (1995 оноос одоог хүртэл)

2.1. Анхны бандид хамба лам Дамба Даржа Заяев



Дамба Даржа Заяев

Бурхан багшийн сургаалыг Оросын эзэнт гүрний уламжлалт шашны нэг хэмээн батлуулж, мөн Бандид Хамба ламын институтыг байгуулж чадсан, анх дугаар Бандид Хамба лам Дамба Даржа Заяевд Оросын бурхан шашинтнууд онцгой бишрэл хүндэтгэлтэйгээр ханддаг. Энэ агуу их үйлс нь Буриадын ард түмний түүхэнд давтагдашгүй баатарлаг амжилт мөн бөгөөд эдгээр чухал ололтын ач холбогдолыг ойлгодог. Оросын бурхан шашинтнууд, лам, шавь нар нь харьцуулашгүй агуу багш Зая Хамба ламын бадамлянхуан өлмийд толгойгоо хүргэн мөргөж бишэрдэг.


Заяа хамба агуу бясалгаач байсны дээр өөрийн бүх өнгөрсөн болон ирээдүйн төрлөө мэддэг онцгой нэгэн байв. Түвдэд сурч байх үедээ тэрээр Далай лам болон Ванчин ламаас “Би өнгөрсөн амьдралдаа хэн байсан бэ?” гэж асуухад тэд түүнийг хувилгаан гэдгийг хэлж дээд бурхан асран хамгаалагч Гомбо-Чойжон сахиусандаа хандан бясалга тэгвэл бүгдийг дэлгэрэнгүй мэдэхийг зөвлөсөн. Ингээд хүчит Чойжонгийн тааллын дагуу түүний өмнө өнгөрсөн болон ирээдүйн эцэс төгсгөлгүй залгамж үзэгдэл нээгдсэн.

XII Хамба ламын эхний таван хувилгаад болох ариун сэтгэгч Намтай Ванбу, Махасидха, Лизова Сингээ, Гэлон Гэлэг Балсанбу, аргын нигүүлсэнгүй мастер Канчен Шираб, мөн мэргэн Гунга Одчен нарнь Энэтхэгт төрсөн. Дараагийн таван хувилгаад түвдэд төрсөн. Тэнд тэр бүх зүйлд өндөр ур чадвартай Ванзадва, ДувченДхарма, Бодхисаттва ШоннуНиод, өглөгч ШадбиДорже, мэргэ төлөгч ЛодойЧогдан – түвдээр <<ДармаДаржа>> хэмээн алдаршсан Хайдуб Нимой болон төрсөн бошигтой байв. Ингээд эндээс түүний шинэ хувилгаан I Бандид Хамба Лама Заяев нэрээр алдаршсан.



БАЛДАН БРАЙБУН ХИЙД

Хувилгааны хоёрдугаар дүр будучи ЛизаваСэнгэ нь дэлхий ертөнц хойд сүнсний болон оюун санааны эв нэгдэл буурсан үед хамаг амьтны тусын тулд дахин төрж Бурхан багшийн сургаалыг түгээн дэлгэрүүлэхээ Шакьямуни Буддад амлан тангаргалсан ёсоор Лизава Сингээ энэхүү тангаргаа биелүүлэн буй хувилгааны арван нэгдүгээр дүр нь одоогийн Буриадын нутагт анхдугаар Бандид Хамба Лам Дамба Даржа Заяев болон 1777 онд одоогийн Кяхтын районы нутагт орших Хилгантуйн дацангийн Балдан Брэйбуний сүсэгтэн олны ерөөлийн хүсэлтээр тэр Забайкальск хэмээхэд эргэн төрөхөө амласан ёсоор лагшин мэндэлжээ. Мөн энэ үгэндээ тэр хүрсэн ба хувилгааны 12-р залгамж хамба лам XII Бандид Хамба лам Даши ДоржаЭтигэлов билээ. Өөрийн ерөөл мөргөлийн хүчээр бүх амьд амьтны төлөө тэр өөрийн төрөх газар тэр бүү хэл эцэг эхийгээ сонгосон. Түүний эцэг ноён Заяа Сахулага гурван эрдэнийн сургаалийг дагагч байсан. Түүний аймаг бусад овог аймгуудын хамтаар XVII зууны төгсгөлд Монголоос Сэлэнгэ Чикой-ийн хөндий рүү нүүн очив. Ээж Дэжид нь хүүхэд наснаасаас сайн үйлсэд хүсэлтэй ариун журамт ач буянтай эмэгтэй байжээ.



Заяа хамбын төрсөн нутагт босгосон суварга

Дамба Даржа 1702 оны арван хоёрдугаар жарны усан морин жил төрсөн. Түүний төрсөн газар их устай догшин Чикой голоос зүүн тийш голын баруун хойд эрэгт Цагаан Чулуутай тосгоноос 15 километр Оцонхан уулын бэлд байдаг. Энэхүү газар нь олон төрлийн ургамал, булаг шандаар дүүрэн нуга газар байсан. Оцонхан гэх газар нь аянга цахилгаан их буудгаараа алдартай байв.

Дамба Даржа төрсний дараа шууд гайхам шиг үүссэн, тэрээр нэг жилийн дотор долоон настай хүүхэд шиг өссөн. Хүүхэд насандаа тэрээр их хөгжилтэй , бусад талаараа бусдаас ялгаатай байв. Багадаа ээж ааваасаа Түвдэд сургахыг хүсдэг байсан ч тэд түүнд <<Тийм хол очиж юу хийх юм>> гэж хэлэн сонсдоггүй байжээ. Тэгээд тэр гэртээ орохоос татгалзаж хоол унд идэхгүй байснаас болж эцэг эх нь түүнийг Түвдрүү явахыг зөвшөөрчээ. Түүний сүнсний байрлал эргэн ирж тэр гэрт орон хоол ундыг сэтгэл ханамжтайгаар хүлээн авчээ. Энэ болоод өөр авьяасуудаараа тэр бусад хүүхдээс ялгардаг байжээ.

1764 онд төрөлх сэлэнгийн язгууртнуудын хүсэлтээр Дамба Даржа Заяев буриадын анхны хамба ламаар өргөмжлөгдсөн байна.

2.2. II Бандид хамба лам Содномпил Хэтырхеев



Содномпил Хэтырхеев (Зураг олдоогүй учир орлуулав)

II Бандид Хамба лам Хэтырхеев нь Оросын эзэнт гүрний бурхан шашинтнуудын тэргүүн Дамба Даржа Заяаевын зээ дүү байсан. Чухам хүү тэр л бага наснаас нь түүнд багшилж байжээ. Хэтырхеев Тантрагийн олон сургаал, авшиг, херүка, ямантаки, хаянгрива зэрэг ядамын авшиг авч Манжууширын болон олон тарнийг цээжээр мэддэг байсан ба онцгой ой тогтоолттой, хамгийн хүнд текстүүдийг ч төвөггүй санадаг агуу ухаантай нэгэн байв. Дамба Даржа Заяаев өөрийг нь нирваан дүр үзүүлснээс хойш оросын бурханы шашинд буюу Сангхад уналт болно гэдгийг ойлгосон тул бурхан шашинтны тэргүүний суудалд суух

залгамжлагчийг хайх нь чухал байсан. Тэр хүн нь Содномпил Хэтырхеев байжээ.

Эхлээд Дамба Даржа Заяев зээ дүүдээ дотно мэдлэгийг сутра, тантрын бүгдийг ёсоор нь зааж өгсөн. Хэтырхеев сүсэглэн шашины эрдэмд хичээнгүйлэн суралцсан. Дээр нь гүн ухаанд суралцаж бясалгал, ёогоор хичээллэн Буддын Майтрей болон билгүүний чанадад хүрэхүй дор суралцжээ. Гүн ухааны хэлэлцүүлэгт төгс суралцсанаар тэр өөрийн мэдлэгээрээ алдартай нэгэн болсон юм. Дараа нь Заяев сүмийн нарийн амьдрал, тэр дундаа сүмийн дүрэмд өөрөө суралцуулсан. Тэрээр хамба лам болохоосоо өмнө хурлыг зөв журмаар явуулах хариуцлагатай цорж лам нь байжээ. Мөн Дамба Даржа Заяев түүнийг Сангхагийн зохион байгуулалтын ажилд идэвхтэй сургасан. 1767 онд Хэтырхеев хамба ламтай Москва руу шашны үйл хэрэгт тус боловсруулах төрийн комисс дор оролцохоор явцгаасан. Ийм байдлаар 1777 онд Дамба Даржа Заяев нирваанд одохоосоо өмнө өөрийн найдвартай залгамжлагчаар зээ дүүгээ сонгосон ажээ.

Бурядийн Сангхийн удирдлагад ирээд II Бандид Хамба Лам Содномпил Хэтырхеев дацангуудын хэтийн хөгжлийн бодлогоо үргэлжлүүлж байв. 1780 онд Эрхүүгийн засаг дарга Кличка нь хамба ламд одоо байгаа лам нарын тоог цөөлж хэргэм зэргийг нь хураах санал тавьсан юм.



ХЭТЫРХЕЕВ ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

Хамба лам Хэтырхеев <<амьд хүн өөрийн язгуур цолыг алдсанаас үхсэн нь дээр>> хэмээн шийдвэртэй татгалзсаны хүчинд захирамж цуцлагдан шинэчлэгдсэн түүхтэй.

Бандид хамба лам Хэтырхеев Буриадын хуваргуудыг аажмаар доройтох уналтын эсрэг байсанд талархан хойч үеийхэн нь залбирал үйлддэг. Хэрвээ засаг дарга Кличкиний тушаал биелсэн бол юу болох байсан бол? Гэвч Хамба лам Хэтырхеевийн ачаар Орос улсад буддын сүмийг босгох ажил амжилттай үргэлжилсэн юм. Эрхүүгийн орон нутгийн засаг даргын 1774 оны 3-рсарын 24-ны №850-р тушаалаар Содномпил Хэтырхеев ардын төлөөлөгчөөр батлагдсан. Үүгээрээ тэр аймгийн нийгмийн болон улс төрийн ажлуудад идэвхитэй оролцож эзэн хаанаас алтан медал хүртэж байжээ.

Тэрээр буряд-казакийн цэргийг бий болгоход онцгой ач холбогдол өгч байсан. Учир нь Чин эзэнт гүрний хилийг хаах нь

тухайн үеийн төрийн даалгаврын нэг байсан бөгөөд Буриадуудын хэн нь ч жинхэнэ морьтон болон хилийн цэргийн албанд явж чаддаггүй тул казакуудыг ашиглаж байв.

Буддизм ялалтын жагсаалаа үргэлжлүүлэн өөр бусад буриадын овог аймгууд бурхан шашны сургуульд ирэн, шинэ дацан дуган барьж лам нарын тоо ч өссөн. Нөгөө талаараа буддын лам нарын боловсрол чанартай байх шаардлагатай болсон. Хамба лам Хэтырхеев лам нарын боловсролд онцгой ач холбогдол хандуулдаг байсан ба үүний тулд дацангийн номын санг хангах хэрэгтэй байлаа. Чанартай хөгжил өсөлтийн асуудлын шийдвэр нь чойрын гүн ухааны сургууль байгуулах байсан ба тэрээр Тамчийн дацанд чойр нээж байжээ. Чойра факультетийг энд Хамба лам Хэтырхеевийн гол шавь Дандарей лам байгуулсан. Нэгэн удаа хамба лам Хэтырхеевд түүний багш Дамба Даржа Заяаев үзэгдсэн ба Хамба лам энэ нь Сангхийн төвийг хилгантаас тамчид авч ирснийг сайшааж буй тэмдэг хэмээн хүлээн авчээ. Багшийнхаа гэрээслэлийг биелүүлсэн Хамба лам Хэтырхеев Сангхийн удирдлагыг Тамчийн дацангийн ширээт лам, Жимба Ахалдаевд шилжүүлсэн. Харин хамба ламын ширээг Ахалдаевд өгөхийг бусад лам нар эсэргүүцэж байсан ба тэд төгсгөл хүртлээ явахад бэлэн байсан нь Сангхид эмх замбараагүй хагарал үүсэх аюул байжээ. Гэвч үүнийг оросын засаг захиргаа зөвшөөрөөгүй. Энэ хүнд үед Хамба лам Хэтырхеев маш их тэсвэр, мэргэн ухаанаар бууж өгөх шийдвэр гаргасан. Тэрээр өөртөө болон өөрийн итгэгч нартаа амьдралыхаа төгсгөл хүртэл бандид хамба лам хэвээр үлдсэн.

2.3. Ш Бандид хамба лам Лубсан Жимба Ахалдаев



Лубсан Жимба Ахалдаев (зураг олдоогүй учир орлуулав)

XVII-XVIII зуун Монголын хувьд самуун цаг байлаа. XIV зуун дэх эхлэн нэгдсэн монгол төрийн задралын төгсгөл, халх монгол чин улс, хятадын засагт шилжсэн байв. Энэ үйл явдал манжуудын дотоод эвдрэлтэй зэрэгцсэн үе тохиов. Буриадын домогт энэ үйл явдал Сайн ноён хан, Галдан бошогт нар хаан болох гэсэнтэй холбоотойгоор дотоодын үймээн гарч түүнээс аврагдахын тулд монголын овог аймгийн төлөөлөгч нар Прибайкаль буюу байгалийн ойр орчинд нүүн ирсэн. Энэ тухай Сэлэнгийн буриадын бичвэрт Сайн хан маш хатуу хууль дүрэм чанга удирдлагатай хүн байсан ба харин цагаан хааны нутагт

амгалан газар нутаг гэж Ахалдей болон Буда нар өөрийн төрөл садангийн 10 хүнийг аван өрнөд зүгрүү явсан. Тэдний араас нэхүүл хөөж эхлэсэн. Ахалдай тэдэнд баригдсан ч, Буда тэдний мөрөөр мөшгин хоёр анчиныг хөнөөн Ахалдайг суллажээ. Дараа нь тэд хил дээр Тамчийн нутагт амьдарцгаав. Тэднийг оросын хаан иргэний харьялалдаа авсан.



АХАЛДАЕВ ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

Энэ бүхэн 1718 онд болсон. Мөн тэдний араас овог аймгийн бусад хүмүүс очсоор байв. Бүгд атаган овогт нэгдэн орж байгаад дараа нь өөрсдөө Хатагин овгийг байгуулсан. Ийм маягаар хатагинчууд Халхын Сайн Ноён ханаас явцгаажээ. Д.Ж.Ломбоцыреновын бичвэрт бичигдсэнээр 1721 онд Ахалдейн хүү Жавзандамба хутагтын хүрээнд илгээгдсэн гэжээ.

Ахалдайн хувьд буддын гүн ухааны Ганжуур, Данжуур судар нь түүний гол зэвсэг байсан.

Ундэр-Шихой гэх газар Темникийн эрэгт монголоос гарсан Ахалдай овгыг үүсгэсэн хүмүүс, Ахалдейн сүмийн ширээт ламын дүү, мөн түүний үеэл Санжа ламтай хамт эсгий дуган тавьж хурал ном хурж эхэлсэн.

Монголын Манжушри хийдэд суралцсаныхаа дараа Жимба Ахалдай эх нутагтаа эргэн ирж хурал хурахын тулд сүм хийд барихаар шийдсэн.

1776 онд Лубсан Жимба Ахалдаев Бандид хамба ламаар өргөмжлөгдсөн. Харин 1783 оны 7-р сарын 11-нд Дорнод-Сибирь болон забайкалийн бүх бурхан шашинтнуудын хамба лам болсон.

1809 онд тамчийн дацан нь буриадын дацангуудын тэргүүн дацан болжээ. 1930-аад онд энд оросын бурхан шашинтнуудын тэргүүн байдаг байсан. Мөн үүнд III Бандид Хамба лам Лубсан Жимба Ахалдаев түүхэн гавьяатай.

Тамчийн дацан бүтэн хагас зууны турш зөвхөн буриадын бус сибир, оросын соёл шашны төв дацан байсан.

2011 онд оросын холбооны улсад буриад улс байгуулагдсаны 350 жилийн ойд цогчин дуганы шинэчлэл болж, мөн оны 6-р сард уг сүм 1000 сүсэгтний оролцоотойгоор ариусгагдан равнайлагдан, 70 жилийн дараа дацангийн өмнөх талбайд цам шашны бүжиг болсон.

2.4. IV Бандид хамба лам Данзан Дэмчог Ешижамсуев



Данзан Дэмчог Ешижамсуев (зураг нь олдоогүй учир орлуулав)

Одоогийн Сэлэнгийн районы хонины нуга гэх газар бол IV бандид хамба лам Данзан Дэмчог Ешижамсуевийн төрсөн нутаг юм.

Хиагтын зүгт баруун талаар явбал уулын бэлд ар араасаа дөрвөн цагаан суварга баригдсан. Тэдний нэг нь III Бандид хамба лам Лубсан Жимба Ахалдаевд зориулагдсан. Эхний суварга 2007 оны зун баригдан тэр жилийнхээ 9-р сарын 12-нд равнайлагджээ. 2008, 2009, 2010 онуудад өөр 3 суварга

баригдан IV, V, VI-р Бандид Хамба лам Ешижамсуев Данзан Дэмчог, Данзан Гыван Ешижамсуев болон Чойбон Дорж Ешижамсуев нарт зориулагдан босгожээ.

Данзандэмчог Ешижамсуев өөрийн бүхий л амьдралаараа Тамчийн дацанг хамгаалж байсан. Тэрээр Тамчийн дацанг бандид Хамба ламын институт болгох зорилгод өндөр үүрэг гүйцэтгэсэн. Тэр үнэт сургаалийн цэвэр байдлыг хангалттай хамгаалсан. Түүний ялалтын цуваа зөвхөн өргөөшөө бус мөн гүндээ үргэлжилсэн.

Данзан Дэмчог Ешижамсуев нь 1797 онд Лубсан Жимба Ахалдаевыг нирваанд одсоны дараа Бандид хамба лам болсон.



**ДЭМЧИГ
ЕШИЖАМСУЕВ ХАМБАД
ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА**

Баримт бичигт түүний тухай маш бага тусгагдсан байдаг ба сэлэнгийн монгол буриадын түүхэнд зохиолч Д.Ж.Ломбоцыренов нь Данзан Дэмчог Ешижамсуев 1801 онд зуурдаар таалал болсон гэж бичсэн байдаг.

2.5. V Бандид Хамба лам Данзан Гыван Ешижамсуев



Данзан Гыван Ешижамсуев (зураг нь олдоогүй учир орлуулав)

1800-аад оны эхэнд Данзан Дэмчог Ешижамсуев хүндээр өвдөн өөд болсон учраас түүний бага дүү Данзан Гыван Ешижамсуев хамба лам болсон гэж Д.Ж.Ломбоцыренов бичжээ. Тэрээр 1809 онд энэ бурханы нирваан дүрийг үзүүлжээ.

1784 онд тэрээр тамчийн дацангийн Ноён цорж болж бүх хурлын эмх замбараа болон мөргөлийн үг бичгийг хариуцдаг байв. 1797 онд түүний ах хамба лам болж тэр сэлэнгийн 5 дацангийн тэргүүн цорж болжээ.

1801 оны 6-р сарын 27-нд бандид хамба лам Данзан Дэмчог Ешижамсуев нирваанд одсоны дараа нутгийн захиргааны комиссарын тушаалаар хамба ламын ширээнд суусан. Хамба лам болсныхоо дараа жилээс дуган барих ажлыг удирдсан ба тэр хугацаандаа зөвхөн Тамчийн дацанд л гэхэд 6 дуган шинээр баригдсан байжээ.



***ГЫВАН ЕШИЖАМСУЕВ ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА***

1825 онд Дүйнхор, Дамдин сүмийг, үүнээс 4 жилийн дараа буюу 1829 онд Ногоон Дарь-Эх болон Сандуйн сүмийг босгосон. 1834 онд Данзан Гыван Ешижамсуев нирваанд одсон.

Сэлэнгийн шастирт Д.Ж.Ломбоцыренов: тэрээр V Бандид Хамба ламын эрх мэдэлд байхдаа маш олон дацангуудыг барьсан гэж өндөр үнэлгээ өгсөн. Тэрээр лам хуваргуудыг архи

уухыг хориглон, тэдэнд архины хор уршигыг тайлбарладаг учраас, лам хуваргууд зан үйлд хичээл чармайлттай болсон.

33 жил хамба лам байснаар 1834 онд нас барсан. Бандид хамба лам Данзан Гыван Ешижамсуев сангхийн болон буриадын бурхан шашны шатлан захирах ёсыг зассан. Тэр яаж үүнийг хийв? гэж монголын лам нар асуухад хариулт нь: түүнийг нэгэн агуу ламын дүрд хувилсаны үр дүн хэмээн тайлбарлажээ.

2.6. VI Бандид хамба лам Данзан Чойван Ешижамсуев



Данзан Чойван Ешижамсуев (зураг нь олдоогүй учир орлуулав)

Хамба лам Данзан Чойван Ешижамсуевийн тухай намтар нь зөрчилтэй. Тэр Гыван ламын бага эмэгтэй дүүгийн гурван хүүгийн бага нь байсан. Чойван болоод түүний ах нар хүүхэд байхдаа өнчин хоцорч тэднийг нагац ах нь Гыван лам өсгөсөн. Гыван Ешижамсуеваас хойш тэргүүн ламын албанд гурван шашны төвийн дахин тэмцэл, өрсөлдөөн бий болсон. Эрхүүгийн засаг дарга Чойван Ешижамсуевийг Хамба ламд батлан, хоринскийн овгийн хуварга лам Сувановыг түүний туслахаар томилжээ.

1838 онд Данзан Чойван Ешижамсуев Дорнод-Сибирийн бүх лам нарын хамба ламаар өргөмжлөгдөн мөн 1855 онд эзэн хаан Николайгаас диплом хүртсэн.

Данзан Чойван Ешижамсуевийн үед дацан барих ажлууд багассан ч буриадын бурхан шашны хөгжлийн хамгийн эхэн үе байсан.

Данзан Чойван Ешижамсуевийн ачаар буриадын дацангуудад шашны цам бүжгийн эхлэл тавигдсан.



ЧОЙВАН ЕШИ ЖАМСУЕВ ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

Лам нарын сургууль, дацангуудын сүлжээний хурдастай хөгжилд хувиргууд болоод сүсэгтэнгүүдэд шашны уран зохиол зайлшгүй шаардлагатай байв. Монголоос шашны уран зохиолын үнэт илгээмж илгээсэн. Үүнтэй холбоотойгоор дацангуудад ном хэвлэх ажил хөгжсөн. Данзан Чойван Ешижамсуев 21 жилийн турш бандид хамба ламын суудалд сууссан. 1859 оны 11 сард

тэр Гэгээтүй Сартуулын дацанд шашны цайллаганд оролцохоор явсан ч зорьсон газраа хүрч чадаагүй. Замдаа Иройн дацанд зогсож тэндээ нас барсан. Түүний чандарыг Тамчийн дацанд авч ирсэн. Дацангийн дэргэд томгүй сүм баригдсан ба тэнд түүнийг оршуулжээ.

2.7. VII Бандид хамба лам Галсан чойрав ванчигков**Хамба лам Галсан Чойрав Ванчигков**

Хамба лам Галсан Чойрав Ванчигков Сэлэнгэ аймгийн Ацуло тосгоны хажууд цагаан бургасан гэж газарт 1816 онд гал хулгана жил намрын 3-рсарын 27 нд тэнгэрээс бууж мэндэлсэн, ээжийн нэр нь Галсан долгораав нь Сандэлэгийн гэр бүл ба тэднээс олон эрдэмтэй хүмүүс тайшаа нар төрсөн юм. Аав ээж нь сүсэгтэй хүмүүс байсан, өдөржингөө маань мэгзэм тоолдог байсан. Ламыг төрхийн өмнө аавд нь олон сонирхолтой зүүд харагддаг байсан. Зүүдэнд нь олон лам нар гэрт нь орж хүндэлж өглөгийн эзэн болооч гэж гуйдаг байсан. Галсан цорж лам цагаан дунгаар бэлэг өгсөн. Хүүхэд нь төрсний дараа цорж лам Галсан гэрт нь ирж нэр хайрласан нь Галсан чойров гэж нэр өгсөн

бөгөөд том болохоор нь лам болгоорой гэж захисан. 7 настайдаа ширээт лам Санжидаас хуврагийн буюу гэнэн сахил хүртэж хуврага болсон. 10 настайдаа дацанд орсон. 26 настайдаа Хорчин хошууны Сэнгээринчин вангийн урилгаар Галсансодовналжирваа Эгэтүйн дацан, жасааны дацан, күдүн дацанд ном айлдаад Янгаажин дацан морилоход нь хамба болох хүү маань номонд суухаар ирсэн. Энд Түвшин гэх жиндагийн эзний гэрт нь байж байтал Налжирваа Галсан чойров хүүг хараад “одоо сайн шавьтай болсон намайг дагаад яв гэжээ” 3 жил дотор багшийгаа дагаад ном сурч явсан. Гэгээн лам олон хүмүүс урд нь дандаа хэлдэг байсан, миний Чойрав найдвартай бүгдийг мэднэ сайн лам гэж хэлдэг байсан. 1846 онд Сүүүл дацан очиж ширээт ламаас олон ном сонссон. Тэр үед Гүмбүмээс цорж лам заларч ном айлдсан. Энэ ламаар ондогжин заалгасан. Жонжог цээжилсэн. Нутагтаа буцаж ирээд шинэ заншил оруулсан байна, дацандаан нэг өдөрт 3,7,9 удаа тоосыг арилгаж байхдаа өөрийгөө цэвэрлэж байна гэж бодож тахил өргөхдөө тахилгын уншлага заавал уншиж байх хэрэгтэй гэж ламрим унших, бичих, гэх зэрэг дацандаа их ажил явуулсан. Дүйнхорын дуганд засвар хийлгэсэн.

1848 онд газар бичин жилд Сүүүл дацанд чойр сурж байхад нь Да хүрээнээс гаарамба Агваандампил хүрж ирсэн. Энэ ламаас 10 өдөрт олон ном сонссон. Тэндээ байж байгаад номын хаан Ганжуурваатай учирч олон ном заалгасан. Тэндээс цаашаа яваад Хэнтийн рашаанд Дамдин бишрэлт ламаас ном сонссон. Хамба Егүзэрийн хутагтын хатигин хошуунд Бишрэлт ламаар захиа явуулсан. Буриад нутагт ном айлтгаж өгөөчээ гэж заллаг өгчээ. 1850 онд Галсан чойров өндөр богд хамба ламтай хамт олон лам нарт гэлэн гэцэл убаши сахил хүртээсэн. Урдаас бурхан багшийн дүрийг хоёр шавь нартай залсан. 1852 онд Сүүүл дацанд дахин заларч олон ном айлтгасан. 1853 онд Гомбожав цорж ламтай Буриад нутагт ямар ном уншихуу, ямар сахиус шүтэх, ямар дияанд суухав ийм асуудлуудыг шийдсэн.

1860 онд 34 дацаны лам нар Сэлэнгийн засгийн газарт цугларч хамба ламыг сунгах гэж асуудал тавьж Галсан чойровыг сонгосон 1860-1872 он хүртэл 7-дугаар бандида хамба ламаар дацангуудыг удирдаж, шашин их дэлгэрч байсан.

2.8. VIII Бандид хамба лам Чой Василин



Хамба Чой Василин

Хамба Чой Василин хамбын дээд үе Халх Монголоос 17-р зууны үед гарч торой нутагт суурьшиж, Вашилин Чой хамба ашбагад овогтой буюу гаралтай байсан. Аав нь Заазан нэртэй бөгөөд өвөөг нь Дурам гэдэг байв. Дурамын аав ээж нь Начигсан өвгөн, Ханхарцаг эмгэн байсан гэдэг. Тэрээр Вашилин хүлээгдэж байсан хүүхэд юм гэнэлээ. Учир нь түүний ээж их удаан төрж чадаагүй байсан бөгөөд олон жил хүлээсний дараа аав нь Даа хүрээнд ганданд очиж мөргөж яваад нэг унзад ламтай учирч, тэр лам жадамба ном хайрлажээ.

Тэгээд “энэ номд шүтвэл сайн хүүтэй болно” гэж айлдсан гэдэг. Тэр үгээр нь болсон түүхтэй. Түүнийг төрсний дараа бага настай байхад нь Сартуул Булга дацанд шавь болгож суулгасан. Олон жил сурч эрдэмээ дээшлүүлж, Сартуул Булга дацаны ширээт лам болж байсан байна. Тэрээр 1872 онд VIII Бандид хамба ламаар сонгогджээ.

2.9. IX Бандид хамба лам Чойдор Мархаев /1872-1873/



Чойдор Мархаев

Есдүгээр Хамба лам Лупсан Чойдор Мархаев 1838 онд Хоринскийн аймгийн Хара Ацагат гэх газарт хубдуг овгийн сурвалжит гэр бүлд төрсөн. Хүүхэд байхаас нь түүнийг Шулуутын дацанд сэтгэл их татагддаг байсан ба мөн эндээс тэрээр сургааль номонд сонирхолтой болжээ.

Нэгэн удаа эцэг эх нь дацангийн хуралд сууж түүнийг лам болгохоор шийджээ. 1866 оны 9-р сард өөрийн анхны багшид хөх хадаг өргөн мөн түүнээс хүрэн улаан номын хувцас, аяга авсан

нь хуварга болсныг илтгэжээ. Түүний багш Шулуутын дацангийн Ширээт лам Жанчип Ванчуков байсан.

Гурван жилийн дараа 1869 оны 6-р сарын 11-н долон лам нарын цуглаанд гэлэнгийн сахил хүртсэн. Тэр жилдээ Цүгүүлийн дацан уруу сургалтаа үргэлжлүүлэн Забайкальд гүн ухааны сургуулийг үүсгэн байгуулсан. Лопсан Чойбсанд шавь орохоор явж, түүнээс Дэмчиг Доржи гэх алдар хүртэв.



ЧОЙДАР МАРХАЕВ ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

1873 оны 2-р сарын 16-нд 35 настай байхдаа бандид хамба ламын суудалд суусан. IX-р Хамба лам болсон нь буриадын лам хувиргуудын түүхэнд 11 Хоринскийн овог аймгийн анхны төлөөлөгч лам байсан.

Чойдор Мархаев бандид Хамба лам байх богинохон хугацаандаа дацангуудын бэхжүүлэлтэнд асар том ажил зохион

байгуулав. Энэ тухай тэр үеийн олон архивын материалууд гэрчилдэг. 1872 онд бүс нутгийн захиргаанаас дацангуудын хил хязгаарыг тодорхойлохыг заасан. Гурван жилийн турш дацангуудын хилийг байгуулах хүнд ажлаар явсан.

Анхандаа Буриадын дацангууд газар нутгийн чиг хязгааргүй байсан. Харин шатлалтайгаар дацангуудын бүтэц овог аймгаар тодорхойлогддог болсон.

1875 онд Хамба лам удаан өвдөн бандид хамба ламд Тамчийн дацангийн Ширээт лам Дампил Гомбоевыг өргөмжлөхөөр болсон.

2.10. X Бандид хамба лам Дампил Гомбоев



Дампил Гомбоев

Буриадын бурхан шашны зүтгэлтнүүдийн дунд бандид хамба лам Дампил Гомбоев онцгой эрх үүрэгтэн байсан. Буриадын бурхан шашны түүхэнд чадалтай шинэ үе бандид хамба лам Д.Гомбоевоор эхлэн, Д.Иролтуев, Д.Этиголовоор үргэлжилсэн.

Дампил Гомбоев 1831 онд Сэлэнгийн хөндийд Хатагин овгийн 7 гэр бүлийн нэгд нь төрсөн. Түүний эцэг онцгой чадвараараа нутаг орондоо нэртэй хүн байжээ. Тэр бясалгалаар хичээллэн ууланд ганцаар удаан хугацааг өнгөрүүлдэг байв. Нэгэн удаа гурван жилийг тэнд өнгөрүүлсэн гэдэг. Том хүү Дампилаас гадна

түүнд Найдан, Чомпол гэх 2 хүү байсан. Баттай эх үүсвэрт Дампилыг Сэлэнгийн сургуульд сурч эхэлсэн гэдэг ч 7 настай байхдаа Тамчийн дацанд хуваргаар очсон. Цүүголын дацангийн алдарт гүн ухааны сургуульд суралцаж төгссөнийхөө дараа төрөлх дацандаа эргэн ирж орон тооны ламаар орсон. 19 насандаа гэцүл, мөн 4 жилийн дараа гэлэн сахилтай лам болсон.



**Дампил Гомбоев ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА**

1873 онд Тамчийн дацангийн Ширээт лам болов. Харин 1876 онд бандид хамба ламаар сонгогдов. Бандид хамба лам Дампил Гомбоев буриадын бурхан шашинтнуудын шатлан захирах

ёстнуудаас анх европын шинжлэх ухаантай холбох холбоосыг сайжруулсан.

XIX зуунд Монгол, Түвд, Хятадаас бурхан шашны утга зохиол маш үнэтэй авсан. Ном болоод бусад буддын соёлын эд зүйлсэд маш их мал, алт, мөнгө төлсөн. Энэ явдлаас үүдэн гаднаас ном худалдан авснаас буриадын дацангууд ном хэвлэх ажлыг хөгжүүлсэн нь илүү дээр гэсэн санаа төрсөн. Оросын засаг захиргаа ч мөн буриадын бурхан шашинтнууд далай ламын ивээлд байдаг, мөн гадаадын буддын төвүүдтэй нягт холбоотой гэдгийг ойлгожээ. Иймээс засгийн газрыхан зөвхөн оросоос өргөн хэрэглээний үнэт материал гаргахаас гадна өөрсдийн хилийн аюулгүй байдлыг гадаадынхны эрхшээлээс зайллуулах сонирхолтой байв.



Дампил Гомбоев хамба лам

Үүний дүнд Д.Гомбоевын бандид хамба лам байх үедээ 1880 онд Тамчинск, Агинск, Анинск, Цугольск,, хохюртайск, Эгитуй, Цолгины дацангуудад өөрсдийн бичсэн ном бичвэрүүдийг хэвлэх эрх засгаас авсан байна.

Д.Гомбоевын бүртгэлд Э.Ухтолимскийн: танилцуулснаар 1887 онд 29 дацангууд ойролцоогоор 600 ном монгол, түвд хэл дээр бичсэн.

2.11. XI Бандид хамба лам Чойнзин Доржи Иролтуев



Чойнзин Доржи Иролтуев

Тэрээр 1843 онд Нарийн Ацагат гэх газар Ироолт зайсангийн гэр бүлд төрсөн. Залуу насандаа тэр Шулуутын дацанд очсон.

Чойнзин Дорж Иролтуев монгол түвдийн анагаах ухааныг машинд идэвхтэй судалдаг байсан, тийм ч учраас түүнд дадлага хийх мөн бусдыг сургах өөрийн гэсэн эмнэлэг хэрэгтэй байжээ.

Шулуутын дацангаас холгүй Манба дацанд эмнэлэг байгуулж Дорж Иролтуев их эмч байсан. Тэрээр маш гайхалтай эмч нарын бүрэлдэхүүнийг цуглуулсан. Тэдний нэг нь Лудан Шагдаров 1917 он хүртэл ерөнхий эм найруулагчаар ажилласан.

Түүний сургууль 70 хуудаснаас бүрдэх хуучин монгол хэл дээр бичигдсэн Анагаах ухааны атласыг бэлтгэсэн, уг атлас нь эмчилгээ оношилгооны асуултуудыг дэлгэж мөн орчин үеийн европ, монгол-түвдийн анагаах ухааны эмчилгээний аргуудтай хосолдог байв.



**Доржи Иролтуев ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА**

1891 онд Иролтуев нь Шулуутын дацанд Оросын ирээдүйн эзэн хаан II- р Николайн хүлээн авалтын ёслолд оролцсон. Мөн 1895 онд Санкт-Петербург -д тэрээр эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын ажилбарыг амжилттай хийсэн. Тухайн үед европын анагаах ухаанд ийм төрлийн мэс засал нь боломжгүй байсан юм.

Дэлхийн нэгдүгээр дайны үед Иролтуев нь бандид хамба лам Этиголовын хүсэлтээр бурят-казакын цэргүүд тулалдаж байсан өрнөдийн фронт руу явсан. Арын албаныхан байрладаг Архангельскийн мужид байрлан, шархдагсадыг эмчлэн тэдэнд

дайны хүнд нөхцөлд хэрхэн мөргөл үйлдэхийг сургамжилдаг байжээ.

Иролтуевыг зөвхөн эмч лам байсан гэдэг бол буруу ойлголт. Түүний багш Шулуутын дацангийн Ширээт лам Жанчип Ванчиков байсан. Тэрээр бурхан шашны гүн ухаан судлалын бүтэн курс төгссөн. Гэбш, Гавжийн зэргийг амжилттай хамгаалсан хүн байв.. 1982 онд Шулуутын дацангийн Ширээт ламаар сонгогдон, 1896 онд бандид хамба ламын суудалд суусан.

1910 онд Даши Доржи Этиголов нь Янгаажингийн дацангийн Ширээт ламын суудлаас сайн дураараа явж, генерал засаг даргын тушаалаар орон тооноос хасагдсан. Бандид хамба лам Иролтуев нь Этиголовыг хувилгаан хэмээн мэддэг байсан тул өөрийн хүсэлтээр хамба ламын суудлыг түүнд өвлүүлэн өгжээ. Ингээд Даши Доржо Этиголов эхлээд Янгаажингийн өөрийн албандаа эргэн сууж дараа нь өндөр гэгээн хамбын ширээнд суув. Иролтуев хамба лам суудлаа өгсөнөөс хойш 10 жил амьдарч 1918 онд нирваанд одсон.

2.12. XII Бандид хамба лам Даши Доржи Этиголов




Даши Доржи Этиголов

XII Бандид хамба лам Этиголов 1852 онд одоогийн Иволгийн районы Оронгой тосгонтой зэрэгцээ Улзыт Добо гэх газар төрсөн. 15 насандаа 300 км зам туулан Агинскийн дацанд очин 25 жил тэндээ суралцаж Гэвш, Гавж цол хамгаалсан. 1898 онд өөрийн төрөлх Янгаажингийн дацанд эргэн ирж буддын гүн ухаан бусдад заадаг байв. 1904 онд уг дацангийн ширээт лам болсон.

1911 онд Тэр Оросын их хаан II Николайд бичгээр тангараг өгч, тэдний гэр бүлд үнэнч зүтгэнэ гэж тангараглаж байжээ. Хувьсгал болж, хааныг засгийн эрхээс түлхэн унагахад тэр

өөрийн биеийг мөн адил суудлаасаа огцрох ёстой гэж үзсэн юм. Дашрамд хэлэхэд, тэр энэ бүх хугацаанд Буриад нутагтаа амьдарч хөдөлмөрлөж байжээ. Тэр ганцхан удаа нутгаасаа гарч явсан нь 1913 онд хаан Романовынхны 300 жилийн ойг ёслон тэмдэглэх үеэр Петербург рүү явжээ. Тэр Хааны ордны хүндэтгэлийн зоогт уригдсан байсан аж.



**Даши Доржи Этиголов *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА***

Дэлхийн нэгдүгээр дайны үед Итгэлт хамба бүх буриадын фронтын тусламжийн нийгэмлэгийг санаачлан байгуулжээ. Дэлхийн нэгдүгээр дайнд олон буриад хүн оролцож байсан. Итгэлт хамба фронт руу болон фронтын ар талд өөрийн лам

нарыг болон цэргийн эмнэлгүүд рүү маарамбуудыг илгээж байсан. Тэр өөрөө буриадын хийдүүдийг тойрч хөрөнгө цуглуулж, түүгээрээ Петербургэд цэргийн эмнэлэг байгуулсан. Цугларсан хөрөнгө нь фронтын хангамжинд явж байлаа. Үнэн алдартны лалын шашинтнуудын баярт дайчдад зориулж илгээмж явуулж байх түүний даалгавруудыг бид олж авсан. Ингэж түүний буддын шашинтны нигүүлсэн энэрэнгүй сэтгэл биелэлээ олж байсан юм. Эдгээр үйлсийнх нь төлөө II Николай хаан түүнийг Ариун Анны II зэргийн одонгоор шагнаж байв.

1917 оны Хувьсгалын дараа Итгэлт хамба нь өөрийн бурхан шашны тэргүүний бүрэн эрхээс татгалзаж, өмнө нь шавилж байсан Янгаажины хийдэд буцаж иржээ. Тэнд тэр гүн ухаан болон анагаах ухааны бүтээлүүдээ туурвисан байна.

1927 онд Итгэлт хамба ертөнцийн мөнх бусыг үзэх гэж байгаа тухайгаа өөрийн шавь нарыг цуглуулж хэлжээ. Ингээд хамбын захиснаар түүнийг 6 хоногийн дараа оршуулжээ. Бясалгалын 7 дахь өдөр нь хамбын толгой цээж рүүгээ буусан байв. Ингээд шавь нар нь хамбын захиснаар түүнийг очир завилуулж, хуш модоор хийсэн хайрцагт хийж оршуулжээ

2002 онд хамба ламын гэрээслэлийн дагуу анагаахын шинжээчид, эрдэмтдийг байлцуулан хайрцагийг нээж, хамбын бие ямар ч өөрчлөлтгүй, очир завилж суусан хэвээр байхыг харжээ. Тэр үед Оросын Буддын шашинтнууд Итгэлт хамбын биеийн үнэн учрыг олох болон сүсэгтэн олонд мөргөх боломж олгох үүднээс Иволгийн хийдэд байрлуулахаар шийдвэрлэсэн.

2.13. XIII Бандид Хамба Лам Цыбикжап Намжил Лайдопов



Цыбикжап Намжил Лайдопов

Хамба лам Цыбикжап Намжил Лайдопов нь 1847 онд Ташир Сэлэнгийн районы ойролцоо Иройскийн хөндийн өргөн уужим газарт төрсөн. Энд далайн түвшнээс дээш 1200 метрт гайхалтай Бүрэнхан гэх сэлэнгийн буриадын ариун уул байдаг.

Цыбикжап Намжил Лайдопов нь үнэхээр өнгөрсөн амьдралдаа бурханы хамгаалагч сахиус Лхам бурхантай нягт холбоотой байсан ба гүн бясалгалын дүнд өөрийн бурханы орших газраас холгүй Иройскийн хөндийд шинэ төрөлтөө сонгосон. Бүрэн Хан уул нь Таширын зүгээс хэвтээ бөгтөр өндөрлөг нь хэвтэж буй аварга том баавгайн нуруутай адилхан. Уулын оройд хэзээ ч ширгэдэггүй анагаагч хоёр рашаан байдаг.

Түүнийг 7 настай байхад эцэг эх нь Тамчийн дацанд шавь оруулсан. 1861 онд Лайдонов дацангийн сургалтын дунд шатыг дүүргэсэн ба яг энэ үед дацанд буддын гүн ухааны Чойрын сургууль нээлттэй байсан бөгөөд тэрээр бурханы сургаалийн гүн ухаанд идэвхитэй суралцаж эхэлсэн.



**Намжил Лайдопов *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА***

Түүний багшаар: тус сургуулийг үндэслэгч VII Бандид Хамба лам Галсан Чойраб Ванчиков, IX Бандид Хамба лам Лубсан Дампил Гомбоев, дацангийн чойрын сургуулийн удирдагч Гуру Дарма Цыденпилов мөн Цүүгүүлийн дацангийн Даш-Чойпэллингийн гүн ухааны тэнхимийн анхны төгсөгч Самбуу Жалсараев нар байсан. Суралцсанаас 10 жилийн дараа тэрээр гэвш, сургалтаа дуусгасны дараа Бандид хамба лам Л.Д.Гомбоевыг дагалдан дээд эрдмийн зэрэг гавж болох

шалгалтыг даван гарсан. Тэгээд тус сургуульдаа багшилж эхэлсэн.

1904 онд Забайкалийн цэргийн дарга бандид хамба лам Чойзан Доржи Иролтуевын хүсэлтээр Лайдоповыг тухайн үеийн буддын төвийн лам нарын сургалтаараа алдартай Анинскийн дацангийн ширээт лам болгосон. Энэ суудалд байхдаа тэрээр дацангийн хэтийн хөгжилд маш олон зүйл хийсэн. Орос японы дайны үед фронтод, шархадсан цэргүүд, амь үрэгдсэн цэргүүдийн ар гэрт туслахаар хандив цуглуулж хөдөлмөрийн улаан загалмайн медалиар шагнуулсан .

Хамба ламын суудалд тэрээр дөнгөж жил гаран хугацаанд суусан. Энэ богинохон гэхдээ маш хэцүү үе буюу дэлхийн нэгдүгээр дайны үед Хамба лам Лайдапов нь дацангуудыг хадгалж үлдэхэд маш их зүйл хийсэн.

2.14. XIV Бандид Хамба лам Гүрү Дарма Цыренпилов




Гүрү Дарма Цыренпилов (Зураг нь олдоогүй учир орлуулав)

Бандид хамба лам Гүрү Дарма Цыренпилов нь одоогийн зайгравскийн дацангийн нутагт Хошомо Хори овог аймагт төрсөн. Бие даруу төлөв дунд зэрэг чадалтай айлын хүү гэж өөрийн намтартаа бичсэн. 7-8 насандаа эцэг эхийнхээ хүсэлтээр дацанд орсон. Ирээдүйн Хамба лам Курбиний анхан шатны сургалтыг амжилттай дүүргэж, 2 дахь шатны дараа эцэг нь Верхний удинскийн сургалтанд суулгасан. Сурагч болоод Гүрү Цыренпилов хожим үед шашны бус төр захирагааныхантай харилцахад тус болно хэмээн орсоор бичиж уншиж сурсан. Орос

улсад амьдран мөн орос хэмээгддэг байх нь зүгээр л байж болшгүй зүйл байлаа.

23 насанд надад буддын гүн ухаан Цанид-д суралцахаар Амдо болон түвд явах хүсэл төрж тэрээр үргэлжлүүлэн сурчээ. Амдоод тэрээр Лавран сүмд суралцахаар элссэн. Лавран болон Буриадын дацангууд эртнээс нягт холбоотой байв.



**Дарма Цыренпилов *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА***

Бүх хүнд нөхцөлийг даван тэрээр 30 жилийн турш суралцахдаа гэр рүүгээ богино хугацаагаар буцан заримдаа бадарчингийн амьдралаар амьдарч байсан. Эцсийн эцэст буриад лам түвдэд эрдмийн зэрэг хамгаалан гэртээ

эргэж ирсэн. Гүрө Дарма Цыренпилов нь бүх хамбууд дундаас Дооромба ламын зэрэгтэй цорын ганц лам байсан. 1917 онд Намжил Лайданов хамба ламаар сонгогдон, харин


Цыренпиловыг дэд хамба буюу орлогчоор сонгосон. Энэ албанд тэрээр бандид хамба лам Намжил Лайдоновыг нирваанд одох хүртэл 3 жил суужээ. Энэ үед буриадын ард иргэд дараагийн хамба ламыг сонгох шаардлагатай байхад хүн бүрийн хариуцлагыг өөртөө хүлээхийх хүсэхгүй байлаа. Харин Цыренпилов Хамба ламаар сонгогдохыг зөвшөөрч шашин болоод бүх лам нарын хувь заяаны хариуцлагыг өөртөө хүлээсэн.

2.15. XV Бандид хамба лам Цынгунжап Баниев**Цынгунжап Баниев**

1846 оны морин жилд Удунги Сэлэнгийн талын ойролцоо Галтай гэх газар XV Бандид Хамба лам Цынгунжап Баниев төрсөн. Эцэг эх нь Тамчийн дацанд шавь оруулж, энд тэрээр түвд цагаан толгой, мөргөл үйлдэхийг сурсан. Энэ сургалтын курсыг амжилттай даван тэрээр чойрын гүн ухааны тэнхимд элсэн орж амжилттай дүүргэн гавж болсон.

1879 онд Тамчийн дацанд хуваргуудын сургуульд сурахаар явжээ. 2 жилийн дараа Кударинскийн дацангийн бандид лам, жилийн дараа өөрийн төрөлх дацангийн гэлэн ламаар очсон.

Тамчийн дацангийн ширээт лам Балдан Еши Доржиевыг өвдсөн байх үед 1901-1904 онуудад Баниев ширээт ламын үүргийг гүйцэтгэж байсан. 1904 онд Бандид Хамба лам Ч.Д.Иролтуевын дэвшүүлгээр Цынгунжап Баниевыг ширээт ламаар сонгон диплом гардуулсан. Орос-Японы дэлхийн нэгдүгээр дайны үед шархдагсад болоод амь үрэгдэгсэдийн ар гэрийхэнд тусламж үзүүлэн 1907 онд Хөдөлмөрийн улаан загалмайн хүрэл медалиар шагнагдсан.



**Цынгунжап Баниев *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН*
*СУВАРГА***

Ширээт лам байхдаа Баниев Тамчийн дацангийн сүмийн бүтэн засвар, дуган болоод аж ахуйн барилгыг барихыг цэргийн

даргаар зөвшөөрүүлсэн байв. Бандид Хамба лам Ч.Д.Иролтуеваас хойш шинэ хамбыг сонгох хүртэл 1910 оны 4 сарын 8-наас 1911 оны 4 дүгээр сарын 4-ний хугацаанд тэрээр Хамба ламын үүргийг гүйцэтгэсэн.

1922 оны 12 сард Тамчийн дацанд шинэ хамбыг сонгохоор цуглан, Ихэнх нь Цынгунжап Баниевыг сонгохыг дэмжсэн тул тэр XV Хамба лам болсон.

2.16. XVI Бандид хамба лам Данжа Мункожапов



Данжа Мункожапов

Данжа Мункожапов Сэлэнгийн тал Удунга тосгоноос дээш Галтай гэх газарт төрсөн. Долоон настай Данжааг Иройскийн дацан Чойдон Даржалин-д сургахаар өгсөн. Энд тэрээр анх сахил хүртсэн. Хэдэн жил дацанд суралцсаны дараа тус дацанд гүн ухааны сургууль байдаггүй байсан тул түүнийг Тамчийн дацан руу өөрийх нь хүсэлтээр явуулжээ.

Суралцах хугацаандаа Данжа гэлүн ламын бүтэн сахил хүртэв. Гэлүнгийн сахилыг завьтай харьцуулж болно. Голыг олмоор гаталхад унаад живж болно, харин сахил бол яг завь шиг хүнийг алдаа болоод буруу алхмаас холдуулна. Данжа сургалтын зэргээ амжилттай хамгаалж, гэбш, дараа нь чойрын тэнхимд бүтэн курс дүүргэн дээд хувиргын зэрэг болох гавж болсон.

Хүмүүст туслах хүсэлтэй тэрээр дорнодын анагаах ухааны боловсрол эзэмшихээр дацангийн манба тэнхимд суралцахаар элсэв. Төгссөнийхөө дараа хэсэг хугацаанд Шулуутын дацангийн манба тэнхимд ажиллажээ. Харин дараа нь эмчилгээ хийж дадлагжин алдартай эмч лам болсон.



**Данжа Мункожапов *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН*
*СУВАРГА***

1925 оны 12 сарын 22нд Верхнее удинск хотод болсон хуваргуудын 2-р чуулганаар Данжа Мункожапов бандид хамба лам болсон. 1928 оны 8 дугаар сарын 21-24нд тус хотод хуваргуудын 3-р чуулган болж сүүлийн жилүүдийн шинэтгэлийн үр дүнг хэлэлцсэн. 1930 оны 12 дугаар сарын 12нд Хамба лам Данжа Мункожаповыг өөрийх нь оршин суух Тамчийн дацангаас нь баривчлан 10 жил хорих ялаар шоронд хорьсон. Тэрээр удаан найман жилийг шоронд өнгөрөөсөн.


2.17. XVII Бандид хамба лам Лубсан Нима Дармаев



Лубсан Нима Дармаев

Лубсан Нима Дармаев баатарлаг амьдралаар амьдарсан. 1890 онд Торейн аймагийн Гэдэн Ньюга гэх газар Гурван эрдэнэд итгэгч олон хүүхэдтэй Дармажапа Цыреновынд төрсөн. Түүний 4 хүүгийн хоёр дахь нь болох Лубсан Нима нь 7 насандаа Сартуул-Булагийн дацанд орсон. Олон жилийн сургалтын турш харийн хил дээр судалсан буддын гүн ухааны дүнд тэрээр гавж цолыг хүртжээ. 1920-оод оны төгсгөлд Сартуул-Булаг дацангийн ширээт лам болсон. 1928 оны хуваргуудын 3-р чуулганд төвийн хуваргуудын холбооны гишүүнээр сонгогдсон. Шашны хавчлага хэлмэгдүүлэлтийн жилүүдэд хиагтийн шоронд хоригдож Наушки-

хиагтын төмөр замыг барихад ажилласан. 1937 он өнгөрч эцэж туйлдсан ч ажил үргэлжилж байлаа, нэгэн удаа шоронгийн хянагч нар түүнийг ухаангүй байхыг олоод үхсэн гэж бодон хаясан. Түүнийг Торейн оршин суугч Гомбожапов Сосоров олон үхлээс аварчээ. Нэгэн үе тэрээр Лубсан Нимаатай хамт Сартуул-Булагийн дацанд суралцаж байсан ч төгсөж чадалгүй гэртээ ирэн төрийн хар хүн болсон байв. Тэрээр өөрийн ангийн хүнээ танин гэртээ авч ирсэн байна. Гэхдээ энэ тохиолдол байсан гэжүү? Лубсан Нима Дармаев ухаангүй байсан ч эргэн тойронд болж байгаа зүйлсийг удирдаж байв. Маргах зүйлгүй, тэр бол итгэлийн хамгаалагч.



Нима Дармаев *ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА*

Сайн санаат сүсэгтэн ард иргэд түүнийг хооллож асардаг байв. 1940 онд нэгэн удаа түүн дээр дээд Торейгаас анчин ирэв, тэр үед Лубсан Нима Дармаев энд үлдэх нь зөвхөн түүнд бус хоол унд авчирч байгаа хүмүүст мөн аюултай гэдгийг ойлгон

анчинд өөрийг нь авч явж засгийн газарт тушаа гэв., цаашдаа зам бурханы гарт байх болно гэж хэлжээ. Тэгээд бүх зүйл ахиад эхнээсээ эхэлсэн.

1942 онд иволгийн ойролцоох зам дээр ажиллан шоронгоос суллагдсан. 1947 онд Хамба лам болж, 1956 онд Иволгийн дацанг барьсан.

2.18. XVIII Бандид хамба лам Еши Доржи Шарапов




Еши Доржи Шарапов

1892 онд Оронго Шираповын гэрт Еши Доржиев гэх нэртэй хүү мэндэлсэн. Гурван насандаа тэрээр өөрийн багш Мунхэжаб Лобсан Данжин балсангаас адис хүртсэн. Түүний аав нь 24 насандаа түвдийн анагаах ухаанаар хичээллэн эмч лам болсон.

Еши Доржи 12 насандаа Эгитүйн дацанд орсон. Тамчийн дацанд суралцахдаа нэг жилийн дотор монгол түвд хэл, бичиг сурч хуврагын сургалтыг гайхалтай сурсан. Ой тогтоолт сайтай тэрээр 22 насандаа гэбш ламын цол хамгаалсан. 1925 онд тантрын сургаалийн нууц дадлагыгаа дараа габж цол Тамчийн дацанд хамгаалжээ.

1930-аад оны үед хэлмэгдүүлэлт хавчлагад Хамба лам Беломоро-Балтийн сувгийн барилгын ажилд хуваарилагдсан

байв. Амьдралын болоод ажлын нөхцөл Хамба ламын эрүүл мэндэд муугаар нөлөөлж тэрээр цэргийн эмнэлэгт хэвтхэд нутгийн найз Школьников тэнд ажилладаг бөгөөд түүний ачаар Еши Доржи амьд үлджээ.



Доржи Шарапов ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

Олон жилийн туршилтын дараа Еши Доржи өөрийн ахын хамт Улан-Удэд ирж томгүй өрөө хөлслөн амьдарч байв. Ах нь гараараа юм хийж зах дээр заран, харин Еши Доржи агуулахад нягтлан бодогчоор ажилладаг байжээ.

1956 онд Бандид Хамба лам Еши Доржи Шарапов бурхан шашны төвийн удирдлагын даргаар сонгогдон, тэр жилүүдэд

шашны сэргэлтийг зөвхөн дотооддоо бус олон улсад ч мөн зарласан.

1963 онд Японы айлчлалын дараа хүндээр өвдөн Колочноод гэртээ эргэн ирсэн. Намрын орой тэрээр өөрийх нь эцгийн гэр төрсөн газартаа аваачихыг хүсэн, энэ газрын усыг ууж тэрээр нирваанд одов.

2.19. XIX Бандид хамба лам Жамбал Доржо Гомбоев




Жамбал Доржо Гомбоев

1897 онд Табтанай тосгоны ойролцоо Сас-Шэбэр гэх газарт малчин Дамдинай Гомбын гэр бүлд төрсөн. 8 насандаа Агинскийн дацанд хуваргын сургуульд элсэн оров. Энд тэрээр монгол түвд хэл, бурхан шашны түүх болоод гүн ухааныг судалж эхэлсэн. Цаашлаад шат дараалалтайгаар гэвш, гавжийн зэргийг хүртсэн.

Эхэндээ Жамбал Доржо Гомбоев Агинскийн дацанд ажиллаж байсан. 1927-1929 онд Хойморийн дацанд гүн ухааны хичээл зааж, 1937 онд Агинскийн дацангийн ширээт лам болсон. Хэлмэгдүүлэлт эхлэх үед зовлон Жамбал Доржо Гомбоевыг тойрч гарсангүй. Гэхдээ гүн ухаан, бодлын хүчинд тэрээр албадан баривчлагдахаас зугтаж чадсан цорын ганц Хамба лам юм. 1937 онд Красноярск руу зугтаан, дайн эхлэх үе хүртэл

шилний үйлдвэрт ажиллаж байв. 1941 онд фронт руу илгээгдэж, 1943 оны 4 сард эрүүл мэндийн байдлаас шалтгаанаар бүр мөсөн халав. Төрсөн нутагдаа эргэн ирсэн ч Жамбал Доржо Гомбоев Красноярск уруу шилний үйлдвэрт илгээгдсэн.



Доржо Гомбоев ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

1947 оны 5 сард Агинскийн дацандаа эргэн ирж, 1950-1963 онд ширээт ламаар байсан. 1956 онд Иволжийн дацангийн ширээт лам Еши Доржо Шараповыг хамба ламд өргөмжлөхөд Жамбал Доржо Гомбоев түүний орлогч дэд хамба болгосон. 1963 онд Хамба Шарапов энэ хорвоогоос явахад Гомбоев түүний залгамжлагчаар XIX Бандид Хамба лам болжээ.

1930 аад онуудад лам нарыг бэлтгэх сургууль байгууллага хаалттай байсан. Хамба Гомбоев буддын сургуулийг нээхгүй бол чанарын өсөлт гарахгүй гэдгийг ойлгож монголд болоод оросод буддын их сургууль нээж чадсан.

Жамбал Доржо Гомбоев 1983 онд 88 насандаа нирваанд одсон. Бандид хамба лам Гомбоевын өв бидэнд үргэлж үнэлэгдэх болно.

2.20. XX Бандид хамба лам Жимба Жамсо Эрдынеев



Жимба Жамсо Эрдынеев

Жимба Жамсо Эрдынеев 1907 онд Хойто-Ага гэх газар Дашийн Эрдэнийн гэр бүлд төрсөн. Тэр тайван, томоотой бөгөөд насандаа баймааргүй зан ааштай хүүхэд байжээ. 10 настай байхдаа ээж ааваасаа дацанд орохыг хүсэхэд аав нь эрс эсэргүүцэж байсан ч эцсийн бүлэгт түүнийг дацанд өгөхөөр шийджээ.

Дацанд ороод өөрийн зөвлөх багшаар хамгийн олон шавьтай Балжир гавжийг сонгосон. Балжир гавж шавь нараа энгийн бус аргаар сургадаг байв. Тэр бүх сонсогчидоо суулгаж, дараа нь бүгдэд нь аарц тараан хичээлээ эхэлдэг. Эхэндээ хүнгүй жижиг тосгоноос олон зуун лам хуваргатай том дацанд ирсэн Жимба Жамсо өөрийн эрхгүй ичиж эмээж байв. Тэр үед хуваргууд өдөр тутмын дадлага хийж байжээ. Оройн тойргийн үед амжилттай

суралцсан 2,3 хуваргууд дацангаар алхах зуураа анхан курсын сонсогчдын мөргөлийг сонсгон шалгажээ. Жимба Жамсогийн ээлж ирэхэд тэрээр сандарсандаа бүх үгээ мартан будилсан ч багш нь түүнийг зоригтой байхыг зөвлөжээ.



**Жамсо Эрдынеев ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН
СУВАРГА**

10 жил суралцаж гэвш зэргийг хамгаалж, дараагийн зэрэг болох гавж цол хамгаалсан. Гэвч 1933 оны намар эмх замбараагүй цаг үүсч түүнийг ард түмний дайсан хэмээн цөлсөн. Энэ үеэс түүний амьдрал хүндэрч эхэлсэн. Читийн муж Могойтой өртөөнөөс

бусад цөллөгдөгсөдтэй хамт Жимба Жамсо Эрдынеевийг ачааны вагонд тэсгэм хүйтэнд Эрхүүгийн Зима өртөө хүртэл авч явжээ. Тэр вагонд хөгшин залуу хүүхэд, эрэгтэй эмэгтэй гээд бүх насны хүмүүс байсан бөгөөд тэднийг мод бэлтгэл руу илгээжээ. Хүйтэн болоод өлсгөлөн, хүнд ажлаас болоод хүмүүс үхэж эхэлж байв. Унтахаар хэвтээд л өглөө нь босдоггүй. Энэ бол Сталингийн хуваарийн дагуу гэмгүй үхэл байв.

1937 он болж, бүх эрчүүдийг черновийн шоронд илгээхэд, Жимба Жамсо Эрдынеевд зугтах аз тохиолгүй хатуу дэглэмтэй шоронд нүүрсний уурхайд ажиллуулав. Хөдөлмөрийн хүнд нөхцөлийг тэсэлгүй хоригдлууд өвдөн үхсэн. Нөхцөл байдалд өөр гарц олдохгүй Жимба Жамсо зугтахаар шийдэж оргосон.

Дайнаас хойш 1942 онд тэрээр эрүүл мэндийн байдлаас агуулахын харуулаар томилогдсон. 1957 онд ширээт лам Жамбал Доржи Гомбоевын урилгаар Жимба Жамсо Эрдынеев Агийн дацанд эргэн ирсэн.

1963 онд Жамбал Доржи Гомбоевыг Хамба ламд өргөмжлөгдөхөд Жимба Жамсо Эрдынеев дэд хамба ламаар байсан. Харин 1982 онд 76 насандаа Жимба Жамсо Эрдынеев өөрөө ХХ Хамба лам болсон.

2.21. XXI Бандид Хамба лам Мунко Цыбиков




Мунко Цыбиков

Мунко Цыбиков 1907 онд Витим сумын Турхул гэх газар малчин Батанайн гэр бүлд төрсөн.

Эгитийн дацанд 8 насандаа хуврагаар очсон. Залуу сонсогч Мунко Цыбиков тэвчээртэй буддын сургаалийн гүнд хүрэн, түвдийн анагаах ухаан, тантра, буддын гүн ухааныг судалсан. 1930 онд гэвш зэргийг хамгаалсан. Энэ үйл явдлын дараа буддын шашин хар үүлтэй холилдон хэлмэгдсэн. Дацан хаагдсаны дараа Мунко Цыбиков хамтын аж ахуйд галч зуухч хийдэг байв.

1923 оныг хүртэл буддын сүмийн амьдрал өөрийн энгийн урсгалаар урсаж байсан. 1930 аад онд Буриадад бусад орны адилаар хэлмэгдүүлэлт болоход Эгитүйн дацан хаалгаа барьж чөлөөтэй үлдсэн лам нар отог аймгуудаар тархсан. Мунко Цыбиков старлингийн хорих ангид бүтэн 12 жил байсан, тэнд лам нар бас олон байдаг байв.



Цыбиков ХАМБАД ЗОРИУЛАН БОСГОСОН СУВАРГА

1956 онд Урнай лам Жалсан гавжийн шаардлагаар Иволгийн дацанд Мунко Цыбиков орсон. 1962 онд тэр цагаатгагдан, 1963 оноос Иволгийн дацангийн ширээт ламаар ажилласан.

1990 онд Мунко Цыбиков Хамба ламаар сонгогдсон. Хамба лам Мунко Цыбиков 1993 онд нирваанд одсон, түүний дурсгалд Эгуйтийн дацанд Намжал Чойдан суварга мөн түүний төрсөн газарт суварга босгосон.

2.22. XXII хамба лам Жамьян Шагдаров



Жамьян Шагдаров

Жамьян хамба лам нь 1970 онд Монгол улсад Шашны дээд сургуулийг нээгдэхэд хамгийн анхны зиндаанд орж суралцан шашны боловсрол эзэмшсэн улмаар хамба лам Мунко Цыбиковын ойрын шавь байсан учир хамба ламаар орлон ажиллаж эхэлсэн.

2.23. XXIII хамба лам Чойдоржи Будаев



Чойдоржи Будаев

Чойдоржи хамба лам нь Монгол улсын Бурхан шашинтны төв Гандан Тэгчилэн хийдийн дэргэдэх Шашны дээд сургуулийн 3-р зиндаанд элсэн орж төгссөн. Улмаар Буриадын Шажны их сургуульд багшаар ажиллаж байгаад Оросод их өөрчлөн байгуулалт явагдах үед богинохон хугацаанд хамба ламын ажил эрхэлсэн.

2.24. XXIV Бандид хамба лам Дамба Аюшеев



Дамба Аюшеев ОХУ-ын ерөнхийлөгч Д.А.Медведевийн хамт

1962 онд Хиагтын аймагт Шаргалжин хэмээх тосгонд Бадамын хоёрдугаар хөвүүн болон мэндэлсэн. Бага насандаа ерөнхий боловсролын сургуульд болон Багшийн сургууль төгсөж, ерөнхий боловсролын сургуульд хичээл зааж байгаад төрсөн нутагт нь байгаа Алтан ганжуур шүтээндээ үргэлж мөргөж шүтдэг байсан ба Түвд хэлээр бичигдсэн учир уншиж судалж чадахгүй, эзэмшиж чадахгүй харамсалтай байсан учраас түүнийг эзэмшихийн тухайд лам хуврага болж орон нутгийнхаа шүтээн судрыг судлахаар сэтгэл шулуудан тэр үеийн Иволгийн дацаны хамба лам нартай уулзан лам болох хүсэлтээ уламжлалжээ. Нийгмийн аюулаас хамгаалах яамны хүнд сорилтыг даван байж Монгол улсын Бурханы шашны төв Гандан хийдийн шашны дээд сургуульд 1983 онд элсэн орж суралгын онц, сайн дүнтэй Хамбын нэрэмжит шагналтай дүүргэн лам хуврагын гараагаа эхэлсэн. Сургууль төгсөж очоод эмч ламаар ажиллаж байгаад Хиагтад томилогдон ажиллаж Балдан Брайван хийдийг хуучин ёсоор нь сэргээн засварлаж уншлага, урилгыг нь урьд байсан чигт нь сэргээсний ач буянаар 1995 онд ОХУ-ын Бурханы Шашинтны төв

Иволгийн дацаны тэргүүн хамба ламаар олон нийтээс сонгогдож хамгийн анхны Заяа хамбыг Оросын хаан хүлээн зөвшөөрч Бандидаа цол олгож байсантай адил Дамба хамба ламыг ОХУ-ын Госдум буюу Оросын парламент хуучин уламжлалыг сэргээж Бандидаа хамба цолоор өргөмжлөж, устав буюу дотоод дүрмийг нь батлан ОХУ-ын ерөнхийлөгч Елцин гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг.



Дамба Аюшеев ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины хамт

Мөн ОХУ-ын Аюулгүйн зөвлөлийн 21 гишүүний нэгээр сонгогдон ажилладаг болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИТГЭЛТ ХАМБЫН АМЬДРАЛ, ТҮҮХЭН ЗАМНАЛ

3.1. Хүүхэд болон өсвөр нас

Итгэл 1852 онд Цагаан нуурын зүүн эрэгт “Өлзий дов” хэмээх газарт хүний биеийг олон мэндэлжээ. Одоо бол энэ нь Буриадын Иволгийн дүүргийн Оронго тосгоны нутаг бөгөөд Улаан Үдээс зүүн урагшаа 50 километрт байдаг. Өнөөдөр энэ газраар авто зам болон Монголын нийслэл Улаанбаатар хот руу гарах төмөр замын нэг салаа 5717 км дэх зогсоол дайран гарч байна.

Итгэл хүү хэдэн сарын хэдэнд төрсөн нь тодорхойгүй. “Цаг хугацаа” гэдэг ойлголт Үхлийн эзэн буюу өөрөөр хэлбэл Эрлэг хаантай шууд холбоотой учир сэрэмжтэй байхын үүднээс буддын шашинтнууд төрсөн өдрөө тэмдэглэх болон насаа шууд хэлэхээс болгоомжилдог” гэж Хамба Лам Дамба Аюшеев хэлдэг. Гэхдээ ганцхан уламжлалт ёсонд ч биш, ер нь Итгэлийн амьдралын замнал тэр чигээрээ нууцлаг билээ. Түүнийг 43 нас сүүдрийг зооглох хүртэлх 1895 он архивын баримтуудаас үзвэл төрсөн өдөртэй нь холбоотой гурван таамаглал байдаг.

Эхнийх нь дурьдагдаж буй үйл явдлуудад биеэр оролцсон, Итгэлийн шавь Буджап Будаев гэдэг хүний бичсэн “Итгэл Хамба Ламын намтар”,

Хоёр дахь нь 1913 онд Итгэл 61 настайдаа өөрөө бичсэн /Буриадын үндэсний архивт хадгалагдаж байгаа / “Албан үүрэг гүйцэтгэсэн он дарааллын бичиг”,

Гурав дахь нь лам нар, орон нутгийн иргэдийн хэлсэн болон дээрх архивын баримтуудыг нэгтгэж зохиосон дүгнэлтүүд юм.

Итгэлийн хувьд нэлээд учир холбогдол бүхий 1895 оны таамаглалууд харин чөдрийн зангилаа шиг нэгдэн нийлсэн

байдаг нь түүний цаашдынх нь ажил үйлс, гавъяа зүтгэлд нөлөөлсөн ч байж болох юм. Жишээ нь, мэдээллийн эх үүсвэрүүд ямар асуудал дээр нэгдэж чадаж байна хэмээвээс – тэрээр бага насандаа тун ч зоргоороо, амьдралд хайртай бас өөрийн гэсэн бодолтой хүүхэд байжээ. “Багш минь багадаа тун ч хөдөлгөөнтэй, дүрсгүй хүүхэд байсан” гэж Будажап Будаев тэмдэглэсэн байдаг.

Будаев намтарчийн хувьд учир зүйн сэтгэлгээтэй, бодит амьдралд тулгуурладаг хүн. Христийн шашны гэгээнтнүүдийн намтрыг хатуу тогтсон дэг жаягт захируулан бичдэг ба хэрэв сүмээс ариун гэгээнтний тоонд оруулсан христчийн амьдралыг бичиж байгаа бол хүүхэд насандаа тоглоомд тэгтлээ шимтдэггүй, эрх дураараа биш байсан гэж тодорхойлдог уламжлалтай. Харин Будаевын хувьд бол Дашдорж гэдэг хүү бол ердөө л нэг эрэгтэй хүүхэд гэхээс өөрөөр хандаагүй.

Энэ хүүхэд “дураараа, тийм гэхийн аргагүй зантайгаараа бусдаас ялгаатай байсан” гэж Дарма Нацов Гэнэн хэлжээ.

Дашдорж хүүд өгч буй бусдын тодорхойлолтыг арай өөр үгээр илэрхийлбэл: “бусдаас үл хамаарах”, “зорилго чиглэлтэй” гэсэн үг болж байна.

Харин түүний талаархи бусад мэдээллүүд хоорондоо зөрөөтэй байдаг. Түүнийг төрүүлсэн эх нь хэн болох нь тодорхойгүй ба энэ талаар олигтой мэдээлэл олдохгүй байгаа нь Итгэл яг Газар дэлхийд мэндлээгүй гэх дохио ч юм шиг. Итгэл хаанаас ирсэн нь бүү мэд, гэнэт л гараад ирсэн мэт сэтгэгдэл төрдөг. Ямартай ч энэ асуудлыг судалсан лам нар шууд л таван настай үеийг нь мэддэг.

Хамба Лам Аюшеев: “Буддын шашны жам ёсоор ямар ч хүний бие нэгэнт эх дэлхийд төрсөн л бол сүүлдээ үхэж бас задарч бутран алга болдог. Харин одоогийн энэ тохиолдолд дээрх жам ёс үйлчлэхгүй байгааг бид нүдээрээ үзэж байна. Иймээс нэгэнт

бие нь задарч бутрахгүй байгаа болохоор бидний мэддэг ердийн хүн эхээс төрдөг жамаар төрөөгүй, харин ямар нэг ид шидийн хэлбэрээр буй болсон гэсэн үг” гэж хэлсэн юм.

Итгэл өнчин ганцаар өсчээ. Садан төрлийн холбоо нягт байдаг нь буриадуудын нэг гайхамшигтай давуу тал. Хүүхэд нэгэнт эцэг, эхгүй болсон тохиолдолд хамаатнууд нь авч өсгөдөг ёстой.

Буриадууд угийн бичгээ тун ч нямбайлан хөтөлсөөр иржээ. Зарим нь 10 хүртэлх үеэ, зарим нь 17, бүр 30 хүртэлх үеэ ч бичиж тэмдэглэсэн байдаг. Ингэхдээ эцгийн талыг хөөж бичдэг ба эмэгтэйчүүдийг оролцуулдаггүй. Тийм болохоор 160 жил өнгөрсөн хойно Дашдорж Итгэлын эхийн талаар мэдээлэл байхгүй байгаад гайхах зүйлгүй юм.

1928 онд төрсөн, Оронго тосгоны Мария Банзарова гэгч эмэгтэй садан төрлийнхөө нэрсийг салаалуулан зурсан угийн бичгээ нандигнан хадгалсаар ирсний дотор Бух Ноён гэгчээс салбарласан нэг салаа нь явсаар Итгэл дээр очдог.

Энэ бичигт ердөө л хорин үеийг дурьдсан байх ба дээд өвгөөс нь доошлуулан хүү рүү нь дараалуулан зуржээ. Дашдорж Итгэлыг хүртэл 15 үе байна. Мария Намжиловнагийн хэлж байгаагаар бол түүний эцэг Намжил Базарович Базаров 1905 онд төрсөн хүн байх ба 1940 онд угийн бичгээ бичсэнийг нь тэрээр хуучин монголоос кириллд шилжүүлэн бичиж, үргэлжлүүлэн 1970-аад оны үед сэргээн бичиж нэмж хөтөлсөөр одоог хүртэл хадгалж байгаа юм байна. Надад муугаар нөлөөлнө гэж эцэг минь айгаад бидэнд юу ч ярьдаггүй байсан, магадгүй, хориглодог ч байсан юм уу бүү мэд. Харин биднийг Жидад амьдарч байхад, барагцаалбал 1937 оны үед аав маань сургуульд багшилдаг Васильев Цыдендоржо гэдэг хүнтэй ярилцаж байхдаа түүний эмэг эх нь Итгэл Хамбын төрсөн эгч байсан тухай хэлж байсныг би тод санаж байна” гэсэн юм.

Угийн бичгээс үзвэл Дашдорж нь булгадын Готол-буумалын удмын Итигэл Мункотагарэ гэх айлд төржээ. Булгад гэдэг нь буриадын дөрвөн том овгийн нэг бөгөөд домогт дээд өвөг Булгадын нэрээр нэршжээ. /Харин өнөөгийн Эрхүү мужийн нутаг дэвсгэр болох Байгал нуур орчимд нутаглаж байгаад XVII зуунд зүүнтээ шилжиж, Байгал нуурын нөгөө талд гарч сүүлдээ Буриад улс үүсгэн байгуулагдсан газарт суурьшсан Кормины болон Хапсагайн улсуудыг Готол-буумал гэх/

Зарим эх үүсвэрүүдийн таамаглаж байгаагаар бол, оросын засаг захиргааны зарлигаар улс орны өмнөд хязгаарыг хамгаалуулахын тулд Байгал нуур орчим нутаглаж байсан булгад овгийн таван зуугаад өрхийг Иволгийн хөндий рүү XVIII зууны эхэнд (1702 онд) шилжүүлэн нутагшуулсан аж.

Итгэлын гурав дахь үеийн ач Борис Буянтуевич Балжиевт арай өөр мэдээлэл байна:

Байгал нуурын баруун талд суурьших буриадуудын хувьд тэсч тэвчишгүй хүнд цаг үе байжээ. Оросын хасагууд дураараа авирлах, хүч түрэмгийлэх, алба гувчуурын хэмжээг хэдэн арав дахин нэмэх, иргэдээс агуулах хашаа сав барихад бас хөрөнгө гаргуулах, хүмүүсийг барьцаалах, золиослох, хэм хэмжээ тогтоох, газар нутгийг булаан авах зэргийн улмаас буриадуудыг бослого гаргахад хүргэсэн юм. Бослого гаргасан буриад-монголчууд хасагуудын шивээг нь бүслэн шатааж, дааж давшгүй өр төлөөс нэхэж, хүний ёсноос гажуудаар хорьж барьцаалж байсан хүүхдүүдээ хүчээр суллан авах гэж оролдоцгоожээ.

Гэвч хүч тэнцвэргүй байсан болохоор бослого дарагдснаар буриадууд төрөлх нутгаа орхин зайлахаас аргагүй болсон аж. XVII зууны дундуур Готол бослогод бусдаас идэвхтэй оролцогч байсны учир жирэмсэн эхнэрээ дагуулаад оросын залхаан цээрлүүлэгч хасагуудаас зугатаан Куда голын хөндийгөөс явж,, Хөлтөг (Култук)-өөр дамжин Өвөр Байгалд алан хядагч Багаб-

ханы /Иван Похабовыг тэр үед буриадууд тэгж нэрлэдэг байсан / бараг л хамар доор нь нууцаар хүрч иржээ.

Аянга цахилан нүргэлж байх зуур тэд байлдааны өндөржүүлсэн бэлэн байдалд байсан Хөлтөгийн шор үзүүрт шивээ хашаанаас мэдэгдэлгүй өнгөрч чадсан боловч Байгал нуурын эрэг дээр очоод эхнэр нь хүүхдээ төрүүлжээ. Гайхалтайгаар аврагдсанаа бодоод Готол хүүдээ “тэнгэрээс буусан” гэсэн утгаар Буумал гэдэг нэр өгчээ.

Зугатаагсад Оронго голд хүрээд өвлийн бэлтгэл хийж, орох оромж барьж, хүнсээ базааж, Готол өдөр бүр анд явах болов. Хавар нь тэдний цорын ганц хул гүү унагалж, уух сүүтэй болсноор Бухын Нуга хэмээх газартаа Готол тахил ч өргөж амжжээ. Сэлэнгийн хөндийд амьдарч асан булгадууд урьд нь ч өвөг дээдэстээ, тухайлбал, Өвгөн (Убукун) голын эхэн дэх Жаргалантын овоонд гарч Бух Ноёндоо тахил өргөдөг байсан аж.

Хожим нь Готол буцан ирж Байгалд тулж нутаглах болсон боловч Похабовын залхаан цээрлүүлтэд өртөхгүйн тулд өөр нэрээр амьдарч, байнга газраа солин нүүдэллэж байлаа. Тийм болохоор Готолын омгийнхны угийн бигчигт өөр өөр утгатай мэдээлэл агуулагдан буй.

XVII зууны сүүлчээр 39 настай Буумалаар толгойлуулсан готолчууд дахин Өвөр Байгал руу очиж, Иволга, Сэлэнгэ, Оронго, Темник голуудын орчмоор суурьшин одоо ч тэндээ амьдарсаар байна.

Хамба Лам Итгэлын хамаарагдах готол-буумал овгийн дээд өвөгийн түүх ийм болой*.

Итигэл Мункотагарэ гурван хүүхэдтэйгээс нэг нь Дашдорж , бас нэг охинтой аж. Нацовын мэдээнээс үзвэл тэдний амьдрал боломжийн байжээ. Гэвч амьдралынх нь түүхийн цаашдын өрнөлөөс дүгнэхэд хангалуун гэх ойлголт төрөхгүй байгаа юм. Тухайлбал,: “..Итгэлов бүүр бага байхдаа Очирбулагийн

Батобаторынхны удмын Надмит, Ринчин нарын малыг маллаж, жилд дөрвөөс долоон рубль авдаг байсан” гэж багшийнхаа талаар Будаев өгүүлжээ. Оронго тосгоны оршин суугч, Итгэлын нутгийн хоёр хүн үүнийг бас нотлодог. “...хар багадаа өнчирсэн хүүхэд, хонь хариулж, өвлийн хүйтэнд нүцгэн хөл нь даараад болохгүй болохоор үхрийн халуун баасанд хөлөө хийж дулаацуулдаг байсан юм” гэж Борис Бальжиев хэлсэн бол Цырен-Доржо Цыденов:”Тэрээр ядуу айлд төрсөн” гэжээ.

Иволгийн дүүргийн төвөөс баруун тийш 8 километр орших, газар доороос оргилон гарч буй булгийг өдгөө ч Очирбулаг гэдэг. Ходоод гэдэсний замын өвчин болон ангиныг энэ булгийн ус сайн анагаадаг. Дашдорж Итгэл хүүгийн хонь хариулж явсан газар энэ. Итгэлыг мэндэлэхээс бүүр өмнө нэг лам булгаас ус авч явахдаа тэнд нэг очир (ваджра) булсан ба түүнээс хойш булгийн уснаас уусан бүхэн эрүүл, хүчтэй болж байсан гэх аман яриа байдаг.

Очирбулагаас холгүй, одоо юу ч үгүй хоосон байгаа газарт хэзээ нэгтээ Янгажины хасаг суурин байсан байна Энэ сууринтай зэрэгцээд Янгажины дацангийн таван зуугаад лам нарын байр байсныг бүгдийг нь дэлбэлж, шатаасан ба Итгэлын төрсөн газар болох Нарсан Нарасуны Өлзий Довоос зүүн хойхно байсан дацанг ч бас устгажээ.

Итгэлын мэндэлсэн газар одоо модод, дов толгодоос өөр юмгүй хавтгай газар бий. Янгажины дацангийн лам нарын дурсгалд зориулж 1997 онд суварга босгосон юм.

Хамба Лам Итгэлын Эрдэнэт Мөнх Лагшинг хадгалах ажлыг удирддаг лам Доржиев Бимба өгүүлсэн нь:

- Миний өвөг эцэг Дэнжэнов Гэндэн Хиагтын дүүргийн Бурдун тосгонд 1900 онд төрсөн. Өвөг маань Доод Иволгад шилжин очоод 1927 онд өөд болоход гурван хүүхэд нь үлдсэн

байна. Миний эцгийг гурван настайд нь Ользон удмын Шарын Доржо өргөж авчээ.

Итгэл Хамба Ламын талаар ахмад хүмүүсийн яриаг би хүүхэд байхдаа сонсч байсан. Миний санаж байгаагаар манай аав Доржин Сэдэн, хөрш Сырен Даша нар Зая Хамба болон Итигэлэй Хамбын талаар ярилцдаг байсан юм.

Дашдорж Итгэл өнчин өссөн ба Очирбулаг гэдэг газарт Батобатор хэмээх чинээлэг эзний мал хариулж байжээ. Итгэл хүүхэд насандаа бусдаас ялгарахуйц өвөрмөц сонин зан авиртай хүүхэд байжээ. Тэрээр байнга оршуулгын газарт малаа хариулж, шарилын дээр тавьсан ёс жаягийн элдэв юмстай оролддог байсан байна. Тэр үед өөд бологсодыг газарт оршоодоггүй, ил тавьдаг байжээ. Тэрээр: “Хэрвээ та нар миний үгэнд орсон бол үхчихээд энд хэвтэж байхгүй байсан юм” гэж үглэдэг байжээ. Энэ талаар Аюуш Хамба хэлэхдээ: Итгэл үхлийн хүчинд бууж өгөөгүй, харин түүнийг мэхэлж чадсан* гэсэн юм. Нэгэн орой Итгэл хүү хүний гавлын ясыг гадсанд хатгаад барьчихсан, бух уначихсан хүрч иржээ. Гэрийн эзэд айж сандран лам нарт хандахад лам нар: Энэ хүү бол хэн нэгний хойт дүр байна, хэнийх гэдэг нь одоохондоо тодорхойгүй. Гэхдээ агуу үүргийг гүйцэтгэх томоохон хувьтай хүн байна гэжээ. Энэ үйл явдал түүний амьдралд ихээхэн тус болсон гэж ярьцгаадаг.

Итгэл өөрөө ч гэсэн: “Би Хамба лам болно” гэж хэлжээ. Тэгэхэд нь гэрийн эзэгтэй: “Нүцгэн гуйлгачин чиний лам болдог гэж юу байсан юм” гэж шоолон инээжээ. Ухаан мөхөс энэ эмэгтэй хөгширсөн хойноо Итгэлт очиж залбиран мөргөсөн гэх үргэлжлэл бас яригддаг хэдий ч энэ бол зүгээр л домог байж болноо. Гэхдээ бүх намтраас нь үзвэл гэгээнтний шинж Итгэлт бүүр хүүхэд байхад нь илэрчээ.

Гавлын яс авчирсан тохиолдлын дараа тун удалгүй арван хоёр настай хүү Жамсаран ламын шавь болсныг Доржиев Бимба лам батлан өгүүлдэг. Түүний суралцаж эхэлсэн үеийн талаар өөр

бас нэг таамаглал бий. Төрөлх нутагтаа Янгажины дацанд дөрвөн жил сурсны дараа Тэгдийн Захрай ламхай түүнийг Анины дацан руу аваачжээ.

Г.Нацов: “Бага хүүхэд байхдаа хулгай хийдэг байснаас болоод төрөлх нутагтаа байх боломжгүй болж гэрээсээ оргон зайлахад хүрсэн” гэжээ. Итгэл 14-16 орчим насандаа гэрээсээ сэм оргож явсан нь олон учиртай аж. Будаевын нотлож байгаагаар бол өсвөр насны тэр хүү ямар нэг юмнаас зугатаан оргосон юм биш, харин ямар нэг зүйлд тэмүүлэн татагдсанаас явжээ. Тэрээр “суралцахын мөрөөсөл болж” байсан тов тодорхой ганцхан зорилготой. Иймээс ч Хорийн тал дахь, тэр үеийн сэтгэл шашны болон гүн ухаан, соёлын томоохон төв гэгдэж байсан, гурван зуун километрийн цаана орших Анины дацан руу явсан байна.

Хорийн дүүргийн Тохорюкта тосгоны, 1935 онд төрсөн Дугар Егнинович Лундуков гэдэг хүн Тэгдийн Захарай Ширап Нимбу ламхай Анины дацанд Итгэлыг авчирсан тухай дурсан ярьдаг. Ядуу амьдралтай, өнчин Итгэл хүүг Анины дацан руу авч явсанаараа тэрээр түүний агуу ирээдүйг тодорхойлох чухал үүргийг гүйцэтгэсэн байна

1840 онд төрсөн, Захарай ламхай бол буриадын нэртэй йогчдын нэг, Ламрим болон бусад олон номыг цээжээр мэддэг, тиймдээ ч том том судар номууд сугавчилж явдаг лам нарыг хөөрхөн шоглочихдог нэгэн. Энэхүү мэргэн лам гэвш болон гавжийн дамжаа барьсан Тамчийн дацангаасаа өөр нэг тодорхой зорилгоор Янгажины дацан хүртэл явж байжээ. Түүнд чойрын ном (буддын гүн ухаан) заасан Жамсаран лам (Жамсаранэй-ламхай)-ын оролцоо үүнд бас бий.

Захрай ламхайгаас гадна 1830 онд төрсөн Хойтын ламхай, 1837 онд төрсөн Баруун ламхай, 1837 онд төрсөн Зодвын ламхай нар Итгэлын багш болжээ. Баруун ламхай, Зодвын ламхай нар дөнгөж төрсөн, Хойтын ламхай бага хүүхэд байхад тэднийг хувилгаан хэмээн үзэж, авч явахаар Төвдөөс лам нар

ирэхэд . Анины дацангийн лам нар:"Бурхад хаана мэндлэхээ өөрсдөө мэддэг" гэсэн эелдэгхэн татгалзах хариу өгчээ.

Эдгээр хүүхдүүдийг Арьябал, Авид Бурхан, Манзушри бурхадын тус тусын дүрээр газар дэлхийд ирсэн гэж үздэг. Бас нигүүлсэхүйн Будда, насан уртын Будда, бэлгэ билгүүний Будда ч гэдэг.

Итгэл Анины дацанд хуврагийн зэрэгт хүрч, лам сахил хүртсэн ба цаашдаа буддын шинжлэх ухааныг судлаж эхлэх зэргээр нийтдээ тэнд 23 жил суралцсан байна.

Хойт ламхай Аюшин Галдан энэ үед Анины дацангийн ширээт ламаар тохоогдон буриадын шашны гол сургаал болох чойрын номыг дэлгэрүүлдэг байж. Нигүүлсэхүйн Буддагийн газар дээрх дүр Хойтын Ламхай /энэ агуу хүний хувцас нь хадгалагдан үлдсэн байдаг./ Итгэлыг энэ дэлхийд ирүүлсэн зорилгыг нь нэгэнт мэдэж байсан учир Дүйнхор дуганын дуганчаар ажиллуулахдаа түүнийг бусад хүүхдүүдтэй харьцуулахад ямар нэг юмаар гачигдаж, бэрхшээл бүү туулаасай гэсэндээ сард таван рублийн тэтгэлэг олгож байжээ. /Итгэл хангалуун гэр бүлд төрсөн гэх таамаглалыг мадаггүй баталгаатай энэ баримт шууд бусаар ч гэсэн эргэлзээтэй болгож байгаа юм/.

Зөвхөн багш нар нь төдийгүй, тэр орчмын тосгоны иргэд ч гэсэн Итгэлыг тэнгэрээс оноосон үүргээ хэрэгжүүлэг хэмээн боллоцоотой бүхнийг хийж байжээ.

3.2. Багш шавийн замнал

1853 онд Дорнод Сибирийн мужийн ерөнхийлөн захирагч генерал Николай Николаевич Муравьев (Амурскийн ирээдүйн гүн) “Ламын шашны тухай журам” гэгч төсөл гаргажээ. Орос улсын засаг захиргаа нийт буддын шашинтнуудыг Бандид Хамба Ламд нь бүрэн эрхийг өгч захируулахын зэрэгцээ, Хамба Ламыг нь хаант засгийн зүгээс хянаж байдаг хатуу журамтай босоо тогтолцоог хэрэгжүүлдэг уламжлалтай. Дацангуудын тоог тухайн үед ажиллаж байгаагаас нь нэмэхгүй байх, татвар төлдөггүй лам нарын тоог хатуу тогтоох, бусад нь тариачидтай нэгэн адил хэмжээгээр татвар төлж байх гэх зэргээр буддын шашины хуврагуудын эгнээний эрчимтэй түргэн өсөлтийг тэр бичиг баримтаар “гацаажээ”.

“Буддизмыг оросын засаг захиргаанаас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн хэдий ч байвал байж болох шашин гэсэн үнэлгээ хэмжээнд л ямагт байсаар ирсэн төдийгүй илэрхий бус аргаар тэмцэж байвал зохих гайтай зүйл гэж засгийн зүгээс буддизмыг үзэж байсан юм. Энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд хаант засаг хуврагуудын тоог хатуу тогтоосон ба хяналтаас гадуур сахил хүртэж лам болохыг хууль бус үйлдэлд тооцож байлаа. Сүм хийд барих, засварлах ажлыг ч хатуу тогтоосон дүрэм журамд захируулж байж. Шашны сургуулийн тоог ганц болтол нь цөөрүүлж, судар ном хэвлэхийг заавал улсын хяналт зөвшөөрөлтэйгээр хийдэг болгосон* “

Тэр үед дацангуудын номын санг зөвхөн, Төвд, Монголоос ирэх номоор л баяжуулж байсан ба дашрамд хэлэхэд тэндээс ирэх ном ч хангалттай, ер нь шашны боловсролын тасралтгүй явцын бүхэл бүтэн тогтолцоо бүрдсэн байжээ. Гэтэл гаднаас ном судар оруулж ирэхийг засгийн зүгээс хориглож, буриадуудыг буддын ертөнцөөс холбоог нь таслаж эхэлжээ. Гэвч гаднын лам нартай харьцаатай байх нь хаант засгийн хувьд таагүй зүйл

байсан тул гагцхүү үүнийг болиулах зорилгын үүднээс 1880 онд буддын ном судруудыг өөрсдийн дацангуудад хэвлэхийг ДХЯ зөвшөөрсөн юм.

Гэтэл хуучин монгол бичгийн онцлогоос болоод бэрхшээл тулгарч, хавтгай модон дээр үсгийн хэвийг толинд туссан дүрс мэт урвуу талаар нь сийлэхэд үйлдвэрийнхэн гэхээсээ илүүтэй гар урчуудаас өндөр ур чадвар шаардаж, хүндээр тусч байжээ. Эхлээд хэвд тохирох модоо сонгон олох, хатуу тогтсон цаг хугацаанд нь модоо бэлтгэх, хатаах, банзлан зүсэх, тосонд чанах, уусмалд боловсруулах, дахин хатаах өнгөлөх гээд л.

Ксилографи гэж нэрлэгддэг, ард түмний хөгжилд саад болсон модон барын ийм аргаар хүмүүсийн оюуны эрэлт хэрэгцээг хангахад тун ч амаргүй байжээ. Төвд, Монголоос шашины эд зүйлсийг хил давуулахгүйн тулд Хоринскт суулгасан цагдаа нар нүд цавчилгүй хянана. Оросын хаант улсын хилийн цаанаас шашны том зүтгэлтэн ирж, түүнтэй хийх уулзалт, семинар, дээд хэмжээний сургалтуудыг нууцаар ойд очиж хийж байсан тухай мэдээ хадгалагдан үлджээ. Тухайлбал, Итгэлын багш Хойтын Ламхай нэгэн монгол ламыг Ойбонтод аваачиж, бүтэн долоон хоногоор ойгоос гаралгүйгээр хичээллэж байсан аж.

“1741 онд буриад лам нараас нууцаар болон ил аль ч хэлбэрээр хил давахгүй, нууцаар болон ямар нэг зүйлээр шалтаглан гадаадын лам нартай холбоо тогтоохгүй байх, ийм зөрчил гаргах аваас цаазын ял оногдох учиртайг ойлголоо гэсэн утгатай баталгаа гаргуулан авахыг Сэлэнгийн цэрэг-захиргааны газарт Эрхүү мужийн амбан захирагчийн орлогч тусгай шийдвэр өгч байсныг * дашрамд дурьдууштай.

Оросын Шинжлэх ухааны Академийн Сибирийн салбарын Монгол, Төвд болон будда судлалын Хүрээлэнгийн дорнын гар бичмэл, сийлбэрийн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Николай Цыренпыловын мэдээллээр бол гадаадын шүтлэг нэгтнүүдтэйгээ хууль бус харьцаа тогтоовол ялын дээд хэмжээ

оноохоор XVIII зууны хоёрдугаар хагаст засгийн газрын зүгээс заалт оруулжээ.

Лам нарыг хэзээ, ямар хэлбэрээр ялгаагүй ийн сүрдүүлж байсан ч, бодит байдал дээрээ цаазын ял оноосон удаа ч үгүй, буриадын лам нарыг бусдаас тусгаарлах бодлолго хэрэгжээ ч үгүй юм. “Зөвлөлт засаг тогтох хүртэлх бүхий л үед хилээр орох, гарах хөдөлгөөн тасраагүй. Буриадын лам нар эргэл мөргөл хийх, шашны боловсрол олох, худалдаа наймааны ажлаар Өргөө, Лавран, Утай-Гүнбум, Лхаст явсаар байсан. Төвд, Монголын шашинлаг амьдралд бүрэн автсан буриадууд Өвөр Байгалыг бүхэлд нь (сүүлдээ Байгал нуурт тулсан газар нутгийн зарим хэсгийг) буддын шүтлэгийн талбар болгон хувиргасан нь Оросын хаант засгийн санааг зовоосоор ирсэн. Ямагт хөдөлж, хөгжиж, өргөжин тэлж байдаг Орос гүрний хувьд өөрсөддөө дагаар орогсод, ялангуяа эзэмшилд бүрэн автаагүй байгаа хязгаар нутгийнхантай эвээ ололцох нь чухал байсан юм.”

Итгэлыг Анины дацанд үүрэг гүйцэтгэх болсон тэр үед дандарын болон чойрын ном /гүн ухааны/-ын хоёр дацанд 200 гаруй хувраг суралцаж байсныг архивын баримт гэрчилж байна. Бүх ёс заншил, уламжлал нь Төвдийн сүмийн сургууль болох Гоман дацангийнхаар явдаг байжээ. Өглөө эртээс эхлээд үдэш орой болтол хичээл хийнэ, чанд сахилгатай (Иволгийн дацанд одоо ч гэсэн: “бүх юм өөрийн санаснаар боловч дэг нь цэргийнх шиг” гэдэг журмаар сургадаг). Сургалтын жилийн эхний улирлуудад төвд, монгол хэлний зүй, ариун судруудыг аялгуулан унших, ёс жаягийн үйлдлүүдэд зориулдаг. Буддын гүн ухааныг арай илүү гүн гүнзгий ойлгохын тулд үндсэн хичээл болох цанид буюу өөрөөр хэлбэл учир зүйн үндэслэлтэй дүгнэлт хийх, зөв хариулах, байр сууриа хамгаалах ухаанд сургадаг.

Гүн ухааны сургалт бол буддын гүн ухааныг реалист чиглэлээр судлах газар (цанид-текла) юм. Сургалтын жилийн эцэс бүрт шалгалт авдаг. Энэ нь шалгуулагсдад бэлтгэх боломж

өгөхгүйгээр шууд л тэмцээний өмнө нь ширээт лам сэдвийг сонгож, ном хаялцуулж эхэлдэг байна. Сүүлчийн сорилд нь арван ухаанаар шалгах (таван гол ухаан болон тэдгээрийн салбар тайлбарууд) шалгалт ордог.

Вандан Юмсуновын он дарааллын бичигт дурьдсанаар бол Гандан Шаддублин (Анины) дацанг 1795 онд Иринцеев тайш өөрийн хөрөнгөөр, модоор барьсан үеэс түүх нь эхлэнэ. 1811 оны түймрийн дараа Анины дацанг ард түмний өргөлийн хөрөнгөөр чулуугаар дахин сэргээн барьсан байна. Байгал нуурын дагуух дацангуудын дотроос чулуугаар барьсан анхны дацан байснаас гадна шинээр хийгдсэн хэлбэр загвар нь үнэн алдартны сүмийг санагдуулмаар болсон талаар аман яриа тархсан байдаг. 1992 онд Доржи-Палан Дымбрыловын хэлснээр “Дамба хэмээх чинээлэг буриад ноён христийн сүм барьж дуусгаагүй орхисныг түүний эхнэр Шойжит-хатан дацан болгон өөрчилж бариулсан “гэжээ. Учир нь Дамба ноёнд элдвийн гай тохиох болсноос барилгынхаа ажлыг зогсоосон гэх яриа байдаг ч зарим эх булгуудаас үзвэл нэрүүд нь өөр өөр байх боловч эхлээд христийн сүм бариулж эхэлсэн гэдэг нь адилхан, харин барилгын ажил зогсож, холоос урьж ирүүлсэн цутгуурчин нь хонхоо цутгаж чадаагүй, сүүлд нь Дамба ноён ирж сүмийг дуган болгож дуусгасан гэсэн байдаг. Шашны байгууламж барих зөвшөөрлийг эзэнт гүрний захиргаанаас хурдан гаргуулахын тулд заль хэрэглэсэн ч байж болох юм. Хамгийн түрүүнд барьж эхэлсэн хүмүүс нь орос урчууд байсан гэж ч үздэг.

Энэ Буддын сүмийн хийц дэлхийн өөр хаана ч байгаагүй, одоо ч байхгүй хэлбэртэй баригдсаны нууц нь үүнд ч байж болох юм.

Хавтгай, дарагдсан шоо шиг хоёр давхар байшинг (нэгдүгээр давхар нь хүний өндрийн хэмжээний зайнаас эхэлдэг) гоёмсог хийц, бариултай хашлага, тагтуудтай, бас хананд нь юм хийх савууд, шургах хонгилуудтай хийж, дээр нь харин дээвэр биш, оройг нь тайрсан цац (пирамид)-ыг мөн чулуугаар хийжээ. Нэг

үгээр бол байшинг цацаар бүрхсэн гэснээс шоо хэлбэртэй барилга нь цацын суурь болсон гэлтэй .Цацан хэлбэрт асрын зэрэгцээ бас дөрвөн жижигхэн тоосгон цамхаг сүмийн дээр толгойн чимэг мэт харагдна. Барилгын урагшаа түрж гарсан хэсэг дээр нь гонхоныг санагдуулам өндөр (24 м) цамхаг бий.

1861 онд хүчтэй газар хөдлөн Байгал нуурын ойролцоохи Цагааны талын нилээд хэсэг нь таван омог иргэдийн хамт усанд живсэн. Мөн сүмийн нэг хананд нь ан цав суусан юм. Дацангийн архивт буй баримтаас үзвэл 1864 оны наймдугаар сарын 1-нд “Анина-д асар хүчтэй шуурга дэгдэж, дацангийн хэд хэдэн газрын төмөр дээврийг хуу татаж, дацангийн модон шатны банзан хажлага болон дээврийн дээрх жижигхэн өрөөг бүрмөсөн авч хаяжээ. 1865 онд Итгэл Анины дацанд очсон яг тэр өдөр дацанг засаж сайжруулахаар төлөвлөсөн байж.

Тэрээр шинжлэх ухаанд шимтэн суралцахын зэрэгцээ дацанд ажиллахдаа өнөөх цацтай барилгад биш, буриад урчуул дорнын маягаар өөрчилсөн, дээвэр нь хийссэн сүмд хурлаа хурах болов. Гол сүмийнхээ хойт хэсэгт агуу их Екатерина хатан хааны цээж барималтай*, хананд нь византи маягаар зураг урласан буддын энэ сүмд Итгэл олон жил суух учиртай байж.

Итгэлын мэндэлсэн газарт болон Янгажины дацанд ойр орших буриадын Дээд Оронга тосгоны Буриад даяар алдартай “Оронгын цуутай дархчуул” болох мужаан, төмөрчин, цутгамалчид, сийлбэрчид, уран барималчид, бурхан урлаачид, дээвэрчид буриадын олон сайхан дацанг барьсан. Тэд Монголд ч ажиллаж байсан ба Байгал нуурын орчимд, Өвөр Байгалд, тэр ч бүү хэл Енисейд хүртэл Оросын үнэн алдартны сүм барьцгаасан юм.

Итгэл Анины дацанд 20 жил суралцаж гэвшийн дамжаа барьж эрдмийн зэрэг /өрнөдийнхөөр бол гүн ухааны доктор/ хамгаалаад дараа нь цанидын, дандарын сургаал болон бусад бүх шалгуурыг амжилттай туулснаар буриадын дацангуудад хүртээж

болох хамгийн дээд цол болох гавж болжээ гэсэн нэг таамаглал байдаг.

Өөр таамаглалаар бол Итгэл 24 насандаа хувраг болсныхоо дараа олон дацангуудаар албан үүрэг гүйцэтгэхээр явсаны дотор Байгал нуурын ойролцоохи дацан ч орно. Энэ таамаглал нь түүний шавийнх нь бичсэн өөрийнх нь намтартай ч, Анины дацангаас авсан мэдээлэлтэй ч тохирдоггүй, гагцхүү Итгэл хамбын өөрийнх нь бичсэн албан үүрэг гүйцэтгэсэн тухай жагсаалтад л байдаг юм.

- Энэ бичиг баримтын эхэнд нь Итгэл өөрийгөө гувчуур төлдөг харь үндэстнүүдээс гаралтай бөгөөд төвд, монгол, орос хэл мэднэ гээд доорхи жагсаалтыг үйлджээ:
- ...1876 оны 3-р сарын 20-нд сахилтай хувраг болсон
- 1880 оны 3-р сарын 18-нд Ацагатын дацанд лам болсон
- 1882 оны 3-р сарын 13-нд Болакийн дацанд гэлэн сахил хүртсэн Албаны эрх ашгийн үүднээс
- 1883 оны 3-р сарын 10-нд Жагасуртайн дацанд гэлэн сахилаараа шилжсэн
- 1888 оны 8-р сарын 13-нд Эрхүү мужийн Аларын дацанд шилжсэн
- 1890 оны 1-р сарын 17-нд Ацайн дацанд шилжсэн гэх бөгөөд
- 1890 оны 8-р сарын 10-нд өвчний учир ламын шашинтнуудын орон тооноос өршөөлөөр хасагдсан
- өвчин эдгэрсний учир 1895 оны 7-р сарын 7-нд Галуут нуурын (Гусиноозерский) дацанд хуврагийн эгнээндээ буцаж орсон... гэх мэт

Итгэлын талаархи бусад эх сурвалжуудтай энэхүү жагсаалт зарим талаар нэлээд зөрчилдөж, бүр эсрэг утгатай ч болдог учир жагсаалт бодит байдалд нийцэхгүй байна гэж үзэх ихээхэн үндэслэл бий. Харин бие биенээс үл хамаарах өөр өөр эх үүсвэрүүдээр арай илүүтэй нотлогддог гуравдахь таамаглал

байдаг нь: Анины дацанд Итгэл 18-20 жил суралцсан бус, харин 20 гаруй жил суралцсан, зарим нь 23 жил сурсан ч гэдэг. Агын талын хурлын Цүүгэлийн дацанд шашны боловсролоо улам төгөлдөршүүлсэн. Бандид Хамба Ламын байнгын байрладаг Тамчийн дацан (Гусино озёрский)–д дээр дурьдсан жилүүдэд байжээ.

Өөр нэг мэдээгээр: VII Бандид Хамба Лам Галсан Чойроп Ванчиков буюу Сандэлэгийн Хамба /өдгөө нэг тиймэрхүү дундын хувилбараар Сандэлэг Ванчиков гэдгээр нэршсэн/ өмнөх дөрвөн Хамба ламын гадаад төрхийг дүрслэн хэлэхийг хувраг Итгэлээс хүсэхэд нь бүгдийг мадаггүй зөв хэлсэн тул “Олны Багш” (буриадаар бол “Олоной Багша” .) гэдэг цолоор түүнийг өргөмжилжээ. Энэ үйл явдлын өмнөхөн Итгэл Цогчин дуганын хоёрдугаар давхараас доошоо хартал дөрвөн хамба лам яг амьд байгаа мэт бүгд харагджээ. Энэ яриа дацанд тэр дорхноо тархсан тул Хамба Лам дээрх сорилыг авсан гэх ам дамжсан яриа байдаг юм байна.

Ванчиков 1860 оноос 1872 оны хооронд эрх захирагч байжээ. Иймээс Итгэл хувраг тэр үед 20 наснаас хэтрээгүй байхдаа Анины дацангаас Тамчийн дацанд гүн ухааны талаар ном хаялцахаар ирж байсан байна.

38 наснаасаа эхлээд Итгэл лам нарын хүсэлтийн дагуу буддын гүн ухаанаар ном бичиж эхэлжээ. /нийтдээ 50 гаруй боть боловч одоохондоо бүгд бүрэн олдоогүй байгаа/. Мөн энэ он жилүүдэд Цагаан хадны Могой ууланд Итгэл бясалгалд суусан нь тодорхой болсон.

1895 онд Итгэл буддын гүн ухааны доктор цолтой, 42 настайдаа дахин хувраг болж, Тамчийн мамба дацанд суралцаж эхэлснийг бүх эх сурвалжууд зөрөө мадаггүй нотлодог. 1896 оны 5-р сарын 1-нд бичсэн нэрсийн жагсаалт хадгалагдан үлджээ: “Сэлэнгийн талын хурлын газар, Сэлэнгийн тойргийн харь үндэстнүүдээс 43 настай Даши Доржо Итгэл 1895 оны 6-р сарын

7-нд хувраг болсон. Өвөр Байгалын мужийн цэргийн амбан захирагч ноёнтны саналаар 1895 оны 7-р сарын 27-нд батлагдсан. Бүрт.№ 4363” гэжээ

1853 оны журмаар гагцхүү Тамчийн дацанд суралцсан хуврагуудаас л бусад дацангуудад орон тооных болгож өгөх ёстой. Тиймээс гэвш, гавж цолтой, өөрийнхөө хүрээнд алдар нэртэй лам нар ч гэсэн шашины эрх захирагч нараас олгосон бичиг баримттай болж, албан ёсоор нэр хүндээ дээшлүүлэхийн тулд Тамчийн дацанд очих суралцах хэрэгтэй болдог байжээ. Энэ журмын дагуу Итгэл Тамчийн дацанд суралцах болсон байна.

Итгэл анагаах ухаанд жинхэнэ ёсоор нь шамдан суралцаж, өнөөгийнхний ой ухаанд гаргууд оточ гэдгээрээ дурсагдан үлдсэн, эм судлал (“Жор”) –ын суурийг тавьж үлдээсэн хүн юм.

Итгэл Янгажины дацандаа эргэж ирснийхээ дараа шууд л орон тооны буддын гүн ухаанч болчихоогүй. Бичиг зохиолуудад түгээмэл тааралддаг энэ мэдээлэл харин архивын баримтаар нотлогддоггүй. Янгажины дацангийн 1897 оны албан үүрэг гүйцэтгэсэн бүртгэлээс үзвэл * хувраг Итгэл 45 настайдаа гэнэн лам болсон байна. Энэ бол эхлэн суралцагч таван сахил хүртсэнээр олгодог шашины хамгийн доод шатны зэрэглэл юм.

Цаашдаа тэрээр гол сүмийн Цогчин дуганын гэсгүй лам /сахилга хариуцдаг/ –ын үүрэг гүйцэтгэх болжээ. Уг сүмийг 1895 онд даруй өөрчилжээ. Хуучин сүм нь хуучирч муудсан учраас буулгаж, оронд нь үнэн алдартны таван оройтой сүмийн загвараар модон сүм барьсан аж. Итгэлыг Янгажины дацангийн ширээт лам болчихсон хойно нэг шөнө түймэр гарч дуган ихээхэн сүйдсэн ч Итгэл ширээт түүнийг түргэн сэргээжээ.

Итгэлээс өмнө дацангийн ширээт ламын албыг гүйцэтгэж байсан (1880-1903 оны хооронд), лам нарын үздэгээр Итгэлын багш нарынх нь нэг гэх Лубсан Ниндак Банзаракцаев гэдэг хүн

анх тэр сүмийг бариулсан яг л тэр хэлбэрээр нь Итгэл сэргээсэн байна.

1910 онд Итгэлын өмнө Бандид Хамба Ламын суудлыг эзлэж асан Чойзон Доржо Иролтуев Янгажин дацанд ирж, дорнын барилгын загвараар, чулуугаар шинэ Цогчин дуган барих нь зүйтэй гэж зөвлөсөн байна. Тиймээс 1913 онд тийм дуган барьж дуусгасан боловч түүнийг Итгэл биш өөр ширээт лам удирдаж хийлгэсэн байна.

Тэр хугацаанд Итгэл ард олон дээр очиж, гэгээрүүлэх, сургах, зааварлаж туслах ажлыг хийж байлаа. “Итгэл шашны гэгээрүүлэх ажлаар тосгонуудаар явж байхдаа ид шид гэмээр өөрийнхөө гайхамшигтай чадваруудыг хааяа үзүүлдэг байжээ. Жишээ нь, Галуут нуур (Гусиное озеро) –ыг мориор туулан гатлахад нуурын ус хага ярагдан урьд нь зам буй болдог байлаа гэж Бимба лам ярьсан байдаг”

Сүүлд энэхүү чадвараа бузар хар үйлтнүүдийг бүрнээ номхотгоход ашиглахад хүрч байсан гэх ч энэ тухай дараа өгүүлдэг.

Итгэлын шидэт үйлдлүүдийн талаар янз бүрийн хүмүүсийн хэлснийг энд дурьдаж байхдаа бид Хамба Ламтан маань сэтгэл, оюуны ер бусын агуу чадвартан байсан гэдэгт огтхон ч эргэлздэггүй. Гэхдээ энэхүү шидэт үйлдлүүд яг л тэгж хийгдсэн гэсэн үг бас хараахан биш, учир нь түүнийг бодитой ноттой хэлэх хүн өдгөө үгүй билээ. Гэвч тэдгээр үйлдлүүдийн талаар хангалттай олон дурсамж баримт байгаагийн зэрэгцээ, Итгэлын өнөөгийн энэ байдал зэргээс үзвэл эдгээрийг үл ойшоож яавч боломгүй. Бид энэ талаар юу ч үл өгүүлэн дүлий дүмбэн сууж байх эрхгүй. Итгэлын гоц үзэгдлийн талаар хэлж буй эрдэмтдийн үг, дүгнэлт, таамаглалуудын тухайд ч мөн ялгаагүй. Энэхүү номыг хэвлүүлэх болсны учир нь хэнийх нь зөв буруу гэж үнэлэн дүгнэх, эсвэл хэн нэгнийг нь нотлох буюу үгүйсгэхдээ бус тэдний үгийг өргөн олны сонорт хүргэхэд л оршиж буй билээ.

Хэрвээ тэд үнэхээр ямар нэг далд санаагүйгээр, ердийн төсөөлөн бодох үндсэн дээр зохиосон байлаа ч гэсэн Итгэлыг тойрсон тийм гэгээлэг домог үүсч байгаа нь эрт үед ард олны дотор, өдгөө судлаачдын дунд ч гэсэн энэ лам хэр их чадал чансаатайг, тэрээр ямаршуу эрхэм зорилготой байсныг шууд бусаар гэрчилж байгаа л хэрэг. Асуудлын бүүр угт нь тулаад, энд дурьдсан дурьдаагүй тэр олон зүйлсийг Итгэл үнэхээр хийж чадаж байсан юм уу—хэмээвээс—энэ бол бидний хувьд үлэмж дээдийн, гоц үзэгдлийн л асуудал. Харин гарт барим нотлогоог тийм ихээр хүсээд байгаа хүмүүс байгаа бол тэдэнд хандаж хэлэхэд: “Өндөр дээд төвшний арга дадалт Итгэл гэгч хүн таны дэргэд байна аа, түүнтэй та уулзсан ч болно “гэж л хэлмээр байна.

Ийнхүү буриадын зон олны дотор хадгалагдан үлдсэн гэрчлэлүүдээс үзэхүл зөвхөн шашинтнууд, сүсэгтнүүдийн дотор төдийгүй, эгэл жирийн ардын дунд ч Итгэл үлэмжийн нэр хүндтэй байсан нь маргашгүй . Итгэл Үдийн тойрог (Удинский округ)-ийн депутатаар сонгогдож байсан ба үүнээс өмнөхөн 1903 оны 12-р сард Янгажины дацангийн ширээт ламаар томилогдож байсан байна. Ширээтээр томилох саналыг Хамба Лам батлаж, дараа нь саналыг мужийн захирагчаар зөвшөөрүүлэн батлуулахаар явуулдаг байсан ба хэрэв тэр нь зөвшөөрөгдвөл ширээт ламын батламж олгодог байж. “1903 оны 12-р сарын 2-нд өргөн мэдлүүлсэн № 7593, 7594 тоотуудыг үндэслэн Янгажины дацангийн гэлэн лам Даши Доржи Этигиловыг тус дацангийн ширээт ламын тушаалд томилж, ширээт ламын 8933 тоот эрхийн батламж олгосугай. Мужийн амбан захирагчийн үүрэг гүйцэтгэгч, дэслэгч-генерал гээд гарын үсгээ зуржээ.*

Энэ гарын үсгээс үзвэл ахиад л Дээд тэнгэр биечлэн оролцсон гэлтэй. Ширээт ламын албан тушаалд бурхан шашины эрдэмийн хамгийн дээд зэрэгтэй, гэлэн сахилыг арваас доошгүй жил сахисан ламыг томилох ёстой билээ.

Тиймгүйсэн бол бичиг баримтад өгүүлж байгаагаар Итгэл гэнэн болж таван сахил хүртээд зургаахан жил хагас болж байхад нь Янгажины дацангийн ширээт ламаар тохоон томилсныг өөрөөр тайлбарлах аргагүй юм. Тодруулбал: гэнэнгийн дараа хоёр дахь шат нь гэцэл бөгөөд 36 зүйлийн сахилтай, дээд шат болох гэлэн сахилтан 253 сахилыг сахих ёстой. Бурхны номд өөрийгөө бүрэн зориулсан эдгээр гэлэнгүүд бол гэнэн нарыг халамжлан сургах эрхтэй бөгөөд энэ шатыг дамжин өнгөрөхийн тулд олон жилийн нүсэр хөдөлмөр шаардагддаг.

Бас нэг баримтаар 1882 онд Итгэл гэлэн сахилтай лам байсан /Итгэлийн өөрийнх нь бичсэн албан үүрэг гүйцэтгэсэн тухай жагсаалтыг үндэслэх аваас/ болохоор дацангийн ширээт ламын суудалд бүрэн тохирох учиртай байжээ

Депутатын мандат болон Янгажины дацангийн ширээт ламын эрхийн батламжийг Итгэл орос-японы дайнд цэрэг дайчлахаар Дээд- Үдэд ирсэн мужийн амбан захирагчийн үүрэг гүйцэтгэгч, зөвлөх Н.П.Беломестновын гараас авчээ.

Янгажины суурингийн хасгуудыг тулааны талбар руу илгээжээ. Янгажины дацангаас баруун хойхно орших, буриаддуудын эртнээс нандигнан шүтдэг Олоны Овоо* (Олоной Обоо) гэдэг газарт Итгэл очиж, дайнд явж буй нутгийнхныгаа адислаж, тэднийг хамгаалах ёслол үйлджээ. Тэдний суурингийн хасагууд фронтоос бүгд эсэн мэнд эргэж ирснийг ард түмэн энэ хамгаалах ёслолтой холбон тайлбарладаг. Арван жилийн дараа энэ үйл явдал дахин давтагдаж, энэ удаад харин Баруун зүгт, Дэлхийн нэгдүгээр дайны фронт руу явж буй нутгийнхнаа адислахаар Итгэл мөн тэр газраа дахин очсон ба настангуудын хэлж байгаагаар тэд мөн л цөмөөр дайнаас эсэн мэнд эргэн ирцгээжээ.

Итгэл тэдэнд үзүүлэх тусаа зөвхөн шашин номын үйлээр хязгаарласангүй, шархдагсдад туслах цэргийн эмнэлэг байгуулах, фронтод хандив тусламж цуглуулан илгээх зэргээр

цэргийнхний хүндрэлийг аль болох хөнгөлөхийн тулд өөрийн чадах боломж бүхнээрээ нүдэнд үзэгдэхүйц, бодитой юм хийж байлаа.

Тэр үед Итгэлын өдөр дутмын үйл ажиллагаа нь үндсэн хоёр зорилгод чиглэж байлаа: тэрээр сүмийнхээ дотор нэлээд далайцтай барилга байгууламжийг эхлүүлсэн нь бүгд л дайн тулаанд оролцож яваа сүсэгтнүүдэд зориулсан байлаа. 1905-1906 онуудад тэдний тусын тулд Диваажин дуганыг босгосон юм.

1911 онд түймэрт өртсөн сүмээ дахин босгохын тулд бүх хөрөнгөө, цуглуулсан 15 мянган рублиэ ч зарцуулжээ. “Эхлэлийг нь тавьсанаар тэрээр ард түмнээс өргөл хандивын журмаар нэлээд мөнгө хуримтлуулсан юм. Мөнгө цуглуулсныхаа дараа гурван ламыг Долнуур руу явуулж, Диваажингийн шүтээн / Цаглашгүй гэрэлт Авид бурхны ариун орныг дүрсэлсэн/–ийг тэндэхийн урчуудаар хийлгэснээр шинэ дуганыг дахин босгосон юм.”

Сүүлд Янгажины дацанд Ирээдүй цагийн Будда – 80 тохой (16 метр) Майдар Бурхны дүрийг дуганын хамт бүтээн байгуулах цаг ирэхэд Итгэл санхүүжилтийг мөн дээрх аргаар олсон билээ. 1920 оны тэр бүтээн байгуулалтад Хамба Лам маань дахиад л хамаг хөрөнгөө бүрэн зарцуулсан байна. 1954 онд Диваажин дуган ч, Янгажины дацан ч бүрмөсөн устгагджээ.

1910 оны эхээр Итгэл эрүүл мэндийн шалтгааны улмаас албан тушаалаасаа чөлөөлж өгөхийг хүссээр байсан юм. Чита болон Улаан-Үдийн архивын баримтуудаас үзвэл буддын шашины байгууллага мужийн захиргаанаас бүрэн хамааралтай байсан нь нотлогддог. Тухайлбал, удаан хугацаанд олон дахин бичиг захидал явуулж, халагдах болсон шалтгааныг нь Сэлэнгийн хошууны даргаас тодруулж, сайтар хянан шалгасны эцэст Өвөр Байгалын тойргийн цэргийн ерөнхийлөн захирагчийн 6679 тоот тушаал 1910 оны 7-р сарын 26-нд гарч: “Янгажины дацангийн ширээт лам Дашдоржийг Эрхүүгийн амбан

захирагчийн зөвшөөрөлтэйгээр, өөрийнх нь хүсэлтийн дагуу албан тушаалаас нь чөлөөлөн халж, орон тооны лам нарын бүрэлдэхүүнээс гаргасугай. Амбан захирагчийн орлогч Беломестнов. Баталгаажуулсан: тасгийн эрхлэгч Юринский . Үнэн: бичиг хэргийн хэлтсийн эрхлэгч. “гэжээ.

Итгэл 57 настай байлаа. Хамаг асуудал дуусчихаагүй, харин ч хамгийн гэнэтийн, хамгийн гайхалтай зүйлс түүнийг хүлээж байгаа нь ойлгомжтой.

3.3. Итгэлт хамбыг Бандид хамбад сонгосны цаад учир

Итгэлыг ширээт ламаас огцрохоос өмнө, 1910 оны хавар XI Бандид Хамба Лам Чойнзон Доржо Иролтуев хорь буриадын нутаг руу явж байх замдаа Янгажины дацангаар оржээ. Иролтуев сүмийн барилга байгууламжийн асуудлыг Итгэлтой хэлэлцсэнийхээ дараа өөрөө чөлөөнд гарах хүсэлтэй байгаа гээд Итгэлыг Хамба Ламын суудалд өрсөлдөхийг санал болгожээ. Иролтуев ч тэгээд нас өндөр болсон, бас өвчний учир суудлаа тавьж өгөх хүсэлтэй байгаагаа үнэхээр уламжилсан байна. Энэ үедээ Иролтуев биеийн байдал бүрэн эрүүл байснаас гадна Итгэлээс ердөө л есхөн насаар ах бөгөөд өөд болохдоо ч Итгэлээс есөн жилийн өмнө явсан юм. Тэрээр тэнгэрт халих хүртлээ өөрийгөө албанаас чөлөөлүүлэх талаар хөөцөлдөхийн зэрэгцээ долоон мянга гаруй километрийг туулан Дэлхийн нэгдүгээр дайнд оролцож буй сүсэгтнүүд дээр очих, Архангельскт очиж дайны ар талд үүрэг гүйцэтгэж буй буриадуудтай уулзах, хүмүүсийг эмчлэх зэргээр ажилласаар байсан юм.

Иролтуевын араас Итгэл мөн явж, дацангийн ширээт ламын албан тушаалаа ч өгч, орон тооны лам нарынхаа бүртгэлээс ч хасагдсан байна. Ингэснээрээ тогтоосон хэм хэмжээг зөрчиж, Бандид Хамба Ламын суудалд өрсөлдөх боломжоо ч үгүй хийжээ.

Түүнээс цаашхи хэдэн долоон хоногт юу болсон нь дахиад л тодорхойгүй байдаг. Хэрвээ өнөөгийн өдрийн байр сууринаас авч үзвэл Итгэл Дорнод Сибирийн болон Өвөр Байгалын шарын шашины тэргүүн болох учиртай байсан нь илэрхий. Иймээс ч түүнийг сонгоход тохиолдож болох бүхий л саад бэрхшээлүүд нэг л далайлтаар бүрмөсөн алга болжээ. Лам нараас эхлүүлээд Дорнод Сибирийн мужийн захирагчаа хүртэлх түүний эргэн тойрны бүх хүмүүс Итгэлийн хувь заяаг зөв чиглүүлэхэд туслаж эхэлсэн байна. XXIV Бандид Хамба Лам Дамба Аюшеев: “Энэ

бол үнэхээр санаанд багтамгүй зүйл л дээ. Итгэлт оногдсон эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд энэ ертөнцөд юу л байнав, тэр бүхэн чиглэгдэж байна гэсэн мэдрэмж төрдөг” гэж хэлсэн юм.

Дорнод Сибирийн буддын шашины Бандид Хамба Ламын сонгуулийг 1910 оны есдүгээр сард зохион байгуулахыг зөвшөөрч Дээд –Үдийн хошууны даргаас 1910 оны наймдугаар сарын 3-нд гаргасан захирамж Буриадын үндэсний архивт хадгалагдаж байгаа. Сул орон тоонд өрсөлдөх нэр дэвшигчдийг тодруулан гаргах сонгуулийг 9-р сарын 10-нд явуулах шийдвэрийг Өвөр Байгалын мужийн цэргийн амбан захирагч 1910 оны наймдугаар сарын 17-нд гаргажээ. Өрсөлдөгчдийн нэрсийн хуудсанд арваад хүн байх боловч тэдгээрээс хамгийн олон санал авсан гурвыг нь дээд байгууллагад танилцуулдаг. Эдгээр нь Галуут нуурын дацангийн ширээт Баниев, Янгажины дацангийн ширээт байсан Итгэл, Ерөө (Ирой) –гийн дацангийн гэлэн лам Лайдапов нар байжээ.

Энэ нэрсийг цааш нь хаант засгийн газарт явуулж, тэндээ тэд эцсийн сонголт хийх учиртай. Дашрамд хэлэхэд, одоогоор юу ч тодорхой болоогүй байгаа тэр үед Итгэл эдгэрч, 1910 оны 8-р сарын 20-нд Янгажины дацангийн ширээт ламаар дахин томилогдсон байдаг. Чита Мужийн захирагчаас 1911 оны 3-р сарын 16-нд Сэлэнгийн хошуу даргад ирсэн 3427 тоот цахилгаан мэдээнд: “Улсын их эзэн хаан ивээж Янгажины дацангийн ширээт Даши Доржиева Итгэлаг Бандид Хамба Ламын албан тушаалд тохоон томилохыг 2-р сарын 13-ны өдөр зөвшөөрсөн болой

Итгэлыг Галуут нуурын дацанд авчирж, ширээт ламаар дамжуулан, та өөрийн биеэр оролцож Бандид Хамба Ламын тангараг өргүүлэхийг тушааж байна. Дээдийн эрхийн бичгийг гардан авахын тулд 3-р сарын 24-нөөс хожимдолгүйгээр Читад ирсэн байхыг Итгэлт мэдэгд” гэжээ.

Ийнхүү Дорнод Сибирийн ламын шашны XII Бандид Хамба Лам болгож тангараг өргүүлэхээр Итгэлыг 1911 оны 3-р сарын 19-нд авчиржээ. **“Доор нэрээ дурьдах миний бие Бүх оросыг өөрөө захиран шийтгэгч аугаа эзэн хаан Николай Александрович танд болон таны эрхийг хууль ёсоор өвлөн залгамжлагч их гүн ноёнтон Алексей Николаевич танд ямагт чин үнэнч байж, Бандид Хамба Ламын албан тушаалыг хүлээн авсны хувьд өөрт оногдох бүх үүргээ үнэнч шудрагаар гүйцэтгэн, өнөөгийн байдлаар надад хамааралтай болон цаашид гарах хууль, дүрэм, заавар, тушаалыг ямагт ертөнцөөс заяасан их эзэн хаан таны болон төрөлх улс орныхоо эрх ашгийн төлөөнөө хэрэгжүүлэхийн зэрэгцээ надад олгосон эрх хэмжээг хэтрүүлэн хэрэглэхгүй, санаатайгаар хэнд ч гарз, хохирол учруулахгүй, харин ч тийм мэтийг арилган устгахын төлөө тэмцэж, надад итгэж хүлээлгэн өгсөн буддын лам санваартан нарыг үнэний замд халамжлан хөтлөнө, эзэнт гүрний хууль журмаар тавигдаж буй шаардлагыг лам хуврагууд чанд биелүүлэхэд нь хяналт тавин гүйцэтгүүлнэ гэдгээ агуу Буддын ариун сургаалын өмнө, сүсэг бишрэлт бүрэлдэхүүнийхээ өмнө, бүхнийг чадагч Бурхны нэрээр батлан тангараглаж байна. Энэ бүхнийг Бурхны өмнө, Эзэн Хааны хуулийн өмнө хариуцахаа санаж явна, үүнийхээ гэрч болгож ариун Бурхан Багшийн айлдварыг хар толгойдоо хариуцуулсу.**

1911 оны 3-р сарын 19-ний өдөр. Галуут нуурын дацан. Тангараг өргөсөн шарын шашины Бандид Хамба лам Даши-Доржо Итгэл. Тангараг өргүүлж, амлаж тангарагласан бүхэнд нь биеэр оролцсон Галуут нуурын дацангийн ширээт Баниев. Байлцсан Сэлэнгийн хошуу дарга Коротков.”

Бичиг баримтаа авахаар Итгэл Читад очжээ. Архивт он сарыг нь 1911 оны 3-р сарын 24 гэж, газрыг нь – Читийн цэргийн амбан захирагчийн байранд гээд үй олон буриад лам нар, мужийн ноёд цугларан Эзэн Хааны баталсан эрхийн бичгийг гардуулаад

Итгэлт баяр хүргэж, сайн сайхныг хүсэн ерөөснийг тэмдэглэн үлдээжээ.

Бүх Оросын Бурхны шашны тэргүүн төвлөрөн залардаг Тамчийн дацанд Итгэлын сонгогдсонд янз бүрээр хандаж байлаа. Ихэнх нь өөрсдийн нэр дэвшүүлсэн ширээт лам Баниевын “талд” байсан болохоор шинэ Хамба Ламыг далд үг, явуулгатайгаар угтагсад байсан аж.

Итгэл албан үүрэг гүйцэтгэх шинэ газар болох одоо өөрийнх нь төвлөн суух Тамчийн тал руу өөрийн итгэлт нөхөр Мархил ламхай (Балчин Нимбу Мархилов) болон төрөл төрөгсөдөө дагуулан хөдөллөө. Тэднийг дацанд ойртон ирж байхад үй олон сүсэгтнүүд түүнийг угтан хүлээж байгааг Хамба Лам харлаа.

Итгэлыг ирэх үед түүнийг эсэргүүцэгч лам нар гол хаалганд жатга (гай дуудсан сөрөг эрчмийн үйл) хийжээ. Яг л шинэ Бандид Хамба Лам ирэх мэтийн баяр ёслолын үед энэ хаалгыг нээдэг, харин бусад ердийн өдрүүдэд гурван талын хашлаганы гол хэсэгт нь байдаг явган хаалгыг ашигладаг аж.

Лам нар, банди нар дацантай залгаа өмнө этгээдэд нь байх зургаан баганат гонхлог дагуулан өнгө өнгийн тууз татаж, дуган руу орох хаалга, нэгдүгээр давхар дахь гучин баганат, том, чулуун танхим (танхимын хэмжээ нь 26 х 22 метр, өндөр нь 5 метр гаруй)-ын дотор зай, бас Бандид Хамба Ламын сэнтий зэргийг утас ороож татан чимэглэжээ. Сүмийн хойморт бурхад, залран буй бодисадва нарын хүрэл болон алтадмал дүр, дэргэд нь буддын шашины үйлд холбогдох бусад дүр баримлуудыг байрлуулж, тэдгээрийн өмнө нь урдаас орох гол хаалга руу хандуулан Итгэлын залрах сэнтийг засчээ.

Итгэл Цогчин дуганын хайсанд тулж очсоноо гол хаалгаар морилсонгүй, хашлаганы нэг хэсгийг нь ав гэжээ. Нэг хэсгийг нь авч зай гаргаснаар тэрээр дотогшоо орсон байна. Сүм рүү очихдоо Итгэл эрихээрээ өнөөх туузуудыг тас цохиж, жатганы

муу эрчмийг зайлуулжээ. Ингэснээрээ аливаа төвөгтэй асуудал, зөрчилдөөнийг Бурхны сургаалд зааснаар шийдэх хүн гэдгээ цугласан олонд ойлгуулсан байна.

Дараа нь долоон олбог дээр дээрээс нь давхарлан тавьсан Бандид Хамба Ламын сэнтийд дөхөж очоод олбогуудын дарааллыг солих явцдаа нэг олбог суга татан гаргаж бусад олбогны дээр нь тавьжээ. Энэ нь V Бандид Хамба Лам Данзан Гаван Ешижамсуев /тэрээр 1809 оноос 1839 оны хооронд тэр суудалд заларсан аж /-ын сууж байсан олбог юм байна. Ешижамсуев эрх захирахаас өмнө Дорнод Сибирийн Цонгоолын /Хялганатын/, Тамчийн /Галуут нуурын/ гэх нөлөө бүхий төвлөрсөн хоёр дацангийн хооронд байнгын өрсөлдөөн тавь шахам жил үргэлжилжээ.

1764 онд Буриаддаа эртнийд тооцогдох Цонгоолын дацангийн тэргүүн лам нь Бандид Хамба Лам болсон хэдий ч Тамчийн дацан болон түүнээс хамааралтай дацангууд /Сэлэнгийн зүүн эргийнхэн/ үнэн хэрэгтээ бие даасан байдалтай байсан аж. 1809 онд Эрхүү мужийн захиргааны захирамжаар Ешижамсуевыг бүх дацангуудын Бандид Хамба Ламаар батласнаар буддынхны удирдлага нь Тамчид бүрмөсөн шилжсэн байна.

Ешижамсуевын олбогийг Итгэл шууд сонгон авсан нь хагарал бутралаас сэргийлж, нэгдсэн удирдлагатай байх уламжлалыг үргэлжлүүлнээ гэдгээ лам нарт ойлгуулсан хэрэг.

Тэр үед Тамчид нэг доор хоёр мянга хүртэл лам хувраг хурдаг, гагцхүү шашны төв төдийгүй, урлаг, гар урлал, ном хэвлэл, анагаах ухааны төв байсан ба соёл, эдийн засгийн, зарим талаар улс төрийн ч төв байжээ. Гудмуудын шугаман төлөвлөлт нь бараг л Петербургийн цэргийнхний загвараар хийгдсэн байлаа. Гэхдээ эндэхийн хэмжээс нь өөр байв. Тухайлбал, сууцыг сүмээс хүний дуу хүрэх зайд барьж болно, түүнээс ойр байж болохгүй гэх жишээтэй. Тэнд бодлогогүй баригдсан сууцуудын дэргэд тодорхой бодлогод захируулан найрамж нийцэмжтэй барьсан

хориод сүм сүндэрлэн харагдах нь орчлонгийн бүтэц зохион байгуулалт, Будда нарын ариун газар орны нандин бэлгэ тэмдэг, нарийн төвөгтэй геометрийн дүрс зураг болох мандал бүтээх зарчмын талаархи буддын ойлголтыг санагдуулна. Жижиг сүм, дуганаар хүрээлүүлсэн төв хэсэгт орой нь алтадмал Цогчин дуган / нийт лам нарын хурал хурах төв байр/ дүнхийнэ.

Итгэлыг энд шашины тэргүүнээр ирсэн тэр өдрөөс хориод жилийн өмнө зохиолч, аялагч Владимир Птицын тухайн үед баригдаад удаагүй, эргэн тойронд нь барилга ч баригдаагүй байх үед уг Цогчин дуганыг ийн дүрсэлжээ: “Элс, чулуу ихтэй бөглүү газарт... хятадын уран барилгын загвараар барьсан гурван давхар том цагаан чулуун байшин байна. Дундаа хорло бүхий хоёр бугын дүрсийг бүрэн алтдан чимж дээр нь бэлгэдэл хийсэн нь наранд гялалзна. Буриадын жижигхэн гэрүүд энд тэнд харагдахаас өөр онцлох зүйлгүй нэг л өнгө төрхтэй тал дээрх энэ цагаан байшин нэн томоороо ялгарах ба сүмийг эрхбиш санагдуулна” гэжээ.

Үүнийг нутгийн урчууд барьжээ.

Зөвхөн барьж босгосон дацангийн болон тосгоны орон зайд зохион байгуулалттайгаар оршин буй байдал нь төдийгүй Цогчин дуганынх нь гадна, дотор төрхөөс нь мандал бүтээх эрмэлзэл илт харагддаг. Буддын ёсоор бол сүм ерөөсөө л Орчлонгийн загвар байх ёстой.

Зоя Чойжонова Галсанова: Миний ээж Дарижаб Балдановна 1907 онд төрсөн

“Хамба Лам Итгэл миний эхийн талын өвөг Гармажаан Балдан гэдэг хүний гэрт нь байнга ирдэг, заримдаа хэдэн хоногоор ч зочилдог байлаа. Тэднийд дандаа л хамгийн хүндтэй нэг олбог түүнд бэлэн хүлээж байдаг байсан гэсэн. Миний ээж тэр айлын ганц охин нь болохоор 10 настай түүнийг их л эрхлүүлдэг байсан гэнэ. Хамба Лам Итгэл “Дарижаб: Чиний

амьдрал сайхан болноо, би чиний төлөө залбирна” гэдэг байж. Гармажаан, Бандид Хамба Лам хоёр нэг үеийнхэн байсан ба Итгэлыг Хамба Ламаар сонгоход лам нар, нутгийнхан нь, түүний дотор миний өвөг эцэг Гармажаан Балдан бас хамт явж байжээ.

3.4. Дахин шинэ төрлөө олсон нь

Тамчийн лам нар Итгэлыг яагаад Хамба Лам байлгахыг хүсдэггүй талаар баримт нотлогоо байдаггүй. Тэд Итгэлыг Цонгоолын талын хүн хэмээн үзэж өөрсдийнхөө нөлөөг алдахаас айсан байж болох юм.

Тамчид болсон үйл явдлаас хойш нэг жилийн дараа /зарим баримтаар бол хагас жилийн дараа гэх/ анхны Хамба Лам Дамба Даржа Заяевын хойт дүр нь Итгэл гэдгийг буриадын лам нар олж мэджээ. Гэхдээ энэ талаар түүнийг амьд сэрүүн байхад нь ч ярьцгаадаг байж. Үүнд нотлогоо бий.

Буриадын хамгийн анхны буддын сүм Цонгоолын дацанг үндэслэн буй болгосон хүн нь Заяев мөнөөс мөн. Тэгээд ч “ХХ зууны эхэнд Цонгоолын дацан Буриадын томоохон дацангуудын нэг нь хэвээр байлаа. Тиймээс Бандид-Хамба Ламын суурин төв болох Галуут нуурын дацангаас ч илүүтэй юм”.*

Итгэл бол Заяевын хойт дүр гэдэг нь олонд илэрхий болохоос өмнө Тамчийн дацангийн лам нар “өөрсдийнхөө шугамаар” мэдсэн байв. Хамба Ламаар ирэхийг тэдний эсэргүүцдэгийг гагцхүү үүгээр л тайлбарлаж болно. Тэд өөрсөдтэйгээ өрсөлддөг төвлөрсөн дацанг хүчтэй болгохоос болгоомжилно

“Оросын бурхны шашныг үндэслэгч анхдугаар Хамба Лам Дамба Даржа Заяевын энэ дэлхийд амьдрах хугацаа дуусч байх үед дахин төрлөө олж бидэндээ эргэн ирээч хэмээн буриадын лам нар түүнээс хүссэн юм. Тэр ч тэгнэ хэмээн амласан болохоор тэрхүү мөчийг лам нар хүлээж байжээ. XII Бандид Хамба Ламын албанд Даши Доржи Итгэл очсоныхоо дараа Заяевын хувийн эд зүйлсийг хаана нуусныг тэр хэлж өгчээ. Энэ бүхэн нь шинэ Бандид Хамба Лам анхны хамба ламын хойт дүр гэдгийн эргэлзэшгүй нотлогоо мөн хэмээн Хамба Лам Аюшеев ярьдаг.

Ам дамжсан яриа хийгээд архивын баримтуудыг хооронд нь авцалдуулая. Цонгоолын дацангийн сүсэгтнүүдийн дунд дацангаа хааш нь аваачих вэ хэмээн маргаан үүссэн нь: Сүхээ гол /оросоор Чикой, монголчууд өнөө үед Цөх гол гэдэг орч/. голдрилоо өөрчилснөөр сүм үе үе усанд автах болсон, Хялганатын элс салхинд туугдан ирж овоорох болжээ. Түүнээс гадна Цогчин дуганы хуучин модон барилга муудсанаас шинэ чулуун дуган барих шаардлага тулгарсан байна. Омгийнхон аль 1908 онд их хуралдай хийж шийдвэрээ гаргасан боловч тэр цагаас хойш яг хаана барих талаар хэлцэл маргаан тасарсангүй. 1912 оны хавар /зарим мэдээллээр бол 1911 оны намар гэдэг/ тус дацанд Хамба Лам Итгэл иржээ. Хамба Лам гол дуганд оронгуутаа олбогуудын дотроос нэгийг нь суга татан гаргаж хамгийн дээр нь тавьжээ. Энэ бол Заяевын олбог байлаа. Итгэл гурван өдөр лам нарын хамт хурал хурсныхаа дараа тэднийг дагуулан явж хуучин байрлалаас 12 километрийн зайтай, Хөмөн хаан (Хумэн Хаан) уулын өвөр бэлд дацан барих газрыг зааж өгчээ. Лам нар тэнд газар ухаж эхэлмэгцээ Бандид Хамба Лам Заяевын хэрэглэж байсан хонх, очир тэргүүтнийг олсон байна. Бимба ламын хэлж байгаагаар бол тэндээс домбо, жижигхэн дамар, хонх олсон гэдэг.

Лам нар дацанг шилжүүлэн барих ажилд орлоо. Сүсэгтнүүд ч бүгдээрээ Заяа Хамба (анхдугаар Бандид Хамба Лам Заяев) эргэн ирлээ хэмээн урамтай, баяртай байлаа. Өмнөдийн буриадууд Итгэлт онцгой мэдрэмжтэйгээр татагдсанаар шарын шажин ч бэхэжжээ ./ихэнх судлаачид ийм дүгнэлттэй байдаг ба тэр нь ч үндэслэлгүй юм биш/.

Энэ асуудалд хамааруулалгүйгээр өөр зарим баримт сөхөхөд Заяев 1775 онд тэнгэрт халихаасаа өмнөхөн Хөмөн хаан уулын хормойд бумба (оросоор сосуд буюу бумбэ гэх) оршоохдоо ирээдүйд энэ газарт дацан баригдна гэж хэлсэн гэдэг. Бараг бүтэн хагас зууны өмнө болж өнгөрсөн дээрх үйл явдлуудын шууд бус нотолгоо нь энэ юм.

Зарим судлаачид (жишээ нь Ф.Гармаев) Итгэл шинээр дацан барих газрыг зааж өгөхдөө Заяевын хэрэглэж байсан зүйлс эндээс л олдоно гэж хэлсэн гэдэг.

2012 оны Цагаан сар /2012 он гарах Сагаалха/–ын өмнөхөн нэг бичиг олонд танилцуулсан нь энэ сэдэвтэй зарим талаар холбоотой:

- Манай Хамба Лам Д.Д.Заяев 1702 онд Оцон хаан /Отосон Хаан/ уулын орчим, Сүхээ голын эрэг дээр хүний биеийг олсон юм. 1713 онд өөрийн найз Батор, Бахлай нарын хамт сэм хил давж Монголоор дамжин Төвдөд суралцахаар оджээ. 18 жилийн дараа буюу 1731 онд тэрээр найзуудынхаа хамтаар эх орондоо эргэн ирсэн байна. Хамба Лам маань бидний дунд ердөө 46-хан жил амьдраад 1777 онд Талын Харгана гэх газар нирваанд одсныг бид мэднэ. Харамсалтай нь, Хамба Лам Заяевын талаар гараар бичиж үлдээсэн зүйл тун ч бага байдаг. Тиймээс өнөө Хамба Лам Итгэлын биед хадгалагдан байгаа түүний нууцыг олж тайлах ихээхэн боломж л үлдээд байгаа юм.

Хамба Лам маань Эрэг Бүүрэг (Эргэ Бургэ)–т Балдан Бэрээвэн дацанг барьж эхэлж байсан тэр газар бол Манзушри бодьсадвын ерөөлөөр тодорхойлогдсон газар гэдэг нь баттай тогтоогдсон. Дацангийн барилгыг Хялганат гэдэг газар шилжүүлсний дараа Хамба Лам 146 лам, хуврагаа дагуулан Ранжин Маань (Ранжун Маани) хэмээх газарт очиж Чойжин (Гомбо Махгал буюу оросоор Чойжон)-д мандал өргөжээ. Гомбо сахиус хариуд нь Хамба Ламд түүний өмнөх 10 төрөл амьдрал (тав нь Энэтхэгт, тав нь Төвдөд)–ынх нь талаар хэлж өгсөн аж.

Заяев эхлээд алт, мөнгө, орос цэмбэ, хадаг, мандал Далай ламд барьж өөрийнхөө өмнөх төрлүүдийн талаар хэлж өгөхийг гуйжээ. Далай лам: энэ лам бол агуу их хувилгаан хүн байна, харин өмнөх амьдралынхаа тухайд бол сургаал сахигчид хандах нь зүйтэй гэж зөвлөжээ. Тиймээс тэрээр Банчин Ламд мөнгө, шүр,хадаг, мандал барьж мөн хүсэлтээ тавихад нь: энэ лам

өмнөх төрөлдөө буддын сургаалын онол, практикийг туйлын сайтар эзэмшсэн, агуу их йогч байжээ, том хувилгаан гэдэг нь эргэлзээгүй гэсэн байна. Банчин Лам ч мөн л Гомбо сахиусанд хандахыг зөвлөжээ.

Яв явсаар эцэст нь тэдний хэлснээр хийхэд Гомбо сахиусан (Махгал): урьд насны арван төрөлд нь лам байсан байна гээд бүгдийг нь хэлж өгсөн гэдэг.

Ийнхүү Итгэлын дамжин төрөл олсоор ирсэн 10 амьдралыг дурьдваас:

1. Од Цэрэн (Гажад Чогдон, “нэн хүнд сорилуудыг даван туулсан”, III Будда Гашибын шавь нь байсан, бүтээлүүдэд нь тайлбар сэлт хийж, бас өөрийнхөө ойлголтоор нэмэлт оруулсан)
2. Сэнгэ гүүш (оросоор орчуулбал “Арслан мэт орчуулагч”), IV Будда Шагжамунигийн дэргэд шавилан байсан
3. Гэлэг Бал Самбуу
4. Хамба Лам
5. Гунгаа Одчин
6. Дхармава (Дхармапала, Дхармавара буюу өөрөөр хэлбэл Номч)
7. Өсвөр Нар (Юное Солнце)
8. Инээмсэглэгч Дорж
9. Лодой Чогдан
10. Хайдав Ням
11. Буриадад хувилан төрсөн нь:
12. Бандид Хамба Лам Дамба Даржа Заяев
13. XII Бандид Хамба Лам Дашдорж Итгэл

Бэрээвэн дацангийн өтгөс лам нарын хэлж байгаагаар бол Хамба Лам Заяев манай ард олны дотор Буддын сургаалыг хадгалж хамгаалахад туслахыг Таван Хааны эздэд зарлиглажээ. Энэ Таван Хаадын оршдог газар нь Хөгт Хаан (Хугтэ Хаана),

Шагт Хаан (Шагтэ Хаана), Хөмөн Хаан (Хумун Хаана), Бүрэн Хаан (Бурин Хаана), Бар Хаан (Бар Хаана)-ы уулс гэдэг.

Түнхин /Тунки/ болон Охь/ Оки/ –ийн буддистууд нас барсан нутгийнхныхаа тухайд, яагаад ч юм, тэд үхээгүй, харин Цаанахи (Санага)-д хонь хариулахаар явсан гэж өнөөг хүртэл их л итгэлтэй ярьцгаадаг. Цаанахи газар гэдэг нь Буддын Диваажин байдаг баруун зүг, буддистуудын очихыг эрмэлздэг тэр газар ажээ. Барууны энэ газрыг Хамба Лам Цаанахи гэж нэрлэсний учир нь Цаана /буюу алсад буй газар/ гэсэн үг юм. Өнөө үед хамгийн хүн ам олонтой буриадын тосгоныг Цаанахи /Санага/ гэж нэрлэсэн нь ч тохиолдлын хэрэг бишээ.

Заяев, Итгэл хоёр Хамба Ламын хооронд садан төрлийн холбоо буй эсэхийг мэдэх гэж оролдсоор бид Буриадын Оронго, Янгажин хэмээх хоёр газар ороны нэртэй тулгарсан юм. Будда Шагжамуни өөрийнхөө Анхны сургаалыг айлдсан Сарнатхад Ороонго нэрт модод байдаг бөгөөд түүний салаа мөчрүүд нь гол ишээ гайхалтай сониноор ороож ургадаг аж. Янгажины дацан байгаа Янгажин нэрт газарт Хамба Лам Итгэл өөрийнхөө эрдэнэт лагшинг бидэнд үлдээсэн бөгөөд энэ газрын нэр нь самгарди хэлний Ямбажин гэдэгтэй адил сонсогддог. Будда Шагжамуни Ямбажин хэмээх газарт сургаалынхаа Хүрдийг гурав дахь удаагаа эргүүлж дүрстийн болон хоосон чанарын орнууд хоорондоо шүтэн барилдлагатай тухай үзлээ буй болгожээ. Эдгээрээс үндэслэвэл Хамба Лам Заяев арван хоёр дахь удаадаа эргэн залрахын тулд дээрх газруудыг урьдаас бэлтгэн, ариусгажээ гэж бодогдоно.

Дөч хүрсэн хүмүүсийн бэлгэ билгүүн сэргэж, амьдралын утга учрыг ойлгох болдог. Харамсалтай нь, хүмүүний төрлийг хаана олох нь түүнээс өөрөөс нь огтхон ч хамаардаггүй, харин сансарын хүрднээ ээлжит удаагаа хүрэлцэн ирэх нь түүний эцэг, эхээс бүрэн хамаардаг. Тиймээс зарим ухаалаг хүмүүс хаанаас Буддын ертөнц рүү явах нь дээр вэ хэмээн бүхий л

амьдралынхаа туршид эрэлхийлж байдаг. Манай агуу их Хамба Лам Заяев маань нирванд одоодоо Талын Харгана хэмээх энэ Дэлхийн хамгийн сайхан газруудын нэгийг сонгон авчээ. Хялганатын дацангийн лам нарын дотроос түүний хамгийн ойрын, итгэлтэй шавь нар нь өнөөг хүртэл энэ газрыг сахин хамгаалсаар, сансар огторгуйд дүүлэн одох буддын талбар гэмээр энэ ариун газрыг бидэнд ямагт мартуулалгүй сануулж байхын тулд гайхамшгийг бас үзүүлсээр байдаг. Сүүлд Тамчийн дацангийн Хамба Лам нар хаврын тэргүүн сарын 18-ны өдөр Цагаан Дара -Эхийг уншицгаасан билээ.

Хамба Лам Заяев хувь хүнийхээ хувьд ямар үүрэг гүйцэтгэсэн, ямар ач тустай хүн байсныг ойлгохын тулд маргаж хэлэлцэх, батлаж нотлох хэрэг бидэнд тулгарнаа. Харин Хамба Лам Итгэл энэ бүхнийг дэргэдээс тольдон харж, ажиглаж байгаа билээ...*

Хамба Лам Аюшеев юуны өмнө сүсэгтэн нартаа хандан өгүүлэхдээ тэдний хувьд бүрэн илэрхий байгаа зарим асуудлыг дэлгэрүүлэн тайлбарлаагүй ба тэд чухамдаа юу мэдэх ёстойг ч хэлээгүй юм. Үүнийг хаанаас олж мэдсэн байхав? Буддын “Даши Чойнхорлин” их сургуулийн багш Жаргал Дугданов 2005 оны 3-р сарын 30-нд Иволгийн дацангийн Диваажин дуганд хадгалагдаж байдаг мянга мянган хуучин бичмэлүүдийн дотроос энэ тухай модон бараар хэвлэсэн нэг багавтар бичгийг олсон байдаг. Цаашид судлан үзвээс төвөд хэлээр бичсэн тэрхүү хуучин бичмэлийг 1973 онд XIX Бандид Хамба Лам Жамбал Доржи Гомбоев (1963 оноос 1980 оны хооронд хамбын суудалд суусан) олж, шинэчлэн тодруулаад Агын дацанд дахин хэвлэсэн нь тодорхой болсон юм.

Лам нарын үзэж байгаагаар энэ бичгийг бичсэн хүн нь Итгэл аж. Тэрээр өөрийнхөө өмнөх бүх 11 төрөл амьдралыг мэддэг байсан ба энэ бичигт өөрийнхөө олон дахин төрөл олж байсан тухай бичсэн байна.

Өгүүлж буй үйл явдлын өрнөл нь гэвэл: Заяев байхдаа ямар байдалтай амьдарч байсан, Төвдөд сурч байсан, сахиусан /сургаалыг хамгаалагч/-даа хандаж өмнөх амьдралуудынхаа талаар асууж хариу авсан тухай юм.

“Хэрэв энэ номд ганц ч гэсэн мадагтай зүйл орсон бол хамбатан хэзээ ч мөнхийн лагшинг бүтээхгүй байх байлаа” гэж Хамба Лам Аюшеев хэлсэн юм.*

Одоо харин “сансарт дүүлэн одох буддын талбар” болох ариун газрын тухай өгүүлсү. Заяев нирванд одоходоо сонгон авсан Талын Харганын хөндий хэмээх газрын нэг онцлог нь Байгал нуур болон Галуут нуурыг яг онож чиглэсэн байдгийг лам нар: салхины эзэн эрчмийнхээ хамтаар саадгүй зорчиж байхад туйлын тохиромжтой гэж тайлбарладаг. Энэ нь салхины хоолой газар болохоор агаар нь тун ч ариухан, бас сэрүүн байдаг. Нирван гэдгийг үгчлэн орчуулбал: “гал дарангуйлагдах газар”, буюу “өглөөний сэрүүн тунгалгийн газар” гэсэн үг.

Хамба Лам Аюшеев: “Хялганатын, магадгүй бусад дацангуудынх ч оролцож байгаа байх, лам нар бодит биеэ орхин одсоныхоо дараа аль нэг газарт дахин төрөл олохоос татгалзаж, энэ ариун газрыг сахин хамгаална гэсэн тангараг өргөсөн ер бусын тохиолдол өнөөдөр буддизмын түүхнээ гараад байна. Одоогоор тэнгэрээс үүнийг сахин хамгаалж байгаа лам нар ердийн хүмүүстэй шууд харьцсан тохиолдол цөөнгүй байна. Жишээ нь, тэд лам хувцастайгаа зам дээр гарч ирэх буюу жагсаалаар явцгааж машиныг зогсоох, эсвэл өөр хэлбэрээр хүмүүст анхааруулга өгч байлаа. Энд зовлонгийн далайд олон жилээр амьдарна гэдэг чухамдаа юу болохыг энэ лам нар биднээс илүү ойлгожээ гэж миний хувьд боддог. Ямартай ч тэд энэ газрын онцлогийг бидэнд сануулж байхын тулд энд үлджээ. Буддын сургаалыг энд түгээсэн төдийгүй, эргэж эндээ төрөл олохоо шавь нартаа амалсан Заяевын буддизмын агуу их суу билгийн төлөөнөө үнэнчээр зүтгэж, гайхамшигтай гавъяаг тэд

байгуулж байгаа хэрэг мөн... Тэрхүү газар орныг хэд хэдэн гайхал төрүүлэм шинж чанарт үндэслэн Заяев сонгон авчээ, харин бусад шинжүүдийг нь бид уйгагүй эрж олох л үлдээд байна” гэж хэлсэн юм.

Буддын сургаалын нотолгоо болгож 2008 онд Талын Харганад суварга босгосон юм. “Тиймээс одоо буддын шашинтнууд цаашдаа нэр төртэйгээр тэнгэрт хальж, Диваажинд ч юмуу, бодсадва нарын сүнс нь очдог бусад газарт очихын тулд огторгуйд дүүлэн одох талбар болох Газар дэлхийн энэ сайхан нутагт ирж, мөргөж залбирч болох нь ээ” гэж Аюшеев хэлсэн билээ.

Босгосон суварга шүтээнүүдийг Хамба Лам Аюшеев өндөрт улалзах гэрлэн дохиололтой зүйрлэн хэлэхдээ: энэхүү галт гэрлээр баримжаалан бурхад газар дэлхийд бууж ирнэ, үүргээ гүйцэтгэж буй лам нар бол агаарын хөлгийн хөдөлгөөн зохицуулагч гэсэн үг, дараа нь тэнгэр төрөлтнүүд буцаж нисэн одно, харин тэдний хойноос дагахын тулд будын шашинтан хүн өөрийнхөө хөлгийг буй болгох ёстой. Газар дэлхийд буддын шашинтан байхын учир утга нь ерөөсөө л энэ – гэсэн юм.

Сүүлчийн хоёр удаагийн төрөл арилжилтад “75”-ын тоо дөрвөн удаа давтагдсан явдалд олны анхаарлыг хандуулсан юм. Тухайлбал: Заяев 1702 онд төрж, 75 нас сүүдрийг зооглоод тэнгэрт одоходоо эргэж ирнэ гэж шавь нартаа амласан. Заяевыг бурхан болсноос хойш 75 жилийн дараа Итгэл мэндэлсэн. Тэрээр мөн 75 наслаж, дахиад 75 жилийн дараа эргэн ирж байна. Ийнхүү 75-ын тоо дөрвөн удаа давтагдсан тухайд Аюшеев хэлэхдээ:

- Манай Хамба лам нар яагаад чухамхүү 75 насладгийн учрыг бид удаан эрсээн. Хөнгөмсөг бодоход 75-ын тоо Буддын сургаалтай ямар ч холбоогүй мэт санагдна. Гэтэл Бандид Хамба Лам Дамба Даржа Заяев болон Дашдорж Итгэл нарын 75 нас нь Гомбо сахиустай холбоотой болохыг саяхан бид олж мэдлээ.

Балдан Бэрээвэн болон Анины дацанг хамгаалагч Гомбо сахиус 75 хүнээр хүрээлүүлсэн байдаг. Тэдгээр нэг бүр нь бараа бологчоо дагуулсан Гомбо сахиусны тааллаар Хамба ламыг хамгаалж, жил бүр түүнд туслаж байдаг. Хамба Лам Дамба Даржа Заяев Гомбо сахиустай онцгой сайн холбоотой байсныг бид Итгэлын бичсэн дуртгалын номоос мэдэх билээ. Итгэл Хамбатан бичихдээ: тэрээр Дамба Даржа Заяевын дүрд байхдаа өмнөх дүрүүдээ мэдэхийн тулд Далай Лам болон Банчин Богдын заавраар 146 шавиа дагуулаад Ранжун Арьяабал хэмээх газарт очиж Гомбо сахиуст бараалхаж байсан, Гомбо сахиус ч гайхалтай сайхнаар хүсэлтийг нь хүлээн авч, Энэтхэг Түвдэд амьдарч байсан өмнөх 10 төрлийнх нь талаар товч яриад 10 нэрсийг ч бүгдийг нь хэлж өгчээ. Харин Хамба Лам Итгэл өмнөх арван төрлийнхөө үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй мэдэх болсон нь ямар учиртайг одоохондоо олж мэдээгүй. Анины дацан болон Хялганатын Балдан Бэрээвэн дацан хоёроос л Гомбо сахиусны тусламжаар үүнийг мэдэх боломжтой гэж бодож байна.”* гэсэн билээ.

Зарим хүмүүсийн хэлж байгаагаар бол Итгэл өөрийнхөө дараахи гурван төрлийг мэднэ гэж амьд сэрүүндээ хэлж байсан гэдэг.

Итгэл өөрийнхөө талаар ямар үнэнийг олж мэдсэнийг тодорхой өгүүлье хэмээвээс 2003 оны 4-р сард Хамба Лам Аюушеев Бүх Оросын Бурхны шашинтны Чуулганд айлдахдаа: Итгэл гэгээрлийг олох замдаа сахиуснууд, ядам бурхад, бодьсадва, будда, Очирдарь Лам нартай уулзаж, туслалцаа авдаг байсан . Тиймээс эдүгээ цагийнхан Хамба Лам Итгэлын “буянтай гурван байдал”-ыг нэгэн зэрэг нүдээр үзэж болох юм. Нэгдүгээрт, амьд сэрүүндээ бурхадтай уулзаж заавар зөвлөгөө авч байсныхаа буянаар цагт нь бидэндээ хадгалан үлдээж чадсан ариун лагшинд нь бараалхах, хоёрдугаарт, Итгэл өнөө ч гэсэн бясалгах дадлынхаа үйлийг үргэлжлүүлж, ингэснээрээ хамаг амьтанд тусыг үзүүлж, буян хураасаар байгаа тэр байдлыг

нь үзэх, гуравдугаарт, ухаан төгөлдөр хүний хувьд ирээдүйд Будда Шагжамунигийн төвшинд хүрэхийн тулд сайн үйлийнхээ үрийг хадгалахын үүднээс сансарын хүрднээс салж, будда нарын хойноос одсон Итгэлын өөрийнх нь орших, илрэх хэлбэрийг үзэх боломж – гэсэн юм.

Жамьян Еши Лам “Прояснение порядка распространения подобно совершению чуда”) нэртэй номдоо олонхи буддын шашинтнуудын хүсэл, мөрөөдлийг илэрхийлэн бичихдээ: хэрвээ та нар өмнөх төрлүүддээ хэрхэн амьдарч байсан хийгээд Багшийнхаа үйлсийг олж мэдээд бүгдийг нь түүнд дарааллынх нь дагуу хэлж өгөх аваас хүсэл бүхэн тань биелнэ гэжээ.

Хамба Лам Итгэл өөрийнхөө өмнөх 11 төрлийг бүгдийг нь бичиж үлдээсэн нь түүнийг тооцон биднийг сайн үйлээ бүтээж байг гэсэн зорилготой. Энэтхэгт амьдарч асан эхний таван төрлийг, ялангуяа Будда Шагжамуниас өмнөх хамгийн эхний төрлийг хэн ч олж мэдэж чадахгүй гэдгийг Хамба Ламтан сайн мэдэж байжээ.

Хамба Лам Итгэлын гаргасан дарааллаас үзэхэд Түүнээс илүү алдар нэртэй нь буддын ертөнцөд үгүй гэдгийг баттай хэлж болох байна. Гуравдахь Будда буюу Будда Гашибын үеийн анхныхаа байдлыг Хамба Лам мэддэг байсан ба түүнээс хойш олон жил өнгөрчээ.

Хоёрдахь төрөлдөө Сэнгэ гүүш байхдаа Хамба Лам маань Будда Шагжамунид түүний сургаал түгээгүй “харанхуй газарт” сургаалыг нь дэлгэрүүлнэ хэмээн тангараглажээ.

Будда Шагжамунийн өмнө түүний тангараг өргөснийг Дээрхийн Гэгээнтэн VII Далай Лам Жавзан Лувсан Галсан Жамц 1720-иод оны үед Дамба Даржа Заяевын хүсэлтээр баталгаажуулж өгсөн байна*.

Түүний дахин дахин төрөл олсоор ирсэн, одоо мэдэгдэж байгаа гинжин хэлхээг харгалзан үзвэл Итгэлын сүүлчийн

амьдралын тайлагдаагүй нууцуудын олонхи нь хэмжээ далайц, ач холбогдлын хувьд өөр болж ирдэг. Жишээ нь, Итгэл сүүлчийн удаа хүний биеийг олсон нь шууд л таван настайгаас эхэлдэг тухай таамаглал байна. Заяев төрснийхөө дараа нэг л жил өнгөрөхөд шууд 7 настай болсон нь нэгэнт тодорхой болсон. Эсвэл малчин хүү Итгэл лам нарт очих гэж газрын мухарт явганаар явж байсан нь Заяев ч гэсэн 11 настайдаа 13 настай хүү Батор, Бахлай нарын хамтаар хонь хариулдаг байхдаа сурахын тулд алсад одож байсан гэх аман яриатай утга нэг бус уу. Найз нартайгаа ярилцаж тохироод эцэг эхчүүддээ дуулгаснаар тэд 1713 онд Богдын Хүрээ явжээ. Дамба Даржа Заяев хүүхэд байхдаа Төвдөд суралцана гэж эцэг эхдээ байнга хэлдэг байсан тухай домог яриа ч бий. Түүнд нь итгэхгүй болохоор гомдож гоморхон хээр хөдөө гүйгээд явчихдаг байж. Түүний эцэг эх, садан төрлийнхнөөс Төвд гэдэг газар байдаг тухай хэн нь ч мэддэггүй байхад шүү.

Заяевын төрсөн нутагт лам хуврагууд хоёр жилийн туршид усны эх ундрага эрж ихээхэн бэрхшээл туулсаар 2008 оны зун арайхийж олжээ. Дашрамд өгүүлэхэд, үүнийг ч бас тайлбарлаж болох талтай: Энэ газар нутгийн ивээгч эзэн нь Очирваань бодьсатва бөгөөд хамаг нууцын эзэн нь нь ч мөн тэр . Олсон ус нь хадны ангалаас бургилах ба цайвар өнгөтэй аж. Усны өнгөөс гадна Оцон хаан (Отосон хаан) уулын оргил нь арслангийн толгойтой, оргилоос доошоо уруудах бэл хад нь арслангийн биетэй төстэй болохоор нь Аюшеев энэ булгийг “Эрслэнгийн сүү” гэж нэрлэдэг ба Бодьсатвын адис ерөөлт газар усны хүчээр Заяев Лхаст хүрч, буцаж ирж, дараа нь Москвагаар аялж эргэн ирж чадсан гэж үздэг. Дээрх олдсон ус, Итгэлын төрсөн нутгийн худгийн ус хоёрыг харьцуулан судлаж үзэхэд мөнгөний агууламжийн байдлаараа ижил байлаа (энэ тухай дараа дэлгэрэнгүй өгүүлэмз).

Намтар хийгээд бусад бодит байдлуудаас гадна өөр бас зүйлс ч буй. Тухайлбал: Итгэл Хамбын мөнхөд суралцсаар байсан

тухай “Даши Чойнхорлин” их сургуулийн буддын гүн ухааны багш, гэвш лам Гомбо Раднаев өмнө бидний ярилцаж байснаар яг онож хэлсэн “мэдэхийн хүслэн”-г нь тодорхойлон хэлэхдээ: Арван нэг дэх төрөл дээрээ Заяев байхдаа тэрээр маш хичээнгүй, шаргуу зүтгэлтэй сурагч байсан. Олон шинжлэх ухааныг уйгагүй судлан дадуулснаар тэр гол таван ухааныг дээд хэмжээгээр мэддэг болжээ. Энэ бол учир зүйн ухаан, чанадыг танин мэдэх, дундач байх зам, орчлонгийн тухай сургаал, шашинтнуудын сахилга журмын асуудал энэ тав юм. Төгсөлтийн шалгалтын үеэр Заяев гойдын сайн мэдлэгтэйгээс гадна гүн ухааны ном хаялцахад гарамгай байснаараа өндөр боловсролтой лам нарын гайхлыг төрүүлж байжээ. Тийнхүү тэрээр гавж цол хүртсэн ба VII Далай Лам Галсан Жамц түүнд “Номын Хан” цол хүртээжээ. Тэр үед буддизмын талаар Орос оронд мэддэггүй байсан ба Заяев Оростоо хамгийн анхных нь өндөр боловсорсон лам байлаа.

Хамба Лам Итгэл байнга өөрийгөө боловсруулан төгөлдөржүүлсээр байсан гэж гэвш лам Раднаев хэлдэг.

- “Мэдэхийн хүслэн” болсон чанар нь түүний ухамсарт өндөр төвшинд хөгжжээ. Түүний өөрийнх нь намтар болон өмнөх төрлүүдийнх нь намтраас үзвэл гэгээнтнүүдийн л мэддэг ихээхэн зүйлсийг тэрээр мэддэг байж гэж бид зоригтой хэлж болохоор байна. Жамбал Данзан “Магтуу” номдоо Хамба Лам Итгэл олон дахин төрлийг олох явцдаа дээрх чанарынхаа ачаар ямар хэмжээний эрдэм мэдлэг олж авсаныг бичжээ. Энэтхэгт тэрээр хоёр дахь төрөл болох Сэнгэ гүүш байхдаа Доржедан гэдэг газарт Будда Шагжамуниас Нууц дандарын сургаал сонсчээ. Гуравдахь төрөл Гэлэг Бал Санбу байхдаа Винайн ёс (Винайн аймаг сав хэмээхэд ёс суртахууны тухай сургаал, дүрэм журам, дэг жаяг, сахилыг заасан байдаг)–ыг барьж байж. Зургаа дахь төрөлдөө Номч байхдаа анагаах ухаан, вед зэрэг шинжлэх ухааны мэдлэгийг эзэмшсэн байлаа* гэжээ.

Ердийн төвшинд бол хүн ихийг мэдэх тусмаа улам их мэдлэг рүү туйлбартайгаар, эргэлт буцалтгүй зүтгэх байдлаар илэрдэгээр Итгэлын эрдэм мэдлэг рүү тэмүүлдэг Номч хүний шинж тайлбарлагдна гэж Буддын бурхан урлаач Александр Кочаров үзэж байна. Тэрээр Иволгийн дацангаас олдсон Итгэлын олон төрлүүдийн тухай бичгээс гадна Итгэлын зургаа дахь төрлийн талаархи материалыг бүрнээр нь судлаж байгаа хүн. Тухайлбал, дээр дурьдсан олон төрлүүд бүгд дахин тэмдэглэгдсэнээс гадна түүний зургаа дахид нь Номын багшийн талаар дурссан байдаг “Тун-раб” зэрэглэлийн бичиг байна.

- Тэнд бичсэнээс үзвэл Номч маань эхлээд ердийн шинжлэх ухаануудыг судлаад дараа нь бүхнийг болгоогч агуу их шидийг олсон байна. Тиймээс түүнд Номч буюу өөрөөр хэлбэл Бурхны номын багшийн алдрыг тусгайлан олгосон хэрэг. Хоёр дахь энэ бичгийг Тенби Нима Чогле Намгьял гэдэг хүн Дашлхүмбэ (Таши Лунпо) хийдэд бичсэн байх ба Бандид Хамба Ламыг төрлийг нь зааж хувилгаан хэмээн хүлээн зөвшөөрөгдмөгц сүсэгтнүүдэд баримт нотолгоо, бас шүтэн бишрэх учиртайг нь мэдүүлэхийн тулд бичсэн бололтой... Манай эриний XII зууны эхэн үеийн Абхаядаттын (ганц л насны хугацаанд дээдийн танин барихуйд хүрч буддизмын зорилгыг хангасан хүмүүс буюу Их шидтэнгүүдийн амьдралын талаархи товч түүх) нэгэн самгарди бичигт Номчийн тухай хоёр тохиолдлыг дурьджээ. Эхнийх нь: Энэтхэгийн Викрамасура гэдэг газарт Бурхны номыг сэтгэл гарган удаан хугацаанд судалсан нэгэн бярман амьдарч байж.Тэрээр йогчтой нэг удаа тааралдаад: Бурхны номыг би удаан судаллаа, гэсэн хэдий ч амьдрал дээр хэрэглэх чадвартай болсонгүй, иймд надад туслаач хэмээв. Йогч түүнийг адислаад: бүхий сургаалын гол агуулгыг нь оюун ухаандаа нэтгэхийг зөвлөсөн байна. Ингэснээр Номч бясалгал хийж, Их Мутарлагын* (Махамудра) шидийг олжээ. Насныхаа эцэст тэрээр Дагинасын оронд* бодит биеэрээ очсон байна. Адислагдсан гэгээнтнүүдийн /посвящённые мастера / талаархи өөрийнхөө номд Улрич

Шродер бичихдээ: энэ Номч бол төрөлхийн бярман бөгөөд Энэтхэгийн зүүн хойт хэсэгт байх Викрамашила хэмээх буддын нэртэй сүмд суралцсан гэжээ.

Хоёр дахь түүх бол Энэтхэгийн Бодьнагар гэх газрын нэгэн эрдэмтэй лам Сургаалыг судалж, бас сурталчилдаг хэдий ч өөрөө дадуулдаггүй тухай өгүүлдэг. Нас ахих тутам “Бурхан багштай би ер нь уулзаж чадахгүй гэж үү?” гэх бодол орж ирэх болжээ. Нэг удаа Дагина /Дакини/ зүүдэнд нь орж, “Би чиний оюун санааны чинь найз нөхөр байна” гэж хэлжээ. Тэгснээ бодитой хэлбэрт орж, адислаад зөвлөмж өгчээ. Номч таван жилийн турш тарни уншиж, Дагинын зөвлөмжийг даган дадуулжээ. Тэгснээр түүний бодит бие нь найман настай хүүхдийнх шиг болж хамаг хүмүүсийн гайхшийг баржээ. Тэрээр танин барихуйн ухаанд суралцан хүрч, улмаар эцэстээ Дагинасын оронд очсон гэдэг.

Энд нэг л хүний тухай яриад байна уу, хоёр өөр хүний тухай юу гэдгийг бид одоохондоо мэдэхгүй. Данжуурын Дандарын хэсэгт энэ Номчийн бичсэн хоёр зүйл байдаг.

84 Их шидтэний амьдралын талаар Төвдөд хэвлэсэн бүтээлд хэдэн зураг бий. Анхны Номчийг йогчийн байдлаар, хоёр дахийг нь санваартны байдлаар дүрсэлжээ. Мөн энэ Багшийн дүр Их шидтэнүүдэд зориулж хийсэн ханын зураг, номын зураг, зурмалуудад дээрх хоёр хэлбэрээрээ үзэгддэг. Тэрээр чухамдаа дандарын йогийг дадуулсны ачаар л танин барьж, нэрд гарсан болохоор Номчийг йогчийн дүрээр үзүүлэх нь зүйд нийцнэ гэж надад санагддаг.

Очирт хөлгөний бурхдын дүрийг бүтээхэд Буддын ариун гэгээн үзлийг танин барихад дадуулалт нь шийдвэрлэх нөлөөтэй байдаг, бас авралын дандарын бүх арга барилуудын үүсгэл болсон Очирдарь бурхны дүр тэргүүн зэргийн голлох үүрэгтэй. Кагью, Сакья болон Гэлүгван ёсны сургуулиуд бурхдын дүрийг бүтээхдээ хамгийн дээд хэсэгт нь арга барил хийгээд билгүүн

ухааныг бэлгэдсэн очир, хонхыг гартаа барьсан хөх өнгийн Буддаг дүрсэлдэг, харин дандарын Дэнсэлгүй йогийн сударт бол хамтрагчтайгаа Яв-Юм байрлалд байгаагаар үзүүлдэг. Нинмава ёсонд түүнийг Гүндсамбуу /Самантабхадра/ гэдэг боловч мөн чанар нь өөрчлөгддөггүй. Буддын дандарын бүтээлүүдэд эдгээр нэрсээр Аз жаргал, Бэлгэ билгүүн, Нигүүлсэл, Бүхнийг болгоох чадвараар дүүрэн Буддын ухааны анхдагч ариун мөн чанарыг илэрхийлэн нэрлэдэг. Номын бие болон тод гэрэл гэсэн ойлголтууд энэ чанарт шууд хамааралтай. Номчийн түүхээс үзвэл тэрээр йогч, Дагинатай уулзаж байсан гэх нь Дордже Чан бололтой. Буддизмын нууц сургаалд бичсэнээр амжилттай дадуулахын тулд Лам, Ядам, Дагина гэсэн гурван тулгуур хэрэгтэй гэдэг. Гэгээн Номчийн амьдралд ч гэсэн энэ гурван үндэс гол үүрэг гүйцэтгэжээ.

Бандид Хамба Лам Итгэл өөрийнхөө Илгээлтэд: Очирдар (мон) буюу Важрадхаратай уулзахад бэрхшээлтэй тухай бичсэн байдаг нь ихээхэн утга учиртай. Гэгээрэлд хүрэхийн тулд Багшийг эрж олж, түүний Будда болохыг нь танин мэдэж, хамаг амьтны тусын тулд гэх Очирдарын уг чанарыг танин барихын үүднээс суурь зарчим хэрэгтэй гэдгийг хэлээд байгаа юм. Үүнийг хийхэд тун ч хүнд, гэхдээ энэ хүндэд нь л хамаг аз жаргал, эрх чөлөөг олохын учир нь байгаа юм. Энэтхэг, Төвд, Буриадад дахин дахин төрлийг олсон үргэлжлэх шугамын арван хоёр дахь нь болох Дашдорж Итгэл маань Их шидтэн Номч болон бусад дээрх багш нарын оюун санааны ололтыг бидэнд хүргэн адислаж, оюун санааны хувьд гавъяа байгуулсан хүн*

Итгэлын 12 удаа төрөл олсон тухай номыг олсны дараа лам нар түүний өмнөх төрлүүддээ амьдарч байсан газруудаар аялж, ёс жаягийг гүйцэтгэн, бас мэдээлэл олсоор ирлээ. Энэтхэгийн хойт хэсэг болон Балба руу явсан судалгааны багийг хэрэгцээт зүйлсээр нь хангаж Итгэлын хүрээлэн ч гэсэн эрэл хайгуул хийсээр байлаа. Итгэлын хоёр дахь төрөл болох Сэнгэ гүүшийн суваргыг оллоо. Дарааллаар нь тоолоход арван хоёр дахь энэ

суварга хойт зүг рүү хандсанаас гадна бусдаасаа ихэд ялгаатай ажээ. Төвдийн ноёны хүү, ихэд боловсорсон йогч, зургаа дахь төрөл болох Номч буддын их сургуульд багшилж байсныг гэрчлэх ул мөрийг оллоо.

“Дашичойнхорлин” буддын их сургуулийн орлогч захирал Жаргал Дугдановын олсон бичгийг Итгэлын Хүрээлэнгийн хүсэлтээр 2005 оны 5-р сард Дуйнхор дуганын ширээт лам Буда, Бүх Оросын Бурхны шашны уламжлалт Чуулганы хэвлэлийн нарийн бичгийн дарга Борис Дондуков нар орос хэлэнд орчуулсан юм.

Их Багшийн дээд төрөл бүрт өргөх залбирал

(Дамба Даржа Заяев болон Дашдорж Итгэлын
Дээд төрөл бүрт өргөх залбирал)

Ом Свасти,
Дээдийн сайн үйлийн буянаар олсон лагшинд нь
Багшийн эрхэм сургаалыг тодоор айлдсан үгт нь
Алив бүхнийг хязгааргүй таньж чадах ухаанд нь
Бусдыг араасаа ямагт дагуулах хүчтэй Багшид
Залбиран мөргөмү!

Хүнд хүчрийг туулан хураасан буян нь далай мэт арвин
Хүрч чадсан төгөлдөр мэргэн ухааны хаялга их
Сайн бүхнийг хураан төгөлдөржүүлсний учир
Сайвар одсоны төвшинд хүрэх нь дамжиггүй!

Ариун нандины үрийг хоёронтаа хурааж чадсан,
Ачит Багшийн сургаал, дадлыг үе шат бүрээр төгс эзэмшсэн,
Буддын дөрвөн газарт од болон гялалзсан,
Бузгай Дээдийн шалгуурыг ажрал үгүй Давагч /Хажид Чогдон/
таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Нууц Тарнийн Сургаалаар ид шидийг олсон, Гүүш таны өлмийд
Сөгдөн мөргөмү!
Бага залуу наснаасаа хүсэл тачаалыг таягдан хаяж,
Баяр цэнгэл хэмээх сансарын хүлээснээс ангижирч, Винайн ёсыг
дээдлэгч,
Эрхэмлэх санваараа чухалчлан, эрдмийн зэрэгт хүрсэн
Гэлэг Бал Самбу танаа
Залбиран мөргөмү!

Харьшгүй мэргэн ухаантан, хачин сайхан сэтгэлтэн
Хайр, нигүүлсэл хоёроор бялхаж байдаг буянтан
Амгалан жаргаланг хүртээх арга эвийн эзэн
Аяа Бэлгэ билгүүн төгс Хамба Ламынхаа өлмийд
Сөгдөн мөргөмү!

Үргэлжидийн хийгээд үргэлжид бусын гоц үзэгдлийг танигч,
Үзэгдэл бүхний хоосон чанартайг ч, үнэхээрийн тэгээд бусдыг ч
таньсан
Асар дээдийн, ариун нандин зүрх сэтгэлийнхээ хүчээр Сургаалыг
түгээгч
Гунгаа Одчин таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Ведын Сургаалыг мэдэж чадсанаар шидийг хүртэгч,
Орчлонгийн бүхий л шинжлэх ухааныг эзэмшигч,
Төвдийн сурвалжит гэр бүлээс гаралтай,
Түмнээ алдаршсан Номч таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Болж бүтэхгүйгээ далдлагч хоосон багийг хэзээ ч зүүлгүй
Бодь сэтгэлээр эмчлэн бусдад туслагч,
Гурван сав, Дандарын дөрвөн аймгийг бүрэн судласан
Гундал үгүй Гийгүүлэгч Идэр Нар таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Өглөгийн барамидын төгс төгөлдөрт цуцал үгүй хүрсэн,
Өрөөл бусдад учирсан зовлон зүдүүр, дутагдал гачигдлыг нь
Өр зүрхнийхээ хайр, өөр юу л хэрэгтэй бүхнээр арилгагч
Инээмсэглэгч Дорж таны өлмийд
Сөгдөн мөргөмүү!

Орчлон ертөнцөд сэтгэл зүрх бүхнээрээ агуу тусыг үзүүлэгч

Оршихуйн мөн чанарыг бүрэн танин баригч
Ядам сахиус, тэнгэрүүдтэй нүүр тулан уулзагч
Лодой Чогдон таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Ямагт сансарын хамаг амьтныг энэрэн нигүүлсэснээрээ
Ялж Төгс Нөгчсөний Сургаалыг арван зүгт түгээж
Дээдийн амар амгаланд хүрэх боломжийг олгогч
Хайдав Ним таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Ачит Бурхны Сургаал хүрээгүй газарт залран ирж,
Ариун долоон эрдэнэсийг сүсэгтнүүдэд хүртээн,
Ашид мөнхийн ухаанаараа улс орноо алдаршуулсан,
Амьд бүхний чигийг заагч Хамба Лам нартаа
Залбиран мөргөмү!

Аз жаргал, сайн сайхныг ямагт түгээгч Агуу их Гэрэл гэгээ,
Арвин их буянт сэтгэлийн уурхай,
Агуу Их Хамбатан гэдэг нь өнөө ч бидэнд тодорхой,
Даан ч содон гайхамшгийг бүтээгч их хүчтэн,
Дамба Даржа Заяев – Их Багштан таны өлмийд
Сөгдөн мөргөмү!

Энэхүү залбирал мөргөл, сайн үйлийн хүчээр
Судар, дандарыг судлан дадуулснаар,
Цэцэн билиг, арга ухааныг эзэмшиснээр
Бүхнийг болгоохуйн хязгаарт
Бүх амьд төрөлтөн хүрмүй!

Тэнгэр, сахиусууд, Багш нарын адистэд ерөөлөөр,
Тэр л Сургаалыг хамгаалан зогсогчдын хүчин чадлаар
Харанхуй бүдүүлэг цагт амьд бүхнийг манлайлагсаддаа
итгэснээр

Агуу Их Хамба Ламтан нарын маань лянхуа мэт өлмий бат оршиж,
Хамаг үйлс бүтээл нь үржин дэлгэрэх болно.

Будда заларсан цагаас эхлээд Хайдав Нимыг хүртэлх Их Багш – Хамба Лам нарын төрөл дамжин ирсэн шугам болон үндсэн гол Багш нарт зориулсан залбирлыг ой ухаанд хадгалан үлдээхийн учир Цэцэн билигт, Агуу их Хувилгаан Маарамба лам Жамбал Данзан тодруулан үйлдэв.

3.5. Итгэлт Хамба Санкт Петербургт

Буддын тооллоор 1913 оны эхэн үеийг Итгэл Оросын эзэнт гүрний нийслэлд угтжээ.

“1913 оны 2-р сарын 4-нд шавь Гатап Бадмаев, сурвалжлагч - нарийн бичгийн дарга Бадма Тудупов болон хэдэн лам, түшмэд нарын хамтаар М.П.Романовынхны гэр бүлийн хаанчлалын 300 жилийн ойн баярт оролцохоор Санкт-Петербург явжээ. 2-р сарын 13-нд Санкт-Петербургт ирэхэд нь 2-р сарын 14-нд шашны департаментын захирал хийгээд түшмэдүүд ихэд найрсаг сайхнаар хүлээн авч, 2-р сарын 16-нд Дотоод хэргийн сайдтай, 2-р сарын 17-нд ерөнхий профессортой, 2-р сарын 18-нд орлогч сайдтай тус тус уулзаж, 2-р сарын 19-нд буддын шинэ дацанд мөргөл үйлджээ. Энд Монголоос ирсэн хошой Чин Ван Ханддорж бусад төлөөлөгч нарын хамт, хоёр торгууд, Бандид Хамба Лам Итгэл хамтрагч нарынхаа хамт, тэнд байсан эрдэмтэд бүгд мөргөл үйлдсэн байна*.

Буриадын төлөөлөгч нарын дотор шашныхнаас гадна энгийн иргэд, түшмэдүүд оролцсон юм. Засгийн газарт Итгэлыг халуун дотноор хүлээн авчээ. Тэрээр Санкт-Петербургийн Гунзэчойнэй дацанд очиж, эзэн хааны болон түүний гэр бүлийнхний эрүүл энх, сайн сайхны төлөө бат оршихын ерөөл өргөсөн байна.

Сүмийн дотоод заслын ажил дуусаагүй байсан тул тахилын ширээг үүдний өрөөнд байрлуулж, бурхан номын үйлийг гүйцэтгэж байлаа. Хэрвээ Хамба Лам Итгэл ирээгүйсэн бол дацангийн заслыг арай өөрөөр хийх байжээ. Түүний зэрэгцээ үүдний хэсгийг улаан хийгээд шар торгоор чимж, бас туг дарцаг хатгажээ. Оросын далбаанаас гадна энд мөн соёмбо үсэгтэй Монголын далбаа, дугираг нарнаас цацран буй зургаан улаан, зургаан хар-хөх өнгийн цацрагаар цацан цагаан уулын энгэрт тоглон буй үл гэр домгийн хоёр цасан арслангуудын дүрс бүхий

Төвдийн далбаа ч бас байлаа. Эдгээр далбаанууд өөрчлөлтийн бэлгэдэл болж байлаа

Итгэлын шавь Буджап Будаев бичихдээ: “Энэ арга хэмжээнд Монголоос Ханд Ван тэргүүтэй төлөөлөгчид, хоёр торгууд, халимаг, Бандид Хамба Лам Итгэл нөхдийнхөө хамтаар бас эрдэмтэд оролцож мөргөл үйлдсэн” гэжээ. Өнөө үеийнхэнд дурсгал болох тэрхүү арга хэмжээнд дээр өгүүлсэн Чин Ван Ханддоржоос гадна бас Оросын алдарт жуулчин, Төв Азийг судлаач Петр Козлов эхнэртэйгээ, Гэгээтийн дацангийн ширээт лам П.Жигмитов, халимагийн ноён бага Тундутов, питерийн энэ байгууламжийг санаачлагч, Итгэлтай зарим асуудлаар санаа нэгдэгч Агван Доржиев, сүүлдээ нэрд гарсан буриадын эрдэмтэн, улс төрийн зүтгэлтнүүд – Цыбен Жамцарано, Базар Барадин, Элбек-Доржи Ринчино нар оролцсон байна.

Эдгээр хүмүүс тэр үед эзэнт гүрний хааны ёслолд оролцож буй ч хаа холын колони маягийн жижиг үндэстнүүдийн төлөөлөгчид болохоор хоорондоо нэгдэлтэй байлгүй ч яахав.

Хоёрдугаар сарын 21-ний өглөө 8 цагт цайзаас 21 удаа их буугаар буудаж Романовынхны бүлийн 300 жилийн ойн сүрлэг баяр эхэлснийг зарлан тунхаглажээ.

Заяев Оросын эзэнт гүрнийг цэцэглэн мандаж байх үед Агуу Их Екатеринатай уулзаж байсан бол Заяевын хойт дүр болох нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн Итгэл Катеринагийн дөч хүү Николай II-хаантай Оросын эзэнт гүрний хувь заяа хаашаа вэ гэх цаг үед уулзжээ.

...Баярын арга хэмжээний үеэр Итгэл “шашины болон эгэл” бүх буриадуудын нэрийн өмнөөс эзэн хаанд талархал илэрхийлсэн ба 2-р сарын 22-ноос 24-ний өдрүүдэд гол арга хэмжээнүүдэд, тухайлбал, уучлалын бүтэн сайн өдөр баяр дуусч Өвлийн ордны танхимуудад 1200 зочин цугларсан “асар том баярын үдийн зоог”* ч оролцжээ.

3-р сарын 19-нд Александровын ордонд буриадын төлөөлөгчдийг эзэн хаан тусад нь хүлээн авахад тэд хаанд шашны шүтээн болсон эд зүлсийг хадгийн хамт өргөн барьсан байна. Чухам ямар эд зүйлс гэдгийг саяхан болтол хэн ч мэдэхгүй байсан ба Итгэлээс хаанд болон гэр бүлд нь өгсөн хишиг төд удалгүй гарсан нийгмийн хямралын явцад алга болсон байх гэж үзэж байлаа. Харин 2002 онд Итгэл эргэж ирсэн нь эдгээр зүйлс олдоход гайхалтай сайхан дэм өгсөн юм.

Мөнхүү 2002 онд Оросын Шинжлэх ухааны Академийн Сибирийн салбарын Буриадын шинжлэх ухааны төв Итгэлын шавь Будажап Будаевын бичсэн Итгэлын намтрыг Бандид Хамба Лам Аюшеевт шилжүүлэн өгсөн байна. Тэр үед нь Итгэлын Хүрээлэнгийн хүсэлтээр намтарыг хэл судлалын ухааны доктор Дарима Санжина орос хэлэнд орчуулсан юм. Тийм ч их юм бичигдээгүй тэр бичигт Романовынхны гэр бүлийн 300 жилийн ойн баярт оролцохоор Итгэл явсан тухай гайхалтай олон газарт тэмдэглэн бичсэн байна.

Намтараас дурьдвал: “3-р сарын 19-нд агуу их хаантанд Өвөр Байгалын буддын шүтлэгтнүүдийн нэрийн өмнөөс буддын нандин шүтээн болох таваг, домбо, үнэт алтан эдлэл долоо, цагаан мөнгөн эд зүйлс, хадаг өргөсөн. Мөн хатан –ээж, агуу их хатантан, удам залгах хаан хөвгүүн, дөрвөн хүүхэд – бүгд найман хэсэг бэлэг өргөн барьсан. Эрхэмсэг хаантантай хийсэн уулзалтад Хамба Ламтай хамт Цүүгэлийн дацангийн ширээт лам, Гатап Бадмаевын шавь, ах дүү Гомбо болон Сокто Бадмажапов* нар оролцсон. Агуу их хаантан бэлгийг хүлээн аваад төлөөлөгч нарт талархалаа илэрхийлэн “Миний баярласан, талархсаныг буддын шүтлэгт нийт буриадуудад дамжуулаарай, би буриадуудад ямагт сайны ерөөлийг онцгойлон хүсч байна!” гэж хэлсэн гэжээ.

Хаантны гэр бүлд өргөн барьсан буриадуудын бэлгийн талаар мэдээ олдсоныг мэдмэгцээ Итгэлын хүрээлэн тэдгээрийг эрж

эхэлсэн юм. 2003 онд энэ ажилд Светлана Черникова /Санкт-Петербургийн их сургууль/-г татан оролцуулав. Тэрээр өөрийнхөө зүгээс Санкт-Петербург дахь ОШУА-ийн Агуу Их Петрийн нэрэмжит угсаатны зүй болон хүн судлалын музей /Кунсткамер/-н захирал асан Чунер Таксамиг туслаач хэмээн хүссэн боловч үр дүн гарсангүй.

Оросын угсаатны зүйн музей /Санкт-Петербург/-н ажилтан Елизавета Нератова:

Шинжилгээний ажил гүйцэтгэхээр Буриадын түүхийн музей руу томилолтоор явахыг надад санал болгосон юм. Миний хувьд явах боломжгүй байсан боловч сүүл рүүгээ нөхцөл байдал өөрчлөгдөж би Улаан-Үд рүү /2010 онд / гарлаа. Нэг удаа ажил тарж байхад музейн ажилтнууд Иволгины дацан руу явъя гэснээр би очиж Хамба Лам Итгэлыг нүдээр үзэж, залбирсан. Би ихэд гайхсан боловч түүнээс өөр онцын зүйл мэдрэгдсэнгүй.

Петербургт буцаж ирснийхээ дараа ажилдаа ороод Хамба Лам Итгэл тэргүүтэй буддын шашинтны төлөөлөгчид Николай II хаан болон түүний гэр бүлийнхэнд бэлэг өгсөн талаар 1913 оны 3-р сарын 19-нд ноён Ухтомскийн бичсэн бичгийг оллоо. Бүртгэлээс нь үзвэл тэдгээр нь манай музейн эзэн хааны цуглуулгад байхаар барахгүй би тэр зүйлсийн дэргэдүүр арав гаруй жилийн туршид л яваад байгаа хэрэг. Тэднийг халимагуудын өгсөн бэлэг хэмээн үздэг байлаа. Бас тэднийг 1913 оны 3-р сарын 29-нд нөгөө л Эспер Ухтомский Эзэн хааны гэрээс манай музейд шилжүүлэн өгсөн бичгийг ч тэр дороо л оллоо. Ингэснээр үнэндээ “халимгуудын бэлэг” маань Итгэлын тэргүүлсэн буриадын төлөөлөгчдийн бэлэг болохын нотолгоо олдсон” гэж тэрээр хэлсэн юм.

Найман хэсэг бэлгээс долоо нь олдсон.

Николай II хаанд мөнгөн таваг дээр бэхэлсэн алтан шармал ариун бумба бэлэглэсний зах ирмэгээр нь дацангуудын 35

бэлгэдэл дүрсийг сийлж, бас бумбын дөрвөн талд нь дөрвөн дацангийн дүрсийг босоо байдлаар хийсэн аж. Таваг дээр нь: “Дорнод Сибирийн 35 дацангаас . 1613 – 1913” гэж сийлжээ.

Хаан хөвгүүн Алексейд Жүгдэрнамжил бурхан /Ушнишавиджая/-ы дүрийг алтдаж, бас өнгөт шилээр хээ угалз тавин чимэглэсэн, мөн ёроол дээр нь: “Удам залгамжлагч хаан хөвгүүн танаа. Мөнгөн Будда. Түвшин жаргалыг ивээгч Жүгдэрнамжил, зөвхөн дэлхийн агуу хаадад хамаарах долоон үнэт эрдэнэсийг мөнгөөр дүрслэн урлав” гэсэн бичигтэй мөнгөн тосгуур дээр долоон үнэт эрдэнэсийг тавьж бэлэглэжээ.

Александра Федоровнад: “Улсын их хатан танаа. Буян хишигийг ивээгч Цагаан Дара-Эхийг мөнгөөр урлав.” Гэсэн бичигтэй Цагаан Дара-Эх бурхны мөнгөн дүрийг өргөн барьжээ.

Дөрвөн гүнжтэнд Цагаан Дара-Эх бурхны дөрвөн ижилхэн, арай багавтар дүрийг бэлэглэсэн ба бэлэг бүр дээр нь Ольга, Татьяна, Мария, Анастасия хэмээн тус тусынх нь нэрийг бичжээ.

Их хатан Мария Федоровнад Аничковын ордонд өргөн барьсан Ногоон Дара-Эх бурхны дүр одоогоор олдоогүй байна.

Ямартай ч эдгээр уран бүтээлүүдийг Долнуурт /Өвөрмонголын/ хийсэн байх магадлалтай бөгөөд хосгүй эд байжээ.

Буриадын буддын шашинтнуудын өргөн барьсан бэлэг Оросын Угсаатны зүйн музейн сан хөмрөгт хадгалагдаж байхдаа лавлах материалд нь яагаад “халимагуудын бэлэг” болж тусгагдсан нь ойлгомжгүй юм. Эзэн хаанд өргөн барьсан бэлгийг Оросын музейн угсаатны зүйн хэсэгт шилжүүлэн өгдөг байсан бөгөөд хожмоо бие даасан музей болсон юм.

2010 оны намар Тусгай хадгаламжийн газар болох Питерт номын зохиогч болон Итгэлын Хүрээлэнгийн төлөөлөгч В.Хачатурова нар ирж бэлгийн зүйлсийн гэрэл зургийг аваад,

дараа нь зургуудаа Хамба Лам Аюшеевт танилцуулсан юм. Удалгүй 2011 оны 1-р сард Тусгай хадгаламжийн газарт Ганжуур лам* морилон ирсэн. Тэрээр энд анх удаа ирж байгаа хүн. Гэтэл тэрээр Итгэл Хамба Ламтанаас их эзэн хаанд өргөн барьсан буриадын бэлгүүд хадгалагдаж байгаа газар руу хэнээр ч заалгалгүй шууд яваад очсонд дагалдан яваа хүмүүс ихэд гайхаж билээ.

Эдгээр нь онцгой ач холбогдолтой зүйлс гэдэг нь мэдээж. Тэдний ихэнхийг нь өнгөрсөн зуунд нээж үзсэн хүн үгүй, ёс жаягийн дагуу тэдгээрийн дотор нь хийсэн буддын онцлог бүхий ариун нандин зүйлс 1913 онд хийсэн тэр газраа л байв.

2011 оны 5-р сарын 10-нд XXIV Бандид Хамба Лам Аюшеев Оросын угсаатны зүйн музейн Гантиг танхимд тухайн бэлгүүдтэй үзэж танилцсан юм.

1913 оныг эргэн саная. Николай II хариу болгож Буриадын бүх буддын шашинтнууд, бүх ард түмэнд талархал илэрхийлж, хамгийн сайн сайхан бүхнийг хүссэн байдаг. Мөн энэ уулзалтан дээрээ эзэн хаан “онцгой хүчин чармайлт гаргасны төлөө” ариун Станиславын гуравдугаар зэргийн одонгоор Итгэлыг шагнажээ. Хэдхэн сарын дараа мөнхүү 1913 оны 12-р сард Итгэлыг Ариун Станиславын хоёрдугаар зэргийн одонгоор шагнасан байна. Итгэлын гавъяаг эзэн хаан үнэлсэн нь нэгдүгээрт, агуу их ламтаны хэр далайцтай хүн болохыг, хоёрдугаарт, тэрээр төр, иргэний аль ч хэргээс зайлсхийдэггүйн илэрхийлэл болой.

Сүүлчийн эзэн хааныг устгасан, Итгэлын энэ ертөнцөөс халин одсон хоёрын хоорондын цаг хугацааны ялгаа нь сүүлд Екатеринбургийн орчмоос хааны нэрний үлдэцийг олсон, Буриадын нутагт Итгэлыг 75 жил хадгалсан газрыг олсон хоёрын ялгаатай бараг л дүйж очдог.

Итгэлын эргэн ирсэнд хэрхэн хандах болон Хуучин Коптяковын зам доороос юу олдсон тухай асуудлаас үүдэлтэй

олны дундахи элдэв мэтгэлцээн, шинэ хуучин үлгэр домог ярианууд нь Николай II хааныг сүлдлэн тахиж хүлээн зөвшөөрснөөр, мөн соёл иргэншлийн түүхэнд байгаагүй онцгой байдлаар Итгэл эргэж ирсэн хоёроор дууссан юм.

Энэ тухайд бол доцент, Оросын ШУА-ийн Оросын түүхийн хүрээлэнгийн шинжлэх ухааны тэргүүлэх ажилтан Евгений Пчелов: “Тус орны түүх болох оюун санааны амьдралд энэ хоёр хүн бүхэл бүтэн нэг үеийг эзэлж байсан гэмээр. Аль алиных нь буцаж ирсэн нь бараг л давхцсан шахуу. 2000 онд улсын эзэн Николай II-хааныг Орос даяар албан ёсоор алдаршуулах ёслолыг шашны уламжлалаар хийсэн, харин 2002 онд Хамба Лам Итгэл дэлхийн бүх буддын шашинтнуудын өмнө өөрийн биеэр гарч ирсэн. Сүсэгтэй хүнд энэ бол тохиолдлын гэж үзэх боломжгүй гэж бодогддог” гэж хэлсэн юм.

Зарим судлаачдын үзэж байгаагаар Оросын сүүлчийн эзэн хаан Итгэл хоёрын анхны уулзалт 1891 онд болсон бололтой. Тэд биетэйгээ нүүр тулан уулзсан байж болох тэр үед Николай Романов хаан ширээнд залраагүй, Итгэлыг ч гэсэн Хамба Ламаар сонгох хүртэл хориод жилийн хугацаа байсан хэрэг. Николай бол хаан ширээг залгамжлах албан ёсны эрхтэй л хүн, харин Итгэл өөрийнхөө хүсэлтээр лам нарын бүрэлдэхүүнээс халагдсан нэгэн байж. Николай өмнө зүгт /Европ, Египет, Энэтхэг, Зүүн Өмнөд Ази/ яваад гэртээ буцаж ирэхдээ Японы эзэн хааны үе залгамжлагчийг илдэдсэн, Николай Александрович болон түүний гэр бүлийнхнийг буриадын лам нар эмчилсэн гээд л санаа сэтгэл хямраасан нилээд юм сонсож иржээ.

Чойзон Доржо Иролтуев /Итгэлын өмнөх Хамба Лам/ 1896 онд Петербургт Николай II хааны хамаатан ахад чонын уушгийг амжилттай суулгасан тухай Буриад даяар мэдэх болсон явдал домог болон тархаж байлаа. Сибириэр дамжин Красноярск хүртэл өртөөчлөн явах ламын зам тэр үед зөвхөн Енисейн эрэг

хүрээд зогсдог байжээ гэх зэргээр ам дамжин яригддаг зүйлсийн ихэнх нь үнэн бодитод тулгуурладаг байлаа. Зарим нь ч ихээхэн хийсвэр, уран сэтгэмж оруулсан зүйлс байдаг байв. Тухайлбал:

Иролтуевт итгэж агуу их ноёнтныг эмчлүүлэхээсээ өмнө түүнийг туршин шалгасан гэдэг. Тэрээр судсыг нь бариад петербургийн эмч нарын оношийг хэлдэг байсан ба нэг удаа түүнд гүрвэлзсэн дээс бариулаад /зэргэлдээх өрөөнд байгаа тотьтой уясан дээс/ асуухад энэ дээсний үзүүрт шувуу байна гэж яг хэлсэн гэдэг.

“Улсын эзэн хаан Николай II хаан 1890-1891 онуудад дорно зүг аялсан нь” гэдэг ном бичиж хэвлүүлсэн ноён Эспер Ухтомский эрхэм аялагчийг дагаж явсан хэдий ч Буриадын нутагт түүнийг Итгэлтой уулзсан тухай бичээгүй байдаг. Гэхдээ энэ нь хаан ширээг залгамжлагч Итгэл хоёр уулзаж ярилцаагүй гэсэн үг хараахан бишээ. Учир нь, Ацагатын дацанд /өөр он жилүүдэд Шулутын, Шолотын, Курбины, Челутаевын гэх зэргээр янз янзаар нэрлэгдэж байсан/ болон Өвөр Байгалын аль ч газар нутагт хаан ширээг залгамжлагч маань зогсож, ард түмэнтэй уулзан ярилцаж байсан нь олонтаа. Николай Александровичаас сүлбээрэн зүү, ханцуйны товч, тамхины сав, янжуурын хайрцаг, цаг гэх мэтийн бэлэг сэлт авч байсан хүмүүсийг л Ухтомский нэрсээр нь бичсэн байдаг. Заримдаа бас аль нэг тосгон, газар орны тэргүүн нь болох хүмүүс хаан ширээг залгамжлагчид бэлэг өгсөн бол нэрсийг нь бичжээ. Тиймээс харахад жирийн л нэг лам Итгэл, тэгэхдээ бүр түүнд ямар нэг бэлэг сэлт өргөн бариагүй болохоор Ухтомскийн анхааралд өртөх нь үгүй биз.

Хаан ширээ залгамжлагч лам хоёр уулзсан эсэх, юуны тухай ярьсан байж болох, түүний үзсэн сонссон нь хаан ширээ залгамжлагчид хэрхэн нөлөөлж болох гээд л домог таамаглал тоймгүй олон. Өвөр Байгалын Петровск (Петровск-Забайкальск) –д Итгэл ламтан хаан ширээг залгамжлагчтай уулзсан ба немец хэлээр ярилцаж, Казанийн их сургуулийг төгсгөсөн, Итгэлын

нутгийн хүн, Эрдэни Зодбоев орчуулсан тухай нутгийн оршин суугчдын гэрчлэлийг бичиж тэмдэглэн авсан нь Итгэл Хамбын Хүрээлэнд байдаг.

Итгэл Буриаддаа буцаж ирснийхээ дараа Хойт-Америкийн Нэгдсэн Улсын элчин ноён Рокхиллийг Тамчийн дацанд эхнэрийнх нь хамт хүлээн авч уулзжээ. Чин улс задран бутарч, Петербургт баяр тэмдэглэхээс өмнөхөн 1913 оны 1-р сарын 23-нд XIII Далай Лам Төвдийн тусгаар тогтнолын Тунхаглал гаргасан, үүнээс арай өмнөхөн газар сайгүй үндэсний чөлөөлөх хөдөлгөөн өрнөж нуран унаж буй дэглэмээс Монголыг чөлөөлөн 1911 оны 12-р сарын 29-нд ламын шашны тэргүүн VIII Богд гэгээнийг хаан ширээнд өргөмжилсөн билээ.

Аль 1912 оны 12-р сард Өвөр Байгалын мужийн цэргийн захиргаанаас Итгэлт Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөхийн зэрэгцээ “Өргөөгийн хутагт Монголын хаан ширээнд заларсанд” нь баяр хүргэх төлөөлөгчдийг илгээх зөвшөөрөл өгчээ. Итгэл Петербургээс буцаж ирмэгцээ шууд л Жигжит Галсанов, Намдак Дылыков, Линхово Санжиев, Шагжи Ринчинов, Бальчин Нимбу Мархилов нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг хэрэгцээний зүйлсээр ханган илгээжээ. Тэд буддын шашины тэргүүн Жавзандамба хутагтад талархлын бичиг өргөн барьсан байна.

Дорнод Сибирийн буддын шашны төлөөлөгчдийг халуун дотноор хүлээн авсан ба баяр хүргэж ирсэн төлөөлөгч нэг бүрийг хүндэт цол, төрөл бүрийн одонгуудаар шагнажээ. Итгэл хожмоо шагнагдагсадын нэрсийг танилцуулж, Өвөр Байгалын мужийн цэргийн захирагчаас “Монголын одонгуудыг хүлээн авч, зүүж байх талаар анхаарал тавьж, зөвшөөрөн туслах”-ыг хүсч байжээ. Итгэлын энэ захидал хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд даруй 1915 онд л Өргөөгийн хутагтын шагнасан одонгуудыг зүүхийг дээрээс зөвшөөрсөн тухай ажилтнууддаа мэдэгдэж байжээ.

Бандид Хамба Ламыг өөрийг нь монголчууд бас шагнажээ. 1913 оны 6-р сард “анхаарал тавьсанд талархсаны тэмдэг болгож” Өргөөгийн Хутагт Жавзандамба түүнд “Шашиныг хүндлэгч” цол олгож, I зэргийн “Эрдэнийн Очир” одонгоор шагнажээ. Энэ тухай Орос улсад 1913 оны 11-р сард албан ёсоор мэдэгджээ. Шагнал одон харин сүүлд хаашаа алга болчихсон нь тодорхойгүй. 2011 оны 9-р сард Монголын Засгийн Газрын тэргүүн Сүхбаатарын Батболд Итгэлт мөргөхөөр Иволгин дацанд ирэхдээ 98 жилийн дараа тэрхүү шагналыг дахин шинээр баяр ёслолын байдалтайгаар олгосон юм.

Хүн төрөлхтний түүхэнд тиймэрхүү зүйл тохиож байсан удаагүй. 84 жилийн өмнө тэнгэрт хальсан хүнийг гадаад улсын төрийн тэргүүн шагнасан юм. Нэхэн шагнасан хэрэг бишээ, харин Итгэл үр ач нартаа үлдээсэн ариун лагшинг нь амьд сэрүүн гэдгийг хүлээн зөвшөөрч одонг нь энгэрт нь зүүж өгсөн билээ. Монголын Засгийн газрын тогтоолд: **“Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд жинтэй хувь нэмэр оруулсан гавъяаг нь үнэлж Буриадын Бандид Хамба Даши Доржо (Дашдорж .ред) Итгэлыг Монголын хаан Богд Жавзандамба төр-шашны дээд шагнал болох I зэргийн Эрдэнийн Очир одонгоор шагнасаныг дурсан тэмдэглэхийн сацуу эдүгээ хүндэтгэл үзүүлж Эрдэнийн Очир одонг Эрхэм Дээд Хамбатаны Мөнхийн Лагшинд хүртээсүгэй. Монгол Улсын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд, 2011 оны 9-р сарын 14, Улаан-Үд, Иволгины дацан”** гэжээ. Одонг монгол урчууд урьдын загвар ёсоор нь сэргээн үйлдсэн юм.

...Тэр он жилүүдэд Итгэл Тамчийн дацанг өргөтгөж, аравнайлан бас Жэлгэний дацанг нээжээ. Тэрээр, үнэн хэрэгтээ, “одоогийнхоор бол Буриадын боловсролын, соёлын, эрүүл мэндийн яамдын сайдын үүргийг хамтруулан гүйцэтгэж байжээ” Хамба Лам Итгэл болон Буриадын тэргүүлэх сэхээтнүүд хүн ардыг гэгээрүүлэхийн тулд сургалтын байгууллагуудыг байгуулахын чухлыг хэлэлцдэг байж. Нийт Буриадын

нийгэмлэгийн ерөнхий хорооны дөрөвдүгээр их хурал /дарга нь Д.Итгэл/-ын тогтоолд: “Дээд-Үд хотод онцлог хөтөлбөр бүхий багш нарын тусгай семинарыг нээх талаар хөөцөлдөх..., Эрхүүгийн их сургуулийг нээх тухай санааг дэмжих..., Бандид Хамба Лам Итгэлын нэр дээр хандив цуглуулж, Эрхүүгийн их сургуулийн дэргэд буриадын гэгээрлийн асуудлыг боловсруулах, сурах бичиг, гарын авлага зохиох үүрэгтэй буриадын багш нарын дамжаадыг байгуулж чадсан байх” гэж заажээ. Их сургууль барих, байгуулахад буян үйлдэж, хандив өргөсөн лам нарын нэрсийн жагсаалт хадгалагдан үлджээ.

Хамба Лам Итгэл Оросын эзэн хааны Газарзүйн нийгэмлэгийн жинхэнэ гишүүн / гишүүний татвар төлж байсан тухай баримт бий/ байж, дорныг судлаач Щербатский, Руднев, Котвич /тэдэнтэй харилцаж байсан зарим бичгүүд нь архивт буй/ нартай харилцаа холбоотой байсан ба профессор Позднеевын саналыг хүлээн авч 1916 оны наймдугаар сард дацангуудынхаа дэргэд орос хэл судлах сургууль байгуулах шийдвэрийг бүх ширээт лам нарт өгч байсан байна.

Дэлхийн Нэгдүгээр дайн эхлэхийн өмнөхөн Петербургт баригдаж буй сүмийг барьж дуусгахад туслуулахаар эзэнт гүрний нийслэл рүү лам нарыг томилон явуулж байжээ.

Дацангуудын хэвлэх газрыг зохион байгуулан өргөтгөж, хэвлэлийн үйл хэрэгт багагүй хүч хөдөлмөр зарцуулан, лам нарын хүсэлтээр ном ч бичиж байлаа.

1912 оны 5-р сард тэрээр бүх дацангуудад бурхан шашны судрыг дөрөв дөрвөн хувь хэвлэх шийдвэр өгч байсны нэг хувь нь Санкт Петербургт очих ёстой байлаа. Жирийн иргэдэд зориулсан номыг ч гэсэн дацангууд идэвхтэй хэвлэсээр байв.

Оросын ШУА-ын Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэнгийн Сурун-Ханда Сыртыповагийн үзэж байгаагаар бол “1914 оны байдлаар буриадын 40 дацанд байгаа

буддын зохиол бүтээлүүд хамгийн багаар бодоход 450 мянган боть (дунджаар нэг нь 400 орчим хуудастай) байжээ. Энэ тоонд, мэдээж, хэдэн зуун мянган боть буддын судар бичиг болон соёлын үнэт бүтээлүүдийг агуулан байсан хэдэн мянган суварга / залхаан цээрлүүлэлтийн үед тэднийг бүгдийг устгасан /–д байсан зүйлс ороогүй”. ажээ.

Янгажины дацанг тонон дээрэмдэж, дараа нь эвдлэн сүйтгэж, тоос тортог болгосны дараа бурхны судар талаар нэг тархаж, тал хөндий цайрч байсан гэдэг.

Академич Щербатскийн архивт эдүгээ хадгалагдаж байгаа илтгэх хуудсанд: “Гагцхүү Агын дацанд л гэхэд ЗСБНА Буриад - Монгол улсдаа хамгийн том нь гэгдэх тиймэрхүү модон бар зуун мянга хүртэл тоогоор байлаа. Цүүгэлийн, Галуут нуурын болон бусад дацангуудад ч хэдэн арван мянга байсан юм. Тэдгээрийн ихэнх хэсэг нь биш юмаа гэхэд нэлээд хэсэг нь өөрийнхөө шашин шүтлэгийн агуулгатай биш, харин төвд, монголын янз бүрийн сэдвүүдийг хэвлэхэд зориулсан хэв байсныг зайлшгүй тэмдэглэвэл зохилтой. Тухайлбал: төвдийн шинжлэх ухаан, гүн ухаан, уран зохиол, урлагийн нэн ховор хувь тэдгээрийн дотор байсан юм. Төвдөд өөрт нь ч байхгүй болсон ганц хувь гар бичмэл ч байж байх жишээтэй. ..ЗСБНХУ-ын ШУА-ийн хэсэг нөхөд 1931 онд ЗСБНА Буриад-Монгол улсын Агын аймагт ажиллаад ирэхдээ нэгэн харамсалтай баримтыг дурьдаж байсан нь: цагдан сэргийлэх байгууллагад ирсэн төвдийн модон барын болон гар бичмэлүүдийг районы албан газруудын цонхны зай завсрыг наах болон бие засах газарт ашиглаж байсан гэх явдал юм. Гар бичмэлүүд хийгээд модон барын бүтээлүүдийг үе үе шоголоос нь гаргаж хог дээр аваачиж овоолон хаях буюу шатаадаг байжээ, учир нь орон нутгийн ажилтнуудад тэдгээр бичээсүүд нь биш харин үнэ хаялцан зарагддагаараа шоголууд нь хэрэгтэй байсан аж.”

3.6. Итгэлт хамба дайны үед

Хамба Лам Итгэл бусад лам нарын хамтаар Бүрэн хаан ууланд ёс гүйцэтгэхээр иржээ. Уулын оройд гарахад тахил өргөсөн 108 хонины толгой байгааг Итгэл олж харжээ.

“Энэ яасан харгис хэрцгий уул гээч вэ, зуун найман амьд амьтны амийг тасласан байдаг. Толгой идэх гээд байдаг юм бол, май, минийхийг ид” хэмээн Итгэл хонины толгойнуудыг доош нь тал тал руу шидлэж байхыг уншлага уншихаар зэхэж байсан лам нар хараад балмагдсан гэдэг. Тэр цагаас хойш энэ ууланд зөвхөн цагаан идээгээр тахил өргөх болжээ.

Энэ явдал Дэлхийн нэгдүгээр дайны он жилүүдэд болсон гэж ардын дунд яригддаг. Пурбодоржо Гармаевын эцэг Дава Самбу гэдэг лам дээр дурьдсан Бүрэн хаан ууланд очсон лам нарын дунд байсан тул нүдээр үзсэнийгээ хүүдээ ярьж байсныг нь хожим Борис Бальжив Пурбодоржоос сонссон байдаг.

Доржиев Бимба ламын хэлж байгаагаар бол Бандид Хамба Ламын албанд Итгэл очсоны дараахан, дайн эхлэхээс өмнө энэ түүх болсон гэдэг. Тэгээд ч сүсэгтнүүд тэр үед Итгэлыг зүг зүг рүү хонины толгой шидлэн байгааг харчихаад энэ хүн хамба ламын суудалд удахгүй байхаа гэгцгээсэн аж. Гэхдээ цаашид зөвхөн тэнд төдийгүй, Өвөр Байгал болон Байгал орчмын бусад газруудад ч гэсэн амьтны амь таслаж тахил өргөхийг бүрмөсөн хориглож чадсан байна.

Дээд –Үд. 1915 оны 1-р сарын 25:

“Өвөр Байгалын болон Эрхүү мужуудын нийт буриад, хамниган нарт.

Дэлхийн түүхнээ гараагүй агуу их дайн Европ даяар дэгдлээ. Хамарч буй хүрээгээрээ ч, учруулж буй хохирлоороо ч, хэрэглэж

буй аргаараа ч урьд өмнө сонсож дуулж байгаагүй догшин ширүүн тулаан болж байна.

Энэ дэлхийд тийм их цус, нулимс асгарч, тийм их орь дуу тавьж, хараал зүхэл болж, тулааны талбарт энэ удаагийнх шиг тийм олон хүн үхэж үрэгдэж байсан нь үгүй ээ.

Газар дэлхий дээгүүр, улс гүрэн, хүн ардын дээгүүр хүмүүст зовлон таригч аймшигт, бузар ухаан, мэдрэмж үхлийн хар үүл болон нөмөрсөөр даруй долоон сар өнгөрлөө. Бүхэл бүтэн долоон сар өнгөрсөн хэдий ч цус урсгасан энэ ухаангүй үйлдэл, аймшигт эзэрхийлэл дуусах шинж алга, харин ч өдрөөс өдөрт, цагаас цагт улам бүр өргөжин шинэ шинэ районуудыг хамарсаар байна. Европод ч, Азид ч, Африкад ч, Өмнөд Америкийн эрэгт ч хүний хайран амь нас, эрх, эрх чөлөөг мунхагаар үрж байна...

Буриадууд, хамниганчуудаа, жирийн иргэд сэхээтэн нараа, сүсэгтэй, сүсэггүй нийт хүмүүс ээ! Улс, аймгаараа, нутаг нугаараа нэгдэж хороо болцгоо, хаа л бол хаа өглөг хандив цуглуулцгаа, бидний уриалгыг халуунаар хүлээн авч, энэ ажилд сэтгэл чармайлттай хандацгаа, та нар минь эх орныхоо иргэд, охид хөвгүүд гэдгээ харуулцгаа, эх орноо гэсэн ариун сэтгэлтэйгээ үзүүлцгээ.

Хандивыг Буриадын хорооны дарга Бандид Хамба Лам Д.Д.Итгэлын Орос, Азийн банкны салбар дахь урсгал зардлын дансанд шилжүүлэхийг хүсье.

Эх орны хоёр дахь дайны хэрэгцээнд зориулж хандив цуглуулахаар Дорнод Сибирийн ламын шашинтнуудын Бандид Хамба Ламын удирдлагаар Буриадын хороо хуралдав” гэжээ.

Энэ үед дайн эхлээд хагас жил гаруй болж байлаа. Цэргийн эмнэлгүүд болон Улаан Загалмайд Итгэлын байгуулсан хороо 150 мянган рубль илгээсэн ба Кавказын фронтын цэргийн эмнэлэгт 21 ор, Баруун Фронтод мөн тийм тооны ор,

Петроградын эмнэлэгт 30 орны өвчтөнд шаардагдах бүх хэрэгцээт зүйлсийг хангадаг байжээ.

Хотуудын бүх оросын холбооны тусламжтайгаар нүүлгэн шилжүүлэх галт тэрэг болон эмнэлэг-сувилгааны бааз ажиллуулах шийдвэртэй байгаа тухайгаа ард түмэндээ мэдэгдэж тусламж хүссэн байна.

Петроград дахь буриадын цэргийн эмнэлгийг Краковын Их сургуулийн профессор, Польшийн хүн судлалын ухааныг үндэслэгчдийн нэг, нэрт эрдэмтэн, эмч Юлиан Талько-Гринцевич /1850-1928/ удирдаж байлаа. Тэрээр үүнээс өмнө бараг хориод жил амьдарч, эмчлэх ажил хийж байсан газар нь болохоор Сибирь нутаг, ялангуяа, “хадган цэнхэр тэнгэр” нь эрхгүй сэтгэл гижигддэг буриадын уудам талд элэгсгээр ханддаг нэгэн. Өвөр Байгалын эртний оршин суугчид, тэдний соёлыг хүн судлалын талаас нь сонирхон мэдээлэл олох нь түүний сонирхол байлаа. Тэр чулуу, шороон булшийг ухан үзэж, хүннүгийн үеийн дурсгалууд олныг нээсэн хүн. Буриадын ард түмэн түүнийг сайн мэдэхийн хувьд итгэл хүлээлгэж, цэргийн эмнэлгээ удирдаж ажиллахыг санал болгосон аж. Энэ үүргээ тэрээр 1917 оны дунд үе хүртэл гүйцэтгэсэн ба 1916 оны 1-р сарын 8-нд Итгэлт талархлын захидал илгээсэн нь хадгалагдан үлджээ.

Хамба Лам Итгэл “дайтаж байгаа улсынхаа амь үрэгдсэн дайчдын талаар” мөргөл залбирал хийдэг, дацангуудын ширээт лам нар “эзэн хааны болон түүний эрхэм гэр бүлийнхэн эрүүл энх, сайн сайхан байх тухайд, дайсныг ялах тухайд”, мөн дэлхийд өмнө нь гарч байгаагүй энэ агуу их дайныг удалгүй намжаан зогсоохын төлөө “Бурхны Ганжуур”-ыг 108 ботиор нь уншиж байгаа хэмээн түүнд илтгэдэг байжээ.

Дайны эхний өдрүүдээс л Итгэлыг туслалцаа үзүүлэхийг хүссэн байдаг. Петроградаас шашин соёлын хэлтсийн эрхлэгч: “Австри, Германитай хийсэн дайны хохирогчид болох шархадсан болон өвчтэй байгаа дайчдад туслахын тулд эзэнт гүрний ламын

шашны бүх дацангуудаар хандив цуглуулгах, мөн энэ зорилгоор цуглуулсан мөнгийг Сангийн яамнаас тусгайлан гаргасан шийдвэр ёсоор орон нутгийн санхүүгийн байгууллагууд руу шилжүүлж, улмаар тэднээр дамжуулан Петербургийн Улсын банкны Улаан Загалмайн Оросын нийгэмлэгийн зориулалтын урсгал зардлын дансанд төвлөрүүлэх шийдвэр гаргуулах талаар Улаан Загалмайн Оросын нийгэмлэгийн ерөнхий газраас Дотоод хэргийн Яаманд хандсан” гэж мэдэгджээ.

Итгэл хариуд нь: хандиваар цугларсан 1724 рубль 80 копейкийг 24 дацангийн ширээт лам нараас хүлээн авлаа. Түүнээс гадна дайнд явагсад, шархдагсадын ар гэрт туслахын тулд дацангууд өөрсдөөсөө 1638 рубль гаргаж мужийн захирагчид өгсөн гэж илтгэжээ.

Итгэл ийн илтгэж байх зуураа аян замд гарахаар бэлтгэж байлаа. 54 хоногийн хугацаанд шашины хуврагуудын бүрэлдэхүүнийг бүрэн тойрон явж, 1914 оны 12-р сарын 3-нд илтгэхдээ энгийн иргэд хийгээд лам хувраг нараас 80 мянган рубль цуглуулсан ба 10 хувийг нь Улаан Загалмайд шилжүүлж, бусдыг нь Петроград, Кавказад цэргийн эмнэлгүүд буй болгох, дайнд явагсадын ар гэрт туслахад зориулах саналтай гэсэн байна. Мөн нутгийн иргэд фронтынхонд зориулж дулаан хувцас бэлтгэж байна гэжээ.

Итгэл Дамба Хишигтуевын хамтаар дацангуудаар хэрхэн явж мөнгөн хандив цуглуулж байсан талаар Будаев намтарт дурьдсан байдаг. “Хулунгийн дацан шийдвэрийг дэмжиж мөнгөн хандив өгцгөөсөн ба бас хувцас, гутал, ханцуйвц, тамхины хавтага, задгай болон бэлэн тамхи, сахар, жимс зэргийг тулааны талбар руу, шархдаад эмнэлэгт байгаа цэргүүдэд явууллаа. Эдгээрийг Улаан өндөгний баяраас өмнө хүрэхээр тооцож явуулсан” гэж бичжээ.

1915 оны үнэн алдартны улаан өндөгний баяраар буддын шашинт Буриадын бэлгийг цэргүүд үнэхээр хүлээн авч чаджээ.

Түүнээс гадна Дэлхийн нэгдүгээр дайн дөнгөж эхэлмэгц Итгэл Дээд-Үдэд “Дайны хэрэгцээнд хандив цуглуулах нийт буриадын нийгэмлэг”-ийг байгуулсан ба түүнд өмнөх Хамба Лам Иролтуев, бүх дацангуудын бүх ширээт лам нар зэрэг шашныхнаас гадна энгийн иргэд ч орж нийтдээ 120 хүний бүрэлдэхүүнтэй байжээ. “Нийгэмлэг “өөрөө хандивлаж, хандив цуглуулж, хасгуудад хүнс, шархдагсдад эм хэрэгсэл цуглуулж өгдөг байсан ба фронтынхны ар гэрийнхэнд анхаарал тавьж байлаа.

Тухайлбал: агаарын цэргийн хүчнийг хүчирхэгжүүлэхэд хандивыг шилжүүлж байжээ (хариу болгож лам нарт 1915 онд “цэцгийн баглаа бүхий нисэх онгоц”, “нисэх онгоц болон Андреевын тугтай бүргэд” зэрэг тэмдгийг гардуулж байсан юм). XI Хамба Лам Иролтуеваар удирдуулсан эмч лам нар фронтын эмнэлгүүд болон арын ажилд дайчлагдсан буриадууд дээр очиж ажилладаг байлаа.

Итгэлын тусламжтайгаар цугларсан мөнгө 1916 оны 1-р сарын 1 гэхэд 200 мянган рублиэс давсан байсныг тэр үеийн хэвлэлийн материалаас олж үзэж болно. Хотуудын холбоонд 40 мянга, Петроград дахь эмнэлгийн хэрэгцээнд 60 мянга, Кавказын фронтын эмнэлэгт 6 мянгыг шилжүүлээд тэр үед нь Итгэлын удирдлагын доор Нийт буриадын их хурлаар хэлэлцэн дүгнээд, 1916 ондоо дайнд явагсадын ар гэрт туслах хөдөө аж ахуйн ажилд 82 мянгыг зарцуулахаас хагасыг нь хаврын тариалалтад, хагасыг нь намрын ургац хураалтад гэж тогтоожээ.

Эзэн хааны хатан Александра Федоровнагийн удирдаж дайнд оролцогсод, шархдагсад, амь үрэгдэгсэдийн ар гэрийнхэнд анхаарал тавих талаар хэлэлцсэн Дээд Зөвлөлийн хуралдаанаас “Онцгой хүчин чармайлт гаргаж, гавъяа байгуулсны”-х нь төлөө Итгэлыг Ариун Аннын II зэргийн одонгоор шагнасан байна.

Нийгмийн байдал улам хүндэрч, сайн санаагаараа хандив өргөх нь нэн ховордох болсон тул хандивын хэмжээ ба хугацааг нутгийн захиргааны хурлаас: “төлбөл зохих хүн нэг бүрээс хоёр рубль” гэж тогтоожээ. 1917 оны 7-р сарын 10-15-ны хооронд хуралдсан Нийт буриадын их хурлаар “Дайны хэрэгцээнд хандив цуглуулах нийт буриадын нийгэмлэгийн “захиргааны тайланг ээлжит бус хурлаар сонсож хэлэлцжээ. Яаралтай сонсох болсны шалтгааныг бэлхнээ илэрхийлэх хурлын протоколыг үзье: “Өвөр Байгалын мужийн хошуудаас авбал зохих 52730 р.29 к-ийн авлага байна. Эрхүүгийн болон Верхоленскийн хэлтсүүд тайлангаа ирүүлээгүй болохоор Эрхүү мужийн авлагын хэмжээ мэдэгдэхгүй байна. Их хурлын зүгээс аймаг, хошуудын албан тушаалтнуудад иргэдээс хандив цуглуулахад бүх талаар туслалцаа үзүүлэхийг үүрэг болгохын зэрэгцээ бага гэж чамлахгүйгээр бүхий л боломжоороо нийгэмлэгийн дансанд хандивын мөнгөө аль болох түргэн хугацаанд оруулахыг иргэдэд уриалсан байна. “

Мөн Агын аймгийнхан өөрсдөөсөө хөрөнгө гаргаж дамжаадыг зохион байгуулсан болохоор багшийн дамжааг ажиллуулахын тулд Агын аймгийн хэмжээнд 10 копейкийн хандив цуглуулан нэгтгэх тухай аймгийн хорооны өргөдлийг их хурал сонсож шийдвэр өгсөн байна.

1923 онд төрсөн Намжилма Бадмацыреновна Раднаева хэлэхдээ:

-Итигэлэй Хамба (Хамба Лам Итгэлыг хэлж байна. Ред) тэргэнд хөлөлсөн мориор Өндөр (Ундэр) хэмээх эгц өндөр уул руу гараад явчихдаг байсан. Бүгдээрээ үүнийг гайхацгаадаг байлаа. Тэрээр лам нартаа: “Та нар буян хураахгүй байна. Удахгүй үйлийн үрээ эдлэж, өөрсдөө өвсөө хадаж, тариагаа хураах болно доо” гэж хэлдэг байлаа”

Итгэл Хамбад зориулсан дуу ч байдаг. Фронтод явахдаа Итгэл Хамбаас адис авсан нь бүгд л эргэж ирцгээсэн” гэсэн юм.

Намжилма авгай энэ дууг дуулсныг нь бичиж авсан нь хадгалагдаж байдаг. Энэ дуу бол үнэндээ ардын дуу бөгөөд өөр хувилбараар ч дуулдаг. 1923 онд төрсөн, Буриадын Соёлын гавъяат зүтгэлтэн Софья Содномовна Содномовагийн үгийг Борис Бальжиев бичиж авсан нэг хувилбар байдаг ба Итгэлын Хүрээлэнд энэ дууны дахиад хоёр ч хувилбар хадгалагдаж байгаа. Бальжиевын хэлж байгаагаар бол энэ дууг хасагууд өөрсдөө зохиож, фронтоос ирэхдээ дуулж тараасан гэдэг. Хоёрдугаар сарын хувьсгалын дараа тэд буцаж ирээд Хамба Ламтай уулзахдаа тэр дуугаа дуулахад “түүний нүднээс нулимс урсаж байсан” * гэх.

Сэтгэлийн угаас гарсан агуулга бүхий энэ дуунд хайртай эх орноо орхиод Германитай дайтахаар явлаа, Хамба Лам Итгэлынхоо адисласнаар эсэн мэнд эргээд гэртээ ирнэ гэсэн утгатай .

3.7. Итгэлт хамба хувьсгалын үед

1938 оны 1-р сард Буриадын нийгмийн болон шашины нэрт зүтгэлтэн, дипломатч, цанид Хамба Агван Доржиев ганц удаа байцаалт өгсөнийхөө дараа зүрх нь тасалдаж хорвоог орхисон юм. 1921 онд Хамба Лам Итгэлын сануулан хэлсэн үг үнэн байжээ. хэмээн тэрээр ярьдаг байлаа гэж 1937 оны сүүлчээс эхлээд түүнтэй нэг өрөөнд хоригдож байсан Янгажин дацангийн лам Доржиев гавж сүүлдээ гарч ирсэн хойноо ярьжээ. Доржиев тэр үед Монголоос ирж байсан бөгөөд Итгэл түүнтэй тааралдаад: “Та наашаагаа дэмий л ирлээ дээ. Тэндээ хилийн цаана үлдсэн нь дээр байсан юм. Удахгүй лам нарыг баривчилж эхлэнэ, тэдний гарт та ороод амьд үлдэхгүй” гэжээ. Тэгэхэд нь Доржиев: “Тэгвэл та яагаад гадагшаа гарахгүй байгаа юм бэ? “гэхэд “Тэд намайг баривчилж амжихгүй” *гэж хариулсан аж.

Ирээдүйн зөвлөлт засгийн тухай хий үзлийг Итгэл таашаадаггүй байлаа. Шашин маань шинэ дэглэмтэй эв номоо ололцно гэж найддаг, Зөвлөлт засагтай үзлийн хувьд ч нэг төрлийн гэж үздэг буддын зарим хэсгийнхнээс ялгаатай нь энэ. Хувиа хичээхгүй, хэрэглээний болон өдөр тутмын амьдралын үнэт зүйлсийг чухалчлахгүй гэх зэрэг нь ч хамтран оршин байж болох чухал суурь юм.

Большевикуудын хойчийг залгамжлагчид Итгэл амьд уу, үхсэн үү гэдгийн ул үндсийг олох хэмээн чармайсаар. Амьд оршихуйн аливаа өөр хэлбэрийг тэд хүлээн зөвшөөрч чаддаггүй. Хайрлах ч биш, үзэн ядах ч биш, харин энэрэн нигүүлсэх хэмээх туйлширлаас ангид дундач зарчимыг бүх зүйл дээр баримтлан амьдарч болдог өөрийн гэсэн бодот үнэн түүнд байж болдогийг тэд мэдэхгүй. Буддын шашинтнуудын хувьд “амьд” хийгээд “амьгүй” гэхийн тухайд өөр төсөөлөл байдаг юм. Яалаа гэж дээ, тийм юм байдаггүй, тодруулж, учрыг олж, цэг тавимаар...

Лам нарын нэлээд хэсэг нь большевикуудтай эвцэн амьдрах оролдлого ч хийж амжаагүй – зарим нь хилийн чанадад гарч, зарим нь баривчлагдан цаазлуулсан. Ер нь Итгэлын зөгнөн хэлж байснаар л болсон юм. Буддын ариун нандин бүхнийг устгаж, дацангуудыг үнсэн товрог болгожээ.

Гэхдээ энэ бүхэн Итгэлээс хойш болсон хэрэг. “Тэд намайг баривчилж амжихгүй” гэдгээр нь л болсон.

1936 онд Янгажины дацангийн гавж лам Бато Васильевыг хорьжээ. Удалгүй түүнээс төрөл төрөгсөддөө хэл дуулгасан нь: Хэсэг хугацааны дараа түүнийг хүүр болгоод шоронгоос гаргаж ирнэ, тэгэхээр нь шарилыг Овоо Шүнгэтэд тавиарай гэсэн байлаа. Бүгд хэлснээр нь болжээ. Шоронгийнхон уг ламыг үхдэл боллоо гэж ойлгожээ, гэтэл лам эдгэрээд алс холын Кемеровт нуугдсан байна. Дайны дараа 1947 онд эргэн ирж Иволгийн дацандаа суужээ. Бүүр 1964 онд тэрээр хойт төрөл рүүгээ одсон гэдэг.

Буриадын йогчдыг баривчилсан, хорьсон тухай олон домог байдаг. Лам нарын нэг болох Дашинама гэдэг хүнийг дотоод хэргийнхэн олон удаа ирж баривчлан оджээ. Тэдний өмнө тэрээр суугаад юм уншиж байдаг ч нөгөөдүүл нь түүнийг олж хардаггүй. Ийм тоглоом тохууд аргаа барсан дотоод хэргийнхэн шавь нарт нь заналхийлж эхэлсэн тул тэрээр аргагүйдэж өөрийн биеийг засагт тушаасан гэдэг. Гэвч удалгүй түүний үхсэн байхыг харгалзагчид олжээ. Лам биеэ орхин одсон аж.

Цүүгэлийн дацангийн лам Дарма Санжаевыг ер хүрсэн настайд нь Читад шоронгийн доод хонгилд хаяжээ. Нарны гэрэл үгүй, өдөр тутам анхаарч халамжлаад байх зүйлгүй, үнэгүй, нүнжиггүй цагаан хоолыг тэрээр бясалгал хийх туйлын таатай нөхцөл хэмээн үзжээ. Хагас жилийн дараа бясалгалаа дуусгаад гэр рүүгээ явах гэж байхад нь түүний шавь Базар ламыг мөн дуудаж хамт явуулахаар зэхжээ. Өглөөгүүр шоронгийн хонгилд

тэдний бие нь хэвтэж байсан ба харин өөрсдөө гэр рүүгээ явсан байжээ хэмээн ярьцгаадаг.

Итгэл үнэмшил дундаршгүй болохоор л эдгээр эмгэнэлт түүхүүдэд үлгэр домгийн гэмээр юм бага байдаг хэрэг үү. Ирээдүйг зөгнөн мэдэж чаддаг Итгэлын гоц мэдрэх чадвар нь чадалтай багш нарынх л гавъяа. Итгэлыг ихийг мэдэж сайн лам болоосой хэмээн бүхнийг хийж байсан Анины дацангийн ширээт, Хойт Ламхай Аюшин Галдан далдыг мэдэх увдисаа гагцхүү тэр өнчин хөвгүүнд ч зориулаагүй юм. Хаан хөвгүүн Николай Буриадад ирэхэд нь Хойт Ламхай: Түүний ард цусан далай харагдаж байна, ирээдүйн эзэн хаан маань засгаа алдаж үхэх нь гэж хэлж байсан хэмээн ярьцгаадаг.

Хойт Ламхайн дотнын нөхөр, Итгэлын бас нэг багш, ард түмэндээ “Багш” хэмээн хүндлэгддэг, өмнө нэр гарч байгаагүй Еше Од гэж нэг лам бий. Тэрээр эрдэмтэйгээс гадна гантай үед бороо урьж чаддагаараа алдаршсан нэгэн. Итгэлын нэг гол багшийн талаар Д.Лундуков: “Захарай Ширап Нимбу Анины дацангийн ширээт лам байхдаа Цам болон Арван сахиусанд очихоор Тамчийн дацан руу явжээ. Тэнд байранд хонож байхдаа түүнд жатга хийснийг мэдсэн байна. Гарахын тулд тэрээр ханыг нураахыг тушаасан (хаалган дээр нь жатга тавьсан байх тул) байна. Сэлэнгийн эрэг дээр ирээд Захарай лам: биднийг гүйцэх нь байна гээд морио шууд усны голдрил дагуулан давхижээ. Түүнийг дагалдан явсан, шавь Доржо гавжийг нүдээ ань гэжээ. Шавь нүдээ нээхэд тэд аль хэдийнэ Анины дацангийн нутаг Овоотод ирсэн байлаа. Туйлын эгзэгтэй мөч байсан болохоор Хоосон чанарыг ашигласан юм, энэ талаар яриа битгий гаргаарай гэж Захарай лам шавьдаа хэлэхэд нь тэрээр мөрдөж ирэх вий хэмээн айсан”* гэдэг гэж ярьжээ.

Сүүлд 1894 онд Захарай ламхай хорин хоёр зуны бясалгалд гарч, 1916 онд төгсгөсөн бөгөөд түүнийг гарч ирэхэд нь Хамба

Лам Итгэл, Агван Доржиев нар угтаж авахаар ирсэн гэж Лундуков болон бусад хүмүүс нотолдог.

“Тэр үед лам нар хөөрөн нисч, хана нэвтлэн гарч, алс холын зайг ганцхан хоромд туулж, мориор ус гатлахдаа замаа хув хуурай болгож чаддаг нь ердийн үзэгдэл байлаа “гэж Раднаев Ганжур лам ярьж байна.

Баримт нотолгоо нь олдсон олон тохиолдлуудтай уялдуулан буриадын йогчдын чинадын чадварын талаар Ганжур лам ярихдаа: 1917 оны 5-р сарын 1-нд Сэлэнгэ аймгийн бүрэн эрхэт төлөөлөгч нарын хурал болж, нийгмийн аюулгүй байдлын аймгийн хувьсгалт хороог байгуулж бүх эрхийг түүний гарт шилжүүлэх тухай хэлэлцсэн юм.

Цаашдаа дахин өөр өөр хурал хийж байтал суурингийн толгойлогч Дондок Абидуев фронтоос ирсэн нөхдийг уриалан дуудаж, зуу гаруйхан хүний бүрэлдэхүүнтэйгээр дацан руу очоод шинээр байгуулагдсан өөрийн удирдлагат байгууллага болох аймгийн хороог тараан хөөжээ. Цаашдаа юу болсон тухайд Даша –Дондог Менжигийн “Буриадын сартуул омгийнхон” гэдэг номдоо: “Аймгийн хорооны дарга С.Б.Цыбиктаровыг баривчлах гэсэн боловч түүнийг олж чадаагүй, Буда Цыренжаповаг баривчилж сэлэнгийн хошууны сэргийлэхэд өгсөн, аймгийн хороог хөөж тараасантай холбогдуулж, хил дамнасан наймаачдаас хураан аваад сэргийлэхэд хадгалагдаж байсан архийг авч дацангийн нутаг дээр замбараагүй архидацгаасан” **гэж бичжээ.

Энэ эх адаггүй юм болж байх үед Итгэл Дээд-Үдээс ирж байжээ. Цагааннуур (эдүгээ сульфатное озеро буюу хүхэр хүчлийн давстай нуур гэсэн утгаар нэрлэдэг) орчимд ирээд дээрх болсон явдлыг мэдсэн Итгэл дацан руу дөтлөхийн тулд тэргэнд хөлөлсөн морио ташуурдан нуурын мандал дээгүүр хатуу хучлагатай замаар давхих мэт давхин оджээ. Дараа нь баруун талынх нь эгц эрэг дээрээс газарт буугаад Хул-Нуур (Галуут нуур)-ын усыг яран хуурай ёроолыг нь гаргаад түүгээр дацан руу

чигээрээ давхив. Түүнийг эрэг дээр гарахад араас нь дагаад ус нь хоорондоо нийлж байжээ.

Дацанд цугларсан үймээн дэгдээгчид болон бузарлагдсан газар нутгийг нь усны долгион угаан ариусгажээ. Үлдсэн зарим нь Хамба Ламын ирж байгааг хараад айн зугатаасан байна.

Итгэл алс холын зайг хормын төдийд туулдаг байсан тухай дурсамж ч байдаг. 2004 оны зун Харгана тосгоны ахмадууд ярьсан нь: “Этигэлэй Хамба (Хамба Лам Итгэл.-ред) Убукун (Өвгөн нэрт газар)-д ирж хамаатнууддаа очиход нь түүний яаж тэгж хурдан явдгийг нь олон хүн учрыг нь олдоггүй байлаа. Барьж байгаа хашааны дэргэдүүр өнгөрөөд хормын төдийхөн хугацаа өнгөрч, хоёр гуравхан мод хатгаж байтал хамбатан тэртээ алсад оччихсон бараг нэг цэг шиг харагддаг байлаа” гэж дурсав.

Хааныг хаан ширээнээс нь буулгаж, буддын шашинтнуудын амьдралд эрс өөрчлөлт гарч болзошгүй байгаатай холбогдуулаад 1917 оны 3-р сарын 25-нд Итгэл ард түмэндээ хандаж дотоод дэг жаяг болон дацангуудын байдлыг хэрхэн өөрчлөх талаар өөрийнхөө болгоосныг танилцуулсан юм.

1917 оны 7-р сарын 10-наас 15-нд Тамчийн дацанд Нийт буриадын II их хурал хуралджээ. Их хуралд Байгалийн чанад дахь муж болон Эрхүү мужийн буддын шашинтнууд, буриадуудын төлөөлөгчид оролцсон ба Итгэл болон Читад төвлөрдөг Буриадын үндэсний хорооноос зарлан хуралдуулсан нь хурлын тэмдэглэлээс илтэд харагддаг.

Бандид Хамба Лам хурлыг нээж, цаашид хийгдэх өөрчлөлтүүдийг авч хэлэлцээд: Зохион байгуулах хурлын сонгуулийн тухай, буриадуудын удирдлагын газрыг тодорхой журамд оруулах тухай, шүүхийн тухай, цагдан сэргийлэх байгууллагын тухай, үндэсний сургуультай болох тухай зэрэг асуудлуудыг сонсож хэлэлцжээ.

Петроградын буддын сүмийг эзэмшиж буй газрынх нь хамтаар халимаг-буриадын ард түмний өмч болгон шилжүүлэх, энэ үйл явцыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг боловсруулах комиссыг байгуулж, бүрэлдэхүүнд нь Хамба Лам Итгэлыг оролцуулахаар их хурлаас тогтжээ*. Мөн энэ сүмд төвдийн анагаах ухааны эмч-ламыг томилж өгөх шаардлагатай бөгөөд зохистой гэж их хурлаас үзсэн байна.

Фронт дээр буй буддын шашинт хасагууд бас өөрсөддөө лам томилж өгөх хүсэлт тавиад байгааг Итгэл их хуралд танилцууллаа. Өөр шүтлэгтэй фронтынхны ч гэсэн сэтгэлийг нь санваартнууд тэжээн тэтгэж байдагтай яг адил үндэслэлээр тэдний энэ хүсэлтийг хангаж өгөхийг их хурлын зүгээс Хамба Ламд хүссэн тогтоол гаргажээ.

Мөн энэ их хурал дээр Итгэл Бандид Хамба Ламын бүрэн эрхээс өөрийгөө чөлөөлж өгнө үү гэсэн хүсэлтээ танилцуулсан байна. Түүнийг албандаа хэвээр үлдэх талаар их хурлын зүгээс олон дахин хүсэлт тавьсан боловч Итгэл буцалтгүй зүтгэсэн хэвээр байсан тул эцэст нь “удаан хугацаанд үр ашигтай ажилласных нь төлөө” их хурлаас санал нэгтгэйгээр талархал илэрхийлэхэд хүрчээ.

1853 оны дүрмийг дахин хянаж үзэх асуудлыг хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд Бандид Хамба Лам өөрчлөлт орууллаа. Өөрчлөлт шинэчлэл хийх анхны оролдлогыг Итгэл аль 1913 онд хийж байсан бөгөөд дацангуудын дэргэд сүмийн тусгайлсан хурал маягийн байгууллага байгуулах талаар хөөцөлдөж байсан баримт нь архивт эдүгээ байдаг. Тэгэхэд нь Өвөр Байгалын мужийн ерөнхий захирагч: энэ бол одоо хүчинтэй байгаа 1853 оны дүрэмд өөрчлөлт оруулах гэсэн цагаа олоогүй оролдлого байна гэдгээр шалтаглан татгалзаж байсан аж.

“Дацангуудын ахуйг цэгцлэх” талаархи асуудлыг төлөөлөгчид хэлэлцжээ. Энэ асуудлыг их хурлаас өмнө шийдэж амжаагүй болохоор тэр үед хурлаар шашны асуудал эрхэлсэн комиссын

дарга цанид Хамба Агван Доржиевын болон Итгэлын илтгэлүүдийг сонссоны үндсэн дээр лам нарыг өдөр тутмын амьдралдаа дундач байр суурь баримтлаж байхыг уриалсан тогтоолыг хурлаас гаргажээ

Ийнхүү бүх дацангуудын лам нарыг нэг загварын хувцас өмсөж, хувцсан дээрээ үнэтэй торгон эдлэл хэрэглэхгүй байх, гэртээ үнэтэй тавилга тавихгүй байх, ганган чамин зүйлсийг үл хэрэглэхийг лам нарт үүрэг болгожээ. Дацангуудын болон лам нарын барилга байшин ч илүү дутуу юмгүй, даруухан байх ёстой гэжээ. Өмнө нь шалгалтын хурлуудад зориулж ард түмнээс юм авдаг байсныг хориглосон байна. Эдгээр хурлууд дээр гагцхүү цагаан идээ болон талхыг хэрэглэж, нэг ламд нэг л удаагийн хоол өгч, энэ нь ч бас хандивлагсадын санал хүсэлтээр болдог журам тогтоожээ. Дээр дурьдсан болон бусад хурлууд дээр, гурван дүйцэн өдөр хийгээд Буддын онцгой өдрүүдэд одооноос эхлээд махан гүнцэг хэрэглэхийг бүх лам нарт бүрмөсөн хорьжээ.

Үүнээс өмнө ч Итгэл лам нар, сүсэгтнүүдийг даруухан, дундач байдалтай байхыг уриалдаг байлаа. Хамба Лам Итгэл эмэгтэйчүүдэд: “Та нар толгой дээрээ торгон алчуур тохчихоод харин бурхан тахил дээрээ хэрэггүй муусайн даавуу тавьчихдаг!” гэж хэлдэг байсан гэж Буриадын ахмад эрдэмтдийн нэг Бимба Цыбиков дурсан ярьдаг юм.

1917 онд Итгэл хэн нэгэнд асуудлыг ойлгуулах, ятгах гэж огтхон ч хичээсэнгүй, харин төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд нөхцөл бололцоо хийгээд хугацаагаа ухаалгаар сонгож, хатуухан журамтай ажиллаж байлаа.

Бандид Хамба Ламын дэргэдэх шашины асуудал эрхэлсэн Нийт буриадын хорооны нэрийн өмнөөс гарсан дээрх тогтоолыг нийтэд зарлан мэдээлсэн өдрөөс эхлээд хувцсанд хатуу журам тогтоох асуудал тухайн дацангийн лам, сүсэгтнүүдийн тухайд шууд мөрдөгдөж эхэлсэн. Харин гэр орны үнэ цэнэтэй эд

хогшлыг үгүй хийх тухайд энэ өдрөөс эхлээд лам нарт нэг жилийн хугацаа тогтоож өгчээ. Бусад хориглосон зүйлүүдэд ч гэсэн хугацаа тогтоож, хугацаа дууссаны дараа зөрчил гаргасан лам нарт шийтгэл оногдуулахаар заажээ. Зөрчлийг дахин давтан гаргасан тохиолдолд тэдний шашин санваарын цол хэргэмийг нь хураах хүртэл арга хэмжээ авах юм байна.

Мөн: “шашны амьдралын шинэ зарчмуудыг боловсруулж дуусах хүртэл дацан бүрийн дэргэд доод шатны гүйцэтгэх хороодыг лам нар хийгээд жирийн иргэдийн бүрэлдэхүүнтэйгээр түр байгуулах”-аар тогтоолд заажээ. Эдгээр хороод нь дацангуудад журам сахиулах, буддын сургаалын дүрэм журмыг мөрдүүлэх учиртай юм байна.

Санваартны амьдралын дотоод хэв журмыг элдэв янзаар л хэлэлцэж, дотроо зөрчилдөж байцгаадаг, яв явсаар эдгээр зөрчил нь буддын шашинтнуудын дотор шинэчлэгчид, “шашиныхаа дэг жаягаар амгалан амьдрагсад” гэх мэтийн ялгавартай байдлыг буй болоход дөхөм үзүүлдэг. Энд цочирдох ч зүйлгүй, энэ ертөнцөд ашиг хонжоо үл хөөцөлдөгчид болон “аж ахуйн талыг баригсад” хэмээн ялгаварлахгүйгээр, янз бүрийн авир араншин, хэм хэмжээг барин маргаан үүсгэдэггүй нэг ч сүм үгүй билээ.

Энэ удаад бол энэ маргаанд ойрын ирээдүйн ноцтой нөлөө буй: Петроградад эргэлт хийхэд гурван сар хагасын хугацаа үлдээд байсан боловч хар сүүдэр улам улам нөмөрсөөр байлаа.

Нүцгэн ядуус дураараа авирлан, тэр нь улмаар учир замбараагүй байдлыг үүсгэж, тэгснээр сүм хийдүүд уруудаж доройтон, бурхан шүтээнгүй эгэл бор шийдвэр гаргацгаан ард түмнийг уруу татаж байгааг, мэдээж, урьдаас мэдэрсэн Итгэл өөрчлөлт хийх замаар дацангуудаа хамгаалан үлдэх, ард олон ба шашинтнуудын хоорондын холбоог бэхжүүлэхийг оролдож байлаа.

Гэвч бүх юм санаснаар болоогүй нь мэдээж. Эрүүл мэндийн байдал муу байгаа талаар Итгэл ярьсан боловч их хурлын төлөөлөгчид Бандид Хамба Ламын сонгуулийг хойшлуулахаар шийдэж, Итгэлыг албандаа хэвээр үлдэхийг хүссээр байлаа. Итгэл өөрийнхөөрөө зүтгэсээр... Эцсийн эцэст тэд дундач хувилбарыг сонгож, биеэ амраах болон эмчлүүлэх зорилгоор Итгэлт амралт олгож, энэ хугацаанд өөрийг нь түр орлон ажиллах хүнийг өөрөө сонгох эрх олгожээ.

10-р сарын эргэлтийн дараа* 1917 оны 11-р сарын 25-нд Лайдубон (Намжил Лайдапов) Бандид Хамба Ламын албан тушаалд очлоо.

Итгэл 9-р сард Янгажины дацанд эргэж ирээд тэндээ ардын дунд ном заах, гэгээрүүлэх, эмчлэх ажил хийх болжээ. 1919 онд “Багштай гайхамшигтайгаар харилцан холбогдох нь” нэртэй ном буюу Багш нараа хүндлэн дээдлэх удирдамж бичсэн юм. Очир булагаас гаралтай гавж лам Санжа- Цыбик Цыбиковын хийсэн Ирээдүй цагийн Будда буюу 16 метр өндөр Майдар бурхны сэрэг дүрийг 1920 онд босгож, Янгажины дацанд Майдарын дуган барьжээ. Энэ байгууламжид Итгэл ч тэр, Янгажины дацангийн ширээт лам Мархилов ч тэр өөрсдийнхөө хамаг хөрөнгийг зарцуулсан байна.

Цыбиков Буриад улсын хувьд Сэргэн мандлын эзэн гэмээр хүчтэй хүн. Уран барилгач, бурхан урлаач, барималч гээд л түгээмэл авъяас хосолсон зураач, гүн ухаанч тэр хүнд “буддын сургаалын хийсвэр санааг өөртөө агуулагч бурханлаг төрлийг олж болно гэдэг үнэнд итгүүлэн нүүдэлчин буриадуудын ухамсарт нэвтэрч, буддын бурхдын дүр төрхийг амилуулан бүтээх онцгой хувь заяа тохиожээ”. Цыбиковын хамгийн гол багш нь Итгэл байлаа.

Ирээдүй цагийн Буддаг шүтэх явдал Өвөр Байгалд өргөн дэлгэрч, мянган бурхдаар хүрээлүүлсэн Майдарын сэрэг дүрийг дацан бүр л өөртөө буй болгохыг хүсч байлаа. Аврага том эдгээр

бурхдын дүр дотроо хоосон байдаг ч бүрдүүлээд бүтээгээд ирэхийн цагт доторхи хоосныг нь ариун бичээс, ургамлын болон тарианы үр, анхилуун үнэрт өвс, хүж, эдийн дээд хадаг, үнэт чулуу зэргээр дүүргэж сүншиглэдэг. Ингэхдээ биеийн чухам аль хэсэгт нь юуг хичнээн хэмжээгээр хийхийг заасан тодорхой журам горимтой. Бурхдын дүрд бузар буртаг суулгахгүйн тулд цайвар шаргал хувцас өмссөн хүн мах, сонгино идэх, хамар, амны тамхи хэрэглэхгүйгээр зөвхөн цагаан идээгээр хооллон биеэ ариусган байж хийх ёстой.

Янгажины Майдар Бурхны дүрийг Цыбиков модоор урлан хийхдээ Иволгийн ойролцоохи хушин төгөлөөс хорин морин тэргээр бэлдэц татжээ. Майдарын дүрийг бүтээх явцад бэрхшээл ихэд тохиолдсоны учир муу нөлөөг арилгах зорилгоор гавж лам Цыбиков Янгажины дацангийн Цогчин дуганы босгон доор хэвтчихсэн тул гарсан хүн бүхэн түүн дээр зайлшгүй гишгэж гарахад хүрч байжээ. Ийм арга хэрэглэсэн нь Майдар бурхныг бүтээхэд ихэд дөхөм үзүүлжээ. Дүрийг дүүргээд дээрээс нь алтдан битүүлдэг.

1930-аад оны сүүлчээр уг бурхны дүрийг хэмхлэн шатааж, доторхийг нь тонон дээрэмджээ. Цыбиков энэ явдал хүртэл амьд сэрүүн байж чадаагүй. 1931 онд намрын шөнөөр түүнийг хөнгөн нимгэн хувцастай нь аваачаад Дээд Үдийн шоронд хорьсон байна. Түүний хувьд өлсч байна уу, цатгалан байна уу, даарч байна уу, дулаан байна уу гэдэг нь ялгаагүй байсан гэж садангууд нь ярьдаг юм. Харанхуй шоронд тэрээр бясалгаж л байдаг байж. "Түүний хамаатнуудын ярьсанчлан тэрээр уулаас үг дуу цөөтэй, хоригдогсодын хэнтэй нь ч юу ч ярьдаггүй, үг, юм дамжуулахаас татгалздаг, гаднахи байдлаараа хачин сэтгэгдэл төрүүлэм хүн байж.

Лам нарыг өдөр бүр аваачиж буудан хороосоор хамгийн сүүлд шоронд тэр ганцаараа үлдэж. С.Ц.Цыбиковтой холбоотой бичиг баримтууд гэнэт алга болчихоод хаанаас ч эрээд олдохгүй

байсан тул шоронгийн дарга түүнийг суллахаас өөр аргагүй болсныг хожим олж мэджээ. Шоронгоос суллагдсаныхаа дараа тэр удаан амьдраагүй аж”

Цыбиков 1934 онд 57 настайдаа энэ ертөнцөөс хальжээ. Түүний нилээд нэрд гарсан шавь, бурхан урлаач Данзан Дондоков баривчлагдахаасаа өмнө Красноярскийн хязгаар руу 10 жилээр цөллөгт явжээ. Буцаж ирээд дахиад л буддын дугануудын тахилын өрөөний зураг чимэглэл зурах болжээ. 1979 онд түүний бүтээлүүдээр Парист үзэсгэлэн гаргажээ.

1922 оны 10-р сард Итгэл Ацагатын дацан руу явж ЗСБНХОУ болон Алс дорнодын Бүгд Найрамдах Улсын буриад - монголчуудын бурхны шашны Анхдугаар Их хуралд оролцож, буддын шашины шинэчлэлийн тухай асуудлыг дахин хэлэлцсэн байна. Ард түмэндээ Морхилын багш хэмээн хүндлэгддэг, түүний хамгийн ойрын нөхөр, хамтран зүтгэгч Бальчин Нимбу Мархилов их хурлын өмнөх зун нь нирванд оджээ.

Түүнийг Ямандаг бурхан /Манзушри бодьсадвын догшин дүр/-ы хувилгаан гэцгээдэг байсан ба Итгэлыг сөрөг хүч, элдэв сайнгүй нөлөөнөөс зайлуулж, аль болохоор хамгаалдаг байсан гэж бүгдээрээ үздэг ажээ. Лам нарын хэлж байгаагаар бол тэрээр одоо ч гэсэн Итгэлын дэргэд байдаг ажээ. Бусдыг бодоход түүний гэрэл зургийг Хамба Ламд арай ойрхоноор хананд бэхэлсэн байдаг.

Мархиловыг тэнгэрт халихад хүчит шуурга дэгдэн, тэнгэрээс хувингаар цутгах мэт ус асгарч, уулын чулуунууд салхинд хийсч, хаа сайгүй оргилон урсаж байсан гол горхины голдрил, ангал руу шидэгдэж үндсэндээ галав юулж байжээ. Дараа өдөр нь Морхиловын нутгийнхан уулнаас өнхрөн ирсэн чулуунуудыг цуглуулж байхдаа энэ чулуугаар суурь тавибал барьсан байшин маань Морхиловын сахиусанд багтна гэж сүслэж байсан гэдэг.

Түүнийг Гильбир тосгоноос зүүхэнтээ Хөх Зүрхэн (Хухэ Зурхэн) гэдэг газарт бунхлан оршоожээ. Надаас хойш таван жилийн дараа Итгэлыг ч энд авчирна гэж тэр айлджээ.

Хамба Лам “Захиа” (“Илгээлт буюу “Шашины гэрээслэл”) бичсэн нь сүүлд 1996 онд олджээ. .

Кингижиний лам Самдан Цыденов буддын шашинт тусгаар улс байгуулж, өөрийгөө шашины захиргаатай улсын тэргүүн, гурван гүрний хаан, сүсэгтэн олны бүрэн эрхэт эзэн” хэмээн зарлажээ. Романовынхныг гэр бүлээр нь буудан хөнөөснөөс хойш аль ч дээд эрх барих засаг баталгаатай бус, тиймээс тусгаар тогтнолоо олох хэрэгтэй гэж тэр үздэг гэнэ.

XIV Бандид Хамба Лам Цыренпилов Колчактай хийсэн хэлэлцээрт Агван Доржиев оролцсоноос гадна түүнд бас улс байгуулах эртний нэг төсөл байсан гэнэ. Энэ нь төвд, монгол болон шарын шашинтай бусад ард олныг Далай ламааар тэргүүлүүлсэн шашины захиргаатай улс болгоод тэрхүү улс нь дамаа Оросын эзэнт гүрний хараат байх ёстой гэж төлөвлөжээ.

Гэхдээ эцэстээ Доржиев буддын шашины үзлийг эв хамтын нийгэмтэй авцалдуулахыг оролдож, буддын үзэл бол шашин биш, түүнд бурхан гэж байхгүй, энэ бол гүн ухаан юм, тиймээс ч эв хамтын нийгмийг байгуулагсдын үзэл онолд харшлахгүй гэж большевикуудад үнэмшүүлэх гэж оролдсоноор дууссан юм.

Итгэл Доржиевтэй хамтран шашиныхны амьдрал дахь тансаг чамин хэрэглээг хязгаарлах, ард иргэдээс алба авдагийг болиулах талаар тэмцэж байсан юм. Гэхдээ Итгэл Буддын сургаалыг үндэс болгож, Доржиевын улс төрийн үзэл бодлоос зайгаа барьж, иргэний зөрчилдөөнийг дацангийн босго алхуулахгүй байлаа. Болж байгаа бүхэнд Хамба Лам яасан ч яахав хэмээн хандаж байсан нь юу л бол, Тэрээр уулаасаа Буриадын олонхи буддын шашинтны адил эмзэглэж л байсан.

Удахгүй ноёлох Сталины дэглэмийн хувьд лам нарын ийм үл оролцох дундач байр суурь нь маргаашийн аз жаргалтай эв хамтын нийгэм рүү орох эрхийн үнэмлэх болж чадахгүй. Зөвлөлүүдийн засгийн зүгээс нийт монголч үзэл (панмонголизм)-д янз бүрээр хандаж ирсээн заримдаа хатуу тэмцэл явуулдаг байсан бол, заримдаа Дорнын хязгаарт “хувьсгалт түймэр” дэгдээхийн тулд дэмжиж байсан ч тохиолдол бий. Гэлээ гээд Буриадын нийт угсаатны, нийт буддын үзлийг хамарсан төсөл зохиогчид, зүтгэлтнүүд, бас үл гүйцэлдэх либерал үндэсний үзэлтнүүдийн хувь заяа хэрхэн шийдэгдэх нь нэгэнт тодорхой: Сталины дэглэмийн шоронд тамлуулсаар үхэх нь дамжиггүй.

1930-аад онд залхаан цээрлүүлэх ажиллагаанд Буриадын 16 мянга орчим лам өртжээ.

Харин 1920-иод онд бол буудан хороож, цөллөгт явуулж эхлээгүй байхдаа лам нарыг “хөдөлмөр эрхэлдэггүй элемент” хэмээн нэрлэж шинэ амьдралын хүрээнээс шахаж гаргах, зайлуулах оролдлого хийдэг байж. Хүн чанарын эрх чөлөөний тухай Лениний шийдвэрийг хэрэгжүүлэхдээ санаан зоргоор хүч хэрэглэхдээ хараахан тулаагүй, харин 1923 оны 2-р сарын 2 гэхэд бүх дацангуудын болон лам нарын хөрөнгийг хурааж “орон нутгийн хувьсгалт хороодын шууд мэдэлд өгөх” тухай хүнд сурталт заавартай л байлаа. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд тийм ч амаргүй, коммуны гишүүд хаа сайгүй эсэргүүцэлтэй тулгарч байсан тул ОК(б)Н-ын ТХ-ны Алс дорнодын хорооны шийдвэрээр энэ кампанит ажлыг түр зогсоожээ. 1926 онд шашины байгууллагад үүрэг гүйцэтгэгсэдийг сонгуульд оролцох эрхийг нь хассан байна. Дацангуудаа орхиж төрөлх тосгондоо очихыг хүссэн хүмүүсийг ч бүртгэж авахыг хориглож байж. Бүх лам нар газар эзэмших эрхгүй болжээ. Тэднээс авах татварын хэмжээг тусгайлан нэмсэн байна.

Гэхдээ Итгэлыг Янгажины дацанд байгаа хугацаанд лам нарыг “японы тагнуул” гэж зарлахгүй л байлаа.

Лам нар өөрсдөө: хуучин үзлээ баригсад болон большевикуудын үед тэсч гарахын тулд чуулганаа өөрчлөх оролдлого бүхий шинэчлэгчид гэсэн хэсгүүдэд хуваагджээ. Итгэл, мэдээж, шинэчлэгчдийн талд байх хэдий ч большевикуудын засагтай зэрэгцэн оршино гэдэг нь бүтэхгүй санаа гэдгийг мэдэлгүй яахав.

“Жинхэнэ ёсоор нирванд одох аргыг судлахад өөрсдийгөө зориулагч буддын шашинтнуудын бусдаас үл хамаарах бүлэг “болох гурав дахь хүчин ч гарч иржээ. Хуучныг баримтлагчдыг ч, шинэчлэгчдийг ч аль алийг нь шүүмжлэгч нирванчууд буддын шашины өөрийгөө илэрхийлэх хэлбэр болох сүм, бурхад, ёс заншил, залбирал мөргөл, лам нарын хэргэм зэрэг нь жинхэнэ буддын шашиныг гажуудуулж байгаагийн илрэл гэж тунхаглаж байлаа.

Шашиныхны дотор хагарал гарснаас үзэл бодол таарахгүй бүлгүүд хамтран шашины зан үйл хийхээс татгалзаж, баярын арга хэмжээ ч явагдахгүй байжээ. Ах дүүсээ алуулж, санаа сэтгэлээр бүрмөсөн унаж, галзуурахдаа хүрсэн ард олон эцэстээ толгой нь эргэж, хэн нь хэнийхээ төлөө юу хийж байгаа, өөрсдөө ч хаана яаж байхаа мэдэхээ больжээ. 1922 онд төрсөн, Алан Хорийн районы Мыжид Ахай Шарапов:

Хориод оны сүүлчээр Анины дацангийнхан хоёр хэсэг хуваагдсаныг тод санаж байна. Шинэчлэгчид дацанг эзлэн авч хэдийгээр олонхи нь байсан боловч нирванчууд хашааны гадна гарч банзаар дуган барихад хүрсэн юм. Этигэлэй Хамба байхгүй байгаад тэд тун ч их харамсч байсан... Түүнийг эргэн ирсэн (2002 онд) гэж сонсоод би магнай хагартлаа баярлаж, Анины дацан байсан газартаа сэргээн босгогдох байхаа гэсэн найдвар төрж билээ* гэж ярьсан юм.

Шинэчлэгч лам нарыг “комсомолч-лам” /монголоор бол эв хамтын нийгэмлэгийн залуу лам нар гэсэн утга.орч / гэж

нэрлэдэг, харин хувьсгалт өөрчлөлт шинэчлэлтийг эсэргүүцсэн, дацангаасаа явсаныг нь бол “нирванчууд” гэдэг байжээ.

1935 онд Ан Хорийн аймагт төрсөн Солбон Гасаранович Базардараев гэдэг хүн 1908 онд Аны улст төрсөн өөрийн эцэг Базардара Жамбалович Гасарановын өдрийн тэмдэглэлийн бичлэгийг үндэслэн доорхи зүйлийг ярьсан юм:

- Кушок Хамба Лам Агван Доржиев (тэрээр шинэчлэгчдийн тэргүүнээр гарч ирсэн) Анины дацангийн их чуулган /сугунды/ дээр хэлэхдээ: “Өнөөгийн засгийн хуулиар бол лам та нар ард түмний нуруун дээр ачаа болж байна, худалдаа худалдаахан эрхлээд ажил хийлгүй амьдардаг цаг өнгөрсөөн. Лам бүхэн хөдөлмөр хийж, тариа төмс тарих хэрэгтэй” гэсэн юм. Агван Доржиевыг ийн хэлсний дараа лам нарын дунд бөөн маргаан дэгдэв. Зарим нь: “лам нар бид хуучин байдаг журмаараа л байх болно” гэж байлаа. Ингэж лам нарын дунд хагарал гарснаар тэд хоёр бүлэг болон хуваагдсан юм. Кушок Хамба Ламын саналыг дэмжсэн хэсэг нь дацандаа үлдэх эрхтэй болж, эсэргүүцэгчид нь тийм эрхгүй болж дацангаас явах хэрэгтэй болсон ба тэд хожмоо “нирванчууд” гэдэг нэртэй болсон юм. Дацанд хоёр хороо ингэж үүсчээ. Хөдөлмөр эрхлэх үүргээс зайлсхийж, хуучин журмаа баримтлан дацангаас хөөгдөгсөд сүсэгтнүүдтэйгээ хамтран амбаар, байшингийн доорхи өрөөнүүдээ тоноглон тэдгээрийг хооронд нь нэгтгэх замаар том саравч болгож, 2-3 пийшин тавиад тэндээ хурал хийдэг, энэ саравчаа дуган гэж нэрлэх болжээ.

Анины дацанд болж байгаа үйл явдал бусад газарт ч бас л байлаа. Цүүгэлийн болон Цонголын дацанг улсын мэдэлд авч (эхний сүмд нь Итгэлын ирээдүйн багш нар болох Янгажины болон Анины дацангийн, Итгэлын ирээдүйн багш нар сурч байсан, харин хоёр дахид нь бол Итгэлыг өөрийгөө шилжүүлэн байрлуулах газрыг зааж өгсөнөөр Заяевын хойт дүр хэмээн хүлээн зөвшөөрсөн гэдгийг сануулан хэлье) шинэчлэгчдэд

шилжүүлэн өгсөнөөр улс төрийн тогтолцоонд өөрсдийн нөлөөг бэхжүүлэхийг чармайгч шат шатны лам нарын доторхи тэдний эсрэг үзэлтнүүдийг баривчлахад хүргэсэн юм. Иймд лам нар болон сүсэгтнүүдийн зарим хэсэг нь Өвөр Монгол руу дүрвэжээ. Тэндээ Барга, буриадын цагаачлагчдын төв болох Шэнэхэн дацан байгуулагдав.

1927 оны 1-р сард ЗСБНХУ-ын буддын шашинтнуудын Бүх холбоотын анхдугаар чуулган шинэчлэгчдийн ялалтыг хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрсөн юм.

Мөн 1928 оны 8-р сард, Итгэлыг тэнгэрт хальсны дараа Буриадын буддын шашинтнуудын гуравдугаар их хурал зөвлөлт засгийг дэмжих нь буддын шашинтнууд, санваартнуудын үүрэг гэж үзсэн байна.

1929 онд хамтралжуулах ажилтай зэрэгцээд дацангуудыг эзлэн авах, эвдлэн сүйтгэх үйлдэл ч эхэлсэн байна.

ЗСБНХУ-д буддын шашины асуудал 1938 он гэхэд бүрмөсөн “арчигдсан” бол мөн тэр үед Монголд ч хэдэн зуун сүм хийдийг үгүй хийж, Хятадад ч бас Оросынхтой төстэй үйл явдлууд өрнөж, шинэчлэгчид, шинэ хэв маягийн буддын сургуулиуд буй болж, сүм хийдүүдийн газрыг хураан авч, ихэнх лам нарыг харлуулсан байна.

3.8. Итгэлт хамбын бумба оршоох ёслол

1922 онд төрөлх нутагтаа таван ариун бумба оршоожээ. Эдгээр бумбууд гаднахи байдлаараа түүнээс есөн жилийн өмнө Николай II хаанд бэлэглэж байсан бумбатай нэн төстэй аж.

Буддын ариун шүтээнээр дүүргэсэн эдгээр бумбыг Хамба Ламтан оршоохдоо ер бусын ёс жаяг хэрэглэсэн нь: бумба оршоох ёслол дуустал өөрийнхөө хөлийг газарт хүргэж болохгүй гэж шавь нараасаа хүссэн явдал байлаа. Байгаль хийгээд амьд төрөлтнүүдийн хоорондохи харилцааг нийцэлтэй болгохын тулд ийм үйлдэл хийдэг.

...Иволгийн дацангийн талбай дээр яваа мөргөлчид газрын хөрсийг эмтлэхгүй гэсэндээ дорно зүгийнхний өмсдөг дээшээ этийсэн хоншоортой шаахай худалдан авдаг. Гараг дэлхий газар шорооныхоо төлөө халамж тавьж гутлынхаа хоншоорыг дээш нь тахийлгадагтай зүйрлэх аваас манай шинжлэх ухаан ч “ёстой жинхэнээрээ амарч байгаа” юм байна гэж нэгэн зорчигч хэлсэн юм даг.

Нүүдэлчин буриадууд газар шороондоо тийн гамтай хандахын үүднээс үеийн үед өмсөж ирсэн ээтэн гутал эхэндээ хачин санагдаж болно. Буриадууд бол маргааш нь газрын мухар руу арилаад өгдөг явуулын иргэд биш, харин энүүхэн хэсэг газар дээрээ, түүнтэйгээ хамт амьдарсаар эцэстээ тэндээ шингэдэг ард түмэн.

Ихэнх хүмүүсийн амьдралынхаа хугацаанд хийж болох зүйлсийн хамгийн дээд нь гэмээр газрыг оролдохгүй, газарт ул мөр үлдээхгүйн тулд буриад, монголчууд газрын хөрсөн дээгүүр гулсах мэт явах нь онцгой тохиолдлоос бусад нөхцөлд газар ухаж төнхөх, ой модонд ямар нэг зүйлийг өөрчлөхийг хориглодогтой утга нэгэн билээ.

Мод унагаана гэдэг бол амь насаа богиносгохын л нэр. Энд ирчихээд загас барьж байгаа славууд зэрлэг бүдүүлэг хүмүүс шиг харагддаг, тэр ч бүү хэл тэдний барьсан загасыг нь худалдаж аваад буцаагаад усанд нь тавьдаг хэмээн лам нар ярьдаг .

Гараг дэлхийтэйгээ хамтран оршихуйн гүн ухаан ээтэн хоншоорт буй, энэ бол тэрхүү ухааны охь шим нь юм.

Итгэл хөлөө газарт хүргэлгүй, газрын хөрсийг үймүүлэлгүйгээр өргөл өргөсөн нь тийм гүн ухааны зарчмыг учир зүйн хувьд бүрэн төгс шийдэлд нь хүргэсэн хэрэг.

Бумба оршоох ёслолын үеэр Итгэл нэг ч удаа хөлөө газар гишгэлгүй, шавь нар нь ямагт түүнийг гар дээрээ өргөн явсаар байсанд Хамба Лам Аюшеев онцгой анхаарал хандуулдаг бөгөөд шороон махбод түүний биеийг эгнэгт хадгалсаар байсны нэг шалтгаан хэмээн үздэг. Өглөг буянг байгаль эх хүлээн авч, хариу талархал илэрхийлжээ.

Оронгын хөндийд тэрээр дөрвөн газрыг аравнайлан ариусгасан юм: Барзгар (тэгш бус, барсгар гадаргуутай уул. бур), Өндөр Өвөр (уулын өндөрлөг бэл. бур), Таарханда (дээрээ тэгшивтэр уул.бур), Баян-Улаан – эдгээр дөрвөн газар одоо ч ариун дагшинд тооцогдсоор байна гэж ярьсан юм.

Ташаа ойлголт төрүүлэхгүйн тулд зарим зүйлийг тодруулан хэлэхэд: тэрээр дээрх газруудад бумба оршоосон боловч Баян-Улааныг аравнайлаагүй юм. Баян-Улаан бол түүний өвөг дээдсийнх нь залбирч сүслэж ирсэн удмынх нь овоо . Нийтдээ бол Итгэлын бумба оршоосон газар тав байгаагийн нэг нь бас Талын овоо гэж буй

3.9. Итгэлт хамба нирваан дүрийг олсон нь

Итгэл 1927 оны зуны тэргүүн сарын 15 (сарны тооллоор)–нд шавь нараа сүүлчийн удаа цуглуулаад: “30 жилийн дараа ирээд миний биеийг нэг хараарай” гэж хэлжээ. “Дахиад 50 жил өнгөрсөн хойно би та нар дээрээ буцаад ирнээ” гэж өөрийнхөө талаар бас хэдэн үг нэмж хэлсэн гэх ч мэдээлэл байдаг.

Тэр өдөр Итгэл “өөд болоочийн хойтохи ерөөл” (“hyга Намши”)–г миний төлөө уншин залбираарай гэж лам хуврагуудаасаа хүсчээ. Энэ нь тэнгэрт хальсан хүний сүнс нь биеэ орхин одоод үйлийн үрийн дагуу очих ёстой газартаа очиг гэж уншдаг ном тул багш нь амьд сэрүүн байхад уншиж болно гэж үү хэмээн шавь нар нь сэтгэл зовнин тээнэгэлзэж байтал Итгэл өөрөө тэр номоо уншаад эхэлжээ. Лам нар ч дагаад уншиж.

Яалт ч үгүй Итгэлын зааварчилсан ёсоор түүнийг бясалгаж байдаг байрлалаар нь хушин бунханд хийсэн ба дараа нь тэрээр лянхуа суултаараа суусаар амьсгалахаа больжээ.

Хөх Зүрхэн (Хухэ Зурхэн) гэдэг газарт түүний лагшинг хусан бунханд нь газар доор оршоожээ. Энэ үед тэнгэрээс нүд сохлом хурц гэрэлтэй гал бууж Итгэлын лагшины хамт газар руу орсон гэдэг. Оршуулгад оролцож, байлцаж байсан хүмүүсийн нүдийг хурц гэрэл бараг л сохлох шахжээ.

1955 онд ЗСБНХУ-ын буддын шашинтнуудын тэргүүн Хамба Лам Лубсан Нима Дармаев, Иволгийн дацангийн ширээт Жамьянов нар оршуулсан газарт нь ирж, эрж олоод үзэхэд Хамба Ламын бие хэвийн сайн байсан тул дахин оршуулж, сүсэгтнүүдийн дунд мөргөл үйлдсэн ажээ

Миний эцэг эх ч, ер нь тэндэхийн хүн бүхэн түүнийг бурхны бүрэлваа хэмээн нэн ихээр хүндэлдэгсэн.

Миний ээжийн дурсан ярьж байснаар бол Итигэлэй Хамба 50 жилийн дараа эргээд ирнэ гэсэн аж. Иймээс өөд болон болтлоо ямар нэг гайхамшиг тохиож, эргээд ирэх он жилүүдийг нь тоолсоор байсансан. Харин ээжийн хамаатан ах Янгажины дацангийн лам Бадмаев Гатапыг 1937-38 онуудад залхаан цээрлүүлэгчид хөнөөсөн гэдэг

Итгэлын лагшин өнөө ч хэвээрээ хадгалагдан байгаа гоц үзэгдлийн талаар эргэцүүлэн дүгнэсэн зарим судлаачдын үзэж байгаагаар бол ламтан амьд сэрүүндээ цаг хугацаатай ер бусын онцлог харьцаатай байсан болохоор алс холын зайг хормын төдийд туулж чаддаг нь ч үүнтэй холбоотой гэж байгаа юм. Гэхдээ тиймэрхүү ер бусын чадвартан нь ганц Итгэл биш, харин гоц үзэгдлийн хэмжээнд хүрсэн нь тэрээр ганцаараа билээ. Эдүгээгийн энэ гоц үзэгдэл Багшийн маань тодорхой зорилго чиглэлтэй үйл явуулж байсны үр дүн үү, эсвэл түүнээс үл хамаарах ямар нэг нөхцөл байдлууд, үйл явцын үр дүн үү?

Сүүлчийн энэ дүр зургаас асуулт урган гарч ирдэг. Лам нар хэрвээ үхэж байгаа хүний толгойг түшиж, түүнд зориулсан ном унших мэргэжлийн хувьд үүрэгтэй л юм бол тэд юундаа тэгтлээ балмагдаж гайхсан байж таарах вэ? (Энэ номыг үхэж байгаа хүний дэргэд унших ёстой биш, харин сүүлчийн амьсгалаа хурааж, зүрх нь зогсож, бие нь хүйтэн болчихсоны дараа л унших ёстой байдаг). Энд нэг л зүйл байна. Багшийн биеийн байдал нь ямар байсан ч байлаа, үхэл нь ирж байгаагийн ямар ч шинж байгаагүй. Энэ тохиолдолд, хэрвээ зүгээр оюун ухаандаа дүрслээд бодох юм бол, үхлийн өмнөх шатаас үхэх хүртлэх бүх үйл явц нь ердөө л ёслол үйлдэж ном унших ажиллагаа байсан, эсвэл Багш бясалгалын төвшинд орчихоод байхад мөн л нэг тиймэрхүү юм болсон гэсэн л үг болж байгаа юм. Үүнээс үзэхэд жам ёсоороо явагдсан ямарваа үйл явцын үр дүнд тухайн хүн үхэлд хүрээгүй, харин Багшийн бие махбодод сэтгэцийн тусгай аргаар нөлөөлсөн, өөрөөр хэлбэл бясалгал хийсний үр дүнд үхэл буй болсон гэсэн дүгнэлт аандаа гарч ирж байна.

Хэрэв энэ тийм бол, Хамба Ламтан энэ ертөнцөөс халин одсон нь урьдаас төлөвлөсөн, зорилго чиглэлтэй үйл ажиллагааны нэгээхэн хэсэг нь бөгөөд яв явсаар “Итгэлын гоц үзэгдэл”-д хүргэжээ гэдэг байр сууринаас авч үзэхэд бидэнд юу ч саад болохгүй. Түүгээр ч барахгүй оршуулсан биеийг эргэж үзэх хэрэгтэй хэмээн хүссэнээс нь үзвэл тэрээр 30 жилийн дараа өөрийнх нь бие бахь байдгаараа бүрэн бүтнээрээ байж байх болно гэдгийг өөрөө мэдэж байсан байж болох юм.

Одоогоор харин бид “Итгэлын гоц үзэгдэл” бол эхнээсээ аваад эцсээ хүртлээ түүний өөрийнх нь зорилго чиглэлтэй үйл ажиллагааны үр дүн гэдгийг л ухаарах хэрэгтэй юм, үүнээс өөр хэлэх зүйл үгүй.

Өнөөгийн өдрийн өндөрлөгөөс үзэхүл 1927 оны зуны тэргүүн сар (сарны тооллоор)-ын тэр нэгэн өдөр Багш маань үхэл гэгч үгийн ердийн утгаар нь үхэлгүйгээр зүгээр л үхэл амьдралын заагийг гэтлэн одсон байна хэмээн батлан хэлж болох байна* гэжээ.

Гэхдээ Итгэл тэр үед яагаад чухамдаа ертөнцийг орхин одох хэрэгтэй болсон бол? Төрөлх нутагтаа байж байж болохоор атал юуны төлөө ямар нэг өөр хэмжээст оронд одсон бэ? Буддын шашинтнуудын тэргүүнийхээ суудлаас огцрох болсных нь цаана, дараа нь тэгээд бидэнд ногдсон энэ бодит амьдралаас эрс шийдвэртэй явах болсных нь цаана ямар учир байна вэ?

Энэ тухай ийнхүү бодохдоо Итгэлын төгс эзэмшсэн байсан “Ариун гэгээнтний эрдэнэт долоон чанар”-ын нэг болох ичгүүрийн тухай асуудалд чанарын шинжилгээ хийх нь ашигтай болох нь дамжиггүй. Буддын гүн ухааны “Даши Чойнхорлин” их сургуулийн орлогч захирал, гэвш лам Пандэ Жигжитов энэ тухайд:

Ичих гэдэг нь буддын гүн ухааны үзлийн үүднээс бол аливаа үйлдэл хийхэд оюун ухаан хангалттай хүрэлцэхгүй байгаа байдал юм. Хийсэн үйлдэл нь буруу байвал ухаан хүрэлцээгүйг

илэрхийлнэ. Хамба Лам Итгэлын дэргэд зарим хүмүүс гайхаж хоцордог бол заримд нь ичгэвтэр санагддаг. Өөрөө бас л бүрэн бүтэн хүн байтлаа өөрийнхөө бие, хэл, оюун ухааныхаа боломжийг бүрэн ашиглаж чадахгүй ахуй амьдралын аар саар юмстай зууралдсаар байгаадаа гүн сүсэгтнүүд түүний өмнө ихэд ичиж хоцордог. Ичих мэдрэмжтэй байхын тулд доорхи зүйлс хэрэгтэй:

Ямар нэг зүйлийн, тухайлбал, хүмүүсийн ч юмуу, эх орныхоо өмнө хүлээсэн хариуцлагаа мэдрэх

өөрийнхөө талаар зөв үзэл баримтлалтай байх Харин өөрийнхөө талаар үзэл баримтлалтай болж, өөрийнхөө боломжуудыг ухаараад ирэхээрээ ичих мэдрэмжтэй болж эхэлдэг.

Хүний оюун санааны хөгжилд ичих явдал асар том үүрэгтэй. Үүний яг эсрэг чанар бол хэтэрхий шунал тачаал, хэрцгий догшин, бүдүүлэг харанхуй байдал юм. Жишээ нь, шунал тачаал нь ихдээд ирэхээрээ ичих нүүр, хүн чанараа гээж эхэлдэг.

...Анагаах ухааны үүднээс бол ичих нүүртэй байх нь хүний бие махбод дахь дөрвөн махбодын тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад тустай. Үүний ачаар хүний биед өвчин бий болдоггүй. Тэр нь өөрийнхөө ертөнцтэй бүрэн нийцэлтэй байдаг учраас тэр.

Ичихийг сэтгэлзүйн үүднээс авч үзье. Ичихийн эерэг, сөрөг талыг нарийвчлаад үзэхээр их ярьж, их бичиж байгаа итгэл гэгч асуудлын чухал болох нь эрхгүй толгойд орж ирдэг. Зарим бичиг сэлтэд эхлээд итгэхийн учрыг, харин сүүлд нь ичгүүргүйн гэмийг өгүүлдгийн учир энэ.

Оюуны хөгжлийн чухал нэг бүрдэл нь итгэл. Түүнээс гадна ичих, даруу зан хоёрын хооронд маш том ялгаа байдгийг мартаж болохгүй. Ичиж байгаа хүнд их зан гаргах, шунахайрах, хүсэн тачаах зэрэг сэтгэлийн сөрөг хөдөлгөөн үүсдэггүй.

Ичихийг нийгэм судлалын талаас авч үзье. Өнөө үед зан суртахууны үнэт чанаруудыг өөрөөр үнэлэх болж, ертөнцийг үзэх үзэл нэлээд бүдүүлэг болжээ. Өдгөө энэ ертөнцөд өдөр бүр, хаа сайгүй хүч хэрэглэж, гэмт хэрэг гарах нь ихэсч, архи дан согтуурах, мансуурах болон бусад дон газар авч, соёл, уламжлал, ёс заншил гэх мэт нь хоёрдугаар зэрэгт тавигдах болсон байна.

Бид эдгээр гажигуудыг анхааралдаа авахгүйг хичээж, ямар байгаа билээ – тийм л байх ёстой гэж өөртөө үнэмшүүлсээр байна.

Бид олон зүйлийн хажуугаар нүдэн балай чихэн дүлий өнгөрч байна. Бид орчин тойрондоо болж байгаа зүйлээс ичихээ больжээ. Гэвч яагаад тэр билээ? Яагаад гэвэл хүнийг ичээж, хүн чанаргүйг нь мэдрүүлдэг тэр учир дутагдалтайн мэдрэмжээс бид айж байна.

Бид илүү хариуцлага үүрэхээс, бас өөрийнхөө дотоод сэтгэлд тавгүйрхэл үүсгэхээс айж байна. Энэ бүхнээс бид зайлсхийж байхдаа ирээдүйд эрт, орой хэзээ нэг цагт туулах нь зайлшгүй зовлон гэдгийг ойлгохгүй байна.

Гагцхүү ичих, хүн чанартай байх хоёр л хүнийг бүрмөсөн задгайруулахгүй, нийгмийн ёс суртахууны шаардлагыг баримтлуулж, хүч чадалтай, тэнцвэртэй нийцэл зохицолтой байлгадаг. Ичгэвтэр байдалд орохгүйн тулд хүн хожмоо түүнээсээ болж ичмээр юм хийдэггүй.

...Бид өөртөө ойр байлгаж байгаа хүмүүсийнхээ өмнө хариуцлагатай байх ёстой. Ичсэнээс болж үүсдэг сэтгэлийн хөдөлгөөн нь хүнийг сайн тал руугаа өөрчлөгдөхөд хүргэж, сайн үйлс, таатай зөв үйлдэл хийлгэдэг. Ичсэнээсээ болоод хүн болгоомжтой, сонор сэрэмжтэй болдог. Эдгээр ховорхон тохиох гайхамшигт чанарууд Хамба Лам Итгэлт байдаг байсан* гэжээ.

Тэрээр шавь нарынхаа дунд байж байж болохоор байтал яагаад 1927 оны зун яваад өгөв? Жигжитовын үзэл бодлын тухайд Итгэл хүмүүстэй хамт байсан саруудын, мөн сүүлийн жилүүдийн он цагийн бичээсүүдийг эргүүлэн үзэх аваас Хамба Лам ямар их зовлон дунд байсныг ойлгохгүй байхын аргагүй.

Түүний нүдний өмнө юу гээч болж байгаа, цаашдаа юу болж сүйрэх нь тодорхой байгаа, ухаан мөхөстнүүд хэрхэн дураараа дургиж байгаа гээд л. Тэгэхдээ бүр түүний энэ ертөнцөд туулж өнгөрүүлсэн зам нь эх орныхоо өмнө, ард түмнийхээ өмнө хариуцлагатай байхын жишээ байсан, тэгснээрээ зүгээр нэг ажиглагч биш, нийгмийн зүтгэлтэн байгаад сурчихсан хүн шүү дээ.

Итгэл гаднахи өнгөн талын өөрчлөлт хийх оролдлогоос татгалзсан юм. Гэхдээ Итгэл эргэж ирэхийн тулд явсан хүн. Тэрээр салах ёс хийж байхдаа тухайн үеийн шинэ дэглэм мөнхөд ноёрхоод байхгүйг, хэдэн жилийн дараа өөрчлөгдөх хугацааг нь тодорхой мэдэж, умард нутгийн буддын шашин дахин сэргэн мандахад бэлтгэсэн юм. Гаднахи ертөнцөд явагдаж буй үйл явдал хичнээн бузар булай, эсвэл найдвар төрүүлэхээр байсан ч түүнийг сонгон авсан үндсэн зарчим, зам мөрөөс нь гаргаж чадахгүй юм. Тэрээр эзэн хаанд өргөсөн тангарагаасаа ч няцаагүй, умард нутгийн буддын шашиныг булшлахыг ч бодоогүй.

3.10. Итгэлт хамба эргэн ирсэн хийгээд цаг хугацааг ялахуй

Итгэл хүүхэд ахуйдаа хонь хариулж асан Очир булаг хэмээх газараас 1945 оны 12-р сард Сталины зөвшөөрөлтэйгээр Оросын буддизмын шинэ түүх эхэлж, Иволгины дацан шинээр мэндэлжээ.

Сталин лам нартай хоёр удаа уулзсан ба энэ уулзалтууд Итгэлын тусаар бүтжээ. Тухайлбал: Дэлхийн нэгдүгээр дайны жилүүдэд тэрээр эртний буриад хэлээр Буриад-Монгол, Чита, Эрхүү мужууд болон Красноярскийн хязгаарт эх оронч уриалга тарааж, Батлан хамгаалах санд хандив цуглуулан ихээхэн хэмжээний мөнгө бүрдүүлж, эмч лам нарыг олж цэргийн эмнэлгүүд рүү илгээж байсан зэрэг төр засагтай харьцаж хандах туршлага нь лам нарт хэрэг болж байлаа.

Буддын санваартнууд тийм үйл бүтээснийх нь төлөө Сталин тэдэнд талархаж байсан хэдий ч эрх баригч дэглэмийн зүгээс буддизмд хандах хандлагаа өөрчлөх шалтгаан болж чадаагүй. Гэхдээ лам нар Дээд Ерөнхий командлагчтай уулзах, дацангууд нээх тухай яриа үүсгэхэд тэдний ийнхүү бүтээсэн үйл үндэслэл, шалтгаан нь болж өгчээ.

Итгэлыг тэд мартдаггүй – буддистуудад хандах төрийн хандлага тэдний хувь заяанд тусгалаа олсон болохоос оюун ухаанд нь тусаагүй. Бандид Хамба Ламын ёсыг 1946 онд сэргээн буй болгож, Лубсан Нима Дармаев дайны дараахи анхны, XVII Бандид Хамба Лам болжээ.

Үүнээсээ өмнө Л.Н.Дармаев Хиагтын шоронд төмөр замын дэр мод суулгах ажилд нухлагдаж байсан ба турж эцэж, туйлдаж доройтсон тэрээр ухаан алдсанахаа буянаар амьд гарчээ. Түүнийг үхсэнд тооцож шуудуу руу хаяжээ. Дараа нь ууланд ухсан газар нүхэнд гурван жил болохдоо йогийн дадлага хийхийн зэрэгцээ орон нутгийн оршин суугчид шуудай шуудайгаар нь авч

ирдэг байсан марксизм-ленинизмын сонгодог бүтээлүүдийг уншиж судласан байна

Цаг нь болохоор Итгэлыг эргэж үзэх учиртайг Дармаев мартсангүй. Гэхдээ түүний гэрээсэлсэн хугацаанаас 2 жилийн өмнө 1955 онд хэсэг лам нар очиж бунханыг гаргаж ирж үзэхэд “зүрхний орчимд нь дулаан мэдрэгдэж байсан” гэж Хамба Лам Аюшеев 2003 онд хэлсэн юм. Лам нар зохих ёс жаягийг гүйцэтгээд бунханд нь буцаан байрлуулжээ.

Анхны бунхалсан модон хайрцгийг нь 1955 онд сольсон ба тэр үед давс хийсэн, түүнээс өмнө давс хийгээгүй байсан гэх мэдээлэл бий. Гэвч энэхүү мэдээлэл нь өнгөрөгч зууны ерээд онд дүрс бичлэгийн хальсанд буулгаж авсан олон тооны гэрчийн хэлсэнтэй зөрчилддөг. Давс ч гэсэн, мөн нөгөөх хушин хайрцаг нь 27 оных юм. Яаж ч бодсон 55 оны лам нар ямар нэг шийдвэртэй бодитой арга хэмжээ аваагүй.

Гэхдээ тэд яагаад хоёр жилийн өмнө бунханыг гаргаж үзэх болоо вэ? Энэ нь гарцаагүй байдлаас болсон: Зүүн Оронгод хүчтэй шуурга дэгдэж, байшингуудын дээврийг хуу татсан ба Хамба Лам Дармаев заасан хугацаанаас нь өмнө шаардлагатай ёс гүйцэтгэжээ.

1973 онд хүчтэй үер болж, Иволгийн дүүрэг болон Улаан-Үд хотыг бүтэн сар тусгаарласан юм. XIX Бандид Хамба Лам Жамбал Доржо Гомбоев /30-аад онд Красноярскийн хязгаар руу 10 жилээр цөлөгдөж, дараа нь торгуулийн батальонд тулалдан гурван медалиар шагнуулж байсан / Иволгийн дацангийн лам нарын хамтаар Хөх Зүрхэнд очиж дахин үзжээ. Бүхнийг эвдлэн сүйтгэгч цаг хугацааны нөлөөнд Итгэл автаагүй ажээ. Лам нар түүнийг буцаагаад бунхалжээ. Тэнд оролцогсодын нэг болох Дашидондок ламын хүү, 1930 онд төрсөн, Базыр-ахай Улзутуев ёслол гүйцэтгэж, биед үзлэг хийж, мөргөл үйлдсэн хүмүүсийн талаар мэдээлэл үлдээсэн байдаг. Тэрээр тухайн үед жолоочоор

ажиллаж байсан болохоор лам нарыг Хөх Зүрхэнд* аваачсан хүн нь тэр юм.

Дарижаб Балдановнагийн ээжээс сонссон зүйлийнхээ тухай 1938 онд төрсөн Зоя Чойжонова ийн өгүүлсэн юм:

- Этигэлэй Хамба (Хамба Лам Итгэл. Ред) –ыг давсанд суулгаж оршуулсан гэж тэр хүн ярьж байсан. 1955 онд түүнийг сэрээж, босгоод, хувцасыг нь сольж, бунханд нь давс хийжээ. Миний өвөөгийн төрсөн ах Митап гэдэг хүн мөн Янгажины дацанд сууж байсан, гавж хүн. Түүнийг 30-аад онд тосгоны зөвлөл дээр дуудсан тул өөрийгөө тэнд хүргээд өгөөч хэмээн миний өвөөгөөс гуйжээ. Цаашдаа тэгээд юу болсныг нь би мэдэхгүй.

Янгажины дацанд Итигэлэй Хамбын хувраг байсан Лувсан-өвөө их хачин хүн байсан, үд хүртэл хэнтэй ч юу ч ярьдаггүй, хоол идэж байхдаа ч хүмүүсээс буруу хараад суучихдаг байсан юм. Итигэлэй Хамбын бумбыг тойрон гороолоход л хамаг амьдралаа зориулсан хүн. Уулын оройгоор дуран бариад явна, Галуут нуурын ойролцоохи уулуудаар ч явсан, савдагуудтай харьцаж чаддаг жинхэнэ “Бурханы хүн” байсан юм.

Лувсан өвөө эхнэр аваагүй, гэр бүл болоогүй явсаар насан өндөр болсон хойноо л хүмүүстэй ярьдаг болсон. Тэр төвд хэлээр олон судартай ба түүнийгээ дандаа уншдаг байсан гэжээ.

Өндөр, Баржагар (Жажин) зэрэг уулуудад Лувсан өвөө гараад Итгэлын бясалгадаг байсан газарт очиж ёс гүйцэтгээд нарснуудад даавуу татаж сүүдэр хийчихээд бясалгадаг байсан гэж Галсанова ярьсан юм.

1923 онд төрсөн Намжилма Бадмацыреновна Раднаева Итгэлын шавь Лувсан-өвөөгийн нэрийг Лубсан Доржа Сампилов гэдэг гэсэн.

1928 онд төрсөн Мария Банзарова эдгээр дурсамжуудыг батлан өгүүлсэн нь:

Этигэлэй Хамбын шавь Шар-ламбагай нэрт Ендон Жамса лам, Лубсан Доржо лам нар зөвлөлт засгийн жилүүдэд их чухал ажил хийсэн гэж би боддог юм. Тэд 1930-1960 онуудад засгаас дандаа нууцгай байдлаар бумба дээр болон бусад зайлшгүй чухал ёс жаягуудыг гүйцэтгэдэг байсан. Миний нөхрийн ээж нь Шар-ламбагайн дүү бөгөөд тэр хүн Красноярскийн хязгаарын Смоленскт цөллөгт байж байгаад 1935 онд өөд болсон. Тэдний гэр бүлийнхнийг бүгдийг нь цөлсөн, Шар-ламбагайг өөрийг нь Черемхово руу явуулсан юм.

Шар-ламбагай Итгэлын гарын шавь байсан тухай мэдээллийг Д.Лундуков, Бальжинима-абгай Лодойбалова нар баталдаг.

Энэ бол буддын уламжлалт заншил гэж хэлмээргүй. Гэхдээ Хамба Лам Аюшеевын үзэж байгаагаар бол Шар-ламбагай болон Лубсан Доржа Сампилов нар өмнөх төрөлдөө мөн лам байсан байна. Тэрээр Бандид Хамба Лам Заяев нирванд одсон Талын харгана гэдэг газарт болсон үйл явдал, бодит биеэсээ халин одсон ч дараа төрөл олохоос татгалзаж, энэ газрыг хамгаалан сахисаар байдаг лам нар зэргийг хүмүүс дурсан ярьдаг ажээ. Үнэхээр ч Новоселенгинск тосгоноос холгүй зам дээр орой, шөнөөр машины гэрэлд лам нар байхыг үзсэн жолооч нар олон байдаг. “150 жилийн дараа эдгээр лам нарын гавъяаг Итгэлын хальсан газарт Шар-ламбагай өөрийнхөөрөө давтан үйлдсэн” * гэж Аюшеев хэлдэг.

1992 оныг хүртэл Сталины залхаан цээрлүүлэлтийг давж гарсан лам нар чуулганыг тэргүүлж байлаа. 1990-ээд онд шинэ үеийнхэн гарч ирсээн. Яг тэр үед Итгэлын гэрээслэлийг сануулах мэт Хамба Ламтаныг тэнгэрт халихаас нэг жилийн өмнө, 1926 онд төрж, дөрвөн настайд нь хүний нутагт авч гарсан Балбар лам гэдэг хүн Хятадаас эргэн ирлээ.

Өнгөрсөн бүхий л он жилүүдэд Өвөр Монголын Шэнэхэн дацанд хадгалагдаж байсан Итгэлын илгээлтийг тэрээр авчирсан юм. Оросод хувьсгал гарсны дараа үндсэндээ Цонголын болон Цүүгэлийн дацангуудаас гадагшаа гарсан буриад лам нар толгой хоргодож байсан, Итгэлын багшийнх нь гүн ухааныг голчлон судладаг, Итгэлтой олон талаар холбоотой энэ дацанд Балбар лам ч сурсан аж. . “Буддизм бол шашин биш, шинжлэх ухаан буюу гүн ухаан ч биш, харин эрх чөлөө юм” гэж Итгэл хэлсэн. Тэр хэлсэн эрх чөлөөндөө тэрээр хүрч очсон юм. Миний зорилго бол чөлөөлөх явдал гэж Будда ч хэлсэн байдаг. Будда ч, Итгэл ч нэг л эрх чөлөөний тухай ярьж байгаа нь эргэлзээгүй. Чухамдаа ямар эрх чөлөөний тухай яригдаж байгааг бүрэн хэмжээгээр ойлгох нь аз жаргал ч байж болох юм.

Хамба Лам Итгэлын Эрдэнэт Мөнхийн Лагшинг хадгалагчдын ахлагч Бимба лам: “Зөвхөн түүнийг өөр ертөнц рүү одсоны дараа л “нандин нууцыг” нь ил болгож болно” гэж үзэж байгаа юм. Түүгээр ч барахгүй өнөө үеийн лам нар Итгэлын бунхныг дахин олж, биеийн байдлыг нь шалгах хэрэгтэй гэсэн бодол ямагт агуулж явдаг байснаа тэрээр нуусангүй. Тэрээр их багштай өөрөө уулзаж байгаагаар зүүдэлсэн гэнэ. Түүний илгээлт олдсон нь Бимба ламын эрмэлзлийг нотолсон юм.

- Итгэлын биеийг гаргаж үзэх хэрэгтэй гэж би нутгийнхандаа байнга ярьдаг байсан. Ядахдаа л хайрцаг нь бүрэн бүтэн байгаа эсэхийг үзэх хэрэгтэй, ямар нэг юм нэмж засварлаж хийх хэрэгтэй ч байгаа юм билүү. Бие нь байдгаараа хэвийн байгаа гэдэгт би ямагт итгэлтэй байсан.

1999 онд л нууцат бунханыг гарган ирж үзэх хэрэгтэй гэсэн санааг Аюшеевт анх удаа Бимба лам хэлж байсан аж.

Өндөр хэргэмтэй лам нар бүгд л үүнд итгэлтэй байсан юм. Ингэж ярьж байсны дараахан 2002 он болоод ирлээ. Тэгэх ч ёстой байсан. Энэ бүхэн газар дэлхийд амьдарч байгаа биднээс үл хамаарах асуудал гэж Бимба лам ярьж байлаа.

Аль Багшийг хаана оршуулсныг яг мэдэх хүн болох Гильбир тосгоны ахмад настан, 1914 онд төрсөн, Амгалан Гомбоевич Дабеев өвөөтэй 1990 оноос эхлэн Бимба лам уулздаг байжээ. Амьдралынхаа хугацаанд ямар ажил хийж байв даа хэмээн түүнээс Бимба лам асуухад: “Хүн алахаас бусдыг нь хийж явлаа” хэмээн хариулдаг гэнэ. Дайны өмнө Амгалан залхаан цээрлүүлэлтэд өртөж, Амар мөрний Комсомольскийн барилга байгууламж руу шидэгджээ. Бимба лам армид алба хааж байхдаа түүний барьсан түр суух байранд 2 жил амьдарсан болж таарлаа. Хамба Лам Дармаев, ширээт лам Жамъян болон бусад лам нар, ахмадууд нууцаар оршуулга дээр очсоны дараа 1955 онд дээрх арга хэмжээнд оролцсон Нимын Бата өөрийнхөө хүргэн Амгаланд газрыг нь зааж өгсөн аж.

Доржиев Бимба лам:

Хамба Лам Итгэлтны лагшинг гаргаж ирэх хүртэл Амгалангаас өөр түүнийг оршуулсан газрыг мэдэх хүн байгаагүй. Түүнтэй хамт бид Хөх Зүрхэнд очиход “Энд Итигэлэй Хамба сууж байгаа” гэж хэлдэг байсан юм. Урьд нь Хамба Лам Итгэл яг хуучин байдлаараа сууж байна гэж нутгийнхандаа хэлэхэд хэн ч ойлгодоггүй байлаа. 2002 оны зун Хамба Лам Итгэлын бунхан хийх шинэс мод бэлтгэхээр Амгалан бид нар ярьж тохирсон юм. Бунхан ямаршуу байх талаар ярьсаар байтал зун өнгөрөв. 9-р сарын 7-нд Ганжур ламын ээжийг оршуулах үеэр Хамба Лам Аюшеев Хөх Зүрхэнд очсон юм. Оршуулсны дараа Итгэлыг оршуулсан газар руу Хамба Лам Аюшеев шууд явж очоод: “Энэ яасан цэвэрхэн газар вэ” гэж хэлээд хэвтэх аядав. “Итигэлэй Хамба энд байгаа гэдгийг та яаж мэддэг юм бэ?” гэж Амгалан өвгөнийг асуухад Хамба Лам Аюшеев: “Би чинь Хамба шүү дээ” гэж хариулж билээ.

Хоёр хоногийн дараа 9-р сарын 9-нд өглөөний мөргөлийн дараа би Хамба Лам Аюшеевтэй уулзлаа. Би мэндлээд - Хөх Зүрхэн рүү явж Хамба Лам Итгэлын бунханыг гаргаж ирэх ажлыг

эхэлж болох эсэхийг асуухад: “Тиймээ, цаг нь болсоон, явцгаагтун” гэж тэрээр хариулсан юм. Тэгээд лам Балбар, Буда, Дагба, мөн оператор Баяр, нярав Санжай-Жамсо нарыг Хөх Зүрхэн рүү явах шийдвэр өгсөн. Үдийн хэрд бид газар дээрээ очсон юм.

Хамба Лам Итгэлын байгаа газарт ургасан тэр олон эмийн ургамлыг Балбар лам, эмч тэргүүтэн ихэд олзуурхан гайхаж байлаа. Эдгээр ургамлыг түүж галын ёслол үйлдээд бид ухаж эхэллээ. Шороог гаргасны дараа нэг метр орчмын гүнд том хавтгай чулуу таарсан ба түүний доороос илч мэдрэгдэхийн хамт бас ууршсан ул мөр ч харагдна. Доор нь бунхан байх бөгөөд мод нь шинэхэн хийсэн мэт хэвийн сайхнаараа байлаа. Энэ бүхний талаар орой нь бид Хамба Лам Аюшеевт танилцуулахад бунхныг мануулахын тулд биднийг буцаасан юм*

Итгэлыг буцаан авчрахын өмнөх өдөр, шөнийн үйл явдлуудын талаар Дээд Березовскийн дацангийн Дуйнхор дуганын ширээт Буда лам (Цыденов) ийн өгүүлсэн юм: 2002 оны 9-р сарын 9-нд өндөр наст лам Балбар тэргүүтэй бид энд ирж, мөргөл уншаад ажилдаа орлоо. Тэр өдөртөө амжуулж чадаагүй. Бунханы дээд оройн хэсэг харагдаж эхлэхэд аль хэдийнэ харуй бүрий болсон байлаа.

Оршуулсан газрын хэмжээ нь бунханы хэмжээтэй байх байх гэж бодсон, гэтэл олох зүйлдээ хүрээд үзтэл хүнийг зөвхөн очир завилгаагаар суух хэмжээний л бунхан байлаа. Чулуунуудыг нь буцааж хийгээд ажлынхаа явцын талаар Хамба Ламд илтгэхээр буцацгаасан юм. Дацан руу явах замдаа ус уухаар Урт булаг (Ута булаг) -аар орсон юм. Тэр үед ер бусын үзэгдэл тохиож, нэг л газарт монос, улаагана бас нохойн хошуу ургасан байхыг харлаа. Энэ бол бидний очиж хийсэн ажилтай л холбоотой гэх санаа бидэнд шууд орж ирлээ. Энэ нь ямар нэг бэлгэ тэмдэг гэж харагдаж байлаа**.

Хиагтын гол замын ойролцоо, Иволгийн дацангаас Итгэлын төрсөн болон 1927 оноос 2002 оны хооронд байсан тэр газар хүртэлх замын барагцаалбал дунд хэсэгт Урт булаг хэмээх 14 булаг байдаг юм. Ойн цоорхойн захад, нэгэн толгойн энгэрт оргилох булгууд. Эдгээр булгийн уснууд нь янз бүрийн найрлагатай, янз янзын өвчинд тустай, радонтой ус ч бий. XIX зуунд лам нар суваг татаж, түүгээрээ Янгажины дацан руу ус урсгаж байсан гэдэг. Энэ газраас Итгэл эмийн ургамал түүдэг байж. Нэг л цэгт монос, нохойн хошуу, улаагана ургадаг тэр газрыг өдгөө хашаалж, хүндэтгэн, өнгө өнгийн өөдсөн даавуу болон тууз зүүж хашааг нь чимэглэсэн байдаг.

Итгэлыг буцаж ирэхээс өмнөхөн өөр бас ер бусын үзэгдлүүд тохиосоон: Хурамша тосгоноос баруун хойш байх Шунгэтэ хэмээх газарт, өнгөрсөн 2001 онд аравнайлсан “Яндум” суваргын эргэн тойронд тэгшхэн хагас дугуй хэлбэрээр хулгана сүүл гоёмсогоор ургасан нь ямар нэг үл үзэгдэгч цэцэрлэгчин түүнийг тарьчихаад тордоод байв уу гэлтэй. Энэ суваргыг Итгэлын удмынхан ХҮИ зууны дунд үеэс мөргөж залбирч байсан тэр газарт босгосон юм. Уулынх нь хормойгоор навчит модод ургасанд хөх дэглий шувууд амьдрах аж. Энд эрт үеэс нааш усны эзэн буюу лусыг аргадах ёслол хийсээр иржээ. Энд Баянгол, Оронго, Убуканы иргэд ирж эргэл мөргөл хийцгээдэг.

2002 оны хавар Анины дацангийн дэргэдэх нууранд хун ирэх болсныг бас л үүний дохио гэж үздэг. Энд хамгийн сүүлчийн удаа хэзээ хун шувуутай байсныг санах хүн нэгээхэн ч үгүй. Энд хун байдаг байсан гэх нь ердөө л ардын аман зохиол болж хоцорсон. Археологичид, нуувар эрэгчдийн хөндлөн гулд хэрж гүйцсэн Анины дацангийн нурангин дундахи нэг бул чулууг Итгэлыг буцаж ирэхээс 11 хоногийн өмнө лам нар санамсаргүй хөдөлгөтөл өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн гурван бурхны дүр олджээ.

Ажлын явцын талаар Аюшеевт танилцуулаад Бимба лам, Буда лам хоёр Хөх Зүрхэн рүү буцаж, бунханы ойролцоо үнэртэн анхилуулж, мөргөж залбирсаар хоносон байна. Бусад санваартнууд Итгэлын хамаатнууд дээр очиж шарилыг дахин гаргаж ирэх зөвшөөрөл авчээ.

Хамба Лам Итгэл 2002 оны 9-р сарын 10 буюу буриадуудын амьдралдаа хэрэглэдэг сарны тооллоор намрын дунд сарын шинийн дөрвөнд эргэн ирсэн юм. Өглөөгүүр Улаан-Үдээс шүүх эмнэлгийн шинжээчид, чуулганы эмч нар, Иволгийн дүүргээс гаралтай, Буддын их сургуулийн хэсэг оюутнууд бас Хурумша тосгоны иргэд ч иржээ. Хамба Лам Аюшеев үд орчимд ирж, Бимба лам, Буда лам нар ч доошоо бууж иржээ. Лам нар бунхны тагийг онгойлгоход нягтарч доошоо суусан давсны дундаас хадгаар ороочихсон суугаа хүний толгой цухуйжээ. Газар шорооны ажил дахин үргэлжилж, бунхныг даруй газар дээр гарган ирлээ. “Хамба Лам тэнгэрт хальсанаас хойш ямартай ч 75 жил өнгөрсөн болохоор бодитын жамд тулгуурладаг бидний оюун ухаанаар бол нас барсан хүний бие их, бага аль нэг хэмжээгээр хэвийн байдалтай байх боломж байхгүй юм” гээд Дамба Аюшеев хамгийн хариуцлагатай үзлэгийн үеэр би бусдыг бунханаас холдно уу хэмээн хүссэн бөгөөд гагцхүү эмнэлгийн шинжээч Мандарханов очиж үзсэн юм. Хэсэг хугацааны дараа тэрээр: бие нь хэвийн байдлаа хадгалсан хэвээр байна, миний санаа ихэд амарч, баяр баясгалан мэдрэгдлээ. Гэхдээ бидний хувьд үнэ цэнэтэй энэ биеийн цаашдын хувь заяаны талаар хариуцлага оноогдож байгаа нь ч мэдрэгдэж байна” гэсэн юм. Урьд нь тиймэрхүү зүйл хэрэглэж байгаагүй болохоор ямар нэг урьдчилан сэргийлэх зүйлс хэрэглэхээс шинжээч татгалзаж, харин комисс байгуулахыг хүссэн юм. Орой болж байлаа, Итгэлыг Иволгийн дацан руу авч явах шийдвэрийг Хамба Лам Аюшеев гаргаж, ариун шүтээнийг хүлээн авахад бэлтгүүлэх мэдээ хүргэхийн тулд түрүүлээд дацан руу буухиа элч явууллаа.

2002 оны 9 сарын 10 ны 21 цагт ёслолын хөгжмийн аялгуу доор “Цаглашгүй гэрэлт Буддын ариун газар орон”-ы загвар байрлуулсан байдаг Диваажин дуганы хоёрдугаар давхарт Итгэлыг гүн хүндэтгэлтэйгээр заллаа.

Гаргаж ирэх, тээвэрлэн хүргэх зэрэг бүхий л хугацаанд лам нар залбирал уншсаар байлаа. Цаашид юмс үзэгдлийн шүтэн барилдлагын тухай үндсэн гол бүтээл болох “Шүтэн барилдахуйн магтаал” /“Дэмбэрэл додво”/-ыг лам хуврагууд бүтэн сарын туршид хоногийн хорин дөрвөн цагт тасралтгүй унших юм.

Зонхов Богдын яг энэ бүтээлд зориулж Итгэл буддын ертөнц даяар алдаршсан тайлбараа бичсэн юм. Алив үзэгдлийн агуу бодитойн хоосон чанарыг танин мэдээд Зонхов өөрийнхөө бүтээлд дурьдсан тэр байдалд нь Итгэл амьдрал дээр бодитойгоор хүрч чадсан юм.

Эрдэнэт Мөнхийн Лагшин (Эрдэни Мунхэ Бэе)-г хадгалагчдын нэг Николай Жалсан лам:

- **Би ганцхан л тайлбар хэлж чадна. Юу хэмээвээс – тэрээр гагцхүү Буддын Сургаалын хүчээр л оршихуйн хүлээсэнд баригдан зовж буй бидэнд өөрийнхөө биеийг сургамж болгон үлдээсэн юм. Ганц ч үг хэлэлгүйгээр тэрээр биднийг сургаж байна! Энэ ертөнцөд байгаа бүхэн хоосон чанартай гэдгийг, бүх юмс мөнх бус гэдгийг, бас үхлийн тухай сургаж байна. Хутагтны дөрвөн үнэн буюу зовлон үнэн, бүхэн гарахуй үнэн, түрдэхүй үнэн, мөр үнэн хэмээн тэр сургаж байна”*** гэсэн юм.

2002 оны 9-р сарын 11-ний өглөө Улсын шүүх эмнэлгийн шинжилгээний товчоо /УШЭШТ/-ны үхэл судлалын хэлтсийн эрхлэгч И.Вологдин УШЭШТ-ны анагаах ухааны криминалистикийн тасгийн эрхлэгч Д.Горин, шүүх эмнэлгийн шинжээч эмч З.Мандарханов нар гаргаж ирсэн биеийг үзэж,

байдлыг нь бичиг баримтад тусгаад дараа нь биеийг бунхнаас гаргасан.

Биед яаж хүрэхээ мэдэхгүйн учир хувцасыг тайлах биш, харин гурван цагийн туршид нямбайлан огтолж хайчилж салгасан юм. Итгэлын хувцасны асуудал дараа нь өөрөө л шийдэгдсэн гэж болно. Учир юу вэ гэвэл, Хамба Ламыг буцаж ирэхээс өмнөхөн удаан хугацааны ярилцлага хэлэлцээр болсны эцэст Буриадын түүхийн музейгаас Цагаан Дара-Эх, Богд Зонхов, Ногоон Дара-Эхийн баримал дүрийг арайхийж нэг юм Иволгийн дацан авах болсон юм.

Итгэлын шавь С.Ц.Цыбииковын гарын эдгээр бүтээлүүд өмнө нь Янгажины дацанд байсан бөгөөд Итгэл тэдгээрийг аравнайлсан байх магадлал тун өндөр. Музейнхантай ийнхүү хэлэлцээр хийж байх хооронд Итгэлын хувцас музейн фондод хаана хадгалагдаж байгааг Ганжуур лам олж мэджээ. Хамба Ламыг эргэн ирсэн болохоор тэр хувцсыг дацанд өгсөн юм (Итгэл өөд болохынхоо өмнө бие нь эрс жижгэрч байсан гэдэгтэй харьцуулахад түүний хувцас нь өөрт нь томдохгүй, таарч байлаа, 1927 онд 1м 64 см өндөртэй байсан хүн эргэж ирэхдээ мөн л тийм байлаа) . Дараа нь дацанд Итгэлт зориулж лам хувцас шинээр оёж өгсөн юм .

Шинжээчид хувцасыг нь биеэс салгаж авсаны дараа хялгасан багсаар давсны үлдэгдлийг арилгаад дахин үзлэг хийж бичиг баримт хөтөллөө. “Оршуулганаас гаргаж ирсэн шарилын гаднахи байдалд тэр өдөр Иволгийн дацангийн байранд үзлэг хийж”, улсын шүүх эмнэлгийн шинжилгээний төвийн тэргүүлэх мэргэжилтнүүд гарын үсгээрээ баталгаажуулсан актад дурьдсан нь:

“... Бунханы доторхи зүйлс болон шарилаас ямарваа нэг анхилуун, давирхайлаг, муудсан үнэр илрээгүй,... арьсны өнгө цайвар боргол, хуурай, хуруугаар дээр нь дарж үзэхэд уян зөөлөн. Шарилын зөөлөн эдүүд нь уян нягтлаг эдээс арай

чангавтар, үеүдээрээ хөдөлгөөнтэй, мөн толгойн үс, хумс хэвээр байна. Шарилыг бунханаас гаргасны дараа ямар нэг түших, дэмнэх зүйлгүйгээр биеийн хэлбэр байдал, суудал завилгаа нь хадгалагдсаар байна, Урьд өмнийн өвчлөл, мэс ажиллавар, гэмтэл бэртлийн ул мөр болон занданшуулах буюу удаан хадгалах зорилгоор их биеийн хэвлийн хөндий хэсгийг нээсэн ул мөр илрээгүй” гэжээ.

Толгой болон хоёр гарыг хадгаар чанга ороосноос болж арьсан дээр нь судалтсан ором гарсан байсан нь шүүх эмнэлгийн шинжээчид биеийг үзэж ороолтыг авсанаас хойш хэдэн цагийн дараа алга болсон.

- Шарилыг авто машин дээр тавиад Иволгийн дацан руу авч явж байх зуур зайлшгүй жаахан сэгсрэгдсэн ба бунхны доод хэсэгт багавтар царцаамал шиг өтгөн цусархуу юм байхыг бид олж харсан. Газар доор 75 жил болоод гаргаж ирсний дараа агаарт гарснаас болоод Хамба Лам Итгэлын бие эхэн үедээ суларсан. Харин Хамба Лам Аюшеев тасралтгүй мөргөл уншихаар зохион байгуулсан нь бүтэн сар үргэлжлэх юм. * гэж Бимба лам ярилаа.

Итгэлын цус нь гүйхгүй, харин царцаамал шиг нягтарсан байна гэх цуу яриа тарсан нь, магадгүй, “царцаамал шиг өтгөн цусархуу юм” гэж Бимба ламын хэлсэн тийм ч оновчтой биш хэллэгээс үүдэлтэй байж болох юм.

Тээвэрлэж явах үедээ түүний баруун хөлд нь зураас гаргасан гэх бусад эх үүсвэрүүдийн яриа ч бий.

Бүх Оросын Уламжлалт Бурхны Шашны Чуулганы удирдлага 1910 онд төрсөн Бимба Доржиевич Цыбиковыг таниулахаар урьжээ /1927 онд тэрээр 17 настай байсан/.

Энэ үйл явдлаас дөрвөн жилийн өмнө 1998 онд Цыбиков Хамба Лам Итгэлтой холбоотой, хүүхэд насныхаа хэдэн тод дурсамжийг оруулсан өгүүлэл бичжээ.

Итгэлын ярихыг сонсож байсан тэр олон мөргөлчдийн дотор ээжээсээ төөрчихөөд байхдаа гадаа түүнийг олж харсан тод дурсамж нь толгойноос нь салдаггүй болохоор ч тэгсэн байж болох юм. Толгой дээр нь торгон алчуур байна, харин бурхан тахил дээр нь түүнээс дор юм байгаа даа хэмээн эмэгтэйчүүдийг зэмлэж байсан Хамба Ламыг тэрээр тод санадаг аж.

Өвөг эцэг нь Янгажины дацангийн хамгийн гол өглөгч буянтнуудын нэг байсан Цыбиков нэр хүндтэй гэр бүлээс гаралтай аж. Түүхийн шинжлэх ухааны дэд доктор Бимба Доржиевич насан эцэслэтлээ толгой сэргэг, ухаан саруул байсан юм. Тэгээд ч Итгэлыг нүдээр үзсэн, түүний тухай тод санаж чадах хүн ганц тэр л байлаа.

Бимба Доржиевичийн хэлж байгаагаар бол Хамба Лам намхан нуруутай, маш туранхай хүн байсан, одоо бүүр жижигхэн болжээ. Гэхдээ тэрээр Итгэлын нүүрний хэлбэр төрхийг шууд л таньсан аж. “Итигэлэй Хамба Янгажины дацанд эргэж ирсэн хойно би байнга очдог байлаа, түүнийг харж байсаан гэж Цыбиков хуучлаад: Таниулахаар намайг урьсан, би ч биенээс нь үлдсэн төдий юмс л тэнд байх байх гэж бодож байлаа, гэтэл амьд юм шиг байж байдаг байгаа. Би шууд л таньсан, тэрээр огт өөрчлөгдөөгүй байна лээ, энэ үнэхээр надад гайхалтай санагдсан” гэж ярьлаа.

Хамба Лам Аюшеев Цыбиковоос: “Таны өмнө хэн байна вэ?” гэж асуухад нь Цыбиков: “Итигэлэй Хамба жинхэнэ дүрээрээ байна” гэж хариулжээ.

Энд бас нэг чухал зүүдний талаар дурьдах хэрэгтэй юм.

Улаан-Үдийн уугуул Эмма Григорьевна Заиграева гэгч эмэгтэйн эцэг Григорий Абрамович Павлоцкий 1930-аад онд ЗСА Буриад-Монгол Улсын Ардын комиссариатуудын санхүүд ажилладаг байжээ.

1938 оны 2-р сард Янгажины дацангийн эд хөрөнгийг шашины эсрэг музейд хүлээлгэн өгөх ажлаар тийшээ томилолтоор очсон байна. Шөнө нэг лам нууцаар түүн дээр хүрч ирээд: **“Таныг боловсролтой, сэхээтэй хүн гэдгийг би харж байна, тиймээс Их Багшид хамаатай, нэн үнэ цэнэтэй энэ нэг авдар байна, түүнийг авч үлдэхийг танаас гуйж байна. Үүний хэрэг болох цаг ирнэ”** гэж хэлжээ.

Григорий Абрамович энэ авдрыг нууцаар авчраад өөрийнхөө нэг харанхуй өрөөнд, бусдын нүдэнд өртөхгүй газарт хадгалжээ. Тэрээр авдрыг өөрөөсөө салгадаггүй байлаа. Павлоцкий Новосибирскэд сургалтад явахдаа хүртэл аваад явж байлаа. Григорий Абрамович өтлөөд ирсэн үедээ авдрыг охиндоо өгөөд: цаг нь болохоор үүнийг өгөх хүнд нь өгөөрэй гэж хатуу хэлжээ. Энэ авдрыг ямартай ч Иволгийн дацанд аваачиж өгөх учиртай юм шүү хэмээн Эмма Григорьевна ямагт боддог байлаа.

Нэг удаа түүнд хэдэн лам зүүдлэгдсэний дотор Буддын хүрээлэнгийн орлогч захирал Ганжур лам байсан ба бусдыг нь Эмма танихгүй байлаа. Авдрыг аваачиж өгөх цаг нь болсоон гэж лам нар хэлж зүүдлэгджээ. Үүний дараа Эмма Григорьевна Ганжур ламтай уулзаж, гэртээ авчраад авдрыг үзүүлжээ. Энэ бол 2001 он. Энэ нь Хамба Лам Итгэлын авдар гэдгийг Эмма мэдэхгүй, зүгээр л ямар нэг Их Багшийн авдар бөгөөд хязгааргүй үнэ цэнэтэй эд гэж л бодож байлаа. 2002 оны 9-р сард Итгэл буцаж ирсний дараа Э.Г.Заиграева түүний зургийг сонингоос олж үзээд нөгөө нэг жилийн өмнө Ганжур ламтай хамт зүүдэнд үзэгдсэн лам нарын нэг нь мөн болохыг таньжээ.

Авдрыг Иволгийн дацанд хүлээлгэн өгсөн бөгөөд Эмма Григорьевна “Итгэлтай хамт” хэмээх Мэдээллийн төвд болсон уншигчдын бага хурал дээр:

- Зөвлөлт нийгмийн доторхи жүүдүүдийн эсрэг үзлийн уршгаар эцгийнхээ үндсэн гарвалыг нуух шаардлага тулгарсан, үүнээс болоод эцгийнхээ өмнө бууруутайгаа мэдэрч сэтгэл ямагт

хөндүүрлэдэг байлаа. Харин эцгийнхээ захиасыг биелүүлж авдрыг эзэнд нь өгсөнөөс хойш, эцгийнхээ өмнө буруутай гэж бодохоо больж, сэтгэл эмзэглэхгүй болсоон гэж хэлсэн юм.

2002 оны 10-р сарын 28-нд, даруй 75 жилийн дараа, Итгэлыг зоригсод дахин цуварч эхэллээ. Сүсэгтнүүд дахин түүнд залбирахаар, түүнээс адис хүртэхээр ирж байлаа. Чуулганы удирдлагын зүгээс “Хамба Лам Итгэлын Эрдэнэт лагшинд мөргөх тусгайлсан өдрүүдийн тухай” шийдвэр гаргасан нь жилд 8 удаа ирж мөргөж болохоор тогтоожээ. Энэ бол буддын долоон их баярын өдөр, мөн найм дахь нь Итгэлын эргэн ирсэн баярын өдөр билээ. Эдгээр өдрүүдэд түүнийг гол сүмийн нэгдүгээр давхарт шилжүүлэн байрлуулдаг.

Нэвт харагддаг тунгалаг бунхан тоноглон бүтээх шийдвэр гарсан ба эхний удаад шилэн бүрхэвч хийсэн.

Итгэлыг буцаан залах гол санаачлага гаргагсадын нэг болох Иволгийн дацангийн унзад-лам Бимба Доржиевыг Итгэлын Эрдэнэт Мөнхийн Лагшинг хариуцагчаар тохоон томилсон. Итгэлт улирал улиралд нь таарсан хувцас оёулсан. Ламын биед 2002 оноос хяналт тавьж байгаа буддын чуулганы эмч Алексей Ажеев: уураг тархинд нь лугшилт илэрсэн гэж хэлжээ. Түүний хэлж байгаагаар амьд хүнд тархины тал бөмбөлгүүд нь минутэд 3-4 “цохилолт” (кранио-сакральний ритм буюу гавал-нурууны хэмнэл) үзүүлдэг байхад хөдөлгөөнгүй байгаа Итгэлт минутэд 1 цохилолт мэдрэгджээ. Бимба лам:

- Биеийнх нь жин эхлээд 46 кг байснаа, сүүлдээ 42 хүртэл буурсан, булчингийнх нь хэсэг нэг сарын хугацаанд яльгүй хатуурч, бие нь бэхэжсэн. Хамба Лам Итгэлыг буцаж ирсэнээс хойш хөдөө нутагт дацан, дуганууд түргэн түргэн баригдаж, амьдрал сайжран, архидах нь багасч, цаг агаарын нөхцөл ч арай таатай болж, зүрхний өвчлөл буурсан юм.

2003-2004 онуудад Хамба Лам Итгэл тун ч ширүүн байсан. Түүний дэргэд мөргөл үйлдэхэд ихэнх сүсэгтнүүдийн толгой эргэж, заримынх нь нүднээс нулимс урсаж, биед нь хүрсэн үед цахилгаан цэнэг мэдрэгдэж байсан* гэжээ.

Итгэлын жин үнэхээр хэлбэлзэл ихтэй. Мөн бие нь ихээхэн ус гүйсэн гэмээр хөөнгө байдаг.

Арьсанд нь гар хүрэхэд заримдаа зөөлөн, зарим үед хатуу байх жишээтэйгээр өөрчлөгдөөд байдгийг олон хүн мэдэрсэн байна. Чуулганы эмч нарын үзэж байгаагаар энэ нь гайхаад байх зүйл биш гэнэ, Байнга усан дотор байгаа гар “угаагчийн гар”-ыг санагдуулам хөөж пэмбийдэг бол, харин түүний гар бие махбодынхоо тэнцвэрийг хадгалах үүднээс үрчийсэн байдалтай болж байна.

Итгэлыг буцаж ирсний дараахи эхний саруудад эрдэмтэд, мэргэжилтнүүдийн тооцож байгаагаар бол цэвэр агаарт гарсан бие тарж бутран унана, түргэн муудна, мөргөлчид гараа хүргэснээс, чийгшил болон халуун хүйтний өөрчлөлтөөс бие үжрэнэ гэсэн боловч тэгсэнгүй.

Ертөнц даяар үймэлдэн Итгэлын тухай мэдээ хүлээцгээж, Хамба Ламын амьдрал, үйл ажиллагааны талаар сонирхсон сэтгүүлчид асуултаар булсаар байна. Итгэлын хамаатан садангууд, нутгийнхан, жирийн хүмүүст итгэл хүлээлгэн, тэдэнтэй холбоо тогтоож, мэдээлэл олуулая хэмээн лам нар шийдэж байна. 2003 оны 4-р сард “Итгэлтай хамт “хэмээх мэдээллийн төв байгуулагдаад хэдхэн сарын дараа Итгэлын хүрээлэн болж өөрчлөгдсөн.

Итгэлын хамаатнууд, нутгийнхнаар мэдээлэл цуглуулгах талаар Чуулган шийдвэр гаргасан нь ойлгомжтой хэрэг: өөр хэн нэгэнд ярьснаас, ялангуяа нэлээд нууцлаг чухал зүйлсийг бол хүмүүс тэдэнд л түрүүлж ярина шүү дээ.

Мэдээлэл цуглуулгах ажлын анхны оролдлого Анины дацангийн нутаг дээр амжилт олж, Итгэлын багш нарын тухай, дацанд түүний суралцаж байсан талаар мэдээлэл олсон юм. Дараа нь өөр зорилт бас дэвшүүлж, олигтой мэдээлэл олж сонссон нөхцөлд анхаарал хандуулахгүй байж чадахааргүй, энэ асуудлыг сонирхдог жирийн иргэд, эрдэмтэдтэй ажиллая гэсэн санаа гарсан.

Ингэснээр зөвхөн Улаан-Үд, Буриадад төдийгүй, Чита, Москвад сайн дурын туслагчид буй болж, АНУ-д суугаа халимаг, буриад үндэстнүүд ч хамрагдах боллоо. Монгол улс энэ асуудлыг ихээхэн сонирхож байгаа. Дашрамд өгүүлэхэд, бүр эхэн үедээ бол ард түмний ой ухааны гүнээс Итгэлын ул мөрийг эрж олох гэхээсээ булш бунхан ухсан, соёлын өвийг сүйтгэсэн, шүтээнээ доромжилсон хэмээх буруутгал зэмлэлээс салах гэж ихээхэн ажил болж байлаа.

Хамба Ламтай ойр байсан хүмүүст юу бодогдож байсан бол, ямар их түгшүүр тэднийг зовоож байсан бол, Итгэлыг цаашид дацанд байлгах тухайд ямар асуудал гарч ирж байсан бол гээд та төсөөлөөд үз дээ. Жишээ нь:, хамгийн анхны хүнтэй уулзаж ярилцахад л “Итгэлыг тэгээд бүрмөсөн гаргаад ирээ юу, эсвэл буцаагаад оршуулах юм уу?” гэж асууж байсан юм даг .

Иволгийн дацанд болж буй үйл явдал олны сонирхлыг улам бүр татаж байхад, харин албан ёсны шинжлэх ухаан маань Итгэлын гоц үзэгдлийг нэг их судлах тэмүүлэлгүй нь илэрхий болж байна. Холын Буриадын энэ мэдээ дэлхий ертөнцийн талаархи тэдний төсөөлөлтэй авцалдахгүй байгаа болохоор эрдэмтэд тэгтлээ эрхэмлэдэг нэр төрдөө сүүдэр тусгахгүйн тулд чинадын үзэгдэл, эзотерик гэх мэтийн хүрээнд л яригдаад өнгөрвөл барав хэмээн үздэг бололтой.

Асуудлын гол нь зөвхөн шинжлэх ухаан хуучинсагтаа ч байгаа юм биш, хуврагуудын Чуулганы болгоомжлол нь хариу бас болгоомжлолыг төрүүлж байгаа юм. Хамба Лам Аюшеевын

анхны өгсөн хатуу захирамж: **“Хэнийг ч битгий урьж дуудагтун. Хэн нэгэн хоёр дахь удаагаа ирсэн ч гэсэн бүү зөвшөөр, харин гурав дахь удаагаа хүрээд ирвэл чухамдаа ямар зорилготойг нь, цэвэр ариун сэтгэлээр явна уу гэдгийг нь ойлгохыг хичээгээрэй”** гэсэн байдаг.

Итгэл дэргэд нь байж байгаа эхний саруудад лам нар цаашдаа чухам яахаа мэдэж байгаа болов уу? Тэд нарыг балмагдсан гэж хэлж, мэдээж, болохгүй, гэхдээ л хажуугийн хэн нэгний зөвлөмжийг сонсоход тэд бэлэн байгаа. Тэр үед эрдэмтдийн зүгээс өгсөн ганц зөвлөмж нь гэвэл: Итгэлын биеийг тогтмол нэмэх 4 градусын дулаантай агаарын бичил орчныг бүрдүүлэн хадгалах хэрэгтэй гэж Улсын Думын депутат вице-адмирал Валерий Дорогинаар дамжуулан академич Жорес Алферов зөвлөжээ. Өөрөөр хэлбэл ямар нэг хөргөгч маягийн юманд хадгална гэсэн үг.

“Байкалфарм” ХНН-ийн удирдагчдын нэг, Хамба Лам Итгэлын нутгийн Татьяна Базыровна Матханова гэгч эмэгтэй Красноярскийн “Бирюса” заводад тусгай зориулалтын хоёр хөргөгч захиалжээ. Шилэн хоргыг тогонд залгаад удаагүй, ганц өдөр өнгөрч байтал Хамба Лам Аюшеев: Итгэл “тэнд таагүй” байна гэлээ. Тэр цагаас хойш энэ төхөөрөмжийг зөвхөн ард иргэд Хамба Ламд мөргөж залбирах үед л ашигладаг болсон юм. Зохисгүй үйлдлүүдээс шилээр тусгаарлан хамгаалагддаг.

Буриадад зундаа дөчөөс дээш градусын халуун болох нь олонтаа байхад өвөлдөө мөн дөч гаруй градусын хүйтэн болох зэргээр цаг агаарын уур амьсгал нэн эрс тэс байдаг. Иймээс хэд гурван жил өнгөрсөн хойно нэгэнт баригдчихаад байсан Итгэлын ордонд ямартай ч түүнд зориулж хорин метр квадрат талбай бүхий тусгайлсан байр зассан нь 16 градус орчмын дулаантай бичил орчинг байнга байлгах зорилготой юм.

3.11. Хамбын дохио

1927 онд Итгэл манай энэ ертөнцийг орхин одоодоо бие нь жирч үгүй болохгүй гэдгийг мэдэж байжээ.

Гэвш лам Пандэ Жигжитов: “Хамбам Лам Итгэлын байдлыг ажиглаад байхад Тэрээр нэг бус удаа сэтгэл нь хямарч, царай нь барайж, сэтгэл дундуур байснаас болоод нүүрэн дээр нь хар хүрэн толбонууд элбэг байгаа нь ажиглагддаг. Бидний буруу зөрүү үйлдлүүдээс болоод заримдаа түүнд ичгэвтэр байдаг байсан биз дээ.” гэсэн юм.

Итгэлын биеийн халуун ихэвчлэн 18-23 градусын хооронд хэлбэлзэж, заримдаа 34 градус хүртэл нэмэгддэг. Энэ нь түүний хувьд тодорхой учир холбогдол бүхий сүсэгтэн мөргөлчдөөс ихэнхдээ шалтгаалдаг.

Оросын буддистуудын Чуулган болон Итгэлын Хүрээлэнгээс энэхүү гоц үзэгдлийг судлах чиглэлээр зохион байгуулсан олон улсын гурван бага хурал гурвуулаа Хамба Лам Итгэлт мандал өргөх ёслолоор эхэлсэн юм. 2009 оны бага хурлын анхны өдрийн орой, баяр ёслолын арга хэмжээний дараа Хамба Лам Аюшеев, Монголын буддистуудын тэргүүн Хамба Лам Чойжамц, XIV Далай Ламын Дармасала /Хойт Энэтхэг/ дахь хувийн дацан болох “Намгъял” дацангийн Кенсур Хамба Лам Жодо Римбүчи гурав хамтдаа Итгэлын биеийн халууныг хэмжихэд оролцжээ. Дараа өдөр нь тэд биеийн халуун нь 34 градус хүрсэн тухай бага хуралд оролцогсдод танилцуулсан юм.

Хамба Лам Итгэлын нүд нь нээлттэй байхыг харсан хүмүүсийн дотроос анхны гэрчлэлийг нь 2003 онд баримтжуулан авсан юм. Дорнод Сибирийн соёл, урлагийн, улсын академийн захирал Раиса Пшеничникова: Итгэлын нүд нь ногоон өнгөтэй гэж хэлсэн юм. Буриадын драмын театрын захирал Доржо Сультимов 2004 онд мөн ингэж хэлсэн. Мөргөлчдөөс авсан судлагаанаас үзвэл

Итгэлын нүд нь нээлттэй байхыг харсан өөр бас хэд хэдэн хүн бий. Нэрт будда судлаач Линнерт Мьяль бас Хамба Ламын нүдийг харсан гэдэг “Намайг амьд байхад Хамба Лам Итгэлын гоц үзэгдлийн учрыг хэн ч битгий ойлгоосой “хэмээн нэн ихээр хүсч байна гэж тэрээр 2008 онд хэлсэн юм. /Амьд байхдаа хорвоогийн гайхамшгийг гайхамшгаар нь л мэдрэх тэр сайхан мэдрэмжээс салмааргүй байна гэсэн үг бололтой.орч /. 2007 оны 2-р сард ард олонтой уулзахаас цөөн хэдхэн минутын өмнө Хамба Лам түрхэн хугацаанд нүдээ нээснийг Константин Жалсараев гэрчилдэг. Тэр өдрөөс эхлээд тэрээр Итгэлын хүрээлэнд сайн дурын судлаачаар ажиллахаар шийдсэн юм.

Сүсэгтнүүдэд нотолгоо тийм ч их хэрэггүй бололтой. Мөргөлчдийн сэтгэл нь хөдөлж, зүрх нь догдолж байгаатай холбогдуулаад өмнө маань нэг үхмэл бие л байна хэмээн бодож эргэлзэж тээнэгэлздэг хүмүүс ямарваа тайлбар хэлж болох л юм. Гэвч аль хэдийнэ хэдэн өдөр, хэдэн долоон хоног, хэдэн сар өнгөрчихөөд байхад энэ нууцын зах зухад аль нэг хэмжээгээр хүрэлцсэн хүмүүсээс нэг нь ч аргагүй л үй түмэн асуулт гарч ирэхэд хүргэдгийг үгүйсгээгүй л байгаа билээ. Харин тэрхүү асуултуудад өгөх хариу одоогоор алгаа.

Эрдэнэт Мөнхийн Лагшинг хадгалагсадын нэг Николаев Жалсан лам:

- Хамба Лам Итгэлээс хүний ухамсрын чадамжийг нээхэд тус үзүүлдэг “хүчтэй адислал” болон “сайн эрчим” гардаг. Ингэснээрээ тэрээр бидний ухамсарт нөлөөлдөг. Түүний дэргэд байхад зарим хүмүүс чичрэх, заримынх нь толгой эргэх, хуруунуудад хатгаж өвдөх мэт мэдрэгдэх, зарим нэг нь уйлах, эсвэл түүний дэргэд өөрийгөө ямар бохир юм бэ хэмээн бодогдож ичгүүр хүрдэг гэх зэрэг нь үүгээр тайлбарлагдаж болох юм.

Түүнээс гадна Хамба Ламын нүдийг үзсэн хүмүүсийн зарим нь түүний нүд улаан өнгөтэй байсан гэж байхад зарим нь ногоон,

цэнхэр нүдтэй гэх зэргээр ярьцгаадаг. Түүнтэй уулзсан хүн бүрт өөрийн гэсэн холбоос, дүрслэн өгүүлэх боломжгүй мэдрэмж үүсдэг.

Та нар өөрсдөө үүнийг биеэрээ үзэж болно...”Билгүүн ухааны үрээр чи бодит ертөнцийн хүлээсэнд орохгүй, энэрэн нигүүлсэхүйн ачаар чи үл үйлдэхүйн амар амгаланд хэзээ ч орохгүй” гэж Ирээдүй цагийн Будда Майдар бурханы “Илт онохуйн чимэг”-т өгүүлдэг.

Итгэлийн хүч хүнийг сайн ба сул аль ч тал руу нь өөрчлөх чадвартай гэдэгт би ч итгэдэг. Хамгийн гол нь ямар учир шалтгаанаар, юунд итгэх вэ гэдэгт оршно. Тиймээс өөрийнхөө дотоодод “харьшгүй нигүүлсэл буюу өөрөөр хэлбэл бодь сэтгэлийг үүсгэсэн хүн хэзээ ч үл үйлдэхүйд ордоггүйг Хамба Лам Итгэлын үжиж муудаагүй биеийн жишээнээс үзэж болно.

Хөндлөнгөөс ажиглахад үл үйлдэхүйд байгаа мэт санагдавч үнэн хэрэгтээ хүрээлэн буй орчиндоо тийм агуу нөлөө үзүүлж байгааг нь хэмжиж тогтоох, үгээр илэрхийлэх аргагүй юм. * гэв.

2003 оны 1-р сард түүний байдаг шилэн бунханд чийгшил ердийн 67 %-иасаа 96 % хүртэл өсчээ. Гурван өдрийн туршид ийм байдалтай байсан тул эргэн тойрныхон нь энэ өөрчлөлтийн учрыг олохгүй, тархиа гашилгаж байлаа.

Итгэл 1922 онд дөрвөн ариун бумба газарт оршоосон гэж үүнээс өмнө үздэг байсан юм. Тэгээд ч Итгэлыг буцаж ирсэнээс нь хойш удалгүй 2002 оны 10-р сард Иволгийн дацангийн лам нар эдгээр бумба оршоосон газрууд дээр ёслол хийсэн билээ.

Тэр үйл явдлуудаас хойш хоёр сар болоод Итгэл дохио өгсөн юм. Ямар дохио? Ямар нэг юм нь буруутаа юу? Итгэлын хүрээлэнгийн ажилтнууд орон нутгийн иргэдээр явж судалтал бумбын тухай мэдээлэл арай өөр болж, 1912 онд төрсөн 90 настай, Зүүн оронгын уугуул Бальжинима Лодойбалова: тийм

бумба үнэндээ дөрөв биш, тав юм шүү, гол бумба гэж бас бий гэдгийг хэлэв.

- Итигэлэй Хамба төрөлх нутагтаа олны мэддэг шиг дөрөв биш, харин таван бумба оршоосон юм. Тав дахь бумба нь Оронго голын эрэг дээр тээрмийн дэргэд буй. Одоо тэнд цэнгэлдэх хүрээлэн байгаа. Өмнө нь Оронго тосгон гэж байгаагүй шүү дээ, коммуныг бүүр сүүлд 1927 онд 14 айл нийлж байгуулсан. Би бүх насаараа Итигэлэй Хамбад залбирсаар ирсэн, тиймээс ч 90 хүртэл насалсан байж болох юм* хэмээн Бальжинима авгай ярилаа.

Тав дахь бумба оршоосон газарт Иволгийн дацангийн лам нар ёслол үйлдсэний дараа Хамба Ламын шилэн доторохи чийгшил хэвийн хэмжээндээ орсон юм.

Эмээ нар урт насалдаг нь бидний аз. Тэд бүгдийг санаж байгаа нь бүр ч сайхан хэрэг. Тэр ч бүү хэл, мэдэх ёсгүй юмыг ч мэдэж байдаг. Тухайлбал, шашины зан үйлтэй холбоотой асуудалд эмэгтэйчүүд тэр бүр оролцоод байдаггүй шүү дээ. Бальжинима авгай урьд нь Баржагар (Баршагар ч гэдэг) гэдэг газарт амьдарч байжээ. Мөн тийм нэртэй уул (Жажан гэдэг нэр нь бас түгээмэл) бол намрын цагт Итгэлын бясалгадаг, эмийн ургамал түүдэг газар нь. Тэнд Итгэлын зуны цагт бясалгах үйлээ хийдэг Өндөр хэмээх ууланд оршоосонтой нэгэн адил бас ариун бумба оршоожээ.

1923 онд төрсөн Намжилма Раднаева зөвхөн дөрвөн бумба оршоосныг л мэдэж байгаа хэдий ч түүний дурсамжуудын ачаар бусад гар хийцийн эд зүйлс /тэдгээр нь хожмоо хүмүүсийн нандигнадаг ариун зүйл болсон юм/-ийг хийсэн хүнийг нь олж чадсан билээ.

- Хамба Лам Этигэлов төрөлх нутгийнхаа дөрвөн зүгт дөрвөн бумба оршоосон юм. Жажан буюу бясалгадаг газар нь бумба оршоосон газраас дээр байсан, Өндөр хэмээх уулан

дээрх болон Баржгарын дээхнэ байх хоёр жажанг би сайн мэднээ.

Итгэл Хамба Өндөр гэдэг ууланд чулуун дээр будгаар Бурхан Багш болон Ногоон Дара-Эх зурсан юм. 2002 онд дүрс нь урссан байна лээ, түүнээс өмнө бол өчигдөрхөн л зурсан юм шиг сайхнаараа байдаг байсан гэж ярьсан юм.

2002 оны 11-р сард лам нар, мөн Буриадын телевизийн бүлэг оролцсон жирийн иргэд Сэлэнгийн эрэг дээр бумба оршоосон газрыг анх удаа эрж явахад эргэн тойрны газар бүгд хөлдүү байхад харин ариун бумба оршоосон газар гэсгэлэн байсан сонин тохиолдол гарч билээ.

2003 оны 5-р сард Хамба Лам Аюшеевын даалгавраар Иволгийн дацангийн лам хуврагууд болон Итгэлын хамаатнууд Талын Овоо гэдэг газарт түүний оршоосон бумбуудын нэгийг нь эрж олоод, гаргаж ирсэн юм.

2003 оны 5-р сард бумбыг гарган ирж шинэчлээд түүнийг дараа нь уг газарт нь эргүүлэн оршоож, харин яг ижил хийснийг нь Итгэлын ордны сууринд хийсэн юм.

Бумбын байгаа газрыг яг тод тодорхой бичих онцын шаардлага үгүй байх. Харин бумбыг хоёр метр гаруйтай нилээд гүнд хавтан маягийн хавтгай чулууны доор оршоосон аж.

Түүнд хүрэхээр ухаж байх зуур нэг яс олдсон боловч фото аппарат, дүрс бичлэгийн төхөөрөмжөөр баримтжуулах гэхэд аль аль нь ажиллахгүй байлаа. Ухаж байх явцад Дашинима лам байнга залбирал ном уншиж байлаа. Чулуун хавтан (доод хэсэг нь цантсан)-г гаргаж ирэхэд нарсны шилмүүсээр бүрхэж тавьсан бумба шууд харагдлаа.

1922 онд Итгэл энэ бумба дотор чухам юу хийгээ бол? Түүний дотор, тухайлбал, “Зонхов бурхан” (Зонховын баримал дүр) болон ариун бумбад хийдэг бусад үнэт эрдэнэс оржээ.

Доржиев Бимба лам:

- Хамба Лам Итгэлын ордны барилгыг эхлэж байсан үе 2003 оны 6-р сарын 26-ны 18 цагт сүмийн сууринд ёслолын зүйлсийг хийхэд Хамба Ламын шилэн хорго дотроосоо бүрэн цантжээ. Биенээс нь дулаан ялгарч байгааг би ойлгосоон. Харин өглөө 8 цагт биенээс нь амгалан тайван байдал мэдрэгдэж байлаа. Өдөр дундын хэрд биенээс гарах амин гүйдлийн хэмжээ нь хааяа ихэсч, ногоовтор нүдээрээ зарим үес намайг ажиглан харах нь ч мэдрэгдэнэ. Мөргөлийн ёслолын үед өөр бусад тиймэрхүү юмс олон гардаг* гэж ярив.

2003 онд Иволгийн дацанд Хамба Ламын ордон барьж эхэлсэн ба 1905-1906 онуудад Итгэлын бариулсан Диваажин дуганын загвар төсөл хадгалагдан үлдсэн байсны дагуу тус Ордонг бариулсан юм.

Хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг Москвагийн нэгэн нэртэй бизнесмен ихээхэн хөрөнгө оруулснаар ордон баригдаж эхэлсэн. 2002 оны 10-р сарын 28-нд Итгэлт анх удаа хүмүүсийг мөргүүлэхэд тэр ирсэн хүн. Удалгүй тэрээр Москвад автомашины аймшигт осолд орсон боловч амьд үлдсэнийг нь нүдээр үзсэн хүмүүс гайхацгаадаг. Ийнхүү “хоёр дахь удаадаа төрөл олсон”-ыхоо дараа тэр шууд л Улаан-Үдэд нисэн ирсэн юм.

Машин мөргөлдөх үед цаас шиг үнгэгдэн нугаларалдаж байгаа төмрийн дотроос түүнийг Хамба Лам Итгэл гаргаж ирж байгаа дүр зураг нүдэнд нь тод харагдсан гэдэг.

Тэр хүн мөргөж залбирахаар иржээ. Одоо бол ерөнхийдөө тиймэрхүү тохиолдол нэн олоон. Мөн энэ түүхийн талаар давтан Жалсан лам өгүүлсэн нь:

- Хамба Лам тэр хүний үйлийн үрд нөлөөлж, “муу үйл”-ээс учрах ёстой гайгийг нь зайлуулсан гэж би итгэлтэй хэлж чадна. Буддизмд үхлийн мөч өөрөө нэн чухал үүрэгтэй байдаг, тиймээс насны эцсийг үзэх цаг ойртож байгаагаа мэдэж, мэдэрч байх нь

чухал. Залхаан цээрлүүлэлтийн үед лам нарыг буудан хороодог байхад тэд бодол санаагаа төвлөрүүлэн, ганц ч үг ганхийлгүйгээр, харин ч өөрийнхөө нас эцэслэх цагаа яг таг мэдэж байгаадаа баярлан үхлийг хүлээж авдаг байсан. Тиймээс Хамба Лам Итгэлт итгэж байгаа хүн хэзээ ч цаг бусын үхлээр үхэхгүй, шавь нараа Тэрээр заавал урьдчилан сэргийлнэ гэдэгт би итгэлтэй байдаг гэсэн юм.

Дараа нь тэр бизнесмен: “Та нар цаашдаа юу хийх гэж байна вэ? “гэж асуусан юм. Энэ бол чийгшилийн заалт хэт ихэсч, цаашид яах вэ хэмээн үргэлж л хэлэлцэж байсан үе бол 1-р сард байлаа. Итгэлыг байлгаж байх дуган барих хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрээд байлаа. Бизнесмен яваад удалгүй ихээхэн хэмжээний тоосго авчирснаар барилгын ажил эхэлсэн юм.

Мөн тэр үеэр Анатолий Чубайс ирлээ. “Түүнд ямар ч хүсэлт, гуйлт битгий тавиарай” гэж Хамба Лам Аюшеев лам нар, ажилтнууддаа хатуу сануулсан байсан юм. Чубайс үүгээр түүгээр явлаа, үзлээ. Дараа нь: “Та нөхөд яаж шуухан амьдарч байна даа.?. Яагаад ч юм танай Буриадад мөнгө байхгүй л харагдаад байна” гэж байна. Тэгснээ: дацангийн хэрэглэж буй цахилгаан эрчмийн төлбөрийг би хариуцан төлж баймаар байна гэв.

Хамба Лам Итгэл өөрөө өөртөө ордон бариулсан гэж ихэнх нь хэлцгээдэг.

3.12. Хоосон чанар

Лам нарын хүсэлтээр агуу их Ламтан маань 50 гаруй ном бичсэн юм. Тэдгээрийн олонхийг нь шашны уламжлалт нэрээр бичсэн байх тул зохиогчийг нь тогтоох, орчуулах, тайлбарлах, тайлал хийх оролдлого одоо ч гэсэн үргэлжилсээр байна. Гараар бичсэн бүтээлүүдээс олдоогүй нь ч нэлээд буй. Тэдгээрийг хэзээ бидэнд өгөхөө Итгэл өөрөө шийднэ . Биднийг оюуны зохих төвшинд хэзээ хүрэх нь вэ хэмээн тэр харж байгаа байх гэж Ганжур лам үздэг.

Гэхдээ хамгийн гол ном нь Бурхны сургаалыг эзэмшүүлэхийн тулд бидэнд үлдээсэн бие нь юм гэж лам нар ярьдаг. Хүний боломжийн талаар бодитойгоор үзүүлсэн сурах бичиг бол энэ мөнхийн лагшин мөн.

Янз бүрээр уншиж болноо. Дэлхийн бүх тивүүд энэ биеийг сонирхож, Америк, Африк, Европ, Азиас түүн рүү ирцгээж байна. 2002 онд Итгэл руу 3000 хүн ирсэн бол 2003 онд 20 мянга, дараа жил нь дахиад л бүүр ч нэмэгдэж 200 мянга, 2005 онд 350 мянга, 2006 онд мөргөлчдийн тоо хагас саяд хүрсэн юм. Тэр хөндийд километр хэрийн урт дараалал үүсдэг ба Итгэл өөрөө түүнийг зохицуулдаг гэж лам нар ярьдаг.

Итгэлын хүрээлэн эрдэмтэдтэй хамтран энэхүү гоц үзэгдлийг гүн ухааны, түүхийн, байгалийн шинжлэх ухааны болон бусад бүх талаас нь шинжлэн судлах зорилт тавьдаг. 2004 онд тус хүрээлэн Оросын Нийгмийн Шинжлэх Ухааны улсын их сургууль (ОНШУУИС)-тай хамтран Хамба Ламын Эрдэнэт Лагшинг бүх талаас /үс, арьс, хумсны бихимийн шинжилгээ/ нь шинжилж байна. Энэ ажилд тухайн чиглэлдээ нилээд нэр хүндтэй шилдэг мэргэжилтнийг бид оролцуулж байгаа. Тухайлбал, ОХУ-ын Эрүүл Мэндийн Яамны шүүх эмнэлгийн шинжилгээний Оросын төвийн хувь хүнийг адилтган судлах хэлтсийн эрхлэгч, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Виктор Звягин байна.

Түүний сурах бичгүүд манай орны шүүх эмнэлгийн шинжээчдийн гарын авлага болдог ба Оросын эзэн хааны гэр бүлийн биенээс үлдсэн үлдэц дээр хийсэн шинжилгээгээр нь түүнийг өргөн олон мэддэг. Ариун гэгээнтнүүдийн өөд болсон шалтгааныг олж тогтоохын тулд тэдний занданшуулсан шарилыг судлах ажилд үнэн алдартны шашныхан Звягиныг татан оролцуулдаг юм.

Бүх Оросын Бурхны шашинтны Чуулган болон Бандид Хамба Лам Аюшеевын шийдвэр ч гэсэн: хэрвээ Итгэлын биед хэн нэгэн эрдэмтэнг ойртуулан судлуулах бол тэр хүн салбартаа тэргүүлэгч мэргэжилтэн, гаргасан үнэлэлт дүгнэлт нь нэр хүндтэй байж чадах хүн байх ёстой гэдэг.

Гэхдээ судлагаа шинжилгээ хийж эхлэхээс өмнө яршиг төвөгтэй асуудал байлгүй л яахав. Хамба Лам Аюшеев Звягинаас: “Виктор Николаевич, та ингэхэд хэдэн настай билээ?” гэхэд “Би жаран тавтай” хэмээж. Аюшеев: “Юу л даа, би таныг Итгэл дээр очих хэрэггүй гэж зөвлөмөөр байна. Өдий нас хүртлээ таны хуримтлуулсан хамаг мэдлэг тань утга учраа алдаж болзошгүй гэдгийг та зөв ойлгоорой. Та хэзээ ч нүдэндээ үзэж байгаагүй зүйлтэйгээ учрана шүү. Тэгэхээр та цаашдаа яах болж байна? Таныг Итгэл дээр очоод хэрэггүй гэдгийг би хүн ёсоор танд зөвлөмөөр байна” гэж. Звягин бодолхийлснээ: анхааралтай, чин сэтгэлээсээ байж чаднаа гэх мэтээр Аюшеевт ойлгуулж чадсанаар ажлаа эхэлсэн юм.

Буриад улсын шүүх эмнэлгийн товчооны захирал А.Югов, Чуулганы эмч А. Ажеев, бас лам нар тэр ажилд оролцсон юм. Шинжилгээний явцад профессорын хүссэнээр Хамба Ламын хөлийн хурууны хумснаас жаахныг авч, Итгэлын толгойноос унасан дөрвөн ширхэг үс, арьснаас хогжрон унасан жижигхэн хэсгүүдийг авч өгчээ. Бүх үйл явдал сүмийн хоёрдугаар давхарт болж өнгөрчээ. Тэгээд бууж явахдаа Звягин, Ажеев нарын хооронд маргаан үүсэв. Тэр биенээс таатай үнэр үнэртэж байсан гэж Звягин хэлэхэд Ажеев гараа савж: “Энэ бол таны

зүгээр л хийсвэр бодол” гэж хэлжээ. / Гэхдээ Итгэлын өмсгөлийг нь солих, биеийг нь арчих үед түүнээс таатай үнэр үнэртдэг тухай Бимба лам нэг бус удаа хэлж байсныг энд тэмдэглэн хэлүүштэй /.Шинжилгээ дууссаны дараа би В.Н.Звягинаас: Итгэлын нүд ямар байна? гэж асуулаа. Профессор: “Би чин үнэнийг хэлж байна шүү, Хамба Ламын нүд эрүүл хэвийн байна” гэсэн юм.

Мэргэжилтнүүдийн дүгнэлт

Москва хот.

2004 оны 11-р сарын 16

XIV Бандид Хамба Лам Дамба Аюшеевын хүсэлт хийгээд адистэд зөвшөөрлөөр ОХУ-ын гавъяат эмч, анагаах ухааны доктор, профессор В.Н.Звягин (ОХУ-ын Эрүүлийг Хамгаалах Яамны Оросын шүүх эмнэлгийн шинжилгээний төвийн техникийн шинжлэх ухааны дэд доктор В.В.Королев (ОХУ-ын Эрүүлийг Хамгаалах Яамны Оросын шүүх эмнэлгийн шинжилгээний төв) нар 2004 оны 11-р сарын 4-нд Хамба Лам Итгэл (1852-1927 он) -ын биед үзлэг хийх явцад биеийнх нь хэсгүүдээс дээжлэн авч шинжилгээ хийж үзлээ.

Үйл явцын товч өрнөлийг 2004 оны 11-р сарын 4-нд Хамба Лам Даша-Доржи Итгэлын биед үзлэг хийсэн тэмдэглэлд тусгасан буй. Үзлэг хийх явцад бидэнд доорхи зүйлсийг биеэс нь авч өгсөн. Үүнд:

дээж-1. Хөлийн тавхайнаас хуурсан арьс (500 мг), дээж-2. Өлмийн I - II хурууны хумсны захаас нь авсан хоёр хэсэг жижигхэн хумс (4 мг), дээж-3. Толгойн зулай, чамархайн хэсгээс авсан, 10 мм орчим урттай 5 ширхэг үс (1 мг орчим) зэрэг нь хэт улаан туяаны шинжилгээ явуулахад хангалтгүй байлаа.

Шинжилгээ хийхэд

“Perkin Elmer” фирмын “Paragon 500” маркийн төхөөрөмжөөр хэт улаан туяаны солонгон задлагийн гэрэл хэмжих (ИК

спектрофотометрия) аргыг ашигласан. Хянах зориулалтаар дээжүүдийг тодорхой нэг ижил шахмал хэмжээгээр шинжилсэн.

Хяналтын дээж болгож насанд хүрсэн эрчүүдийн арьс, үсний хэсгүүдийг ашигласан юм.

Шинжилж байгаа болон хяналтын зориулалттай зүйлсийг 15 минутын туршид гартааман ууранцарт сайтар нухаж нунтаглав. Гарсан нунтагаас 2,5 мг-ыг хэмжин авч сайтар хатаасан 250 мг KBr-тэй холиод дараа нь дахиад гартааман ууранцарт (10 минут) үрэв.

Холилдсон нунтгийг шахмалын хэвэнд хийж, шахагчийн доор байрлуулаад 1 тоннын даралт өгсөн, дараа нь шахмалынх нь хэвнээс форвакуум насосоор хийг нь гаргасны /2 минут / дараа шахмалд үзүүлэх даралтыг 10 тонн болгон нэмэгдүүлж 2 минутын турш барьсан. Буй болсон шахмалыг хэвнээс нь гаргаж солонгон задлагийн гэрэл хэмжүүрийн харах суваг дээр байрлуулав.

Шинжлэгдэж буй зүйлсийн хэт улаан туяаны солонгорлыг гэрэл хэмжүүрт суурилуулсан цахилгаан тооцоолох төхөөрөмж /ЭВМ/ болон “Hewlett Packard” фирмын HP Deskjet 880C принтерийн тусламжтайгаар хүлээн авч цаасан дээр буулгасан юм. Харьцуулах дээж болгож KBr-ийн нунтгийг сайтар хатааж, нухан мөн дээрх аргаар бэлдсэн KBr-ийн шахмал нунтгийг ашигласан юм.

Шахмалын солонгорол (спектр)–ыг $450\text{-аас } 4000\text{ см}^{-1}$ ба $450\text{-аас } 2000\text{ см}^{-1}$ –ийн (фото зураг № 19-22) хоорондохи хэлбэлзэл дээр бүртгэн авлаа.

Хэт улаан туяаны солонгорлын утгыг Л.Л.Шафранскийн арга¹-аар тайлсан.

Өөрийнхөөрөө байгаа арьс, хумсны дээжүүдийн хэт улаан туяаны солонгоролд ихэвчлэн $500\text{-}650\text{ см}^{-1}$ -ийн орчмын PO^{3-}_4

хэлбэлзэл /хэв гажих хэлбэлзэл/, $900-1150\text{см}^{-1}$ -ийн хэлбэлзэл (валент чанарын хэлбэлзэл)-үүдтэй холбоотой анионы CO_3^{2-} 880, 1400 болон 1460см^{-1} -ийн шингээлтийн зурвасууд, мөн метилийн CH_2 болон CH_3 бүлгүүд / -2970см^{-1} -ийг оролцуулсан уургийн хэсгийн / амид III 1240см^{-1} / амид II 1540см^{-1} , амид I 1660см^{-1}) хэлбэлзлүүдэд хамаарах шингээлтийн зурвасууд илэрч байлаа.

Арьс, хумснаас авсан дээжүүдэд хэт улаан туяаны солонгорлын шинжилгээ хийж үзэхэд Итгэлын биеэс авсан дээжүүд нь хяналтын дээжээс солонгорлоороо доорхи байдлаар ялгаатай байлаа. Үүнд:

Арьс - $1057,4\text{см}^{-1}$ -ийн хэсэгт
Хумс – $601,0\text{см}^{-1}$, $1058,4$ хэсгүүдэд

Солонгорлын дээр дурьдсан хэсгүүд арьс, хумсны, PO_4^{3-} хэлбэлзлүүдтэй холбоотой органик бус бүрдлүүдэд хамаарна. Харин карбонат болон уургийн бүлгүүдийн тухайд бол шинжлэгдэж байгаа болон хяналтын дээжүүдийн хооронд ямар нэг ялгаатай байдал илрээгүй

Дүгнэлт:

Хамба Лам Итгэл (1852-1927)-ын биеэс авсан арьс, хумсны дээжүүдэд хэт улаан туяаны солонгон задлагийн гэрэл хэмжүүрээр шинжилгээ хийж үзэхэд тухайлбал фосфатын бүлгийн зэрэг органик бус бүрдлүүдтэй холбоотой үл ялих өөрчлөлт илэрлээ.

ОХУ-ын гавъяат эмч, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор В.Н.Звягин

Техникийн шинжлэх ухааны дэд доктор В.В.Королев

Профессор В.Звягины амаар тайлбарлан ярьснаас дурьдая: “Биеийнх нь эдүүдийн байдал амьд сэрүүн байх үеийн

үзүүлэлтүүдтэй бүрэн тохирч байна. Итгэлын бие шиг ингэж хэвээрээ хадгалагдан үлдсэн тохиолдолтой бид урьд өмнө хэзээ ч тулгарч байгаагүй. Энэ бол шинжлэх ухааны нэгэн үл тайлагдах нууц юм даа” “Хамба Ламын биеийн олон үзүүлэлтүүд амьд хүний бие гэсэн сэтгэгдэл төрүүлж байна. Арьс нь уян зөөлөн, үе мөчүүд нь хөдөлгөөнтэй гэх зэргээр. Биеийнх нь эдээс дээжлэн авч хэт улаан туяаны гэрэл хэмжүүрээр бид үзэхэд миний хувьд тун ч санаанд оромгүй байдалтай тулгарч эдийн бүрдэл нь амьд хүнийхээс бараг ялгарах юмгүйг нүдээр үзлээ” гэсэн юм.

Хүний биеийг хэвийн хадгалахын тулд занданшуулах, хатаах гэх зэрэг шинжлэх ухаанд нэгэнт илэрхий болсон зохиомол аргуудын нэгийг нь ч энэ тохиолдолд хэрэглээгүйг эрдэмтэд нотолсон билээ. Нээлт хийж уураг тархи болон дотор эрхтнүүдийг гаргасан буюу тариа, зүслэг гэх мэтийг хийсэн гэх ямар ч ул мөр илрээгүй.

Мэргэжилтнүүдийн дүгнэлтийн талаар хуврагуудын Чуулган болон Итгэлын хүрээлэн Буриадад мэдээлэл түгээж байна. Звягины бүлгийнхний хийсэн шинжилгээний үр дүнг Орос Улсын ерөнхийлөгчийн ажлын алба удалгүй Москвад олон нийтэд мэдээлэх тухай санал ирж байна. 2004 оны 12-р сарын 1-нд Итгэлын хүрээлэнтэй зохицсоны үндсэн дээр “Интерфакс” мэдээллийн агентлагт ОНШУУИС-ийн профессор Г.Ершова хэвлэлийн бага хурал хийлээ.

Хэдэн хүний хэлсэн үгийг “Интерфакс”-ын материалаас дурьдая:

...”Буддын нэг ламын бие өөрчлөлтгүй хэвийнхээрээ байгаа асуудалд хийсэн шилжилгээний шуугиан дэгдээсэн үр дүнгийн талаар Лхагва гарагт Москвад мэдээллээ.” Оршуулснаас нь хойш 75 жилийн дараа биеэс нь авсан дээжээс үзвэл энэ өөд болсон хүний арьс, үс, хумсны химийн үйл явц нь амьд хүнийхээс ямар ч

ялгаагүй байгаа талаар түүхийн шинжлэх ухааны доктор, ОНШУУИС-ын профессор Галина Ершова ярьлаа.

...”Түүний үч мөчүүд нь нугарч, зөөлөн эдүүдийг дарж үзэхэд амьд хүнийх шиг байсан . Дотор нь ламын биеийг 75 жил байлгасан бунханг нээхэд дотроос нь таатай үнэр гарч байлаа” гэж Г.Ершова хэллээ. Түүний хэлснээр: “Энэ бол оршуулаад 75 жил болсны дараа хүний бие ямар болох ёстой тухай бидний төсөөллөөс тэс ондоо байлаа” гэжээ. Ийм зүйл болж байсан тухай баримт зөвхөн буддизмын түүхэнд төдийгүй хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө ерөөсөө хэзээ ч байгаагүй гэдгийг Г.Ершова бас нэмж хэлсэн.

...Хэвлэлийн бага хурал дээр мөн эдүгээгийн Бүх Оросын уламжлалт Бурхны шашинтны Чуулганы тэргүүн Дамба Аюшеевын өгсөн ярилцлагын хэсгээс үзүүлжээ. Аюшеев: “Энэ гоц үзэгдэл сүсэгт буддистуудын итгэл бишрэлийг улам нэмж, эргэлзэгчдийн эргэлзээг нь арилгаж, харин үл итгэгсдийг эрхбиш эргэцүүлэн бодоход хүргэсэн юм” гэж хэлжээ.

Гадаадын сэтгүүлчид энэ асуудлыг мөн асар ихээр сонирхож байсан болохоор арван хоёрдугаар сарын 21-нд Москвад суугаа гадаадын сурвалжлагч нарын холбооны Ерөнхийлөгч ноён Адиб Аль Саедын хүсэлтийн дагуу профессор Виктор Звягин бид хоёр Оросын “Новости” мэдээллийн агентлагт хэвлэлийн бага хурал бас хийсэн.

Профессор Звягин: өөд болсны дараа ийм байдалтай байгаа биеийг хүн төрөлхтний түүхнээ анх удаа шинжлэн үзэж, бичиг цаасан дээр тодорхойлж байнаа, Хамба Ламын биеийн байдлыг илэрхийлэн хэлэх нэр томъёо байхгүй гэсэн юм.

“Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл” эсвэл “үхлийн дөрөв дэх байдал” гэсэн нэр томъёог шинжлэх ухааны эргэлтэд оруулах саналыг тэрээр гаргасан юм. Мардагнах буюу занданшуулах /байгалийн эсвэл зохиомол/, хүлэрт шүүлэх, мөн жировоск

/тосоор лавдах замаар биеийн эд эрхтэнг саван мэт болгох / гурвыг хүмүүс аль эртнээс мэддэг. Звягин чухамхүү яагаад энэ байдлыг ер бусын гэх атлаа яагаад үхэл мөн гэж үзэж байгаа гэж үзэж байгаа талаар асуухад профессор өөрөө: биед үзлэг хийхэд биеийн халуун нь 20 градусаас хэтрэхгүй байсан болохоор амьд гэж үзэх боломжгүй хэмээсэн юм.

Мөн Ершова өөр нэг хэлсэн үгэндээ:

- Энэ ертөнцөд албан ёсоор бүртгэгдсэн ийм төрлийн үзэгдэл өөр хаана ч байхгүй. Дашрамд өгүүлэхэд Төвдөд бараг л хоёр хүн бүрийн нэг нь ийм байдалд орчихоод мянга мянга жилээр байгаад байдаг гэх яриа олонтаа сонсогддог. Гэвч тийм баримтыг эрдэмтэд үзэж нотлосон нь нэгээхэн ч үгүй. Төвдөд, Зүүн Өмнөд Азид байгаа тэдгээр лам нарын биеийг /шарилыг/ үзэхэд амьд гэж санагдахгүй төдийгүй, лак, алт зэргээр бүрсэн байдаг. Харин урьд хэзээ ч гараагүй онцгой содон зүйл Улаан-Үдэд бидэнд тохиолдлоо гэсэн юм.

2004 оны 12-р сарын 21-нд Оросын Мэдээллийн “Новости” Агентлагт хэвлэлийн бага хурал дээр тайлбар хийж том дэлгэцэн дээр зураг дүрс үзүүлэхээр бэлтгэж байхад тэдгээрээс хоёр зургийг гэрэл зургийн болон дүрс бичлэгийн аль ч хэрэгсэл үзүүлж чадахгүй байлаа. Энэ бол Хамба Лам Заяевыг даавуун дээр урласан дүрс, Хамба Лам Итгэлын 2004 оны гэрэл зураг хоёр юм. Энэ дүрсүүд дөнгөж дэлгэц дээр үзэгдэх төдийд аппарат хэрэгсэл салчихаад байлаа. Адиб аль-Сайедын хүссэнээр дахин үзүүлэх оролдлого хийсэн боловч мөн л бүтээгүй.

Буриадад буцаж ирснийхээ дараа Хамба Лам Аюшеевт энэ талаар хэлэхэд тэрээр: Итгэл зөвхөн надад зориулж өөрөө үүнийг хийсэн хэмээв. “Яагаад” гэж асуухад: “Яагаад гэвэл түүнийг та нар Заяевын хойт дүр гэдэгт итгэхгүй. Тиймээс та нарын жирийн иргэдийн нөхцөлд нь тохируулан асуудлыг тайлбарлахыг оролдсон хэрэг” гэлээ.

Итгэлтой нэг биш удаа уулзаж байсан, өөр өөр он жилүүдэд түүнийг өөрийн биеэр харж байсан хүмүүсийн хэлж байгаагаар: тэрээр ердийн амьд организмын нэгэн адил өөрчлөгдөж байна, тэгэхдээ бүр жилээс жилд залуужиж байгаа сэтгэгдэл төрүүлдэг гэнэ. Түүний үс нь ургаж, бас харлаж, арьсных нь өнгө ч өөрчлөгдөж байгаа гэж олон хүн ярьж байна.

Буддын бурхан урлаач Александр Кочаров:

- Хэдэн жилийн туршид Хамба Лам Итгэлын биеийг үзэж ажиглаж байх боломж надад олдсон юм. “Тэр биеийг харахад жилээс жилд улам сайжирч байна гэсэн бодол надад төрдөг. Бие дээр нь хуруугаараа дараад үзэхэд зөөлхөн байгаа нь шууд мэдрэгддэг. Арьсны өнгө нь наранд жаахан борлосон хүнийхтэй төстэй. Шанаандаа бууралгүй, богинохон хар үстэй. Үе мөч нь хуучин шигээ хөдөлгөөнтэй хэвээр. Нуруу нь биеэ бариад цэх байлгадаг. Үжирч муудаж байгаа гэх ямар ч үнэр байдаггүй. Гайхалтай л даа! Үхсэний дараа ходоодны доторхи болон бие махбодын бусад хэсгүүдэд байсан нянгууд идсээр байгаад ихэвчлэн биеийг дуусгадаг гэж эрдэмтэд үздэг. Гэвч энэ тохиолдолд тийм зүйл огтхон ч байхгүй “гэлээ.

Итгэлын өнөөгийн байдлын талаар нэр хүндтэй лам нар өөр өөр санал хэлцгээдэг. Итгэл сансрын хязгаарыг гэтэлж, дахин төрөл олохгүй болсон гэж IX Богд гэгээн үзэж байгаа бол Монголын буддистуудын тэргүүн Хамба Лам Чойжамц: Итгэл бодьсадвын төлөвт хүрсэн гэж байна. XIV Далай Лам: зөвхөн цөөн хэдэн бодьсадвууд биднийг дээд хэмжээгээр энэрэн нигүүлсэхийн учир ийм байдалд хүрэх боломжтой гэлээ. Итгэл гэгээрснийхээ эцэст чухамдаа хэн болсон тухай олон үзэл байгаа талаар Дэд Хамба Очиров Дагба лам дурьдаад: “Би хувьдаа бол тэрээр Будда болсон. Би түүнд Буддад ханддагийн нэгэн адил мөргөж залбирдаг” гэсэн юм.

Йогчдын хэлж байгаагаар бол самадийн төвшинд байхад “бүдүүн биеийн “амьдралын явц бүрмөсөн зогсох буюу эсвэл

амьдын үйл явц хэдэн сая дахин удааширдаг гэх тул Итгэл самадийн байдалд орчихоод ч байгаа юм билүү. Йогч зориудын ухамсартайгаар ийм байдалд ордог бөгөөд тэр үед “нарийн бие” амьдарсан хэвээр байдаг аж. Өөрөөр хэлбэл тухайн хүний амьсгал, зүрхний цохилт эрс буурч, бодсын солилцоо удааширдаг байна. Ухамсар нь үүргээ гүйцэтгэсэн хэвээр байх боловч мэдрэмж, учир зүйн сэтгэлгээний хэлбэрээр илэрдэггүй, тэр бүхнээс бүрмөсөн ангижирсан байдаг байна.

Тэгвэл самадид орсон хүн амьдралынхаа үйл явцыг зохицуулж чаддаг уу? Лам нар, буддын үзэл судлаачид үүнд тийм гэсэн хариу өгдөг. Итгэлын сүнс нь буддын ухаанд ийм ойлголт байдаггүй ч ойлгоход хялбар болгох үүднээс энэ хэллэгийг ашигласан гэгээрэлд хүрсэн бөгөөд мэдээж биеийнхээ гадна оршин байгаа, гэхдээ биетэйгээ холбоотой, буцаад ирж бас чадна.

Буддизмаас хол хөндий боловч тайлбар олж сонсохыг хүсч байгаа хүмүүсийн хувьд “самади” гэдэг ойлголт ямар нэг юм ойлгуулах нь юу л бол. Гэлээ гээд тэд Итгэлыг ирж үзсэнээр буддистуудын олж харсныг л харна.

Үхсэнийхээ дараа биеэ амжилттай хадгалж чадсаныг гэрчлэх тохиолдол хүн төрөлхтөнд урьд өмнө байгаагүй, ганцхан мэдэх жишээ гэвэл буддын үзлийг шинэтгэгч, гэлүгваан ёсны сургаалыг үндэслэгч Богд Зонхов лам юм. Тэрээр 1357-1419 оны хооронд амьдарч байсан ба алив үзэгдлийн хоосон чанарын тухай түүний гол сургаал болох “Шүтэн барилдахуйн магтаал” нь Итгэлыг өнөөгийн гоц үзэгдлийн төвшинд хүргэх үндэс болсон юм.

Гаднаас нь харахад Зонхов яг л байгаа дүрээрээ долоон хоног хэвээрээ байсан бөгөөд энэ ертөнцөөс халин одсоных нь дараахи наймдахь өдрөөс үс нь ургаж эхэлсэн байна. Тиймээс хамаг амьд амьтны тусын тулд Буддын сургаалыг цаашид хөгжүүлэх зорилгын үүднээс түүнийг суварга Гандан Сэрдун–д байрлуулан хадгалахаар шийдэж, Лхаст байлгаж байсан байна.

Гэвч 1959 оны төвдүүдийн бослогын үеэр хятадын цэргүүд түүнийг дэлбэлсэн ажээ.

2005 оны 3-р сард Дармасалад Буддын их сургуулийн захирал Раднаев Ганжур Ламд Хамба Лам Итгэлын тухай асуултад нь хариу болгож, тиймэрхүү төстэй асуудал байсан тухай IX Богд гэгээн хэлэхдээ: “Эрхмийн дээд Зонхов ламтаны тохойн чинээн бие иймэрхүү байдалд байж байсан боловч 50-иад онд үрэгдсэн гэх баримт байдаг. Бас нэг лам мөн иймэрхүү байдалд орж байсан боловч өөрийнхөө биеийг өт хорхойноос хамгаалах гээд хэрэггүй гэж шавь нартаа захисан болохоор өтөнд идэгдсэн тухай би бас сонсч байсан. Үнэнийг хэлэхэд энэ бол чухамдаа ямар үзэгдэл вэ гэдэг талаар би тайлбарлан хэлж чадахгүй... “гэсэн юм.

Итгэлын биеийн эдүүдэд төмөр, цайр, мөнгө, йод байхгүй, эсвэл бараг байхгүй шахам гэж болно. “Дотор нь юу ч байхгүй, доторхи нь хаачаа вэ?” гэж бодогддог хэмээн шинжээч Елена Александровская хэлсэн юм.

Зарим махбодууд огт байхгүй буюу бараг байхгүй тухай одоо хүртэл яагаад ч юм яригдсаар л байдаг. Гэхдээ бид энэ талаар шинжлүүлэхээр Оросын ШУА-д өмнө нь явуулахад бид маш бүдүүн тоймын шинжилгээ хийлээ, алдаа мадаг их байгаа гэсэн утгатай хариуг 2005 онд ирүүлж байсан билээ. Манай улсын химийн салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдийн нэг Мария Залетина: “Манайд ирсэн аналитик шинжилгээний үзүүлэлтүүдээс шинжлэгдэж буй объектуудын химийн бүрдлийн талаар зөвхөн ерөнхий төсөөлсөн дүгнэлт л гаргаж болохоор байна. Рентгений туяарлын аргын нэг гол давуу тал нь дээжийг өөрчилж гэмтээхгүйгээр шинжилдэг явдал юм. Гэвч шинжилгээний дүнд гарсан тоон үзүүлэлтүүд зөвхөн харьцангуй утгатай. Энэ нь ижил бус гадаргуутай объектуудыг шинжлэх тухай яригдаж байгаа хэрэг бөгөөд ийм нөхцөл арга барилынхаа талаас бол огт тооцогддоггүйтэй холбоотой юм. Ийнхүү ижил бус

гадаргуунуудын туяарлыг ойлгох, тусган авахтай холбоотой тооцогдохгүй байгаа тогтолцооны гажуудал хэдэн зуун хувьд ч хүрч болдог. Энэ нь үнэндээ бол, жишээлэхэд, шинжлэгдэж буй объектод бромын агууламж хэтэрхий их байна. Хамба Ламын арьсанд 20 % гэсэн дүгнэлтийг баттай үнэн гэж үзэх үндэсгүй, яагаад гэвэл 100 %-ийн гажуудалтай нөхцөлд энэ нь 2% гэж ойлгогдох бөгөөд гажуудал түүнээс их бол хувь нь бүүр ч багасна. Өгч явуулсан үзүүлэлтүүдэд тогтолцооны болон гажуудал үүсгэгч бусад зүйлсийг хэрхэн үнэлэх тухай зүйл огтхон ч алга.

Түүнээс гадна ийм шинжилгээ хийхэд адилтган харьцуулах дээжийг сонгон олох явдал туйлын ихээр хүндрэл учруулж байна. Хатуухан хэлэхэд энэ бол магадлал багатай зүйл. Мөн тэгээд тэдгээрийн байхгүй тухай баримт нь тоон тодорхойлолтыг бас үгүйсгэдэг. “гэсэн байна.

Түүгээр ч барахгүй Итгэл “амьд ахуйдаа өөрийгөө занданшуулах”-ын тулд ургамлын ханд, мөөг, магадгүй, амьтдын эрхтэн зэрэг тусгай зориулалтын хоол хүнс хэрэглэж байсан гэх цуу үг тархсан юм. Ийм аргаар тэрээр өөрийнхөө бие эрхтнээс байвал зохих элементыг нь гадагшлуулж, гагцхүү 35 номерын махбод буюу бромьг ихээр хуримтлуулсан гэх. Бром бол “тайвшруулагч” гэдгээр нь хүмүүс сайн мэднэ. Уураг тархины гадаргад хөөрөл, саатлын үйл явцын зохицол алдагдсан тохиолдолд, мөн нойрсуулах болон үжил эсэргүүцлийн зориулалтаар бромт эм бэлдмэлүүдийг хэрэглэдэг. Бром арьсыг хатууруулдаг болохоор аж үйлдвэрт бромт нэгдлүүдийг идээлэгч уусмалд хэрэглэдэг. Мөн модыг агаарын нөлөө, хөгц, мөөгөнцөрөөс хамгаалахын тулд бромьн уусмал шингээдэг. Бромт кали нянг устгагч бактери агуулдаг шинжтэй тул жимс, хүнсний ногоо хамгаалахад тустай.

Бром нь олонхи ургамал, мөөгт агуулагдаж байдаг тархмал махбодод хамаарагддагийг хэлэх нь зүй. Гэхдээ түүний хамгийн

гол эх ундрага нь далайн шорвог ус юм. Янгажины дацангаас хамгийн ойрын далай тэнгис хүртэл мянга мянган мод зайтай. Тэгээд бас эдгээр далай тэнгисүүд зүүн зүгт байдаг, гэтэл Буриадад ихэвчлэн баруунаасаа салхилдаг. Далайн агаар устайгаа адилхан бром маш ихтэй, гэвч баруун зүгийн хамгийн ойрхон далайн уснаас Янгажины дацан хүртэл бараг 10 мянган километрийн зайтай. Буриад болон бусад эрс тэс уур амьсгалтай газруудын агаарт байдаг бромдын агууламж далай орчмын нутгийнхаас зүйрлэшгүй бага. Түүнээс гадна загсанд бром их байдаг.

Үүнтэй уялдаад: тэгвэл, далайн орчимд амьдрагсадаас ганц нь ч Итгэл шиг өөрийгөө хадгалж чадаагүй юм бэ? гэх асуулт гарч ирэхгүй байж чадахгүй. Хэрэв үнэхээр л хэргийн эзэн нь бром юм бол тэд үүнийг хийхэд тун ч амархан байх биш үү?

Ер нь ч тэгээд хоолны дэглэм, хоол сойх гээд л өөрийгөө элдвээр зовоодоггүй хэн байгаа билээ, гэтэл яахаараа ганцхан Итгэл л үүнийг хийж чадсан бол. Магадгүй, идэж ууж байгаад нь асуудлын учир байхгүй ч юм билүү?

Эрдэмтэд нэгэнт тохиролцоогоо зөрчсөн (Александровскаягийн шинжилгээ төлөвлөгөөнд байгаагүй) болохоор 2005 оны 1-р сарын 3-нд биеийн эдээс авсан дээжийг нутаг руу нь буцаахаар шийдсэн. Үүнтэй уялдаад нэг эвгүйхэн түүх гарч ирсэн юм. Тухайлбал: Их ламтаны нүцгэн гэрэл зураг /хүн судлалын чиглэлийн шинжилгээнд зориулж ийм зураг авахыг зөвшөөрсөн юм /-ийг өөр ямар ч зорилгоор ашиглахгүй байх, ялангуяа хэвлэлийнхэнд огтын хүртээлгүй байх ёстойг эрдэмтэдэд урьдчилж анхааруулсан юм. Ер нь тийм л байдаг шүү дээ. Шинжилгээний ажлыг удирдаж байгаагийн хувьд намайг Хамба Лам Аюшеев дуудаад:

- “Эрдэмтэд хэрвээ энгийн зүйлийг тайлбарлаж чадахгүй бол цаашдаа тэд нарийн төвөгтэй рүү нь яаж орох болж байнав? Та юу гэж бодож байна вэ? Миний бодлоор бол энэ шинжлэх

ажлыг зогсоох хэрэгтэй байна, учир нь үүнд ямар ч утга алга. Хэрэв тэд хэвлэлийн бага хурал дээр өнөөгийн шинжлэх ухаан энэ гоц үзэгдлийг тайлбарлах чадамжгүй гэж мэдэгдэх юм бол ийм шинжилгээ хийхийн хэрэг юу байгаа юм?” гэж хэллээ.

2005 оны 1-р сараас Итгэлын биеийг шинжлэх ажлыг зогсоож, дээжүүдийг Итгэлын хүрээлэн рүү буцаан ирүүлсэн юм. Дахиад шинжлэх ажил хийгдээгүй.

Ариун нандин шүтээнүүд өөрсдөө ч, мөн тэрхүү шүтээнүүдээ шүтдэг хүмүүс ч аль аль нь элдэв шинжлэх ухааны шинжилгээгээр дутаагүй. Итгэл халин одоходоо өөрийнхөө биеийг шинжлүүлэх тухай ямар ч шийдвэр зөвлөмж өгөөгүй.

Итгэлын гоц үзэгдлээс үүсэн гарч буй бүх асуултуудад шинжлэх ухаан хариулт өгч чадна гэж, бичил дуран абайгаар харж, зургийг нь хэсэгчлэн авсан нь тус болно гэж бодлоо ч гэсэн буриадын энэ ламаас хүн төрөлхтний одоогийн олж аваад байгаатай зүйрлэвээс илүүтэй юм юу өгнө гэж? Хоёр мянганы зааг дээрх Итгэлын үзэгдлийн ганц л баримтын эерэг нөлөөг харгалзан үзэж: нууц бүхнийг нээх гэж оролдоод байхын хэрэг байна уу? гэх асуултыг давтан тавья.

Итгэлын Эрдэнэт Мөнхийн Лагшинг “цэргийн эмч нар” цөмийн соронзон резонанс (ЯМР-ядерно-магнитный резонанс)-ын аргаар шинжлээд эсүүд нь амьд эсийн цөм нь бүрэн бүтэн, эсийн сийвэн нь амьд эдийн шинжтэй байсан гэх мэдээлэл хэвлэлүүдэд үзэгдээд байна. Үүнтэй холбогдуулаад хэлэхэд тийм туршилт хийх зөвшөөрлийг Итгэлын хүрээлэн өгөөгүй, тийм талын бичиг цаас ч аваагүй. Тиймээс энэ ажлыг эсвэл тэдний ар хударгаар хийсэн, эсвэл бүр зохиомол зүйл гэсэн үг.

Иволгийн дацанд суудалдаа хөдөлгөөнгүй, чив чимээгүй заларсаар буй ламын талаархи эрдэмтэд хийгээд БОБШЧ-ы харилцааны арван жилийн ажил Итгэлын гоц үзэгдэл орчин

үеийн шинжлэх ухааны онолтой тохирохгүй төдийгүй, зөрчилдөж байгааг тогтоон тэмдэглэснээр дууссан юм.

Эрдэмтдийн дотроос энэ гоц үзэгдлийг ухааран ойлгохыг оролддог төдийгүй эгэлгүй эрэлхэг зориг гаргадаг зарим нь Хамба Лам Итгэлын тухай яриаг шинэ шинжлэх ухаан буй болгоход түлхэц болгох үндэслэл хэмээн үзэж байна. “XII Бандид Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл” сэдэвт III бага хурал дээр Д.Менделеевын нэрэмжит ОХТИС-ийн профессор, эдийн засгийн шинжлэх ухааны доктор Александр Хачатуровын тавьсан илтгэлийн хэсгээс:

- ...Бодит ертөнцийг ер нь танин мэдэж чадаж байна уу, эсвэл бид шинжлэх ухааны аргаар хариулт өгч чадахгүй асуултуудтайгаа зууралдсаар үлдэх үү? Нэг бол бид асуултаа буруу тавиад байгаад ч учир нь байгаа юм болов уу? Магадгүй бид энэ ертөнцийн зөвхөн ганцхан л талыг нь танин мэдсэндээ дасчихаад хэзээ ч хариулт өгч боломгүй “шинжлэх ухааны бус” асуултууд байдаг хэмээн танин мэдэх хүрээгээ дэмий хязгаарлаад байна уу? Эсвэл Альберт Эйнштейний мөрөөр явж* өөрийн эрхээр буй байгаль орчины бүх үзэгдлүүд ба оюун санааны ертөнц хоёрын хоорондохи хав барилдлагат нэгдлийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байх. Мөн шинжлэх ухааны танин мэдэж чадахуйц илэрхий (экспликативный буюу explicate) ертөнцийн цаана, бас Орчлонг зохицол нийцэлд байлгаж чаддаг, цаг хугацаа-орон зайн хязгаарлалтад өртдөггүй илэрхий бус (имплекативный буюу implicate) ертөнц нуугдан байдаг тухай илүү нарийн эдэт оршихуйн төвшингийн талаархи Эйнштейний хамтран зүтгэгч Дэвид Бом (David Joseph Bohm)-ын онол хийгээд ертөнцийн бүрдэлзүйн зураг (голографическая картина) –ийг нь эргэн санах хэрэгтэй юм. “Хэмжих боломжгүй юмыг танин мэдэхийн тулд нөгөө л ердийн шинжлэх ухааны аргуудыг ашиглах боломжгүй “гэж Грин Брайм бичжээ**”. “Нигүүлсэл, хайр, оюунлаг чанарыг яаж хэмжих билээ? Гэхдээ нигүүлсэл ч, хайр ч,

оюунлаг чанар ч Орчлон ертөнцтэй салшгүй холбоотойгоор бодтой оршин байдгийг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй ээ”.

Орчлон ертөнц маань материаллаг хийгээд оюунлаг эх үүсвэрүүдийн нэгдэл гэдэгт Никола Тесла итгэж, ертөнцийн нийцэлт байдал байгалийн жамд тусгалаа олж, харин ёс зүйн бүрдэл нь дутуу бол хүмүүсийн чөлөөт дур зорго түүнийг зөрчихөд хүргэдэг гэж үзэж байсан юм.

Энэ бол эрэл хайгуул хийж явсаар ертөнцийн материаллаг тал нь оюуныхтайгаа салшгүй холбоотой, оюуны хийгээд жам ёсоороо байгаа байгалийн бүх үзэгдлүүд хоорондоо нэгдэлтэй, тиймээс энэ харилцан хамаарлыг хэмжиж чаддаг болохын тулд хүчин чармайлт тавих хэрэгтэй болжээ гэсэн дүгнэлтэд хүрч байгаа хэрэг. Энэ харилцан хамаарлыг хэрэгжүүлсэн, одоо ч хэрэгжүүлсээр байгаа, ингэснээрээ бидний оюун ухаан, мэдрэхүйг уриалан дуудаж буй Итгэл гэгч хүний энэ гоц үзэгдэл бол ийм харилцан хамаарал бодитой оршин байдгийн тод жишээ бөлгөө!

Итгэлын буцаж ирсэн гоц үзэгдлийг судлахад уламжлалт позитивист хандлагаар хандсанаар нөхцөл байдлыг тодруулах биш харин ч бүр орооцолдуулан үймүүлнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байгаа. Орчин үеийн шинжлэх ухаан “хялбарчил, эрхшээ” хэмээх уриатай гэж профессор Г.Г.Малинецкий бичиж байна. Ийм хандлага Итгэлын гоц үзэгдлийг судлахад ч, материаллаг хийгээд оюунлагийн харилцан хамаарлыг эрж олоход ч аль алинд нь тохирохгүй. Шинэ шинжлэх ухаан, технологийн соёл иргэншлийн хөнөөлтэй, өөрийгөө сүйтгэгч арга замын үрлэг зарлагыг бүрмөсөн үгүй хийхэд хүн төрөлхтөнд туслахуйц тийм шинжлэх ухааныг буй болгох ажилд шамдан орох хэрэгтэй байна. “Хүрээлэн буй ертөнцийн хүчин чадлыг түүнийг өөрийг нь хөнөөхгүйгээр ашиглаж чадах чадварыг оюун ухаан гэнэ” гэж ах дүү А. болон Б. Стругацкий нар бичсэн юм.

Гэхдээ одоогоор нэг талаас хуврагуудын Чуулган маань бүх туршилтуудыг зогсоож, эрдэмтдийнхээ чадамжид найдвар тавин азнаж байна, нөгөөтэйгүүр эрдэмтэд ч гэсэн гоц үзэгдлийн учрыг олох гэж нэг их хүчлэн чармайхгүй байна. Ершова-Звягины шинжилгээ өөрт нь зөвшөөрөгдсөн “оршуулалтын онцлогийг нь судлах” чиглэлээр л явагдсан юм.

Профессор Ершова тухайн сэдвээ дуусгаад өөрийнхөө дүгнэлтийг танилцуулахдаа: Итгэл үхэлд автаж энэ ертөнцөөс явсан биш, харин зохиомлоор өөрийгөө амьгүйдэлд оруулсан байна. 75 жилийн туршид тэрээр “хөнгөн амьсгал” өнгөцхөн төдий амьсгалдаг йогчдын нэр томъёог ашигласан байж болох юм гэсэн билээ. Гэхдээ Ершовагийн үзэж байгаагаар бол Хамба Ламыг бунхнаас нь агаарт ил гаргаад ирэхээр биеэс нь чийг огцом ихээр гадагшилсан гэнэ. Үхэх үед хүний бие махбод огцом түргэн чийгээ алддаг – гээд Ершова: Итгэлыг суулгасан байсан шилэн бунхан 2003 оны 1-р сард гэнэт цантсан доторхи чийг нь 67-оос 96 % хүртэл өссөнийг эргэн дурсаад: энэ бол Агуу Их Багштаны бүрмөсөн энэ ертөнцөөс халин одсон цаг мөч гэж тайлбарласан ба Итгэл амьд эргэн ирнэ гэсэн амлалтаа биелүүлж, сэтгэл оюуны хязгааргүй хүчийг нотлон харуулсан “түүнийг би чин сэтгэлээсээ бахархаж байна” гэсэн юм.

Ершовагийн хэлж байгаагаар бол Итгэл эргэж ирээд бидний дунд дөрвөн сар амьдрахдаа үхэх үйл явц нь үргэлжилсээр байгаад дараа нь бүрмөсөн явсан болж таарах нь ээ? Өөрөөр хэлбэл, үлгэр домогт гардаг шигээр эрчмээ хааяа алдан амьгүйдэлд нэг хэсэгтээ байж байгаад тэр нь мөнхийн нойрсолт болж хувирсан байх уу? Тэгэхээр ламтаныг сэрээх арга олдоогүй байх нь ээ? Эсвэл сэрээх хэрэггүй гэж шийдсэн хэрэг үү?

Хэрвээ Ершовагийн хэлж байгааг үнэн хэмээвээс үхсэн биед гарах ёстой бүх өөрчлөлтүүдийн гэрч нь бид байж таарах ёстой. Гэтэл ямар ч тийм юм болоогүй л байна.

Итгэл хэнээс ч нуугдаагүй ээ, тэрээр бүхэнд ил, түүний дотор одоогоор үзэл бодлоо илэрхийлээгүй байгаа эрдэмтэдэд ч бас ил л байгаа. Харин буддистууд, жирийн иргэд, лам нарын дунд бол дээрхээс нэлээд эсрэгцсэн бодол байдаг. Болж өнгөрсөн бүхэн итгэл үнэмшлийн үүднээс бол тайлбарлагдаж болж байгаа нь тэдэнд хангалттай бөгөөд бас буддизмын номлолтой ч бүрэн нийцдэг. Хүний талаархи буддын төсөөллийн үнэн нь ч үүгээр хангалттай нотлогддог боловч энэ тэгээд нэг их гайхаад байхааргүй зүйл бас бишээ. “

Хамба Лам Аюшеев 2007.07.2 - 2007.07.5–нд “Новая газета”–д ярилцлага өгөхдөө “Итгэл яах гэж биеэ хэвээр нь хадгалж, бидэнд үлдээгээ вэ? “гэсэн асуултад хариулахдаа:

- Өөрийнхөө биеийг яагаад хадгалан үлдээснийг хэн мэдэх билээ! Энэ бол өөрөөсөө олон олон таамаглалыг төрүүлэн гаргах нэг л оньсого таавар. Тэр чухамдаа юу өгүүлээд байна вэ? Яагаад үлдээв? Юуны тулд үлдээв? Хэрхэн тэгж үлдээв? – гээд л. Дараа нь: “Тэглээ гээд түүнээс би юу олж авах юм бэ?” гэх хамгийн амин чухал асуулт гарч ирнэ. Аль ч тохиолдолд энэ асуултаар хамаг юм дуусна. Энэ нь буриадын ард олонд, буддын үзэл үгүй ердийн эргэн тойрны хүмүүст, Оросод ямар учир холбогдолтой байна вэ? Зарим эрдэмтдийн тодорхойлж байгаагаар түүний нөлөөлөх хүрээ, тэдний нэрлэдэгчлэн “менталь бие” /нарийн эдэт бие гэж ойлгож болох юм.орч /–ийн нөлөө 20 мянган километр байдаг гэх.

Тэрээр цаг хугацааг зогсоочихсон учраас түүний биеийн дотоодод болж буй үйл явц гаднахи цаг хугацаанаас ангид гэх үзэл бас бий. Тэрээр бидэнтэй хамт бараг таван жил болж байна, асуулт гэдэг тоймгүй ээ.

Буддизмыг сонирхдог европчууд өөрийнхөө хүлээн авч чадсан мэдээллийнхээ ерөнхий хүрээнд ихэд сандарцгааж, сэтгэлийн хөөрөлд автан,нэн ихээр сонирхоцгоож байна. Хоёр-гурван жил өнгөрөх хугацаанд: энэ бол хууран мэхлэлт, нүд хуурсан хэрэг,

бие тэгээд байгаад байх боломж ерөөсөө байдаггүй, Оросын ОНМХ-ийн зүгээс тоглоом хийж байна, ерөөсөө тийм юм гэж байхгүй гэх зэргээр ярьж байна. Буриадуудын дотор бол: үүнд гайхаад байх зүйлгүй, тэгэх л ёстой байсан юм, энэ бол буриадуудын ердийн заншил, уламжлал гэх шахуу өөр нэг төрлийн туйлшрал байна. Гэлээ ч түүнийг заавал нүдээр үзэх гэхийн шаардлагагүй гэж бодож байна, тэрээр бидэнтэй хамт байхад л болно.

Энэ хоёр туйлшралын эхнийхэд нь тухайн үзэгдлийг бүрмөсөн үгүйсгэж байгаа бол хоёр дахид нь үнэндээ ердийн л асуудал гэж байна. Харин энэ хоёр туйлын дунд нь оршиж буй хүн тун ховорхон.

Тэгэхээр сэтгэлийн хөөрөлд автаж, дараа нь эргэлзэгсэдийн тухайд хэлэхэд: голын хоёр эрэг дээр нэгэн зэрэг байж байх боломжгүй, ямартай ч аль нэг талд нь гарах л хэрэгтэй. Амьдралаа эргэлзээ тээсээр өнгөрөөж болохгүй – энэ бол бидэнд тохиолдож болзошгүй хамгийн их гамшиг. Тийм болохоор эргэлзээг шийдвэртэйгээр арилгаж үгүй хийдэг. Аль нэг л талын эрэг дээр байдаг нь ертөнцийн жам.

Итгэл одоо байхгүй гэж хэн нэгэн надад хэлбэл би: Яахаараа тэр билээ, би түүнийг өдөр бүр өөрийн нүдээр харж байна шүү дээ! гэж хариулна. Мөн: тэгэх л ёстой, буриадын лам нар, нийт буриадууд бүгдээрээ өндөр хөгжсөн ард түмэн болохоор тийм өндөрлөгт гарсан юм гэвэл би бас л санаа нийлэхгүй.

Харин яагаад, яах гэж гэх мэтийн асуултуудад бид одоохондоо хариулт өгөх боломжгүй байна. Итгэлын гоц үзэгдэл хэдийгээр ердийн хэв хэмжээнээс эрс өөр байгаа ч гэсэн бид тухайн үзэгдлийг өөрийг нь ч юмуу, биеийн байдлыг нь судлахаасаа илүүтэй түүний энэ үйл ажиллагааны хүмүүст үзүүлэх үр нөлөөг нь түлхүү судлаж байгаа. Энэ нь ч хамгийн зохистой хувилбар. Орчныхоо хүмүүст тэрээр ямар байдлаар нөлөөлж байна вэ гэж. Ийм ажиглалтаас л бид дүгнэлт хийж байгаа. Харин бид гадаад

хүчин зүйлийн талаас нь асуудлынхаа мөн чанарт ойртож очих аваас: Ерөөсөө үүнд ойртож очихын хэрэг байна уу? - гэдэг асуулт гарч ирнэ.

Өөр үгээр хэлбэл Итгэлыг буцаж ирнэ гэдэгт хүмүүс бэлэн байгаагүй. Өнөөдөр ч гэсэн бараг таван жил өнгөрчихөөд байхад бэлтгэлгүй хэвээрээ л байна. Итгэлтай уулзагсадын 95 % нь хувийнхаа асуудлуудыг шийдэж байна... Өөрийн нутагт өөдтэй зөнч байдаггүй гэсэн утгатай оросын нэг улиг болсон үг байдаг. Манайхны үздэгээр бол хамаг ухаантнууд гаднынхан, бидний хэрхэн амьдрахыг тэд л зааж өгөхөөр заяасан гэцгээдэг. Хамба Лам Итгэл ирсэн нь Будда Шагжамуни ирсэнтэй адилхан гэж хэлэх гэвэл бидний хэл эвлэхгүй, аймаар зүйл, хамгийн гол амин сүнс нь алга. Тэнэг яриа их л байна. Энэ асуудлыг мэдээж нарийн нягтлан үзэх хэрэгтэй ч гэсэн ялгаагүй.

Одоо бага хурал хийх гэж байна, ард түмний шилдэг хоёр давхрага хэн нь ухаантайгаа үзэх гэж хоорондоо арсалдаж байхгүйн тулд энэ бага хурлыг шинжлэх ухааны ч гэж, шашны ч гэж үзэхгүй. Итгэлын гоц үзэгдэл бол шашины ч, шинжлэх ухааны ч томоохон хүчин зүйл мөн нь мөн. Нэгэнт бүхний сонирхлыг татаж байгаа болохоор ирцгээг, юу үзэж, юу ойлгосноо, юу хүссэнээ ярьцгааг. Тэдний өөрсөддөө итгэж үнэмшиж буй үгийг тэнд хангалттай сонсно гэсэн юм.

Итгэлыг буцаж ирснээс хойш тав дахь жилд нь 2007 оны зун БОБШЧ болон Итгэлын Хүрээлэнгээс “XII Бандид Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл” сэдвээр зохион байгуулсан олон улсын анхдугаар бага хурлын өмнө Аюшеев энэ үгийг хэлсэн юм. Өгсөн бүх үнэлэлт дүгнэлтүүд, тавьсан асуултууд чухал ач холбогдолтой хэвээр үлднэ

3.13. Эргэл мөргөл

Буддын их баярын өдрүүдийг тохиолдуулан Итгэлтой мөргөлчид жилдээ найман удаа уулзах боломжтой.

Түүнээс юу гуйдаг бол? Энэ бол үнэндээ бидний асуудал биш л дээ. Гэвч дунд хэрийн насны нэгэн эрэгтэй хүн хүүхдийн юмнууд хийсэн цүнхийг Хамба Ламын гар, өвдөг рүү дөхүүлэн тавих нь содон харагдна. Өмнө зогсох хос хоёрын гарт уул оруулан авсан цэрэг хүний гэрэл зураг харагдна. Зарим нь Итгэлын гарт боодолтой чихэр ч дөхүүлээд тавьж байна.

Хэн нэгэн рүү нь Итгэл инээмсэглэх шиг санагдсан бол, зарим нь түүнийг нүдээ нээхийг харсан байдаг, зарим нэг рүү нь Итгэл ойртон дөхөх, эсвэл мэхийх шиг ч санагдсан гээд л... Зарим нь уйлна, зарим нь инээнэ. Энэ бүх сэтгэлийн хөдөлгөөн тухайн мөргөлчид ирсэн байх үед хурж буй хурал, уншиж буй номоос бас шалтгаалдаг. Итгэлээс гарч буй эрчимд зарим нь хойшоо түлхэгдэн хөдлөх нь ч буй. Зарим хүмүүс түүнтэй уулзах үед өөрт нь юу тохиосноо хэдэн цаг, хэдэн өдөр, сарын дараа саналаа гэцгээдэг

Тэрээр аниастай нүднийхээ зовхийг нэвт харж байгаа нь олон хүнд бодитой мэдрэгдсэн байхад заримд нь тэрээр бүр гар биеэ хүргэх нь ч мэдрэгддэг. Тэрээр дэргэд нь байж, үйлдэлд нь оролцож байгааг илэрхий мэдэрсэн хүн ч бий.

Мөргөлчид урьд өмнө нь иймэрхүү домог сонсож байгаагүй ч гэсэн энэ асуудалд оролцож, татагдаж байгаа нь илэрхий байдаг.

Тухайлбал: Итгэлээс ямар нэг ганц л зүйлийг хүсэх хэрэгтэй гэх ч юмуу, түүний гэрэл зураг нь бас анагаах нөлөөтэй гэх зэргээр ярьцгаадаг.

Хамба Ламд залбирахаар цувран зогсож байгаа ард олны дотоод сэтгэл оюуны нарийн төвөгтэй асуудлуудыг яриад байж болох ч ихэнх нь өөрийнхөө ямар нэг хүслийг гүйцэлдүүлэхийн тулд ид шидтэн хэмээн үзэж ирцгээдэг нь илэрхий.

Итгэлт залбирчихаад дараа нь автын осол, нисэх онгоцны сүйрэл, гал түймэр, байгалийн гамшиг, өвчин эмгэг зэргээс гайхалтайгаар амьд гарсан түүхүүдийг энэ номд оруулахаа больё.

Бас өөрт нь ирж залбирсан хүмүүсийн үйлийн үрийг Итгэл сайн тал руу нь засан сайжруулж өгдөг гэсэн яриа бий. Хамба Лам Аюшеев ч энэ талаар тэмдэглэн хэлсэн байдаг.

2003 оны 4-р сард Бүх Оросын Бурхны шашинтнуудын Чуулган (БОБШЧ) дээр тэрээр: “Буддын шүтлэгт хүн бүхэн энэ гайхамшигт үзэгдлийн тухайд бодлоо чилээж байна, энэ насныхаа сүүлчийн мөчийг хүртэл ч энэ асуултад хариу эрсээр дуусах биз. Сүсэгтнүүд, жирийн иргэд үйлийнхээ үрийг тэгшлэхийн тулд Хамба Лам Итгэлээс адис авах гэж чармайдаг бол лам нар Хамба Лам Итгэл чухамдаа ямар аргаар ийм гоц үзэгдлийн байдалд хүрээ вэ, сансарын хүлээснээс ангижрахын тулд бясалгалынхаа үйлийг яаж үргэлжлүүлээд байна вэ хэмээх асуулттай зууралдсаар байдаг” гэж хэлсэн юм.

Итгэлын Хүрээлэнгийн ажилтнууд мөргөлчдөд гурван асуулттай анкет тарааж өгдөг. Та хаанаас, хэд дэх удаагаа залбирахаар ирж байна вэ? Итгэлт мөргөхөөр бололцоо гарсан тохиолдол бүрт, тухайлбал, гурав, тав, бүр есөн удаа ч юмуу ирдэг хүмүүс байна. Хаанаас тэд ирж байнав? Газар бүрээс л ирж байна.

“Хамба ламтай өөрийн биеэр уулзахад тань танд юу мэдрэгддэг вэ?” гэх асуултад өгч байгаа хариултуудыг зүгээр л хөнгөн дүгнээд үзэхэд олон дахин ирэх тусмаа сэтгэгдлээ илэрхийлж байгаа үгнүүд нь энгийн хялбараас эхлээд барагтай

хэрэглэгддэггүй нухацтай чухалчилсан үгнүүд рүү шилжсэн байдалтай байдаг.

Тайвширсан, бие хөнгөрсөн, амар амгалан мэдрэгдсэн гэдэг байсан бол дараа нь гайхсан, сэтгэл хөөрсөн, бахархсан, найдвар төрсөн, урам сэргэсэн гээд л, сүүлдээ бүр сүрдсэн, талархсан, сэтгэл хөнгөрсөн, онгод орсон, адреналин цутган орж ирсэн гэх жишээтэй.

“Тийм мэдрэмжийг үгээр илэрхийлэх боломжгүй”, “тайвшрах, бие хөнгөрөх байдлын ямар нэг ойлгомжгүй мэдрэмж үүссэн”, “түүний гарт нь хүрэхэд бие чичрэгнэсэн”, “нэгдмэл сэтгэгдэл бий болсон”, “ойлгомжгүй боловч нэг л онцгой мэдрэмж төрсөн”, “сэтгэл гэгэлзсэн, түгшсэн байдал арилсан”, “хамаг амьд амьтан бүхэн амар амгалан байгаасай гэж бодогдсон атлаа бас харуусах бодол төрсөн” гэх зэргээр ганц нэгээрээ сэтгэгдлээ илэрхийлж л байдаг.

“Хамба Ламтай уулзсаны тань дараа Танд ямар өөрчлөлт гарав?” гэсэн асуултад: “Би ямагт сэтгэлийн хөдөлгөөн ихтэй байдаг болохоор түүнд хэлэх гэснээ мартчихдаг”, “Ирээдүйн талаархи үзэл маань өөрчлөгдсөн”, “Бүх юм сайхан болсон”, “Бүх юм сайнаар эргэсэн”, “Миний амьдрал бүрмөсөн өөрчлөгдөж, эрүүл мэнд сайжран, амьдрал дээшилсэн”, “Түүнтэй хийсэн уулзалт бүхнийг би ихэд эрхэмлэдэг, ерөнхий мэдлэгийн хүрээ болон амьдралдаа хийж байсан олонхи асуудлуудыг хэрхэн үзэх маань ч өөрчлөгдсөн, бас хий дэмий үймж бужигнахаа больсон”, “бүх юм сайнаар эргэсэн, санасан бүхэн бүтэж байна” гэх зэргээр хариулцгааж байлаа.

Иймэрхүү судалгааг Итгэлын хүрээлэн 2003 оноос эхлээд жилд 8 удаа буюу өөрөөр хэлбэл Хамба Лам Итгэлт залбирах өдрүүдэд хийж байгаа. Материалуудын нэлээд хэсгийг Буриадын улсын их сургуульд, нийгэм судлалын шинжлэх ухааны доктор Э.Дагбаевт шинжлүүлэхээр өгсөн. Профессор энэ талаар: 4 хурлын үеэр мөргөлчдийг чөлөөт байдлаар сонгон авч асуулт

тавьжээ. Бүгд 167 хүнд асуулт тавьсан байх ба хурал бүрийн үеэр асуулт тавьж ярилцсан хүмүүсийн тоо харилцан адилгүй байна.

30 хүртэлх насны	38 хүн
31—45 насны	56 хүн
46—60 насны	60 хүн
60-аас дээш насны	13 хүн байна.

Бидний хувьд мөргөлчдийн ирсэн учир шалтгаан, тухайлбал, Бандид Хамба Лам Итгэлын ариун лагшинд мөргөхөөр яах гэж, ямар хэргээр ирснийг нь сонирхсон. Бүх мөргөлчдийг нийгмийн шинж чанараас нь үл хамааран, зөвхөн учир шалтгааны талаас нь дөрвөн бүлэгт хуваан үзэж болох байна.

Бүх хариултуудаас үзэхэд 41,9 % нь залбирч мөргөхөөр иржээ.

Хоёрдугаар байранд хувийн хэрэгцээ сонирхлоор ирэгсэд орж байна. Үүнд хувийн ямар нэг асуудлаа шийдвэрлэх шаардлага тулгараад түүнийгээ ийнхүү залбирч мөргөхтэй шууд холбон үзэгсэд 19,1% байна.

Адис хүртэхээр ирэгсэд 17,1 % байна.

Нэг л шалтгаанаар гэхүйц санаа сэдлээр нь ийнхүү ангилах нь эхэндээ зөв гэж болмоор “дээрх бүх” гэсэн утгаар хариулсан дөрөв дэх хувилбар хариулт өчүүхэн хэсгийг буюу 6,6%-ийг эзэлж байна.

“Тэгэх хэрэгтэй”, “Хамаатнууд маань ингэ гэсэн” гэх зэрэг өөр хувилбар хариултууд ч буй. Эдгээр бол зүгээр л тодотгох, тэмдэглэн хэлэх төдий хариулт.

Хүмүүс ихэнхдээ залбирахаар л ирдэг, энэ нь сэтгэл- оюун, зан суртахууны төгөлдөржилт, оюуны хөгжилтэй мөргөлийг холбон үзэж байгаа хэрэг. Сэдлийн шалтгаан нь мөргөлчдийн сэтгэл хөдлөлийн байдалтай нь нягт холбоотой.

Биеийг очиж үзэх явцад танд юу мэдрэгддэг вэ? гэж асууж байгаа нь нэлээд нарийн төвөгтэй асуулт юм. Сэтгэлийн хөдөлгөөний хүрээ хязгаар янз бүр байдаг ба тэдгээр байдлыг дарвөн бүлэг болгон авч үздэг.Үүнд:

Асуудлын гүнд нэвтэрсэнтэй холбоотой (сүрдэх, заримдаа гайхах, цочирдох – энэ бүхэн асуудлынхаа гүн рүү орсоньг илтгэх бөгөөд тиймээс бид энэ бүлгийг эхнийх гэж үздэг) – 20,2 %

“Тайвшрал, амар амарлингуйн” байдлаар тодорхойлогдох бүлэг хариултууд 42,8%

мөн “Аз жаргал, баяр баясгалан” – 36%

дээрх бүгд нийлсэн 4 %

Мөргөлчид асуудлаа шийдэх гэхээсээ амар амгаланг олох гэж ирдэг нь илэрхий байна. Хүн амар амгалан, баяр жаргалтай байдалд орж байгаа болохоор мөргөл энэ тохиолдолд ямар нэг нөхөн тэгшитгэх байдлын үүрэг гүйцэтгэж байна.

Мөргөж залбирсны дараа хүний амьдралд ямар өөрчлөлт гарав, юу мэдрэгдэв гэдэг асуулт чухал асуулт болж байгаа юм.

Хариултаас үзэхэд арай өөрөөр буюу 35,5 %-иар илэрхийлэгдэж байгаа ч гэсэн “оюун ухаан-ёс суртахууны төгөлдөршил” тэргүүн зэрэгт байна.

Дараа нь 28,5%-ийг эзлэж байгаа сэтгэлийн амар амгалан. Асуултад хариулагсадын 14% нь өөрчлөлт гараагүй гэж үзжээ. Мөргөлчдийн, барагцаалбал, арав орчим хувь нь хэрэглээний ашиг сонирхлын үүднээс ирдэг бөгөөд мөргөсний дараа ямар нэг хэрэглээний ашиг тус олсон гэх хүмүүс 12,5 % байна.

Ингэж асуулга явуулснаар хоёр, гурав, дөрвөн хэмжээст загвар бүтээх, өөрөөр хэлбэл нийгмийн үнэлэмжүүдийг зорилго шалтгааны,сэтгэлийн хөдөлгөөний харилцаатай, амьдралд гарсан өөрчлөлтүүдтэй холбох боломж олгодог. Шалтгаацах хамаарал (корреляция)-ыг энд ашиглаж болох юм.

Ерөнхий хандлага нэлээд байгаа нь харагдаж байна. Санаа сэдлийн талаасаа гэвэл ахмад үеийнхэн хувийн хэрэгцээ сонирхлын төлөө гэх нь тун бага, харин ихэнхдээ мөргөж залбирахаар ирж байгаа нь харагддаг. Дунд, ахимаг насныхан бол харин хувийн хэрэгцээгээ шийдүүлэхийг эрхэмлэдэг.

Нас хэдий залуу байх тусмаа эдгээр санаа сэдлүүд аль аль нь байх хандлагатай. Аль нэг шатны сургуульд суралцагсад, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын ажилтнууд бол энд дурьдагдаж буй сэдлийг бүгдийг хамруулан ирэх нь олонтаа.

Буриад улсын болон бусад автономит тойргуудын оршин суугчид залбирал хийгээд хувийн сонирхолд ихээхэн анхаарал хандуулдаг.

Дунд насныхан, суралцагсад, ялангуяа тэтгэврийнхэн асуудлын гүн рүү тэмүүлж, бас сүрдэх хандлагатай байдаг бол залуус, албан хаагчид, тэтгэврийн насныхан тайвширлыг олдог, тэгвэл ахмад үеийнхэн, тэтгэврийнхэн, гадаад орноос ирэгсэд аз жаргал, баяр баяслыг мэдэрдэг байна.

Амьдралд нь юу өөрчлөгдсөн тухайд: ахмад насныхан, тэтгэврийнхэн, худалдааныхан, бусад газрын оршин суугчид сэтгэлийн амар амгаланг мэдэрдэг нь сэтгэлзүйн шалтгаантай нь тодорхой байдаг. Худалдаа, үйлчилгээний хүрээний ажилтнууд ирж мөргөснийхөө дараа ихэвчлэн материаллаг талын асуудлаа шийдсэн байдаг бол сэтгэл оюун ёс суртахууны төгөлдөршилд ахиц гаргагсад нь ахимаг насныхан, тэтгэврийнхэн, албан хаагчид байгаа юм.

Дүгнэлт:

1. Бандид Хамба Лам Дашдорж Итгэлын ариун лагшинд мөргөж залбирч байдаг нийгмийн тусгайлсан нэг бүлэг мөргөлчид гарч ирж байх шиг. Энэ бүлэгт нийгмийн тодорхой шинж чанар бүхий, нас залуу, өндөр

боловсролтой, газар газрын оршин суугчид хамаарагдаж байна.

2. Энэ бүлэг хэдийгээр олон талтай боловч сэтгэл оюуны төгөлдөршилд тэмүүлэх онцгой тэмүүллээрээ ялгаатай нь эргэлзээгүй.
3. Д.Итгэлын гоц үзэгдлийн өөрийгөө илэрхийлэх нэг хэлбэр нь тайвшруулах (нөхөн тэнцвэржүүлэх) үүрэг бөгөөд өнөөгийн нийгэмд маань ч энэ л дутагдаж байгаа нь эргэлзээгүй* гэсэн юм.

Яг бодит байдал дээрээ бол хүмүүс энд юутай ирээд, юутай буцаж байгааг хэн мэдэх билээ. Янз янзын хүмүүс ирж байна, хүн бүхэн л ирж уулзах боломжтой

ОРДОН

2008 оны 10-р сарын 31-нд Итгэлын Эрдэнэт Мөнх Лагшинг ордонд залсан. Аль хэдийнэ эвдлэн сүйтгэгдсэн Янгажины дацангийн Диваажин дуган (1906 он)-ы загвараар тус ордонг бариулсан юм. Тус ордон өмнөхөө давтан хийсэн хэдий ч илүү хөнгөн, “нисэх мэт сэтгэгдэл төрүүлсэн”, үзэмжтэй, ер бусын сайхан болсоон. Хамба Лам Аюшеев хэлэхдээ:

- Түүний бие, ухаан, ухамсар, үйл хэргийнх нь байдлыг өдөр бүр ажиглан хянаж байх боломжийг бид гагцхүү ордонг бариулсны дараа л олсон юм. Энэхүү ариун зорилгоо хэрэгжүүлэхийн тулд бид Хамба Лам Итгэл болон түүний ойрын Доржиев Бимба ламтай нэн онцгой холбоо тогтоосоон. Ийм хүндтэй албыг залгуулахад түүнээс илүү тохирох хүн байгаагүй гэдгийг би чин үнэн зүрх сэтгэлээсээ хэлэх байна.

Эдүгээ Доржиев Бимба лам өөрийн туслахуудынхаа хамтаар Хамба Ламын ордонд Итгэлын өмнөх бүх 12 төрөлд нь зориулсан залбиралтайгаар сахиус, бурхдад зориулсан өглөөний хурлыг өдөр бүр хурж, Хамба Лам Итгэлээс онцгой дохио тэмдэг хүлээн авсаар долоон сар болж байна. Энэтхэгийн Гоман дацанд

Билиг барамидын номыг бүрэн сурч төгсгөсөн манай их сургуулийн багш нар болон лам нар эдгээр дохио тэмдгүүдийг тайлбарладаг.

Ийм байдалтай байгаа биеийн дохиог тайлбарлаж байсан тохиолдол буддизмын түүхэнд байгаагүй, тэр талаар суралцах хүн ч байхгүй болохоор бидэнд бүхнийг тэгээс эхлэх, эсвэл хоосон чанарын жинхэнэ мөн чанараас эхлэх хэрэгтэй болдгийг үнэндээ хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй* гэсэн юм.

Буддын “Даши Чойнхорлин” их сургуулийн гүн ухааны багш, гэвш лам Раднажаб Содномов хэлэхдээ:

- “Мөнх лагшин” бол “хоосон чанартай” бодот эд юмсын хойноос хөөцөлдөн гүйж буй биднийг түр боловч зогсосхийж, эргэцүүлэн бодоход хүргэж буй, бас маргаашдаа итгэх итгэл үнэмшил бүхний маань бодтой тулгуур болгож заяалгасан хишиг. Аль ч ард түмний дотор өмссөн зүүснээр нь буюу өөрөөр хэлбэл гадаад төрхөөр нь угтан ханддаг байсан, одоо ч тийм байна. Ийм цаг үед гарч ирсэн Мөнх лагшинд анхаарал хандуулах нь учир зүйн хувьд ч зохистой. Учирзүйн энэ л шалтгаанаар ухаанаар нь “үдэж гаргах” буюу, нэг үгээр бол, хүний доторхийг таних нь сэтгэлийн нэлээд чухал чанар.

Энд харин бид Хамба Ламтаны биеийнх нь үйлийг дагалдан гарч ирэх хэлж буй үг, бодож буй ухааныг ...үзэж, сонсож, ойлгож чадаж байна уу гэх асуулт гарч ирдэг. “Нүдэнд үзэгдэх юмгүй бол байхгүй л гэсэн үг” хэмээх материалистуудын тууштай баримталдаг үзлийг бид энд дагах эрхгүй.

Ийнхүү ...Мөнх лагшингийн гаднахи байдлаар илрэх ёстой XII Бандид Хамба Ламын Өглөг буяны илрэлүүдийг “илүү нарийн” ойлгох түлхүүрийг олох гэж бид чимх чимхээр нь цуглуулахыг хичээж байна* гэсэн билээ. Жалсан лам өөрийнхөө гүйцэтгэдэг үүргийн заримхан хэсгийг биднээс нуулгүй:

- Итгэлын Эрдэнэт Мөнх Лагшинг сахин хамгаалагч Бимба ламын хамтаар бид өдөр бүр Хамба Ламын Эрдэнэт Мөнх Лагшинг сахин хамгаалагч дөрвөн тэргүүнт Махгал сахиусанд зориулж хурал мөргөл хийдэг. Энэ хурлын үеэр Бимба лам Итгэл Хамба Ламд төвлөрөн бясалгаснаар тухайн үед Хамбатан ямар байдалтай байгааг нүдээр үздэг.

Хамба Лам янз бүрийн байдалд байдгийг энд хэлэх хэрэгтэй. Иймэрхүү байдлаар ажиглалт хийх болсноос хойш хагас жилийн дараа Хамба Лам Аюшеев шийдвэр гаргаж, Дашдорж Итгэлын байдлын талаар өдөр бүр тайлбарлан хэлж байхыг биднээс шаардах болсон юм.

Манай их сургуулиас томилогдсон долоон багш Хамба Лам Итгэлын байдлыг тайлбарлаж байх болсон. Ийм үзэгдэлтэй анх удаа тулгарч байгаа болохоор эхэндээ биеийн байдлыг тайлбарлах нь амаргүй байлаа. Гэхдээ Итгэлын биеийн янз янзын илрэлүүдийг хариуцлагатай багш нар буддын үзлийн үүднээс тайлбар хийсээр нэлээд туршлагажсан юм.

“Даши Чойнхорлин” их сургуулийн багш нар биеийнх нь тухайн үеийн тодорхой байдлыг ажигласнаа Буддын хэлсэн үг, буддын гүн ухаантнуудын бүтээлүүдээс иш татах замаар холбон үзэж сүсэгтнүүдэд ямар ашигтайг нь тодорхойлдог. Итгэлын ордны өмнө орших самбарт бүх тайлбаруудыг өлгөдөг байлаа. Яв явсаар түүнийг манай лам, хуврагууд, ирсэн мөргөлчид сонирхох болсон юм.

Энд мэдээж,: Бимба лам бясалгаж байхдаа юу олж хардаг вэ?, Тэрээр Итгэлтай хэрхэн харьцаж чаддаг хэрэг вэ? гэх асуултууд гарч ирнэ. Энэ бол бясалгалын үр дүн гэдгийг хэлж болно. Ерөөсөө бясалгалын агуулга нь өөрийнхөө ухаан санааг хяналтдаа авахад оршдог. Гэхдээ энд бол арай өөр.

Хамба Лам Итгэлыг төлөөлөн Бимба лам үүрэг гүйцэтгэж байх үед нь Хамба Ламд хүмүүс дөхөж очиход нь тэрээр бурхан

байдлаар үзэгдэх, эсвэл хажууд нь мал адгуус харагдах зэрэг тохиолдлууд гардаг байна.

Энд мэдээж нарийн нягтлан үзэх шаардлага тавигдна. Энэ бол далдыг харах үзэгдэл гэж би зориглон хэлье,... Бимба лам ийн харж байгаа нь үйлийн үрээр ногдсон далдыг харах чадвар гэхээс өөрөөр тайлбарлагдашгүй юм. Өөрөөр хэлбэл урьд насандаа хураасан сайн үйлийн үр юм.

Хамба Лам чухамхүү Бимба ламыг сонгон авч, хожим далдыг харах чадварыг нь нээж өгчээ. Түүнээс гадна Хамба Лам Итгэл өөрийнхөө ямар байдалтай байгааг өдөр бүр Бимба ламд үзүүлж, бас түүгээр дамжуулан сүсэгтнүүддээ илгээлт явуулдаг.

Гэхдээ Хамба Лам Итгэлын илгээсэн зарим дохиог тухай бүрд нь тайлж чадахгүй, тэрээр чухамдаа юу хэлээд байгааг ойлгож чадахгүй байгаа нь Бимба ламын далдыг харах чадвар хараахан бүрэн дүүрэн хөгжөөгүй байна уу гэлтэй.

Жишээ нь, буддын суут Зөнчдийн дэргэд ямагт орчуулагч нар байж, тэдгээр нь Зөнч зуурдын байдалд байхдаа ямар хэлц дохиогоор яриад байгааг ойлгох чадвартай байдаг. Тэгэхдээ Бимба ламын чадвар яв явсаар хөгжиж, Хамба Ламын өгүүлээд байгааг хангалттай хэмжээгээр ойлгож эхэлнэ гэдэгт би бүрэн итгэлтэй байгаа.

Бас нэг сонирхолтой баримт дурьдахад Хамба Лам Итгэлын биеийг гаргаж ирэх санаачлагыг анх дэвшүүлж, энэ саналаа Хамба Лам Аюшеевт хоёр жил Итгэлын хүрээлэнд буй мэдээллээр бол гурван жилийн туршид тавьсаар байсан аж. Яагаад ингэх болсноо тэр тайлбар хэлдэггүй, ийм хариуцлагатай асуудлын учир шалтгааныг олны дунд тараахыг хүсэхгүй байна, харин энэ ертөнцөөс өөрөө халих цаг ирэх үед хэлнээ гэдэг аж.

Буддын Сургаал болон үйлийн үрийн жам ёсоор бол тохиолдлын зүйл гэж байдаггүй болохоор үйлийн үрийн холбоо

байгаа гэдэгт эргэлзэх зүйлгүй, гэхдээ тэр холбоо нь бүр ийм их өндөр төвшинд байхад шүү* гэсэн юм.

Хамба Лам Итгэл ямар байдлаар өөрийгөө илэрхийлдэг талаар өдөр дутмын мэдээний сэтгүүлд бичээд дараа нь тайлбарласан байдаг.

Сэтгүүлд бичсэнээс дурьдвал: Итгэл гартаа эрих, илд барьсан, сумаа баруун зүгт харвахаар нум барьсан, улаан буудайн үр өргөн барьж буй, гэрэл цацруулсан толь барьсан, бөөн үүлэн дээр яваа, дүүрэн одод анивчсан үүр шөнийн тэнгэр доор байгаа, залбирал сургаал айлдаж буй, цай юүлж буй, их тэргэн дээр суугаад баруун зүг одож буй, дэргэдээ агуйтай залуу модны доор суугаад бясалгаж байгаа, гартаа мандалын суурь барьсан, дээс таслаж байгаа, зүүн зүг рүү бугуйл шидэж байгаа, тэнгэрийн хаяанд сууж байхад ард нь “илүү хүчтэй гэрэл бүхий” нар үзэгдэж буй, гартаа дүүжин барьсан, баруун урд зүг рүү чиглэн дээш харж буй, доошоо гэрлийн туяа тусгаж буй, Баргузины цаст оргилд очир завилгаагаар залраад бясалгаж буй, тэнгэрээс бууж ирж байхад нь аянга нүргэлж байгаа, өтгөн шигүү өвс ногоон дотор сууж буй, тэнгэрийн хаяанд байхад нь рашаанаар бороо орж буй, зүүн гартаа Ганлин (ад зэтгэрийг номхотгохын тулд дуудан ирүүлэх зориулалттай, ясаар хийсэн, шашины зан үйлийн зэмсэг) барьсанаар дүрсэлжээ.

Итгэлын ойр тойронд элдэв үзэгдэл юмс тохиолдох нь элбэг ба бас хүн, амьтан, тэнгэр төрөлтнүүд үзэгддэг. Тэрээр хоёр европ хүнд адис хүртээж байгаа, нэг шавь түүнээс зөвлөгөө авахаар ирж, дэргэд нь бас баатар эрийн шинжтэй нэг хүн байна, энэтхэг үндэсний шавь, дундад азийн хувцастай эмэгтэй, Гарьд /хаан шувуу/, ихээхэн гэм нүглээ наминчилж байгаа бололтой залбирч байгаа хүн, умард нутгийн үндэсний хувцастай эрэгтэй хүн дөхөж очоод өвдөг сөхрөн унаж байгаа, Буддын гарын шавь нар болох 16 архадын дунд Итгэл байж байгаа, эсвэл түүний дэргэд улаан бух байгаа, чоно, дөрвөн үнээ, хонь байж байгаад

сүүлдээ баавгай болж хувирсан амьтан гэх зэрэг. Итгэл уншлага уншиж байгаагаар үзэгдэж түүний зүүн хажууд долгион үүсч, бас нэг нүд харагдаж, маш том улаан дөл, цэнхэр дөл, дархны дөш байна

Тэнгэрийн хаяанд Хамба Ламын дээгүүр төмөр тор үзэгднэ. Итгэл үүлэн дээр очир завилгаагаар залран байна, баруун талд нь хүний гавлын яс байна. Итгэл баруун гартаа эмийн ургамал барьж, дээгүүр нь цахилгаан цахиж байна.

Итгэл мөн Бимба ламын нүдэнд бүхэл бүтэн тоглолт үзүүлдэг: Итгэл багавтар голын дэргэд зогсоод баруун гараараа баруун эрэг рүү зааж байна, дараа нь голыг гатлаад чулуун шүтээнийг зааж байна. Итгэл бясалгаж байхад зүүн талаас нь бор гөрөөс гүйж явна.

Итгэл цагаан бөмбөлөгийн дүрээр илрэхдээ бөмбөлөг тэнгэрээс бууж, газардмагцаа яг хүнийхээ дүрээр Хамба Лам Итгэл болон хувирчээ. Итгэлын дэргэд дөрвөн нүүрт Махгалын ам үзэгдэж, амнаас нь хоёр могой гулсан гар ирээд нэг нь баруун, нөгөө нь зүүн зүг чиглэн одов. Хамба Лам цаст уулын орой дээр байхад түүнийг тойроод эрих нар зөв эргэлдэж байна.

Хамба Ламын илгээлтийг буддын сургаалын үүднээс тайлбарладаг. Ихэнхдээ тайлбарыг дагаад бодит амьдралын зөвлөгөө гарч ирдэг. Тухайлбал: орчны хүмүүс болон ойр дотныхонтойгоо хэрхэн харьцах, юу унших, юунд анхаарал халамж тавих г.м. Заримдаа бие биесээ нөхөн тодруулсан хэд хэдэн тайлбар гардаг. Зарим үед “тааварлах төдий хоцрох” нь ч бий.

Николай Жалсан лам:

Далдыг харахын хүчинд итгэдэггүй болохоор Хамба Лам Итгэлын байдлын талаар өдөр бүр хийж байгаа тайлбарт төдийлөн ач холбогдол өгдөггүй, тэгээд ч бас ажиглалтын үр дүнг

ихэнхдээ шинжлэн үздэг болохоор өөрсдийнх нь ойлгоцын хэмжээнд төдий ойлгомжгүй энэ үзэгдэлд эргэлзэгчид хүмүүсийн дунд нэлээд буй.

Иймийн учир Хамба Лам Итгэлээс өдөр бүр илрэн гарч буй илгээлтүүд тохиолдлын зүйл бишээ, харин дэлхийн хэмжээний үйл явцуудад тусгалаа олдог юм гэдгийг бид тодорхой хэмжээнд итгэлтэйгээр хэлж чадна. Жишээ нь: 2008 оны 12-р сарын 27-нд түүний хажууд хөх дөл гарч үзэгдсэн.

Бидний мэдэж байгаачлан яг энэ өдөр Ойрхи Дорнодод ээлжит самуун эхэлсэн., маргааш нь бидний амьдрал мөнх бус, амьдрал тийм хурдан өнгөрөх байтал юундаа хоорондоо дайтнав хэмээн бидэнд сануулах мэтээр Хамба Лам маань дүүжин барьж байгаагаар үзэгдсэн. АНУ-ын ерөнхийлөгч Барак Обамагийн тангараг өргөх ёслолын өдөр Хамба лам очир завилгаагаар заларч, баруун гараас нь тод гэрэл гарч харагджээ.

Улсын Думын депутатууд Итгэлын гоц үзэгдлийг тунгаан хэлэлцээд: Орос улс дорнод хязгаараа сахин хамгаалах, эдийн засгаа тогтворжуулах үүргийг гагцхүү түүний өмнө хүлээнэ гэсэн мэдэгдэл хийсэн юм.

Оросын Батлан Хамгаалахын сайд Сергей Иванов 2006 онд Иволгины дацанд ирэхдээ “Итгэл Орос улсын төлөө зүтгэсэн хэвээрээ” гэж хэлсэн бол улсын думын депутат, вице-адмирал Валерий Дорогин түүнийг “үндэсний аюулгүй байдлын нэг бүрдэл хэсэг нь” гэж нэрлэсэн юм.

Иймэрхүү нотлогоог няцаах буюу үнэнийг нь баталгаажуулах амаргүй ээ. Ердийн эрүүл саруул ухаанаар шүүн тунгаах гэгч нь тэр үед ямар ч утга учиргүй болдог. Зүгээр л бид бүртгэн тэмдэглэдэг. Итгэл бидэндээ эргэн ирсэнээс хойш манай оронд үнэндээ ямар нэг тайван амгалан байдал буй болсон юм.

Хамба Лам Аюшеев “Новая газета” (“Шинэ сонин”)-д өгсөн ярилцлага (2007.07.2 болон 2007.07.5 –нд)-аас:

- ... Дараа нь ч гэсэн энэ дэлхий дээрх бүх юм шийдэгдчихдэггүй ээ. Та нар зөв ойлгоорой: бид шийдвэр гаргаж байна гэж яагаад ч юм боддог. Гэтэл бидний ямар нэг шийдвэр гаргаж байгаа тэр үйлдлийн цаана хэн байна вэ? Ухаандаа, Байгал нуураас нефтийн хооллой татлаа. Яахаараа тэр билээ? Энэ талаар хүмүүс тун ч их идэвх чармайлт гаргасан. Яагаад гэвэл:

Байгал нуур бол уламжлалт шүтээн болсон газар. Гэвч юм тийм л байдаг биз дээ. Ариун дагшин Байгал нуурын эргэн тойронд хүмүүст хэрэгтэй байгалийн баялаг нэн ихээр хуримтлагдсан нь бас нэг л жам биз. Энэ бол заавал тийм зүйл болох ёстой байсан юм. Бидний хувьд нэн өвөрмөц ийм нэг мухардал үүссэн.

Хүмүүст асуудал үүсгэхийн тулд үйл явц ингэж өрнөсөн хэрэг. Сайхан амьдармаар байдаг, гэтэл нэг зүйлийг олоод авахаар өөр нэгийг алдаж байдаг. Өөр жам байхгүй. Байгал нуур - Оросын ирээдүй шүү дээ! Цэвэр усны ийм их нөөц байна.

Энэ тохиолдол уу? Байгал нуур яагаад чухамдаа энэ газарт байна вэ?, буриадуудыг яаж байлаа ч гэсэн тэд эндээс холдохгүй яагаад Байгал нуураа тойроод амьдраад байнав, бид яагаад буддистууд болсон байхав, бас тэгээд Итгэл яагаад энд бидэнд хадгалагдан үлдэв, Байгал нуур яагаад цэврээрээ байгаад байна вэ? ... гээд л.

Ухаалаг сайн хүний хувьд бол эдгээр нь дэмий хоосон асуултууд бишээ. ...Би саяхан нэг хүнд үнэнийг ойлгуулах гэж хичнээн удсан гээч. Тийм их нэр хүндтэй хүн атлаа хоолойноос өөр юм бодохоо байчихсан. Яахаараа хүний бодол тийм болдог хэрэг вэ? Өөр арга байхгүй болохоор тэр үү? Хэрэв чи хүн амьтангүй зэлүүд арал дээр байгаа бол нэг хэсэг алт хэрэгтэй юу, нэг зүсэм талх хэрэгтэй юу? Хий чухал уу, эсвэл цэвэр ус чухал уу? гэсэн юм.

Яалаа ч гэсэн Итгэл гагцхүү нефть дамжуулах хоолойг Байгалиас холдуулах гэж эргэн ирсэн хэрэг бишээ гэж бодох олон олон үндэслэл байна.

ХУДАГ БА АНИНЫ ҮНЭТ ЭРДЭНЭС

Итгэлын ордонг бариулах ажилтай зэрэгцээд Хамба Ламын амьдрал, үйл ажиллагаатай холбоотой бүхнийг эрж олох ажил явагдаж байлаа. 2005 оны 9-р сарын 4-нд Итгэлын төрсөн (хүмүүн биеийг олсон) газарт Өлзийт Дов дурсгалын цогцолборын нээлт болсон юм. Хүнийг төрөхөд хойтох (ихэс)-ыг нь булсан газрыг буриадууд тоонто хэмээх бөгөөд буриадын уламжлалаар бол хүн төрсөн газартайгаа ямагт холбоотой байдаг гэдэг.

Одоо энд буддын суварга босгосон болохоор мөргөж залбирахаар мөргөлчид ирэх боллоо.

Үүнээс гурван сарын өмнө, 5-р сарын 28-нд уугуул Буриадын бүх дацангуудын ширээт лам нар Иволгийн дүүргийн Баян-Улаан хэмээх газарт хуран цуглахад ойролцоохи тосгоны сүсэгтнүүд ч хамт ирсэн байлаа. Тэд Итгэлын гэрийнхний зуны байрны газрыг олох ганцхан зорилготой байсан юм.

Лам нар зурхайн тооцоо хийж, бас хамтран бясалгацгааж байлаа. Эрэл бүтэн өдөржин үргэлжилсээр, хөндий дүүрэн улаан хувцастангууд – үүнийг “буддын харваа” (буддискые стрельбы) гэдэг. Олноороо ийнхүү эрэл зохиохоос өмнө овооны орчимд шөнийн бясалгал хийж, Хамба Лам Аюшеев болон Иволгины дацангийн лам нар дахин дахин ирж байжээ.

Оронго тосгоны оршин суугч, эмэгтэй Роза Сыхеновна Ленхобоева зүрхэн хэлбэртэй, үл ялиг довгор газрыг олоод нямбаалан цэвэрлэж, доош нь ухаж үзжээ. Зүрхэн хэлбэртийн гүнд мөс цайран харагдсан бөгөөд мөсний доор худгийн хашлага мод бүрэн хэвийнээрээ байж байв.

Хэдэн сарын дараа түүнийг мөргөлчдөд үзүүлж эхэлсэн бөгөөд одоо Өлзийтийн аршаанд Буриадын өнцөг булан бүрээс, зэргэлдээх хязгаар, мужууд, Монгол улс, Оросын Москва болон бусад хотуудаас хүмүүс ирж байна. Рашаан авахаар ирэгсэдийн тоо маш их болсон тул Иволгийн дацангаас Өлзийт Довд байнга нэг лам суулгаж, тэр нь худгаас рашаан авахыг зохицуулахаас гадна буян номын үйл үйлдэх болжээ.

Давстай нуурын хужирлаг хөрс бүхий энэ газарт гүний өрөмдлөг хийгээд ч цэнгэг ус гарахгүй байгаа нь нэн сонин. Харин Итгэлын худаг тийм усны цорын ганц ундрага юм.

Итгэлын хүрээлэн “Буриадын геотөв”-тэй хамтран шинжилгээ хийж үзэхэд Буриадын бусад усны эх үүсвэрүүдтэй харьцуулахад рашаан дахь мөнгөний агууламж үлэмж их байгаа нь тогтоогдсон саявтархан Заяевын төрсөн газраас олсон усны эх ундаргын мөнгөний агууламж нь дээрх рашааныхтай ойролцоо байсныг хэлэх нь зүй. Лам нар рашааны байдлыг ажиглан хянаж, ирсэгсэдийн тооцоог гаргаж, бас тэдний түүхийг бичдэг. “Сүүлийн үед Хамба Ламыг Өлзийн довын худгийн усаар угаах болсноор нүүр нь гэгээлэг болж байна. Миний бодлоор удалгүй бие нь ч илүү амилаг болох байх” гэж Бимба лам Доржиев хэлсэн юм.

Нутгийн иргэд хадгалж байсан Итгэлын зуны байрыг мөнхүү 2005 оны зун нүүлгэж худгийн тэнд аваачсан. Биеэ амрааж, бас эмийн ургамлаа түүж байх боломжийг нь бүрдүүлэхийн тулд Итгэлыг Цагаан Жалгын рашаан дээр байх үед нь Оронгын урчууд тэр байрыг зуун жилийн өмнө барьж бэлэг болгон өгсөн аж. Намжилма Раднаевагийн хэлж байгаагаар 1930-аад оны үед түүний эцэг эх нь дээр дурьдсан хүрээ (байшин)-г Оронгад аваачиж, хадгалж байсан бурхдыг нь байрлуулсан байна. Оронгын олонхи иргэд зөвлөлт засгийн жилүүдэд энэ байшинд нууцаар ирж мөргөл үйлддэг байжээ.

Өдгөө тус хүрээд музейн цөөн хэдэн үзмэр болон Итгэлын хувийн эд зүйлс байдаг. Худгийг олсны дараа Хамба Лам

Аюшеев суварга баривал зохих газрыг зааж өгсөн юм. Суваргын доор ариун бумба оршоож, дотор нь таван төрлийн амуу будаа, эмийн ургамал, бас, мэдээж, буддын судрууд байдаг. Энэтхэгийн Дарамсалад босгосон суваргын яг хуулбар байдлаар энэ суваргыг бүтээжээ.

Мөн 2005 оны 9-р сард Санкт-Петербургийн дацангийн хананд: 1913 оны 2-р сарын 19-нд энэ сүмд анхны хурлыг Итгэл хуруулсан тухай бичээс бүхий дурсгалын самбар байрлуулжээ. Оросын дүрслэх урлагийн Академийн гишүүн, нэрт уран барилгач В.Бухаев самбарыг хийж, ингүүмэлийг Мариягийн театрын ерөнхий зураач Б.Дашицыренов урлажээ. Колумбын их сургуулийн профессор, Америкийн нэртэй дорныг судлаач Р.Турман энэ ингүүмэлийн хуулбарыг аваачиж Нью-Йоркийн буддын төвд тавьжээ.

Хамба Лам Заяев эрдэнэт хүмүүн биеийг олсон газар болох Оцон Хаан уулын ойролцоо, Цөх голын эрэг дээр мөнхүү 9-р сарын 3-нд бас суварга босгон нээлт хийсэн. Бүх Хамба Лам нарын мэндэлсэн газруудад суварга босгох шийдвэрийг Итгэлээс өөрөөс нь 2005 онд авсан юм.

2010 онд энэ ажлыг дуусгаж, Бандид Хамба Лам нарын төрсөн газруудыг олж, буддын 21 суварга босгосон билээ.

Итгэл 75 насныхаа амьдралыг туулсан Гильбирингийн хөндийн Хөх Зүрхэн хэмээх газарт түүний эргэн ирсэний дөрвөн жилийн ойг тохиолдуулан энэ ариун дагшин газарт зориулсан суварга босгож, аравнайлсан юм.

Эвдэрч сүйдсэн Анины дацангийн эрдэнэсийг олсон тухайд тусгайлан өгүүлүүштэй. Тухайн асуудалд холбоотой буддистууд түүнийгээ “бурхдын үзэгдэл” хэмээн нэрлэх дуртай. Тэнд хорь орчим жил суралцсан Иттигэлов энэ ертөнцөд эргэн ирснийх нь дараа тэр ариун шүтэнүүд урьд нь эрээд олоогүй гадраас өөрсдөө л гараад ирсэн гэж хэлж болохоор.

Дээр өгүүлсэнчлэн эхний гурван бурхны дүр нь Итгэлыг ирэхээс 11 хоногийн өмнө урьд нь зөвлөлтийн археологичид, хараар нуувар эрэгсэд, Дорнод Сибирийн соёл урлагийн улсын академийн оюутнуудын ажиллаж байсан газраас олдсон юм. Олдвор илэрсэн тухай мэдээ сүсэгтнүүдийн дунд тархаж эхэлмэгц лам нар дээр ная орчим насны нэгэн өвгөн ирээд Анины дацангийн 50 бурхан одоо надад хадгалагдаж байна гэж хэлжээ.

Дугжууб хэмээх шашины зан үйл үйлдсэний дараа 2004 оны 2-р сард 2004 оны цагаан сарын өмнө дахиад 150-ыг олсон. Ингэж олдсон бурхдын тоо одоогоор 350 гаруй болоод байна.

Энэ бол Ирээдүйн Будда буюу 80 тохой өндөр Аврага том Майдар бурхны дүрийг тойрон хүрээлж байдаг “сайн цагийн мянган бурхдын” хэсэг нь юм. Жижиг бурхад нь 10 см-ийн өндөртэй, хүрэлээр цутгаж, гадна талаас нь алтаар шарж, эрдэс будгаар өнгөлөн Буддаг очир завилгаагаар заларсанаар бүтээсэн байдаг. Харин гарын байрлал нь бурхад бүрийнх өөр өөр аж. Дотор талд нь мөргөлийн өчүүхэн жижиг хэнгэрэг, эмийн ургамал сэлтээр шүншиглэж, доороос нь металл ялтасаар битүүлж, зах хөвөөгөөр нь лавдан тогтоосон байдаг. Анины дацангийн түүх XVIII зууны сүүлчээс эхтэй болохоор эдгээр бурхад 200 гаруй жилийн настай гэж лам нар тооцдог. Итгэлын багш нарын үед ч эдгээр бурхад гонхонд байж л байсан аж. Анины дацангийн ширээт Дарижапов Лэгсэк лам хэлэхдээ:

- Бидний олсон бурхдын тоо нь өөрөө илрэн гарч ирсэн гэхүйц бурхдын тоонд хүрэхгүй. Тохиолдлын юм гэж байдаггүй, Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл дэлхийд буй болсон яг тэр мөчид энэ бурхад гарч ирсэн юм. Итгэл Хамба Анины дацанд хорь орчим жил суралцаж, амьдарсан хүн шүү дээ. Хамба Лам Итгэлын буцаж ирсэн, бурхад гарч ирсэн хоёрын хооронд гүн гүнзгий холбоо байгааг бид олж харж байгаа гэсэн юм.

Р.Мердыгеев, П.Дамбинов нарын 1927 оны явуулын бүлгийн материалд: “Анины дацангийн Майдар нь Ирээдүйн Буддаг суугаа байдлаар дүрсэлсэн, өндөр нь 5 алд, 2 аршингийн хэмжээтэй аврага том дүр юм. Энэ аврага бурхны өрөөсөн чих нь гэхэд л насанд хүрсэн хүний босоо биеийн уртаас багагүй” гэжээ.

Анины дацангийн Майдарын шүншиг дэх зүйлсийг гараар жагсаан бичсэн нь хэд хэдэн хуудас болдог. Жагсаалтад бичсэнээр Майдарын толгой дээрх ушниши /ушниши гэдэг нь гэгээрэлд хүрсэний тэмдэг болж зулай дээр байдаг төвгөр/-д зуун мянган ариун судар, хуйлаас бичиг орсон бол цээжинд нь Банчин Богд, Далай Лам, Богд Гэгээн нарын хамгийн анхны дүрүүдийн өмсөж хэрэглэж байсан зарим хувцас орсон аж. Жагсаалтад Төвд, Энэтхэг, Монголд ариун нандинд тооцогддог зүйлс болон нэн олон судар бүртгэгджээ.

Буриадын лам Очир Сандакийн удирдлагын доор Долнуурын урчууд Майдарыг бүтээснийг Анины дацанд хувраг асан Рабдан Базарович Мигжитов гэдэг хүн гэрчилдэг.

Шашин, төрийг тусгаарлах тухай тогтоолыг хэрэгжүүлэх болон хувийн өмчийг нийгэмчлэх ажлын хоёрдугаар шатны явцад 1936 оны 4-р сард Анины дацанг татан буулгах комисс “Майдар бурхны суудалд нууц хаалга байна, бас дотор нь галт, хүйтэн зэвсэг байна” гэж шалтаглан бурхны баримлыг задлан үзэж нотломж тогтоожээ. Суудлын доторхийг үзээд бичсэн нь:

1. Галт болон хүйтэн зэвсэг:

- 1). хоёр гол төмөртэй үрлэн сумтай буу 3 ш,
- 2) цахиур буу сум 40 ш,
- 3) Бердан буу 1 ш,
- 4) галт дробовик /монголчуудын хэлдэгээр дарвийнк/ 8 ш,
- 5) Смиттийн револьвер /хүрдэн хүхээгтэй гар буу / 4ш,
- 6) пистолет гар буу /богино болон винтов хэлбэрийн арай урт / 14 ш,

- 7) төрөл бүрийн сум 12 ш,
- 8) хуйтай сэлэм /хуучин/ 11 ш,
- 9) хуйгүй сэлэм 15 ш,
- 10) кинжал хутга 2 ш,
- 11) жад 4 ш, - бүгд галт хүйтэн зэвсэг 106 ш

2. Хаант засгийн хэвийн цутгамал алтан: таван рублийн зоос 4 ш, 10 рублийнх 1 ш, алтан бөгж 3 ш

3. Хаант засгийн хэвийн цутгамал мөнгөн: рублийн зоос 9 ш, 50 копейк 3 ш, 25 копейк 4 ш, мөнгөн бөгж 3 ш, мөнгөлсөн модон аяга 3 ш, аяга, таваг, халбаганы иж бүрдэл 1, хундага 2 ш, сэнжтэй мөнгөн аяга 3 ш, төрөл бүрийн мөнгө, Бурхан –эх (бүрэн иж бүрдэл) -1 ш

4. Торго: ногоон өнгөтэй 18м 7см, шар өнгөтэй 1,5 м, цагаан 10 м 70 см, цэнхэр 14м 20 см, улаан 13 м 35 см, хадгууд...” гэжээ.

Жагсаалтад бас авдар хайрцагнууд, алчуур, төрөл бүрийн цай гэх зэргээр бичжээ. “Эдгээрээс үзэхэд Анины дацангийн лам нар зэвсэг, хэрэгсэл нууж байсан нь Зөвлөлт засгийн эсрэг босох бодлоготой байсныг илтгэх ба энэ нөхцөл нь Зөвлөлт засгийн одоогийн хуулийн эсрэг хандлага юм гээд тогтоосон нь: бүх зэвсгийг ганцыг ч үлдээлгүй ДХАК-ын дүүргийн хэлтэст, бусад эд хогшлыг лацдаж дуганд хийгээд хаалга үүдийг мөн лацдаж дарга болон манаач Будаев, Чимид нарт хүлээлгэн өгч хадгалуул.

Комиссын дарга Антонов, Гомбоев, Гуруев. Хийдийн зөвлөлийн дарга Намжилов. Хамгаалагч Гомбоев, Будаев” гэжээ.

1937 оны наймдугаар сард Анины дацан руу томилолтоор очсон Ленинградын дорно дахиныг судлах хүрээлэнгийн ажилтан В.Д.Якимовын илтгэх хуудсанд: “бүх үзмэрүүдийг хаа тааралдсан газарт нь бөөгнүүлэн овоолсон байна. Ингэснээр үзмэрүүд үй олноороо үрэгджээ. Жишээ нь, нэг сүмийг онгойлгоход нь би орж үзэхэд өмхий үнэр, хөгц ханхлан, тэнд хүн тогтохын аргагүй байлаа” гэжээ.

Хаагдсан дацангуудаас Дорно дахиныг судлах хүрээлэн, Шашины түүхийн музей, Угсаатны зүй, хүн судлалын музейнуудад үзмэрүүд шилэн сонгож авах зорилготой явуулын иж бүрэн бүрэлдэхүүнт бүлэг ЗХУ-ын ШУА-ийн дэд ерөнхийлөгч О.Ю.Шмидтийн шийдвэрээр 1939 оны намар Буриадад ирж ажилласан юм.

Дорно дахиныг судлах хүрээлэнгийн ажилтан Е.М.Залкинд: “Дотор нь ихээхэн хэмжээний үнэт зүйлс хадгалагдаж байдаг... гэх Майдар бурхныг үзэхийг Анины дацанд бидэнд үүрэг болгосон. Майдар бурхныг задлахдаа урьдчилаад зураг дүрслэл хийх, гэрэл зургийг нь авах, хэсгүүд дээр нь тэмдэг тавих зэрэг хамгийн наад захын шаардлагуудыг хангахгүйгээр задалсан байна.” гээд Евгений Михайлович цааш нь тайландаа:

“Аль болохоор их хэмжээний үзмэрийг хог хаягдал болгох гэж чармайдаг” комиссын гишүүдтэй би байнга зөрчилдөхөд хүрч байлаа. Бурхан, шүтээн зэрэг соёлын үнэт зүйлсийг музейд ашиглаж болохоор байтал бөөнөөр нь хогийн бааз руу ачлаа” хэмээн тэмдэглэжээ.

Гатовын тайланд бичсэнээр бол Майдарын дүрийг 1939 оны зун ажилласан комисс задалжээ. Комиссын бүрэлдэхүүнд: Москва дахь Шашины эсрэг төв музейгаас Пупышев, ЗХУ-ын САК Санхүүгийн Ардын комиссариат буюу Наркомфинээс нэг төлөөлөгч орж, ажиллах үед нь ШУА-ийн Дорно дахиныг судлах хүрээлэнгийн ажилтан Е.М.Залкинд байлцжээ. Зэс хуудсаар хийсэн дүрсийг замбараагүй задалж, хуудас хуудсаар нь ханзлахдаа задалсан зураг ч зураагүй, гэрэл зураг ч аваагүй байна. Уран сайхны талаасаа бол энэ дүрс ямар ч хэрэггүй болжээ. Уг нь өнгөрсөн зууны сүүлийн арван жилд хийсэн шинэ бүтээл билээ. Иж бүрэн биш байна, шавь нарынх нь дүр алга. Харин дотор нь судрууд, бүх төрлийн эм тан, шүтлэгийн эд зүйлс гэх мэт байсан нь нэлээд сонирхол татсан тул бид сав баглаанд

хийсэн. Бурхны дүрийг хэтэрхий эмх замбараагүй болгосон байх тул бид түүнийг авахаас татгалзахаас өөр аргагүй байв” гэжээ.

Эдгээр илтгэх хуудаснуудаас үзэхэд Анины Майдарыг дахин хайлуулахаар ачуулжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Р.Б.Мигжитовын мэдээгээр бол Анины Майдарыг “Генин-Дарма Нацовын удирдсанаар” задалжээ. Майдарын баримлыг задлах үед толгойг нь мөн задлаж гудамжинд хэдэн өдөр байлгахдаа манаачаар нь сүмээс холгүй гэртэй, Дондок нэрт ердийн нэг тэнд ирсэн хүнийг тохоон тавьсан гэх мэдээ өндөр настнуудын дунд ам дамжин хадгалагдаж үлджээ. Нэг өдөр манаачийн эхнэр угаадсаа Майдарын толгойн зүг рүү цацаж, нутгийнхны заншлаар бол ихээхэн нүгэл үйлдсэнээс болоод дараа өдөр нь “өөрөө өвчилсөн” гэнэ. Сүмийг тараах ажлыг 1939 оны сүүл, 1940 оны эхэн үед хийсэн ба тэр ажилд нутгийн иргэд оролцоогүй аж. Учир нь тэд Ирээдүйн Буддад, түүнийг ирнэ гэдэгт итгэдэг байлаа.

Алан тосгоны өндөр настан Солбон Базардараев:

- Манай тосгонд нэг хөгшин эмэгтэй байдаг байлаа. Тэр хүн насныхаа эцэст тулаад ирэхдээ намайг дуудаад: “Солбон, нааш ир.Чамд нэг хэлэх юм байна.Манай дацангийн ойролцоо нуучихсан бурхад байгаа шүү, түүнийг мэдэж бай” гэсэн юм. Би түүнийг тогтоож аваад сүүлдээ манай лам нарт хэлсэн. Бид дацангаа сэргээнэ гэж миний эцэг дандаа ярьдаг хүн байсан” гэж ярьсан юм.

Анины дацан сэргэх болохоороо өөрөө дохио өгнө, гэхдээ эхлээд түүний ойролцоохи хоёр толгой нийлж нэг болно гэсэн итгэл өнгөрсөн зууны гучаад оноос эхлээд Хорийн буриадуудын дотор байсаар ирсэн юм. Одоо толгод нь далангаар холбогдож”сайн цагийн будда “нар дацан руу ирсээр байна. Тэгэхээр цаг нь болжээ гэх дүгнэлтийг тэд хийж байгаа.

Саявтархан Дүнчүүр хүрд болон зуун сая тарни бүхий мөргөлийн хүрдний мөргөлийн тамга эргэн ирсэн. Түүнийг сэргээхийн тулд тусгай зориулалтын цаас нэг боодлыг худалдан авсан, одоо сүсэгтнүүд түүн дээр тарни оруулж байна. 2011 онд дацангийн байрлалын захаар буддын 108 суварга босгож аравнайллаа.

Зөвлөлт засгийн залхаан цээрлүүлэлт эхлэх үед газарт булсан судрууд ихээхэн анхаарал татаж байгаа юм. Одоо олдож байгаа хэсгүүдийг нь үзэхэд тэд хэдэн арван жилээр газар доор хэвтсэн биш, харин орчны агаар, чийгийг сайтар тохируулдаг төхөөрөмж бүхий шилдэг номын сангийн тавиур дээр байсан мэт хэв янзаараа байгаа юм.

ИЛГЭЭЛТ

Хуучин монгол бичгээр, ёгт хэллэгээр бичсэн “Ард түмэндээ хандсан Хамба Лам Итгэлын Илгээлт”-ийн гар бичмэл эх 1996 онд Буриадад эргэн ирсэн юм. Итгэлын сэтгэл зүрхний энэхүү гэрээслэл цөвийн цагийн туршид Өвөр Монголын Шэнэхэний дацанд хадгалагдсаар байжээ.

1930 онд дөрвөн настай хүүхэд байхдаа цагаачлан гарсан Гэлэг Балбар лам Хятадаас түүнийг Иволгийн дацанд авчирсан юм. Тэрээр гэртээ буцаж ирэхдээ Итгэлын гар бичмэлийг авч иржээ.

Лам нар түүний утгыг тайлах оролдлого хийж байна. Илгээлт олон давхрагатай, “түүний доторхи нэг л үгийг олон янзаар тайлбарлаж болно”, хэсэг бүр дэх үгийн тоо бас учиртай, нэмэлт утга агуулдаг юм гэж Кырений дацангийн ширээт Базаров Балдан лам хэлж байна.

Илгээлтэд, тухайлбал, 20—30-аад оны үйл явдлууд, Сталины хавчлага залхаалт, бичсэн хүн нь мөнх лагшингаараа эргэн ирэх (хугацааг нууцалсан хэлбэрээр яг хэлсэн) зэргийг дурьдсан

байна гэж үзэх хүн бий. Зарим нь энэ бол Итгэлын бусад бүтээлүүдийн нэгэн адил шашины агуулгатай бичиг болохоор түүнийг юуны өмнө буддын төсөөллөөр унших ёстой гэж үзэж байна.

Хамба Багш Дашидорж Итгэлээс ард түмэндээ хандсан ИЛГЭЭЛТ

Мартаж үл болох Лам багшийн Гурван Эрдэнийн адистэт ерөөлтэн
Мадаг үгүйгээр Оюун ухаанаа ямагт төгөлдөржүүлэх чадвартан
Арван учрал бүрдэх боломжийг буй болгомуй.

Сайн үйлийн буяныг идэр насандаа хурааж чадваас залуу хүний баялаг тэр
Сүмбэр алтан уулыг Таван цогц бүрдэх мэт нүдэндээ үзэх нь тэр

Эрдэнэт ариун бие тань зовоогүй биз, амгалан байна уу?
Тал бүрийг эзлэн салаалж ургасан мод мэт, Таван цогцоос гарах цэцэг мэт
Элдвийн аюулт, цөвийн цагийн шалбааган далай дунд цэвэр ариунаараа үлдээрэй.

Таван хичээнгүй сэтгэл тань мөндөр хярууд цохигдоогүй гэгээн сайхнаараа байна уу?
Хэв янзаар нь байлгаж хэзээд сэргээн санаасай гэж Бурхны Сургаалыг доорхи үгээр хүргэсү:

Үнэт эрдэнэ мэт чөлөөт итгэлийг олсон хүнийг олоход амаргүй ээ!
Буддын Эрдэнэт Сургаалтай учирсаныг олж учирахад ч амаргүй!
Эндэхийн эзэн Очирдар Ламтанд хүрч очиход ч хэцүү, хүүрнэн ярихад ч хэцүү!

Аминд халтай үйлийн аюулт мэхэнд автаж,
Анхаарал халамжгүй явсаар насны заагт хүрэхүйд
Үйл – үрийнхээ улаан эрчмээр араасаа туулгасаар
Үхлийн эзэнд эрхбиш нүүр тулан очно.

Ээлжит тэр ертөнцөд ганцаараа очих цагт
Эд баялаг, төрөл төрөгсөд, ойр дотныхон бүгд чинь
Яав ч чамайг дагахгүй, байгаа газартаа л үлднэ.

Ухаан сэхээгүй цуглуулсан эд баялаг чинь харин
Утга учиргүй хор болон хувирна гэж
Урьд өмнийн Будда бүхэн сургасан юм.

Хөрст дэлхийд амьдрахын учрыг хөндлөнгийн сэтгэлээр
судлагтун
Хойшлуулалгүй, өнөөдрөөс Арван цагаан буяныг нэн даруй
дадуулагтун!!!

Энэ яваа насандаа эцсийн захиас болгож Илгээх зүйл минь
Энэ л байна, өөр онцын зүйлгүй*

Энэхүү Илгээлтийг дахин нэмэлт тайлбарлах хэрэгтэй хэдий ч
одоогоор энд өгүүлсэн зарим санааг тодруулах нь зүй.

Ухамсраа өөрчлөн хөгжүүлж сүнслэг хөгжлийн оргилд
хүргэхийн төлөө зааварчлага болгож үүнийг бичжээ. Шавийн
боловсрон төгөлдөрших нөхцөл хийгээд сэтгэлийн дадалд
суралцах явцыг нь олон төвшинт бүтцээр доорхи байдлаар
илэрхийлжээ:

Шавийн зүгээс багшдаа хандсан төвшин /эхний таван мөр /

Багшийн зүгээс үндсэн сургаалаа илэрхийлсэн төвшин
/дараачийн 8 мөр/

Боловсрох явцын үе шатуудыг илэрхийлсэн /түүний дараахи 10 мөр/

Сургаалыг дамжуулах, уламжлал болон олон үе дамжин төрөл олох явцыг тасралтгүй болгож бэхжүүлэх зорилгоор багшийн н зүгээс дээд төвшин рүү чиглүүлэн төгсгөлийн захиас болгож хэлсэн үг /сүүлчийн дөрвөн мөр/

Гурван эрдэнэ

1. Бурхан Багш (Будда)
2. Түүний сургаал – дхарма
3. Хуврагийн чуулган (Сангха)

Арван чухал учрал

Дотоод (буюу хувь хүнтэй холбоотой)

1. Хүн болж төрөх
2. Оюун ухаан сийрэг
3. Эрхтэн бүрэн (6 эрхтэн)
4. Муу үйл (нүгэл) үл үйлдэх
5. Эх орноо хайрлах

Гадаад:

1. Будда залран ирсэн газар
2. Дээдийн номыг айлдсан байх
3. Дээдийн ном түгээд удсан байх (монголчуудынхаар бол: шашин оршин байх гэж хэлдэг ойлголт бололтой. Орч)
4. Сургаалыг даган орох
5. Бусдын тулд насад энэрэх.

Арван цагаан буяны дадал. Энэ нь Арван Буянт Сэтгэлийг дадуулахтай шууд холбоотой (ямар ч ариун цагаан сэдлээр үйлдэл хийснээс үл үйлдэхүй нь илүү эрхэм байж болно гэсэн

үзэл буддын уламжлалд байдаг). Энэ бол арван хар нүгэлээс татгалзахад үндэслэсэн ёс суртахууны дадал юм.

- Амьд амьтны амь таслах, хулгай хийх, эр эмийн замбараагүй буюу гаж харьцаа гурвыг биеэр үйлдэх гурван нүгэл,

- худал хэлэх, муу үг хэлэх буюу хүмүүсийг хооронд нь хагаралдуулах, хутган үймүүлэх, бүдүүлэг үг яриа, хоосон чалчаа үг дөрвийг үг хэлээр үйлдэх дөрвөн нүгэл,

- атаархах, хорон муу санаа агуулах, буруу номын үзлийг дагах (оршин байгаа зүйлийг байхгүйгээр төсөөлөх)- энэ гурвыг сэтгэлээр үйлдэх гурван нүгэл гэж тус тус нэрлэнэ.

Буддын гүн ухааны “Даши Чойнхорлин” их сургуулийн багш, гэвш лам Нацагдоржо Цыбденов:

Бэлгэ билгийн төгөлдөршилд хүрснийхээ ачаар Хамба Лам Итгэл бясалгалын ихээхэн гүн гүнзгий шатанд орж чаддаг байсан юм.”Газар дэлхийд амьдрахын учрыг тачаалгүйгээр сайтар судлаж, арван цагаан буяныг өнөөдрөөс эхлэн дадуулагтун, хойшлуулж үл болно” гэх зэрэг мэргэн сургаалаа тэрээр айлдсан билээ. Өөрөөр хэлбэл аливаа хүн зовлонг туулах явцдаа өнөө үед түүнд тохиолдож буй төвөг бэрхшээлтэй бүхнээс гарах гарцыг эрэлхийлэн, дүгнэлт шинжилгээ хийж байдгийг тэрээр хэлэхийг хүссэн юм.

Арван цагаан буяны ёсыг баримтлан дадуулж, одоо цагт ухааралд хүрснээр алив хүний үлдээх мөр, үйлийн үр /өнгөрсөн цаг/ нь цэвэр ариун байх бөгөөд ингэснээрээ ирээдүйдээ сайнаар нөлөөлөх нь дамжиггүй. Яагаад гэвэл өнгөрсөн хийгээд ирээдүй маань одоо цагаас хамааралтай шүү дээ.

Бид өөрсдийнхөө үйл хэргийг “дараа” хэмээн үлдээх эрхгүй болохоор нэн даруй ухаарах л хэрэгтэй. “Дараа” хэмээх ойлголт хязгааргүй олон дахин давтагдсаар сүүлдээ зуршил болдог.

Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, будда, Төвд судлалын Хүрээлэнгийн мэргэжилтэн, гүн ухааны доктор Л.Я.Янгутов нэгэн чухал санаа хэлсэн юм: - Хамба Лам Итгэл Хоосон чанарыг таньж чадсан нотолгоо нь түүний бичгийн бүтээлүүдийг шинжлэн судлах хандлагын явцад хамгийн гол үүсгэл үнэн нь болох ёстой, харин шинжлэн судлах арга барил нь энэхүү үүсгэл үнэнийхээ голдрилыг дагавал зохилтой.

Үүнээс улбаалаад онцлон хэлэхэд: Хоосон чанарыг танин гэгээрсэн хүний бичгэн бүтээлүүдийг одоо бидний өмнө тавигдаж байгаа шигээр гагцхүү аман ярианы орчинд авч үзэж болохгүй. Тэдгээрийг Хоосон чанар төвтэй билиг барамидын хүрээнд нь шинжлэн судлах шардлагатай юм.

Билиг барамидын бичиг сэлтүүд Билиг барамидыг ойлгох хүрээнд бол өөрөө биеэ даасан утга учиртай байдаг. Эдгээр бичгэн бүтээлүүд утгыг нь ойлгодог хүний хувьд бол бодитой болгосон ухамсар буюу ухамсрын бодитой тал, ухамсрын үлэмж дээд төлөв, билиг барамидын судруудад өөрийнх нь тухайд чухалчлагдаж байсан тэрхүү бүрдлийн субъектив тал нь юм. Билиг барамидыг нандигнахын үндсэн зорилго нь уншиж, сонсч байгаа хүнийг тухайн бичмэлийг субъектив болгох үйл явцад бэлтгэх явдал гэж үздэг байсан **.

Иймээс бичгийн бүтээлд бол “ухамсрын дүрслэн өгүүлж боломгүй байдлыг” их бага аль нэг хэмжээгээр зөв тусган илэрхийлдэг юм. Дээдийн үнэнийг танин барьсан ухамсрын байдлыг дүрслэн өгүүлэх боломжгүй гэдэг нь билиг барамидын тухай сургаалын нэг чухал тал билээ.

Дээдийн үнэнийг таньсан ухамсрыг бол тиймэрхүү юмтай нь л зүйрлэж болох юм. Энэ бол жинхэнэ бодитой, жинхэнэ оршин буй орчин ямар байна яг тэр чигээр нь олж харж чаддаг ухамсар юм. Ахуйн түгээмэл хөгжлийн тухай үзлийн хэллэгээр юмс ямар байна тэр байдлаар нь олж харж чадаж байвал Хоосон чанар гэгч тэр буй. Үгүйсгэх, байхгүй байх нь утга зүйн хувьд

үндэс нь болдог Хоосон чанар гэх ойлголт нь оюун ухааныг илүүд үзсэн шинж чанаргүй бүхнийг илэрхийлэхэд тохиромжтой нэр томъёо болсон байна.

Нэрт буддист эрдэмтэн Бидия Дандарон: Билиг барамид гэдэг нь “Ертөнц /сансар хийгээд Нирван/ хоосон чанартайг олж харах, Шуньята /мөн адил “хоосон чанар” гэсэн утгатай самгарди үг.орч/-г олж харах тухай буюу” чанад хүрсэн билгүүн ухааны тухай” сургаал “. гэж хэлжээ.

Праджня нь ертөнцийн хоосон чанартайг буюу шуньятыг олж хардагийнхаа хувьд билгүүн ухааны шинжтэй. Хоосон чанарыг олж харах тухай билгүүн ухаан бол нирванд одохтой бүрэн нийцсэн дээд үнэнийг танихад хүргэдэг ухаан мөн. Гэхдээ энэ билгүүн ухааныг ердийн зохист бодлоор шүүн тунгаах, учир зүйн дүгнэлт хийх, үсэг тэмдгээр илэрхийлэх боломжгүй. Энэ нь амаар илэрхийлэх утга чанарыг, объект, субъектын эсрэгцэх шинжийг аль алийг нь үгүйсгэдэг. Өөр үгээр хэлэх аваас Праджня гэдэг нь үг, тэмдэг, бичиг сэлт дээр тулгуурладаггүй, бас гэгээрэлтэй эн тэнцэхүйц дээд үнэнийг шууд танин мэдэх нөхцлийг бүрдүүлдэг тийм билгүүн ухаан.

Ерөөс юмс үнэн хэрэгтээ ямар л байдалтай байнав тэр байдлаар нь олж харахыг гэгээрэх гэдэг билээ.Юмсыг байгаа байдлаар нь олж харах нь хоосон чанарыг олж харж буй хэрэг. Үнэнхүү оршин байвч үр өгөөжтэйгээр тайлбарлан илэрхийлэх боломжгүйг ахуйн түгээмэл хөгжлийн талаас нь хийсэн тайлбарын үүргийг билиг барамидын бүтээлүүдэд хоосон чанар гүйцэтгэдэг гэж болно.

Манай орны будда судлалын шинжлэх ухааны үндсийг тавьсан В.П.Васильев ч хүртэл тухайн үедээ хоёр үнэний онолыг чухалчлан анхаарал хандуулж байсан юм. Энэ онолд өгсөн түүний тодорхойлолт одоо ч гэсэн асуудлаа бүрэн хамарсан, илүү мадаггүй хэвээрээ.

Тэрээр янагуух үнэнийг нэгэнтээ: төрөхөөс өөрт нь заяамал байх ёстой хүчийг өөртөө агуулдаггүй, “материйн шинж байдлаар оршин байдаг зүйл”, “танин мэдэх боломжгүй”, “энэ ертөнц даяар нийтэд заншсан”, “үг ба нэр хоёроос өөр юмгүй зүйл”, “нийтлэг хэллэг”, “нийтлэг ойлголт” гэх зэргээр тодорхойлсон билээ. Түүнээс гадна В.П.Васильев янагуух үнэний ач холбогдлыг дурьдахдаа: “хормын төдийд л оршин байдаг юмсын нэр болохынхоо хувьд нэн хэврэг”, “үнэн биш”, “учир зүйгүй” гээд сүүлд нь үнэмлэхүй үнэний утгыг үгүйсгэдэг” гэжээ. Эдгээр тодорхойлолт бүхний яг эсрэг утга нь үнэмлэхүй үнэнд хамаарна”.

Агуу их Багш нарын бичгээр үлдээсэн буддын сургаалын болон Д.Д.Итгэлын бичгэн өвийн онцлог нь үүнд л байгаа юм. Иймээс Хамба Лам Итгэлын бидэнд үлдээсэн бичгэн өвийн амаар яригдах нөхцөлт чанарын цаана Хоосон чанарын үнэн нуугдан байгааг олж харах ёстой. Энэ бол бичсэн зүйлсийнх нь тэмдэглэгээний учир, бодтой үр дүнгийн агуулгаас нь салгана гэсэн үг өчүүхэн ч биш юм шүү. Энэ утгаараа бол Алс дорнодын буддын уламжлалд боловсрогдон гарч ирсэн шинэлэг сонин үгсийн тухай сургаал арга зүйн тулгуур нь болж ч болох юм. Үг нэг талаас “үхмэл хөшүүн”, нөгөө талаасаа “амилаг сэрмүүн” байж болно.

Бүүдгэр ухамсрын үр дагавар болохын хувьд жинхэнэ бодит байдлыг гажуудалтайгаар тусган илэрхийлж байгаа үгийг “үхмэл хөшүүн” үг гэж үздэг. Учир зүйд тулгуурлан бодож олсон мэдлэгийн үндсийг бүрдүүлэгч бүх ойлголт “үхмэл” үгт хамаарна. Ийм ойлголтуудын талаар тунгаан бодсоноор хүн авралд хүрдэггүй, учир нь тэдгээрийн ганц нь ч гэсэн бодтой оршин байгаа юмсын талаар зохистой мэдлэг өгдөггүй, тиймдээ ч жинхэнэ мөн чанарыг нь танин мэдэх явдлаас улам холдуулж, ухамсрын гэгээрэх явцад саад болж байдаг.

Үүний зэрэгцээ гэгээрсэн ухамсар үгээр илэрхийлэгдэх боломж бас байдаг. Энэ тохиолдолд үг нь тодорхой мэдээллийг өөртөө багтаагч өгөгдсөн агуулгыг илэрхийлэх ойлголт болдоггүй, харин шүүн тунгаах сэтгэлгээний төвшинд агуулгыг нь илэрхийлэх боломжгүй “амьд сэрмүүн” үг болохын хувьд гэгээрсэн ухамсрын тэмдэглэгээ болж байдаг. Тэр нь зөвхөн зөн билгийн ойлголтод л хамаарах зүйл

Эцэст нь нэг зүйлд анхаарал хандуулахад Хамба Лам Итгэлын бичгэн өв бол гүн бясалгалын төвшинд орж биднээсээ салан одсон ч хэдэн арван жилийн дараа хэвийн байдлаараа байгаа биеэрээ эргэн ирсэн хүний өв юм шүү. Тиймээс түүний өгүүлсэн бүхнийг уншлага тарнийн хүрээнд нь авч үзэх ёстой юм.

Түүний бүтээлүүд сэтгэлдээ төвлөрч дүрийг нүдэндээ үзэх чадварыг агуулдаг нь эргэлзээгүй бөгөөд аливаа юмсын үнэн мөн чанарыг хуурмаг хоосон бүрхүүлээс нь ангид тулж ажиглахад тус үзүүлнэ. Энэ утгаараа бол Итгэлын бичгэн өвийг судлах нь Билиг барамидын гайхамшигт судруудын нэг болох, Кумарадживын орчуулснаар таван цогц бүгд хоосон гэх үзэлд аваачдаг, товч боловч тодорхой агуулгатай судар /Билиг барамидын зүрхэн судар/-ыг судлахтай зүйрлүүштэй.

Дүрс нь хоосон чанараас ялгаагүй, хоосон чанар нь дүрсээсээ ч ялгаагүй. Дүрс бол хоосон чанар, хоосон чанар бол дүрс мөн. Сэрэхүй, хуран мэдэхүй, хуран үйлдэхүй, тийн мэдэл зэрэг бусад дөрвөн цогц ч мөн адил хоосон. Ёс суртахуун, буянт сэтгэл, амьдралын зөв зам мөр зэргийг агуулдаг дээдийн номууд ч гадаад өнгөн талаасаа хоосон. Тэдгээр нь буй болдоггүй, алга болдоггүй, бохирддоггүй, ариусдаггүй, ихэсдэггүй, багасдаггүй. Тийм болохоор дүрс гэж ч үгүй, дээр өгүүлсэн дөрвөн цогц ч үгүй. Үзэж, сонсож, үнэрлэж, мэдэрч, хүртэж байгаа субъект ч үгүй, аятана манас ч үгүй, үзэгдэж, сонсогдож, үнэртэгдэж, мэдрэгдэж, хүртэгдэж байгаа объект ч үгүй, аятана дхарма ч байхгүй. Үзэж харж байгаагийн махбод ч, бусад махбод ч үгүй, түүний дотор

ухамсрын махбод ч үгүй. Үл мэдэхийн харанхуй ч үгүй, түүнийг арилгах үйлдэл ч үгүй, өтлөл ч, үхэл ч үгүй, өтөлхийг ч, үхэхийг ч арилгах үйлдэл ч үгүй. Зовлон ч үгүй, түүнийг үүсгэх, эсвэл арилгах үйлдэл ч үгүй, арга зам нь ч үгүй. Билгүүн ухаан ч үгүй, нэгэнт аливаад хүрсэн гэх ололт амжилт үгүй тул хүрэх үйлдэл ч үгүй.

Бодьсадвын ухамсар билиг барамидад тулгуурладаг болохоор саадтай учирдаггүй, тэгээд саад үгүй учир сэтгэлд хямрал ч үгүй, төөрөгдлөөс салснаар эцсийн дүндээ нирванд очдог. Гурван цагийн бүх Будда нар билиг барамидад тулгуурласнаараа дээдийн төгс төгөлдөр гэгээрэлд хүрсэн (аннатару – самья – самбодхи) юм. Иймээс Билиг барамидыг мэдэх нь агуу их ариун гэгээнтний уншлага, энэ бол агуу их ойлгохуйн уншлага, энэ бол үлэмж дээдийн уншлага, энэ бол эгнэшгүй уншлага, энэ бол хамаг зовлонг тонилгох, жинхэнэ, хоосон бус уншлага билээ. Иймээс ч Билиг барамидын уншлага гэж ярьцгаадаг”.

Итгэл өөрөө энэ талаар: “...урьд өмнийн Будда нар ингэж л сургадаг байсан” хэмээн тодруулан өгүүлээд: “Сургаалыг мартал үгүй санаж байх, хадгалан авч үлдэхийн тулд энэ хэдэн үгээр хүргэе” гэсэн байдаг. Учир нь энэ! Мартахгүйгээр санаж байхын тулд, хадгалан авч үлдэхийн тулд гэж байна! Үнэндээ ч буддын сургаалтнуудын зөгнөснөөр барагцаалбал энэ үед Буддын сургаал мартагдан алга болж болзошгүй байсан ажээ.

Сургаал мартагдчихвал юу үлдэх хэрэг вэ? Учир зүйн үүднээс төсөөлөөд үзвэл манай ертөнцөд “түүхэн” шинэ Будда ирж, хүмүүст шинээр Үг сургаалаа айлдаж, ингэснээрээ алга болсон Сургаалыг эргүүлэн гаргаж ирэх учиртай болно. Гэхдээ буддынхны зөгнөдгөөр 5 дахь Их Багшийн ирэх хугацаа нь ихэд хожуу буюу 1000 жил орчмоор яригддаг. Хүн төрөлхтөн өөрийнхөө хийж буй үйлдлээр энэхүү хугацааг ойртуулан

наашлуулж болох хэдий ч үүнд саад болох хэд хэдэн нөхцөл бас байдаг.

Бидний ойлгож байгаагаар бол Итгэл Хамба Ламтаны Илгээлт гарч ирснийг гагцхүү үүгээр л тайлбарлах учиртай байх. Энэ бол зүгээр л нэг юмны учир мэдэхгүй, буруу зөрүүг хийгсэдэд өгсөн анхааруулга биш, харин адис ерөөлөөр гайхамшигт биеэ бидэнд үлдээсэнээрээ сургамж өгч, биднийг ирээдүйд бэлтгэж буй хэрэг*.

Байгаль, нийгэм, хүний олон улсын “Дубна” их сургуулийн шинэ үзлийн тогтвортой хөгжлийн тэнхимийн ахлах багш, математикч Сергей Курсакин:

-Будда Хамгийн Агуугаар Юу ч өгүүлэхгүй байх нь яв явсаар хүмүүс өөрсдөө хажуугийн ямар ч удирдагч, ямар ч аврагч үгүйгээр сайн дураараа үйл ажиллагаагаа хоорондоо зохицуулан бодитойгоор хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм байна гэдгийг бодож олохыг хүлээж байгаа ч хэрэг байж болох юм.

Өнөөгийн ертөнцөд туйлын олон төрлийн үйлдэл- үйл ажиллагааг хүмүүс хийсээр байна. Ямартай ч Илгээлтээрээ бодтой, эерэг сайн үйл хийхийг уриалан буй нь илэрхий. Иймэрхүү эерэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүл хэмээн тунхаглаж болно.

“Хойшлуулалгүйгээр, өнөөдрөөс эхлээд... нэн даруй!!!” Арван Цагаан Буян (Сэтгэл)-ыг Дадуулахын учрыг судлаж, түгээн дэлгэрүүлж, хүмүүсийн хооронд нийгмийн эерэг харилцааг буй болгож, дэмжигч нийгэм – эдийн засгийн технологийг нэвтрүүлснээр сайн үйлсийг үр ашигтай болгох ажлыг хийгүүштэй.

Д.И.Менделеевын нэрэмжит, Оросын хими-технологийн их сургуулийн профессор А.Хачатуров-Тавризян

ГҮН УХААНЧИД ГОЦ ҮЗЭГДЛИЙН ТУХАЙД

Итгэлын гоц үзэгдлийг судлахдаа: байгалийн шинжлэлийн, гүн ухааны, шашины гэсэн гурван талаас нь хандах боломжтой хэмээн ихэнх судлаачид үзэж байна.

Новосибирскийн гүн ухаанч Нима Жамбалдагваев:

- ...Шинжлэх ухаан нь тусгайлсан хэм хэмжээ болохын хувьд, бидний мэдэж байгаачлан, аливаа үзэгдэл хуучин хэвийн, шүүмжлэл дагуулсан, бодит баримтыг барагтай бол хүлээн авах дургүй, зонхилон тохиолддог хэв хэмжээнд үл нийцэх хандлагатай байдаг. Шинжлэх ухааны нэлээд хоцронгуй, сүүл барьсан хандлага чухамдаа яг үүнээс л болдог байх.

Үнэндээ ч “Итгэлын гоц үзэгдэл” шинжлэх ухаанд нэгэнт тодорхой болсон хэв хэмжээнүүдийн нэгэнтэй нь ч адил бус төдийгүй нүдээр үзэж үнэн бодитойг нь үнэмших боломжтой тийм үзэгдэл болж бидний өмнө гарч ирсэнээрээ шинжлэх ухааныханд бүгдэд нь ноцтой дуудлага боллоо. Энэхүү нотолгоо нь зөвхөн шинжлэх ухааны хувьд төдийгүй орчин цагийн соёл иргэншлийн сэтгэл, оюуны талын нэг бүрдэл хэсгийн хувьд ч үнэн бодитой байлаа.

Шашин буюу дотоод сэтгэлийн талаас. Энд уг гоц үзэгдлийг шашны тогтолцоонууд болон дотоод сэтгэл оюуны талын төрөл бүрийн өнцгөөс шинжлэн судлах тухай яригдаж байна. Уг үзэгдэл маань эхнээсээ эцсээ хүртлээ буддын өндөр дээд төвшний ламын үйл ажиллагаатай холбоотой болохоор энэ тохиолдолд буддын шашны талаас хандах нь хамгийн илүү зүйд нийцэх нь тодорхой. Ингэснээр өөр төрлийн, тухайлбал, христийн шашны уламжлалаар ч юмуу, тайлбар өгөх боломжийг мэдээж үгүйсгэхгүй, харин ч сонирхолтой байх болно.

...”Итгэлын гоц үзэгдлийг” орчин үеийн ертөнцөд нийлүүлэх гэсэн ямар ч оролдлого зарчмын хувьд хүн төрөлхтний сэтгэл, оюуны бүхий л нөөцийг аль нэг хэмжээгээр өөрчлөн шинэчлэхэд зайлшгүй хүргэх байх. Ийнхүү “Итгэлын гоц үзэгдэл” нэг талаасаа, бидний мэдлэг, итгэл үнэмшлийн тогтолцооны согогтой, дутагдалтайг нь, түүний нэн зохимжгүй байгааг нь илэрхий заан өгч, бас ингэснээрээ, нөгөө талаас тэдгээрийг өөрчлөн шинэчлэх үндсийг бүрдүүлж байна*.

“Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл” сэдэвт олон улсын анхдугаар бага хурал (2007 он) дээр Андрей Белковский гүн ухаанчийн биш, “хүн судлаачийн эргэцүүлэл” сэдвээр өөрийнхөө санаа бодлыг хэлсэн юм:

- ...хосгүй илгээлтийг уншиж сонссоных нь хувьд, хүн төрөлхтөнд ховорхон тохиох, агуу их оньсого таавар мэт энэ үйл явдалд хамтран оролцогчийнх нь хувьд биднийг энэ дөрвөн хананы дунд цуглуулсан нэг хүн бий. Өөрийнхөө ихэд дээдлэн хүндэтгэдэг XII Бандид Хамба Лам Итгэл болон түүний зүгээс хүмүүстэй харьцаж буй шинэ харилцааных нь талаар би хэлж байна. Гэхдээ түүний илгээлтийн туйлын эрхэм чухал бөгөөд хувь заяаг шийдэгч чанартай агуулга нь Итгэл бидэнд эргэн ирэх шалтгаан нь болсон юм. Тиймээс XII Хамба Ламын зөвлөгөөг ухаалгаар даган, мадаггүй байж, илгээлтийн утгыг зөв ойлгохын тулд оюун ухаан, сэтгэл зүрхнийхээ хамаг хүчийг дайчлах хэрэгтэй болж байна.

.Бусад амьд объектуудын нэгэн адил хүн ч гэсэн оршихуйн хэд хэдэн илрэлүүдэд оршин амьдарч өөрөөр хэлбэл аль нэг хэмжээгээр цаг үетэйгээ зохицон байдаг. Хүмүүсийн тухайд гэвэл эд юмсын оршихуй байгалийн оршихуй, байгаагаараа оршихуй г.м. Хангалттай хэмжээгээр биеэ даасан эдгээр оршихуйн илрэлүүд хамтран материаллаг оршихуйн орон зайг үүсгэдэг. Гэвч олон олон үзэгдэл төгс үлгэр болохуйц (грекүүд логосын оршихуй гэж нэрлэдэг уламжлалтай зүйлийг хэлж

байна) оршихуйг өөртөө мадаггүй* агуулан байдаг. “Ухамсар дахь оршихуй” гэдэг хэллэг нь үүнтэй утга ижил. Ийнхүү байршлыг заасан байгаль дахь оршихуй, соёл дахь оршихуй, ухамсар дахь оршихуй гурван хэмжээст тогтолцоо дахин үүсдэг. Өргөн далайцтай иймэрхүү загвар нь Universum-аас хавьгүй илүү олон хэмжээстэй.

Хэрэв бид Итгэлын гоц үзэгдлийг “ер бусын, ховор үзэгдэл” хэмээн үзэж байгаа бол дүгнэлт нь өөрөө ухаанд ороод ирж байна. Энэ үзэгдэлд янз бүрээр ханддаг хэдий ч нүдэнд үзэгдэхээр бодитой байж байгаа нь мадаггүй юм. Иймэрхүү үзэгдэл байнга тохиолддоггүй, тэгээд бас тохиолдлоо гэхэд бидний мэддэг аргаар, өөрөөр хэлбэл урьд өмнө хэрэглэж байсан, бидний мэддэг бичиг сэлтээр баталгаажуулан баримтжуулсан нь ховор юм.

Тэгэхдээ хүн төрөлхтний түүхнээ бодит биедээ эргэн орж, “анхдагч мөн чанараа сэргээсэн тохиолдлыг бичгэн эх үүсвэрүүдээр нотолсон нь ганц нэг төдийгүй бий. Мария Магдалинагийн хадам Лазарийн үхсэн хүнийг амилуулсныг, бас Иисус Христ үхээд амилсан талаар нэлээд өргөн дэлгэр бичигдсэн байдгийг сануулахад хангалттай. Хаад ноёд, тахилч тайлгачид, бурхан шүтээний зан үйл үйлдэгсэд үхээд амилсан тухай нэг л дүр зураглалын аман яриа ч тархсан байдаг. Уламжлал ёсоор хадгалагдан байдаг ихэнх бичгүүдэд заадгаар бол дахин амилагч (тодруулж хэлбэл бие) нь Логосын орогнох шинэ бие байдаг гэх. XII Бандид Хамба Лам Итгэлын энэ гоц үзэгдлийн хувьд бол магадгүй яг тийм юм болсон байж болзошгүй.

“Гоц үзэгдэл” гэдэг үгийг ойлгох хоёр дахь хэлбэр нь “аливаа объект хүний сэтгэлгээтэй харилцан үйлчлэлцэж байгаа үзэгдэл”-ийн нэр юм. Итгэлын биеийн энэ үзэгдэл хэрвээ гарч ирээгүй, ухаан сэтгэхүйд ороогүй, бид түүний талаар энэ бүхнийг

туулаагүйсэн бол гоц үзэгдэл гэгч ч гарч ирэхгүй байсан гэдэг нь энд хуран цугласан та бүхэнд ойлгомжтой хэрэг.

Хувь хүний сэтгэлгээнд анх удаа ийм гоц үзэгдэл гарч ирж байгаа болохоор “Итгэлын Эрдэнэт Лагшин бол XII Бандид Хамба Ламаас бидний хүн бүхэнд өргөн барьж буй бэлэг мөн. Хүмүүсийн ухамсрын харилцан ойлголцох, хамтран хослолцох шинж чанарын ачаар энэ гоц үзэгдэл биднийг харсаар байтал хувь хүн нэг бүрийн гоц үзэгдлийн цуглуулга байснаа нийт хүн төрөлхтний нэгдмэл нэг гоц үзэгдэл болж хувирлаа. “Хайр”, “баяр”, “инээд”, “уй гашуу” гэдэгтэй л адил хүн бүхний мэддэг нийтийн түгээмэл үзэгдэл гэсэн үг.

“Хоёр дахь мөн чанарын оршихуй” буюу оршихуйн соёл, өөрөөр хэлбэл Итгэлын оршихуй мэдээллийн хувьд цаг хугацаагаа алддаггүйтэй мөн л маргашгүй. Бидний энд авч үзэж буй гоц үзэгдэл өөрөө мэдээлэл дүүрэн, нарийн нягт бөгөөд зохиогч нь болох XII Бандид Хамба Ламын зүгээс гүн гүнзгий бодож боловсруулсан бичиг гэж болно.

Сүүлчийн нэг ажигласан зүйл байна. Хүн үхэлгүй мөнх рүү тэмүүлж байдаг, тодруулбал, алга болчихгүй байхыг тэглээ хүсдэг этгээд зантай. Гэтэл магадлалын онол болон термодинамикийн хуулиуд ядахдаа онолын хувьд ч гэсэн тийм боломжтой гэдэггүй. Хүн биологийн хувьд мөнх байхын үүднээс удмынхаа санг үр хойчдоо давтан хуулбарлаж дамжуулдаг боловч жижигрэл (мейоз)-ийн улмаас дараахи үеийн тоо хичнээн байхаас үл хамааран ямар ч эцэг эхийн хувийн дамжин удамших зарим чанарууд нь алдагддаг.

2009 оны бага хурал дээр А.Белковскийн тавьсан илтгэлийн зарим хэсгээс нь мөн дурьдая:

- Европын шинжлэх ухааны хувьд эсрэгцсэн хоёр бүтэцтэй байх нь заншил болсон зүйл. Нарийн төвөгтэй үзэгдлүүдийг хоёр талаас нь хослуулах байдлаар тодорхойлон илэрхийлэх гэж

оролддог. Ийм байдлаар “сэтгэлийн дээд”, “биеийн доод”, “үл ухамсарлахуй” гэсэн нэр томъёонууд гарч ирдэг тэгээд харамсалтай нь төдөлгүй зүйрлэл болон хувирч, цаашлаад учир утга нь олдохгүй бэлгэ тэмдгүүд болчихдог.

Одоогийн дахин хувилаад байгаа XII Бандид Хамба Лам Итгэлын үйл ажиллагаа нь ихэнхдээ орчлон ертөнцийн өнөөгийн хөөрхийлөлтэй дүр зураг хийгээд хүний тухай олон нийтийн дунд тархсан ядмагхан төсөөллийг арилган ухааруулахад чиглэгдэж байна.

Гэгээрүүлэн сэнхрүүлэх ийм үйл ажиллагааг буддын гүн сэтгэгч маань аль XIX, XX зууны зааг дээр эхэлснийг тэмдэглэн хэлүүштэй. юм:

Петербургийн онолч А.Тихоновын үзэл:

- ...Хүрээлэн буй ертөнцийн талаархи олны мэддэг төсөөллөөр бол Хамба Лам Итгэлын яг хэвээрээ байгаа ариун лагшин шиг тийм биологийн объект байх боломжгүй. Энэ объект зөвхөн оршин байх төдийгүй манай ертөнцийн амьдралд байнгын оролцоотой байна. Тухайн баримтад үндэслэн: энэ ертөнцийн талаархи бидний төсөөлөл төгс төгөлдөр биш байна, засвар өөрчлөлт хийх хэрэгтэй байна гэсэн ганцхан л санааг хэлж болно.

БУДДИСТУУД ГОЦ ҮЗЭГДЛИЙН ТУХАЙД

XXIV Бандид Хамба Лам Дамба Аюшеев:

- ...Бидний өөрсдийн маань харанхуй мунхагийн цаана нуугдан байгаа ухааныхаа чадамжийг бүрэн нээх боломжийг хүн бүрт олгохын тулд Багш маань эргэн ирсэн юм. Хоёр дахь Будда Нагаржуна хэлэхдээ: таван цогц /хүний бие/ –ын явц нь асч буй зулын гэрэлтэй төстэй юм гэсэн билээ. Тиймээс Хамба Ламын биеийг манай зовлонгийн далай дунд бөхөшгүй бадран буй зулын гэрэлтэй зүйрлэж болох юм. Буддын сургаалаар бол дээд Бодьсадва нар, Ядам бурхад, Дагинас, сахиуснууд, мөн тэнгэр төрөлтнүүд буддын тамд тарчилж буй хамаг амьд амьтдын хамтаар Хамба Ламын Эрдэнэт Лагшингаас цацран буй гэрлийг харж, мэдэрч байгаа.

Тиймээс дээд архадуудын хувьд Хамба Ламын бие хамаг амьтдын тусын тулд түүний хийсэн үйлийнх нь баталгаа, илэрхийлж буй талархал болдог бол тамд зовогсодын хувьд авралын чигийг заагч найдвар болж байгаа. Харин дэргэд нь байгаа бидний хувьд бол Хамба Лам Итгэл таван цогцынхоо хамтаар бидний ариун үйлсийг удирдаж чадах Багш маань юм.

Будда Шагжамунигийн сургаалд архад хийгээд хүний дотоод ертөнцийг тодорхойлж, итгэл болон хамгаалалтын таван төрлийг дурьдсан бусад тогтолцоод ч байдаг. Тухайлбал:

1. Ламын эрдэнэт лагшинд итгэх
2. Ламын хэлсэн үгэнд итгэх
3. Ламын ухамсарт итгэх
4. Ламын ухаанд итгэх
5. Ламын үйлд итгэх –эдгээр болно.

Та бидний жишээн дээр энгийнээс нарийн нийлмэл рүү гэсэн зарчмаар би эргэцүүлэн бодож тунгаах аваас их алдаа болохгүй болов уу гэж бодно.

Хүн бүхэн байшин барих, мод ургуулах, хүүхдээ хүмүүжүүлэх гэх зэргээр өөрийнхөө дараа үйлийнхээ үрийг үлдээдгийг бид мэднэ.

Эрдэмтэн бүр шинжлэх ухааны нээлтүүдээрээ оюуныхаа хөдөлмөрийн үр шимийг хүмүүст тус хүргэн үлдээж чаддаг.

Урлагийн авъяастнууд хүн төрөлхтний нандин ухаанаар шүүлгэхээр гайхамшигт бүтээлүүдээ үлдээдэг.

Алдар цуутнуудын дуу хоолойг бичиж авч хадгалан үлдэж чаддаг болсон цаг сайхаан.

Харин өөрийнхөө биеийг огтын өөрчлөлтгүйгээр бүрнээр нь хадгалан үлдээнэ гэдэг ухаанд багтамгүй хэрэг.

Үүнээс үндэслээд: хэрэв Хамба Лам Итгэл өөрийнхөө биеийг хадгалан үлдээх хамгийн хэцүү, санаанд багтамгүйг хийж чадсан юм бол миний дээр дурьдсан бүрдэл хэсгүүд болох үг яриа, ухамсар, ухаан, үйлийн үрийн хэсэг бусгууд нь тэр биед хадгалагдан үлдсэн байж таарна хэмээн даруухан бодож болмоор. Харин бид мунхагийнхаа уршгаар үлдсэн эдгээр хэсэг бусгуудын нөлөөг одоохондоо нарийн тодорхой ойлгох чадваргүй байна. Гэхдээ би алдаж байхыг үгүйсгэхгүй.

Өнөөдөр Хамба Лам Итгэлын алдар Оросын нийт буддистуудын дунд алдаршсан нь нууц бишээ. Гагцхүү Хамба Лам Итгэлын биеийн орчиндоо үзүүлэх нөлөөг бүх нийтээрээ сэтгэн ойлгох учирзүй л дутагдаж байна. Хоорондоо холбогддоггүй юмс холбогддог буддын харилцан хамаарлын жам тэгэхээр энд үйлчилж байна.

1. Үжирч үрэгдээд алга болох ёстой биеэ хэрхэн хадгалан үлдээж болох вэ?
2. Хэрвээ хүн буцаж ирснийхээ дараа ганц ч үг дуугараагүй бол түүнийг хэрхэн таньж болох вэ?

3. Санаанд багтамгүй биеийн талаар хэрхэн эргэцүүлэн бодож болох вэ?
4. Уриагүй байхад нь Хамба Лам Итгэл руу хэрхэн ирж болдог хэрэг вэ?
5. Тэгээд эцэст нь, сануулаагүй байхад нь Түүний тухай хэрхэн санадаг хэрэг вэ?

Эхний тохиолдолд – Түүний бие бол гоц үзэгдэл юм.

Хоёр дахь тохиолдолд – Түүний бие ямар ч хаалт саадыг үл хэрэгсэн хэрэгтэй хүндээ хүрч чаддаг нейтрины эгэл хэсгүүдийг гарган илгээж байдаг хүчирхэг төхөөрөмж буюу гэрэл цацруулдаг жижигхэн нартай төстэй юм.

Гурав дахь тохиолдолд – Хүн Хамба Ламын талаар сонсоод сэтгэн бодож, бас гайхаж эхэлдэг, өөрөөр хэлбэл төгөлдөрших замаа эхэлдэг гэсэн үг.

Дөрөв дэх тохиолдолд – Түүний Лагшин нь хүмүүсийг өөртөө соронзон мэт татаж, ингэснээрээ амьдралынх нь дадсан хэв маягийг өөрчилдөг.

Сүүлчийн тав дахь удаад – Хамба Ламтай уулзсаныгаа хэн ч мартаж чадахгүй. Энэ нь өөр гараг эрхсээс газар дэлхий рүү нисэн ирсэн алив юмсын өчүүхэн хэсгүүдийг барин авч хадгалж байдаг Байгаль нуурын устай ижил юм.

Орон зай (вакуум), хий, гал, шороо, ус гэсэн таван махбод ээлж дараалан энд оролцож байгаа нь нүднээ ил байна. Эдгээр нь Хамба Ламын Эрдэнэт лагшинд идэвхтэй байдлаар оршиж, материаллаг ертөнцийн учир зүйд үл нийцэх хэлбэрээр мөн чанараа илэрхийлж байж болох юм.

Манай Хялганатын дацанд амьдарч асан Агван Еши Самбу гэгч монгол лам гүн ухааны олон ном бичсэн хүн. Тэрээр Богд Зонховын магтаал болох номдоо: Та нар Багшийнхаа

өөрчлөгдөж хувираагүй биеийг харж байхдаа ямар сургаал сонсч байна вэ?– гэж асуусан байдаг.

Бидний багш Богд Зонхов өөрийнхөө биеийг хэсэг хугацаанд өөрчлөгдөж хувираагүй хэвээр нь үлдээсэн ба сүүлд шавь нар нь багшийнхаа Эрдэнэт Лагшинг буддын суваргад байрлуулсныг бид бүхэн мэднэ.

Хамба Лам Заяев уг дацанг шинээр байрлуулах газрыг 1770 онд олж, шийдвэр гарган бумба суулгасныг Хамба Лам Итгэл 1912 онд олсон юм.

Хамба Лам маань Тамчийн дацанд хувраг байхдаа урьд өмнө нь хэзээ ч өөрөө зүс үзэж байгаагүй тус дацангийн урьдын бүх Хамба Ламуудын талаар хэлсэн нэг сонирхолтой үйл явдал тохиолджээ.

Тэгэхээр нь тэр хамба ламууд тэгээд ямар байдалтай байсан бэ хэмээн VII Хамба Лам Сандэлэг Ванчиков хувраг Даши Доржоос асуухад нь тэрээр дөрвөн Хамба Ламын байдлыг бүгдийг нь нэн дэлгэрэнгүй хэлсэн гэдэг. Энэ мэдрэмжийнх нь төлөө Даши Доржо хуврагийг “Олоной Хамба” тодруулбал олны тусын төлөө Хамба хэмээн өргөмжилжээ.

Нутгийнхан нь түүнийг Палын Хамба Лам гэдэг байсан болохоор тэр нэрнийх нь цаана Олоной Хамба нэр нь нуугдан хоцорсон ч байж болох юм.

Сүсэгтнүүдийн ихэнх нь Хамба Ламын араас бүтэн өдөржингөө, хамаг хүчээ гарган дагаад ч түүнийг гүйцэж чаддаггүй байж. Зай уртасч богиносдог үзэгдлийн нэгэн адил цаг хугацаа ч гэсэн сүсэгтнүүдийн хувьд уртсаад, харин Хамбын хувьд богиносдог байсан байх гэж би боддог.

Буддын сургаалын дундач замыг Төв үзэл (Мадхьямика) хэмээх бүтээлдээ тодорхойлсон, мөн нэгэн биед 600 гаруй насыг элээсэн Нагаржуна бээр: урьд нь дээдлэгдэж асан Ламын бие

үрэгдэж, алга болсон бол орчлон бидэнд хязгаар тогтооно, харин үрэгдэж алга болоогүй Ламын Эрдэнэт лагшинг хэзээ нэгтээ чин сэтгэлээсээ хүндлэн дээдэлж сурах аваас бидний хувьд орчлон хязгаар тавихгүй! гэжээ.

Тиймээс Хамба Лам Итгэлын Эрдэнэт лагшинг чин сэтгэлээрээ хүндлэн дээдэлж чадвал Диваажин, Шамбал, Түшит болон Орчлонгийн бусад ариун дагшин газруудад чөлөөтэй хүрч очих сайхан боломж бидэнд олдно*.

2009 онд Аюшеевын хэлсэн санаа цаашдаа ийн үргэлжилсэн юм:

- Өнгөрсөн бага хурал дээр цаг хугацааны гоц үзэгдлийн талаар хөндсөн сэдвээ үргэлжлүүлэн өгүүлэхэд энэ асуудлыг шийдэхэд тийм ч амаргүй гэж хэлмээр байна. “Мөнхийн завсар” гэдэг ойлголтыг үгчлэн орчуулбал “орон зай дахь мөнхрөхүй” гэсэн үг. Хэрвээ түүнийг цаг хугацаатай холбовол цаг хугацааны эрхшээлд байдаг хүмүүсийн хувьд энэ нь цаг хугацаагүй орон зай болно. Тэгэхээр цаг хугацааг эрхшээн захирдаг үхлийн эзэн Эрлэг номун хааны ямар ч нөлөө тусдаггүй мөнхийн нэгэн тусгай орон зайд Хамба Лам Итгэлын бие оршин байна гэсэн үг болж байна.

Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цаг байдгийг бид бүгд мэднэ. Харин дөрөв дэх болон тав дахь цаг байдаг гэх нь уран зөгнөлийн талын л зүйл. Бидний цаг маань цаг хугацааг үзүүлдэг биш, харин бидний мэдэх өрнө, дорно, өмнө, хойт ертөнцийн дөрвөн зүгийг заадаг бололтой. Харамсалтай нь, амьд бүхэн өөрсдийнх нь хувьд ойлгомжгүй цаг хугацааны энэ шинж чанар үгүйгээр амьдарч чаддаггүй. Бас ямар ч хүн энэ ертөнцөд ирэхдээ түүний жам ёсыг дагаж, мэдээж, түүний аясаар амьдрах болдог.

Долоон хоногийн хугацаанд бардо төрөлтөн шинэ төрлөө олж чадаагүй бол дахин нэг жижигхэн үхэл явагдаж, Тод Гэрэл

хүртэлээ уусч, түүний дараа бардогийн бие үүснэ. Долоон удаа ийнхүү давтагдаж болох бөгөөд ингэсний эцэст заавал шинэ төрлөө олно. 49 хоног хүртэл нь хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулдаг нь ийм учиртай.

Их,Бага Хөлгөний ёсоор бадогийн биед үндэслэн Архадын байдалд хүрсэн хүмүүс байдаг бөгөөд тиймээс тэдний хувьд заавал ахин төрөл олох албагүй. Буддизмын түүхэнд Архадууд агуйд, сүмд, эсвэл газрын доор самадийн онцгой төрөлд шилжиж, биеэ олон жилээр хадгалан байлгаж байсан тохиолдлууд бий. Энэ бол Хамба Лам Итгэлын гоц үзэгдэлд шууд хамааралтай асуудал.

Төрөх явцад ирээдүйн эцэг, эхийнх нь цагаан болон улаан язгуур эдүүд нэгддэг. Үхэж байгаа бардо төрөлтний ухамсар энэхүү нэгдлийн голд нь, үр хөврөлийн зүрх байрлах газарт ордог байна.

Зэрэглээнээс Тод Гэрэл хүртэлх байдлууд үргэлжилж, нарийн ухамсар нь Тод Гэрлээс шинэ амьдрал сэргэн буй болдог газар болох улаан-цагаан язгуур эд рүү ордог. 38 долоон хоногийн дараа энэ ертөнцөд хүн буй болно. Түүнд бүх байвал зохих хий, дуслууд, 72 000 судал, хүрднүүд, бусад шаардлагатай бүрдлүүд бүгд бий болсон байдаг.

Ийнхүү орошихуйн эргэн давтагдах тойрогт байгаа хүний ихэнхдээ дамжин өнгөрдөг үхэл, завсрын байдал, төрөлт гэсэн гурван байдлыг дандарын номтнууд Буддын гурван биеийг олоход ашигладаг. Үүний тулд бурхны йогийн уран арга болон бусад зүйлсийг ашиглан үл мэдэхүйн харанхуйгаас бүрэн чөлөөлөгдөж, Бодит амьдрал ямар л байнав яг түүгээр нь туулан гарч, Очирдарийг танин барьж чаддаг.

Хамба Лам Даша Доржи Итгэл Будда буюу Архадын төвшинд хүрсэн үү гэдгийг туршлагатай, боловсролтой хүмүүс шийднэ биз.

**Итгэлийн ордны дэвтэрт
хийсэн бичлэгүүдээс**

2009.10.27.” Хамба Лам ихэд залуу сайхан харагдаж байна”

Проф. Вирний, Оксфордын боловсролын сүлжээ

2010.2.07.”Үзсэнээ ухааран ойлгосны дараа л энэ гайхамшгийн талаар ямар нэг юм хэлж болох юм”

Дэлхийн шатрын 10 дахь аврага Б.Спасский

2010.03.22. “Тун ч сэтгэл хөдөлгөсөн зүйл үзлээ. Хүн бүхний анхаарлыг туйлын ихээр татах учиртай гайхамшгууд байдаг. Мөнхийн билгүүн ухаан, таньж мэдээгүй юмсын зах зухад нь хүрэлцэх боломж олгосонд ихэд баярлалаа.”

Орос Улсаас Монголд суугаа онц бөгөөд бүрэн эрхэт элчин сайд В.Самойленко

2010.06.27. “Хаана л бол хаана очоод баймаар хүч амтагдуулдаг тийм газар орон энэ Дэлхийд байдагт талархалтай байна. Энд ирж үр, ач нарынхаа төлөө залбирч чадсандаа би туйлын баяртай байна”

Н.Зайцева, Израиль, Ашкелан хот.

2010 оны7-р сар.” Энэ газар нутагт ирж сэтгэлийн тогтвор, тэнцвэр олох боломж олгосонд чин сэтгэлээсээ талархая”

Л.Глебова,Оросын Боловсролын хяналтын газрын тэргүүн

2010.12.08. “Бусад ертөнцөөс хүнийг ялгадаг зүйл нь итгэл юм. Хүн ямар шүтлэгтэй нь гол биш, энд харин Бурхан амьдаараа байгаа нь ойлгомжтой байна”

Хошууч генерал В.Бекетов

2011.03.06. “Иймэрхүү юм хэзээ ч үзэж байгаагүй, цаашдаа ч хэзээ ч үзэхгүй биз”

С.Рублёвский, Казань хот

**“XII Бандид Хамба Лам Итгэл. Орос улсын төлөө”
үзэсгэлэнгийн сэтгэгдлийн дэвтрээс**

Дорно дахины улсын музейн орлогч захирал Т.Метакса:

“Үзэсгэлэн ариусгаж, дээшлүүлж байна. Хамба Лам Итгэлын хүчинд сөгдөн мөргөлөө. Энэ үйл явдлыг зохион байгуулагсадад ажлын амжилт, аз жаргалыг хүсье.

Эмч А.Прохоров:“Гайхалтай үзэгдэл юм. Үнэндээ зөв зохист амьдрал ямар нэг онцлог өгөөж хишгээр тэтгэгдэж болох юм. Энэ бол буриадын ард түмэн, Оросын бусад ард олныг ч адислаж буй хэрэг”.

Г.Тихомиров, зураач: “Агуу их, дээдийн оюун билигт хүмүүн – Хамба Лам Итгэлт зориулсан үзэсгэлэнг үзэхээр Москвагийн арван нэгэн сарын энэхүү орой бид гайхалтай, халуун дулаан, сэтгэл догдлуулсан мэдрэмж тээсээр явлаа! Агуу их буддын шашин, соёлыг үзэх боломж миний амьдралд дахин нэг удаа тохиосонд баяр,жаргалтай байна.”

А.Дягтерева, РС-ийн гавъяат жүжигчин (Якути): “XII Бандид Хамба Лам Итгэлын гайхамшигийг өөрийн биеэр үзэх боломж олгосонд их баярлалаа! Та бүхэнд сүнсээ хөгжүүлж, итгэлээ сэргээж, гэгээрэхийн ерөөл өргөө”!

А.Койбагаров, Карма Кагью уламжлалын Оросын холбооны тэргүүн:

“Ийм үйл явдлууд хийгээд сайн сайхан, хайр энэрлийг мэдэрдэг, уриалан тэмүүлдэг төрөлтнүүдийн тусын тулд зохиосон сайхан арга хэмжээний тусламжтайгаар манай оронд, түүний гайхамшигт нийслэлд буддизм түгэн дэлгэрнэ”

О.Скотников, “Versivo” холбооны ерөнхийлөгч: “Агуу их Итгэлтой уулзсандаа баяртай байна. Ийнхүү харьцах явдал үргэлжилж, түүний суу билгийн тээж явдаг баяр жавхлан бүх хүмүүст зохицол нийцлийг авчраасай гэж хүснэ”

С.Антонов, “Культура “телесуваг: “Оюуны хөгжил, амьдралдаа жинхэнэ зүг чигээ олоход нэн шаардлагатай, чухал үйлс. Жинхэнэ бодотод ойртон очих боломж олгосон зохион байгуулагчиддаа баярлалаа. “

Надежда, Нина, Татьяна: “Адис ерөөл, хайр, сэтгэлийн баяр баясгалан,гэрэлт ирээдүйдээ итгэх итгэл хайрласан Хамба Лам Итгэлтаа баярлалаа.

Надежда, Нина, Татьяна: Энэ ертөнцийн юм бүхэн зүй тогтолтой, Энэ үзэсгэлэнгээрээ зүрхэнд маань гэрэл асааж, итгэл найдвар суулгаж, нөхцөл болзолгүй хайр мэдрүүлсэнд баярлалаа”

С.Батарова:“Энэ үзэсгэлэнгээ, нэн ялангуяа Лам Итгэлын юмсыг нааш нь авчирсан нь үзэгчид ямар шүтлэгтэйгээс үл хамааран бид бүхэнд өгсөн үнэлж баршгүй бэлэг билээ. Энэ бол онцын сонирхолтой, гайхамшигтай зүйлс!”

А. ба С. Зробан: Сайхан үзэсгэлэн үзүүлсэнд их баярлалаа. Үнэнийг бид олж мэдлээ! Даши Доржо Итгэлт Оросын иргэний паспорт олгох талаар олон нийтийн санал асуулга явуулах нь зүйтэй.”

П.Осадчий: “Романовынхны гэр бүлийн 300 жилийн ойг тэмдэглэхийн босгон дээр Романынхны найз, хамтрагч – Хамба Багш Даши Доржо Итгэлын гэгээн дурсгалд зориулсан энэ үзэсгэлэн гаргаж байгаа нь Орос орон оюуны талаар сэргэн мандах, Үнэн алдартын хаант Орос гүрэнг сэргээн байгуулахын анхны томоохон алхам юм.”

Зөвлөлтийн улс төрийн хоригдол агснуудын Холбооны гишүүн В.Майер

“Москвагийн газар нутаг дээр буддизмын иймэрхүү үзэгдлийг зохион байгуулсанд туйлын их баярлалаа”

Неразбочиво: “Их баярлалаа. Өнгөрсөн он жилүүдэд Иволгины дацанд очихсон, Итгэлын гоц үзэгдэлтэй танилцахсан хэмээн бодсоор байлаа, ингээд эцэст нь энд танилцлаа”

Ф.Егорова: “Үзүүлсэн бүхний төлөө, бүх хүмүүсийг бодож сэтгэх юмтай болгосонд, сайн үйл ихийг хийхийг ойлгуулсанд Туйлын их баярлалаа!”

И.Розенблум. Орос улсын төрийн шагналт

“Маш сонирхолтой, танин мэдүүлэх ач тустай үзэсгэлэн байлаа. Шинэ мэдээлэл, шинэ сэтгэгдэлийг үй түмээр нь оллоо”

ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТҮҮХ

2010 оны 2-р сар. Буриад Улсын Ц.Сампиловын нэрэмжит Урлагийн музейд “Бандид Хамба Лам Итгэлын гоц үзэгдэл” сэдэвт анхны үзэсгэлэн Улаан-Үд хотод гарсан.

2010 оны 3,4-р сард “Урга Тревэл” компаний санаачлагаар Монголын Улаанбаатар хотод Занабазарын нэрэмжит музейд үзэсгэлэн гаргасан

2010 оны 6-р сар – Санкт-Петербургт зохиогдсон буддын соёлын хоёр дахь арван хоногийн үеэр Санкт-Петербургийн Гунзэчойнэй дацанд үзэсгэлэн гаргав

2010 оны 7-р сар – Монгол дахь буриадын соёлын холбооны урилгаар үзмэрүүдийг хоёр дахь удаа Монголд аваачиж, Олон улсын бүх буриадын “Алтаргана” их наадмын хүрээнд Улаанбаатарт орчин үеийн урлагийн музейд дэлгэн үзүүлсэн

2011 оны 4,5-р сар – АНУ-ын буддын сүмүүдийн дэргэдэх төвүүдэд үзэсгэлэн гаргав: Нью-Жерси мужийн Хауэлл хот, Пенсильвани мужийн Филадельфи хот, Нью-Йорк хотын буддын төв, АНУ дахь Монголын Элчин сайдын Яаманд үзүүлэнтэй тайлбар, Нью-Йорк хотын Анагаах ухааны төвд мөн тайлбар

2011 оны 11-р сар—Монголын дархан хотын музейд хэсэгчилсэн үзүүлэн


2011 оны 11-р сард – Агын Буриадын тойрогт Г.Цыбиковын нэрэмжит музейд үзэсгэлэн гаргав


2012 оны 5-р сард – Цагийн хүрдэн (Калачакра) бурханд болон Бандид Хамба Лам Итгэлын 160 жил, түүний эргэн ирсэний 10 жилийг тохиолдуулан Санкт-Петербургт зохиогдсон буддын соёлын IV арван хоногийн хүрээнд хэсэгчлэн үзүүлсэн

2012 оны 11,12-р сар – Бандид Хамба Лам Итгэлын 160 жил, түүний эргэн ирсэний 10 жилийг тохиолдуулан “Бандид Хамба Лам Итгэл. Орос улсын төлөө” сэдвээр Москва хотод орчин үеийн дизайн, шинэ санаачлагын Төвд хэсэгчилэн үзүүлсэн

Монгол улсын Эзэн Шашин төрийг хослон баригч
Нарангэрэлт түмэн наст хаан Жибзундамба хутагт бээр
Орос улсын эрхэм Бандид хамба Итгэлийн Дашдоржид
Тэргүүн зэрэг, эрдэнийн Очир одонгоор шагнасан тухай
архивын баримт

(Босоо Монгол бичгээр бичигдсэн эх хувь)





Орчин цагийн Монгол хэлэнд буулгасан нь

Олон нийтэд анх удаа ховор баримт!!

Монголын Богд хаанаас тэргүүн зэрэг Эрдэнийн очир одонг Эрхэм Бандида хамба Итгэлийн ДАШДОРЖИД улсын тусгаар тогтнолыг дэмжсэний учир талархан шагнасан тухай захидал (Монголын Үндэсний архивын баримт) 1913 он.

Монгол улсын эзэн шашин, төрийг хослон баригч наран гэрэлт хаан Жавзандамба лам бээр:

Их Орос улсын

Их баатар цагаан хааны зарлигаар тавигдсан зүүн Сибир дэхь орны бурхан Шагжимуний шашинтны тэргүүн Бандида хамба лам хийгээд Шагжимуни бурханы шашныг шүтэгч Буриад Монгол бүгдийн сайныг лавлахын учир аа. Эдүгээ та бүхэн уг язгуур үндэс ба нэг бурханы шашныг шүтсэн ээ бодон сүслэж миний биеийг

Монгол улсыг мандуулан хаан ширээнээ суусанд баясгаланг илтгэн бичиг хүргэж, тоотой(?) хүн зарж илгээсэнд би бээр их л баясаж хүлээн авлаа.

Эрхэм Бандида хамба тэргүүтэн Шагжимуни бурханы шашныг шүтэн түүний ёсыг гол болгож олон та бүхнээр хамаг амьтаны тусын тул, дөрвөн цаглашгүйн үүднээс номлол бүтээснээ шашин нь улмаар бадруулан дэлгэрүүлж харьяа (*хажеяа, хамаг?*) амьтан харшлахын шалтгаан үгүй, зохилдохын шалтгаан зөндөө бүтсээр нас буян, эш онолын эрдэм аугаа гүйцэн цог учрал бүхэн улам улмаар шинийн саран мэт аривдан дэлгэрч, баяр билэг хослон амгалан жаргалан лугаа төгөлдөр оршоор байх ба, бас ч та бүхний

Эзэн их баатар цагаан хааны хутаг урт, дүр нь бат, албат бүхэн амгалантай байтугай хэмээн

Чухаг дээд гурван эрдэнэд залбирсаар буйг сонсгохоос гадна Эрхэм Бандида хамбад Шашныг хүндлэгч цол, тэргүүн зэрэг эрдэнэ очир, зарагдан ирсэн ширээт цорж Шагжид хамбын ямба, дэд зэрэг эрдэнэ очир, цорж Нямбууд цоржийн зэрэг, гутгаар зэрэг эрдэнэ очир, түшмэл Гомбожавд гүнгийн зэрэг жинс, дэд зэрэг эрдэнэ очир, гавж Балчинд хувилгааны зэрэг тус тус шагнасан явдалыг мэдэгдэж үүний тул хариу бичиж илгээв.

Олноо өргөгдсөний гурав дугаар он. Зуны дунд сарын
..... сайн өдөр. Эрдэм итгэмжит сүмд бичив.





Иволгинский дацан, 14.09.2011 г.



Монгол улсын 26 дахь ерөнхий сайд Дархан хан овогт Дамдины Сүхбаатарын Батболд дээрх Монгол улсын эзэн хаан Живзундамба хутагтын Орос улсын Бандид хамба Итгэлийн Дашдоржид Тэргүүн зэргийн Эрдэнийн Очир одонгоор шагнасныг зохих баримтын дагуу магадлан үзэж Итгэл хамбын лагшинд эргүүлэн залах ёслол болвой.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.
БУРИАДЫН СҮМ ХИЙДҮҮД БОЛОН АРИУН
ДАГШИН ГАЗРУУД**





Ариун Байца




Забайкалийн нутгийн Бурят-Агинскийн Дульдургын районы зэргэлдээ орших Акшинскийн районы Байцын цохионы бэлдэх Узонскийн дацанг өнгөрсөн оны 8-р сарын 25-нд нээн равнайлав. Уг нээлтэд Бандид Хамба лам Д.Аюшеев, Забайкальскийн нутгийн Дэд хамба лам Ц.Дондукбаев, Сангхи бусад дацангийн лам нар болон ойр орчмын тосгоны иргэд оролцсон.

Чингэс хааны үеэс алдартай Курулга тосгоноос ойролцоогоор 20 км-д орших Улястуй гэх өвөрмөц газарт 10 давхар байшингийн өндөртэй тэнцэх Байцын цохио оршдог. Байцын орой дээрээс харагдах мутар нь аз болоод элбэг дэлбэгийг өгдөг. Эртний грекид үүнийг баялагийн бэлэг тэмдэг гэж тооцдог. Байцын цохионы ариун мутар нь сургаалийн гэрэл цацруулах Будда багшийн гарын алга юм. Узонскийн дацангийн ширээт лам Б.Ирдынеевын хэлснээр энэ газрыг Курулгийн оршин суугч хөгшин эмэгтэй Примба нээсэн гэдэг. Түүний багш нь сургагч лам Одцэр байсан.

1926 онд Байцын цохионы бэлд том хурал хурсан. Одцэр лам хүнд цаг ирэхэд энэ газрыг орхихгүй байх мөн Байцад байгаа сургаалийн гэрэл өгөгч Минтугва бурханы 100 мянган барималыг нуухыг урьдчилан захиж байжээ. Одцэр лам сайхан цаг ирэхэд Байца цохионы дунд хурууны гүдгэр арилна гэж хэлжээ. Одцэр лам эндхийн аршаануудыг хамгаалахыг уриалсан. Ялангуяа газар дороос оргилон гарах Онхоек нүдний аршааныг, Байцаас холгүй орших амсраас нь хүйтэн агаар үлээх хосгүй уулыг хамгаалах. Астмд шаналсан, ходоод гэдэсний замын өвчтэй мөн тулгуур хөдөлгөөний аппраттай зуу зуун хүн түүний амсар нүхэнд шилэн хүзүүгээ наан гайхамшигийг өөртөө хүртэхийг оролддог. Хөрш радонон горхид Алханайскийн аршааны адил ван-д ордог. 2005 оноос Узонскийн дацангийн лам нар Улайстуйн нутагт жил бүр Түмэн өлзий овооны тахилгыг хийдэг. Энэ утга нь Буриад хэлнээс 10 мянган баялаг гэж орчуулагддаг. Байцын ариун цохионы бэл дэх Узонскийн дацанг барихад Курулга, Нарасун, Тарбальджей, мөн Хужиртайский дацан байрладаг байсан. Ульхун-партия тосгоны иргэд оролцсон.

Алханы бэл дэх Намнан ламын суварга




Өнгөрсөн 2012 оны 8-р сард Агиинскийн дуганы байрлах Алхана-Турын газар нутаг дах Алхана уулын бэлд Оросын бурхан шашинтнуудын хүвд түүхэн явдал болсон. Байгалийн хосгүй дуган нь бүтээн босгов. Тэр нь Забайкальскийкийн нутагт Буриад Агиинскийн орчим Дульдурганы районд байрладаг. Ам дамжсан домогт 19-р зууны 2-р хагаст Намнанэ лам /Урьдхын Шагдар 1825-1898/ бөөгийн сүнстэй Алхана уулыг орхиж тал хээрт буухыг хэлэлцэж чадсан гэдэг. Үүний эцэст Алхана дах өндөр настай бясалгаач түүнийг оршин суугч Димчиг /Чакрасамвара/-д хувиргасан ба тэрээр хойт зүгийн буддын бурханы сүмд өндөр суурь эзэлдэг. Димчиг нь Алханы хамгаалагч болсон. Яг тэр үед ариун ууланд эмчилгээний гайхамшигтай рашаан ус үүссэн. Энд 2010 оны 8-р сард агуу бясалгаач Намнан ламын суваргын равнай болсон. Забайкальскийкийн нутгийн Буриад Агиинскийн орчимын зуу зуун оршин суугчид Дульдургунск районы дарга Б.С.Дугаржапов, захиргааны удирдагч В.Ж.Жамбалов мөн даргын орлогч В.Ц. Черниноваг угтан авсан. Алханы бэл дэх хурлыг Оросын Сангхи уламжлалт бурхан шашны ширээт лам нар удирдсан. Намнан ламын суваргыг нээхийн зэрэгцээ жанчуб болон Чойпрул суваргыг нээж равнайлав..

Алхана-Тур



Ариун Алханы байгалийн сүм Димчиг,Цындыма, , Ворота /гол үүд/, Доржи-Пагма, Наро Хажидад мөргөн гороо хийхээр сүсэгтэн жуулчдын хөл тасардаггүй. Б.А.Дондоков захиралтай Алхана-тур жуулчны товчооны хамт олон энд ирсэн хүн бүрийг хүлээн авдаг. Энд амрахад зориулсан кемп, коттедж мөн майханаар хангадаг. Алхана-турын газар нь амрагчдад зориулсан цайны газар, машины зогсоол, ванн, спортын болон хүүхдийн тоглоомын талбайтай. Алханд Читээр дамжин очиж болно. Забайкальский нутгийн төв нь улсын олон хотуудтай шууд нислэгээр холбоотой. Нутгийн нийт газар нутгаар Транссибирь, Байкал-Амурын төмөр зам болон авто замтай. Читээс Дульдраганд машин унаа явдаг. Читийн төмөр замын вокзалаас Дульдраганы район руу нийтийн тээвэр явдаг. Читээс Дульдраганы тосгон хүртэл 192 км харин Агинскаас 90 км зайтай. Дульдуреган Алханы үндэсний паркт хүрэхэд ердөө 28 км шороон замаар явна.

Иройскийн дацан



1810 онд Эрхүү мужийн Иро Сэлэнгийн нутагт баригдсан Чойдон Доржилин Иройскийн дацангийн сэргэн мандалт 2008 онд Буриадын Сэлэнгийн районы Ташир тосгонд сахиусан дуганы барилгын ажлаар эхэлсэн. 2009 онд Оросын Сангхи уламжлалт бурхан шашны лам нар нээж равнайлсан.

Дээр үед дацанд 300 хүртэлх тооны лам хуваргууд байсан. 1909 онд Бандид Хамба лам Иролтуев дацанг итгэл үнэмшил болгон дацангийн хөгжилийг олон аймагт хуваасан ба дуганы хашааны цаана аймгуудын сүмийг байрлуулсан: хойт зүгт- Аюши, дорно зүгт- Дара эх, өмнө зүгт- Димчиг, өрнө зүгт- Оточи гэх мэт.

1918 онд IV-р бүх буриадын хуралд Намжил Лайданов нь Бандид хамба ламаар сонгогдсон. 1925 онд бурхан шашинтны 2-р хуралд Бандид Хамба ламын сонгосон гавж Данжа мункожапов түүний сургагч байсан.

Өнөөдөр Сэлэнгийн районы зэргэлдээх тосгон болон Таширын иргэдийн цугладаг уламжлалт хурлыг Иройскийн дацанд хурдаг. XIII Бандид Хамба лам Н.Лайдоновын дурсгалд зориулсан үндэсний бөхийн байлдаан нь энд уламжлал болон зохиогддог.

Бултумурын дацан



Бултумурын дацан Дамчой Равжалин 18-р зууны дунд үед хасагчуудын эрх хүсэлээр баригдсан. Сүмийн гишүүдийн ихэнх нь цэргийн алба хаасан байсан. Буриадын Сэлэнгийн, Кяхтын районы зааг дээр баригдсан Бултумурскийн дацан зөвхөн шашны бус соёлын төв байсан ба нутагтаа гайхалтай рашаан болон эмчилгээний шавраар алдартай байгалийн музей болсон.

2006 онд Убур-Дзокойскийн хөдөө аж ахуйн нутагшилын тэргүүн Ц-Б.А.Аюшеевын санаачлагаар Бултумурын дацангийн сэргээн босголт эхэлсэн. Энэ үеийг хүртэл удаан хугацааны турш Нур-Тухум, Дэбэн тосгоны иргэд энд суварга босгож байсан. 2006 оны зун Бултумурын дацанд сүүлийн хэдэн жилийн турших анхны хурал хурсан, харин 9-р сард нь шинэ дуганыг нээн равнайлав.

Одоо энд Оросын Сангхи уламжлалт бурхан шашны дэмжлэгтэйгээр Цогчен дуган баригдана. 2013 оны зунаас эхлэн Ширээт лам Б.Батоцыренёвын удирдлаганд жил бүрийн ёслол

болдог уламжлалтай болсон. Энэ үед уламжлал ёсоор зөвхөн сүү хэрэглэсэн.

Эрт дээр үеэс Бүгдийн обоо-нд ойр орчимын тосгодын эрчүүд оролцдог байв. Нэгэн зэрэг ариун уулын оргилд үл анзаарагдах холбоотой ариун газруудтай, мөн дуганд Нур-Тухун, Дэбэн, Усть-кяхта, Субуктуй, Харьяста, Хоронхой, Наушкийн зуу зуун оршин суугчдын оролцох хурал болон. Дараа нь эрийн гурван наадмаар өндөрлөдөг.

Гэгэтуйн дацан



Гэгэтуйн дацан Дамба Брэйбүнд мандал бүтээх 3 өдрийн бясалгалыг жил бүр тогтмол хийдэг. Улан-Удийн Дуйнхорын дуганы лам, Калачакрын мастер эртний сартуулын дацангийн лам мандалыг бүтээсэн. Буриадын Джидинскийн районы төвтэй адил нэртэй тосгоноос холгүй орших Гэгэтуйн дацан 1769 онд Бургалтай голд баригдсан. Яг энд Дабанай Аман Бургалтайн хөндийд Оросод буддын шашны сүнслэг сэргэлтийн удирдагч Дарма Дэмбэ (Лубсан-Нима Дармаев) хамба төрсөн.

1991 онд гурван давхар Цогчен дуганг нээн равнайлаж Гэгэтуйн дацангийн сэргэлт эхэлсэн. 2002 онд Гэгэтуйн

дацангийн тухайн үеийн Ширээт лам М.Р.Чойбоновын санаачлагаар эмчилгээний мамба дуганг нээсэн.

Гэгэтуй Джидинскийн районы тосгонд 18 м диаметр, 11 м өндөртэй хамгийн том бөхийн ордон баригдсан. Ширээт лам А.Чойдоновт, биеийн тамир спортын байгууллагын удирдагч В.М.Бумбошкин бээр дацанд бөхийн хивс дэвжээ бэлэглэсэн. Гэгэтуй дацангийн газар уг бөхийн гэрийг барьсан.

Атаган-дырестүйн дацан



1930-аад онд ЗХУ-н засаглалын үед устгагдсан, Лхундуб Деченлен Анаган-Дырестуйн дацангийн сэргээлт 2004 онд эхэлсэн.

18-р зууны 2-р хагасд баригдсан Сэлэнгийн буриадуудын анхны дацангуудын нэг байсан юм. Түүнийг Номт уулын бэлд зэд голын зүүн эрэгт атаганчууд барьсан. Түүний гол дуган нь 2 давхар чулуун дуган байсан. Дацангаас Номт уул хүртэл суварганууд байрладаг.

Түвдийн лам Ломумба нь 50 жилийн турш Атаганы дацангийн ширээт ламаар байсан. Тэр үед буддын цогцолбор 16 дуган, 300


гаруй ламтай байсан. Дацанд ном хэвлэл, тайлбар зураг хийх, соёлын уран барилгаар хичээллэж мөн хуврага нарыг сургаж бас хүмүүсийг эмчилдэг байв.

Өнөөдөр Цогчин дуганы хойт хэсэгт уламжлалт хурлыг хурдаг. Дацангийн ивээн тэтгэгчид болон ард иргэдийн оролцсон барилгын ажил 2014 оны зун дуусаж мөн Атаган Дырестуйн дацангийн гол дуганг нээн равнайлав.

Сартуул-Булагийн дацан

Буриадын Джидинскийн районд байрлах Геден Пунцоглинг Сартуул-Булагийн дацангийн хувьд өнгөрөгч он онцгой байсан. 2013 оны 9 сарын 10-нд Цогчин дуганы барилгын ажил эхэлсэн. Бүх Бурханы хүчний хувилгаан гол бурханд тооцогддог Баджрапани суваргын ариусгал 9 сарын сүүлд Алцаг тосгонд болсон. 10 сард Х.Намсраевын нэрэмжит буриадын драмын театрт Сэргэн мандалтын булаг концерт Сартуул-Булагийн дацангийн сэргээлтэнд зориулан тоглов.

Суваргыг 2006 онд Оросын Сангхи уламжлалт бурхан шашны тэргүүн Д.Аюшеев, ширээт лам Б.Раднаев нар равнайлав. Хуучин дацангийн газарт суварга босгосон.



Дараахан нь Сартуул-Булагийн дацангийн газарт сахиусан болон дэмчиг дуганг босгов. Эртний сартуулын дацангийн сэргээн босголтонд Джидинскийн районы оршин суугчид, хотын захиргаа удирдлагууд тусалсан. Ардын хурлын гишүүн В.М.Абушеев болон С.Г.Пашинскийгийн тусламж ихээхэн ач холбогдолтой байсан. Сартуул-Булагийн дацан нь зарим өгөгдөлд 1780-аад он, заримд нь 1805 онд Хурай-Булагт баригдан дээд эрдмийн зэрэгтэй 5 лам буддын шашинд өгсөн гэдэг. VIII Бандид хамба лам Чой Василин эндээс гарсан ба 2009 оны 2 сарын 14нд Петропавловкад түүний тэмдэглэлт ойг тэмдэглэсэн.

Санагийн дацан

Закаменскийн районы газар нутагт Санагийн дацан Даша Пунцоглин байрладаг. 1786 онд Номт гол гэх газар анхны сүм баригдсан. Анхны Бандид Хамба лам ирээдүйн дацангийн газрыг бурханы байх газар гэж нэрлэсэн.



1834 онд анхны модон дуган, 1882 онд 3 давхар чулуун Цогчин дуган баригдсан. Тэр үед Чойра, Диваажин, Майдари, Манбын, Дуйнхор, Цанид, Маанийн дуганууд баригдан равнайлагдсан байсан. Санагийн дацанг Иройскийн дацангийн Ширээт лам нээсэн.

Ширээт лам Зоохэйн Гавжийн ачаар Санагийн дацанд анхны цам болсон. Майдар дуганд баярын хуралд зориулагдсан морь, зааны дүрс болон Майдарын баримлууд хадгалагддаг. Санагуд зөвхөн Закаменскийн уулын иргэд бус Окинск, Пункинскийн районоос мөн Монголын Хөвсгөл аймгаас хүмүүс ирдэг.

1935 онд устгагдсан Санагийн дацангийн сэргэлт 20-р зууны төгсгөлд анхны ширээт лам Р.Д.Зундуевын хүчээр эхэлсэн.

2007 онд Генин-Чинбо уулын бэлд Дуйнхор суваргыг барьсан. Санага болон ойролцоох тосгодын иргэдийн тусламжтай баригдсан Цогчин дуганы барилгын газарт Оросын бурхан шашинтны тэргүүн Д.Аюшеев ариун бумба оршоов. Ширээт ламын удирдлаган дор Санагийн дацангийн явуулдаг уламжлалт

зуны обоо-нд Далахай, Хужир, Утата, Дутулур, Енгорбой, Шара-Азаргын оршин суугчид оролцдог.

Цэжэ-Бургалтайн дацан



Закаменскийн районы нутагт байрлах Дондуп Норбуулин Цэжэ-Бургалтайн дацан 1828 онд баригдсан. Энэ нь тухайн үедээ 300 орчим лам хуврага үйлчилдэг, тэдний дундаас аграмба хэмээх өндөр хэргэмтэй ламтай байсан томоохон сүмүүдийн нэг. Ийшээ Ехэ-Цахираас эхлээд Харацай хүртлэх тосгоны сүсэгтэн ирэн очдог байсан. Дацангийн анхны ширээт ламаар Парын Дагба байв.

Бургалтайн дацан 1935 онд засгийн эрхээр устгагдсан. 82 хүний бүрэлдэхүүнтэй шашны нийгэмлэг байгуулагдсанаар 1991 онд түүний сэргээн мандалт эхэлсэн. Нийгэмлэгийн зөвлөлд

Улекчин тосгоны захиргааны тэргүүн Б.С.Очиров орсон. 1991 оны 8 сарын 12нд томгуйхэн дуганд анхны мөргөл болсон.

Дацанг сэргээн босгоход Бургуй, Хамней, Хуртуг, Михайловка тосгоны иргэд ихэд тусалсан. Дацангийн газарт өөр 2 модон дуган баригдсан байсан.ба 5 тосгоны иргэд өөрсдийн байшинг зөөж авчирсан. Одоо бургалтайн дацангийн ширээт ламаар Энэтхэгт боловсрол эзэмшсэн Дэнзэнгэлэн лам байдаг.

Устгагдсан Цогчин дуганы газар дээр Оросын уламжлалт бурхан шашны дэмжлэгтэйгээр 2012 онд шинэ сүм барих болсон нь Цэжэ-Бургалтай дацангийн хувьд дурсгалт үйл явдал юм. Одоо Усть-Бургалтай болон хөрш тосгодын иргэдийг хамруулсан хурал нь томгуйхэн дуганд хурдаг.

Шибертийн дацан




Хилок голын хөндийд нүүдэллэн амьдрах хөх юрта гэх газарт 1826 онд баригдсан Даша лхундублин хуучны дацангийн залгамжлагч Буриадын Бичурскийн районы Улаан-Хад ариун уулын бэлд байх Шибертийн дацан. Хөх юртын дацан нь гүн ухаан, зурхай, түвдийн анагаах ухаан, төөрөг зурлагын төв болсон, Думын талын Хоринск газар нутагт байрлах 10 дацангийн нэг хожим нь нэрээ Амгалантын дацан болгон

өөрчилсөн. Забайкальск нутгийн Усть-Обор тосгон Бичурскийн районы бурхан шашинтнууд, мөн Кижингинск районы загастай тосгоны нутгийн хүн Б.Бадмаевын тусаар Шибертийн дацан дахин сэргэсэн. Тэнд хэд хэдэн суварга босгосон. 2010 онд шибертийн дацангийн Цогчен дуган баригдсан. Бичурскийн нутагт дацанг дахин сэргээхэд ардын хурлын гишүүн В.П.Доржиев, б.Ц.Семенов, В.А.Павлов нар хөрөнгө оруулсан.

Амгалантын дацангаас холгүйхэн ширээт лам Б.Бадмаевын удирдсан, мөн ижил нэртэй тосгоны иргэдийн хүчээр эртний Буддын сүмийн лам нарын дурсгалд зориулан суварга бүтээсэн. Бичүрчүүдийн энэ баярын өдөр тосгоны дээгүүр онгоц нисэж, түүнээс хүүхэд багачууд анх удаа төрөлх амгалантыг өндөрөөс харсан юм. Цугласан хүмүүсийн алга ташилтан дор шүхэрчид газардан эхэлж баяр нь эрийн гурван наадам уламжлалт тэмцээнээр өндөрлөсөн.

Манжушири ордон



Буриадын хиагтын районы Эргэ Бургэ газарт 2013 оны 9-р сарын 6-7-ны өдрүүдэд түүхэн явдал тохиосон нь Оросод анх баригдсан Манжушрын ордоны нээлт равнай байлаа. Түүнийг 1732 онд Бодхисатвын урисан анхны Бандид Хамба лам Дамба Даржа Заяев: заанЭнд,энэ газарт Бодхисатва Манжушири олон бэлэг тэмдэгүүд үлдээсэн хэмээн үздэг байсан ба энэ нь Эргэ бургийн сэргээгдсэн ордны хаалган дээрээс уншигддаг.

Мэргэн ухааны дарь эхийн гадаад төрх хамгийн ойрын ариун уулан дээр илэрсэн. Яг энэ газраас оросын эзэнт гүрнээр сургааль тархаж эхэлсэн.

Дацангийн газар нутаг дах бүх дуганыг нээх, адислалын хүчийг сэргээх Дашинима Рамнай хурал нь өглөөний 6 цагаас үдшийн бүрий хүртэл үргэлжилсэн. Уг хуралд Оросын Сангхи уламжлалт бурхан шашны ширээт лам оролцсон.

Боддхисаттва Манжушри ордон нь Оросын ерөнхийлөгч, Бүгд найрамдах улсын аж ахуй нэгж байгууллага болон Кяхтийн районд байрлах Балдан Брэйбун дацны гишүүдийн санхүүгийн дэмжлэгээр баригдсан. Тус сүмийн гишүүд Ширээт лам Б.Шараевтай хамт Бандид Хамба лам Д.Аюшеевын удирдлаган дор Усть-Киран тосгоноос холгүйхэн Манжушри ордонг өөрсдийн архитектурын загвараар богино хугацаанд барьсан нь бахархууштай.

Дацанг равнайлсаны дараагийн өдөр нь энд цам, эрийн гурван наадам болон концертын үзүүлбэртэй баяр болсон.

Иволгийн дацан

24-р бандид хамба лам Д.Аюшеевын оршин буй Иволгийн дацан 2013оны хувьд онцгой жил байсан. 2013оны 4-р сард Оросын ерөнхийлөгч В.В.Путин энд зочилсон.Улсын тэргүүн Оросын уламжлалт Бурхан шашны лам нартай уулзсан.



Оросын ерөнхийлөгчийн ажлын алба (захиргааны)-ны тусламжийн ачаар Иволгийн дацангийн (Ширээт лам А.Цырендылыкөв) газарт хамгийн том Цогчин дуганы барилгын ажил эхэлсэн.

Мянга мянган хүн жил бүр бандид Хамба лам Д.Д.Этигэловын хуралд оролцдог. Оронгой тосгоны- ойролцоо Өлзийт-Добо гэх нутагт дах түүний төрсөн газарт болон Иволгийн дацанд зөвхөн Бурядаас гадна олон улсаас ирэх мөргөлчидийн цуваа тасардаггүй

Хоёр жил болоод л Иволгийн дацанд 12-р бандид хамба лам Этигэловын эрдэм шинжилгээний олон улсын бага хурал зохиогддог уламжлалтай. Буриад хэлийг хадгалах олон улсын бага хуралд эрдэмтэд,Буриад хэлний багш нар, олон нийтийн төлөөлөгчид, Буриадийн болон хөрш зэргэлдээх бүс нутгийн Монгол, Өвөр монголын лам нар оролцдог.Уламжлал болсон олон улсын шатрын тэмцээний шагналд Оросын түргэн шатрын төрлийн Оросын цом, Оросын Рапид Гран-При шагналтангууд оролцдог Буриадын соёл уламжлалт шашины төв бөгөөд оросын нутагт байх бурханы шашныг төвүүдийг тэргүүлэн удирддаг болно.

Тамчийн дацан



Оросын Сангхи уламжлалт бурхан шашны 5 дацан Буриадийн Сэлэнгийн районы нутагт байрладаг. 1783-1938 онд Тамчинский (Гусиноозерский) дацан „Даши Гандан Даржаалин нь бандид хамба лам өөрөө байгуулсан. Уг дацан галуут нуурын баруун эрэгт 1741 онд сууриа тавьсан. Галуут нуурын дацанд 14-р бандид хамба лам эндхийнх ба Оросын буддын шашинтны сонин гайхамшиг 12-р дээд шатлан захирагч Даша Доржо Этигэлов хамба хамбаар байсан. Гусиноозерский дацангаас 9 бандид хамба лам нар ээлжлэн суусан байдаг.

1991 онд Тамчинский дацанд буддын шашныг албан ёсоор зөвшөөрсний 250 жилийн ойг тохиолдуулан хийсэн их хуралд

Оросод уригдсан 14-р далай лам оролцож байсан. 2011 онд Галуут нуурын эрэгт Оросын бурхан шашинтнууд (ширээт лам С.Аюшеевын) эртний ариун сүмийн 270 жилийг тэмдэглэн өнгөрүүлсэн.

Сэлэнгийн районы нутагт ариун нандин газрууд байдаг. Тэдний нэг нь Талын Харгана. Энэ газар нь анхны Бандид хамба лам Д.Д.Заяевтай холбоотой ба тэндэхийн дацанд харьяалагддаг. Эндээс нирвана Арайскийн дацан руу хүрэхийн тулд анхны хамба уг газрыг сонгосон . Домогт уг газарт хүний амьдрал болон дахин төрөхөөс татгалзсан 7 ламын сүнс уг газрыг хамгаалдаг гэдэг. 2008 онд анхны хамба лам Д.Д.Заяев-н дурсгалд Суварга бүтээсэн,харин 2011 онд оросын ерөнхийлөгч Путины дэмжлэгтэй Цагаан Дарь Эхийн сүмийн барилга барьж эхэлсэн.Галуут нуураас 4 км зайд орших обоотой гүбэ гэх нутагт Наран гэх Түвдийн анагаах ухааны Москва дахь Клиникийн дарга бүгд найрамдах буриад улсын гавьяат эмч С .Г.Чойжинумаевын санаачлага дэмжлэгээр Загастайн Дэчен Рабжалин дацаныг сэргээсэн.Өнөө цагт ард түмний барьсан харгана тосгон дахь шинэ дуганд хурал хурдаг.

Агийн дацан

Оросын бурхан шашны боловсролын төв Дацан Лхундублинг Агинский дацан 1811 онд бүтээгдсэн . Тэнд Түвдийн анагаах ухааны сургууль Бабу ламын чармайлтаар нээгдсэн бөгөөд дараа нь Энэтхэгийн Дхармасала хотын Түвдийн анагаах ухаан ба зурхайчын дээд сургуулийн салбар болсон. 1998 онд салбар сургууль нь Буриадын Агийн Бурхан шашны дээд сургууль



болон өөрчлөгдөж, 2003 онд Агинскийн бурхан шашны академи болсон. Түүхийг үүсгэн байгуулагч анхны захирлаар Оросын буддын шашны нэрт эрдэмдийн нэг В.Л.Чимитдоржиев байсан. Өнгөрсөн жилийн 8-р сард Агинскийн бурхны шашны академийн анхны захирлын дурсгалд босгосон суваргыг Агинский дацанд Ширээт лам Цыбыков равнайлав. Хурлыг Оросын Сангхи уламжлалт бурхан шашны лам нар уншсан.

Агинскийн бурхан шашны академиас 20 жилийн хугацаанд 200 гаруй хүн Түвдийн анагаах ухаан, буддын гүн ухааны болон буддын зурхайгаар боловсрол эзэмшсэн.

Одоо бурхан шашны боловсрол нь шашны бус анагаах ухаанд тооцогддог ба академийн даргаар Чингис Сультимов ажилладаг.

Энд зөвхөн Буриадаас бус Москва, Санкт-Петербург, Екатеринбург зэрэг бусад бүс нутгаас оюутнууд ирж суралцдаг.


2013 оны Буддын академийн төгсөгчидийн баярын үеэр тэдэнд диплом гардуулсан. Агинскийн дацанд мөн уламжлалт спортын Эрийн гурван наадам зохиож, харин Амитхаши морин тойруулгын газарт хурдан морины уралдаан болдог.

Цуголийн дацан

Цуголийн дацанд Майдарийн хуралд жил бүр зуу зуун хүн зөвхөн түүний ойролцоо бус Забайкальскийн нутгийн орчим дах Буриад Агинскийн Могойтуйн районоос мөргөлчид оршин суугчид цугладаг.

Забайкальскийн эртний дацангийн уламжлалт мөргөл нь Бодхисаттва Майдари мөргөх, Намнанэ ламын суваргыг тойрч гороолох, буддын шашны сүмд хадлагагдсан бунханд гар хүрэх зэрэг боломжтой. Ялангуяа энд хөл хөдөлгөөн ихтэй хурлын өдрүүдэд олон хүн гороонд оролцдог. Саяхныг хүртэл Цуголийн дацанд баяр зуны Дугжууба хүртэл олон хоног болдог .

Өнгөрсөн онд Дид Хамба Цырын Дондукбаевын удирдлаган дор энд Бодхи ариун модоор хийгдсэн сүм мөн Богд Цзонхавын 1000 бяцхан хүн хөшөөг равнайлсан. Забайкальскийн нутгийн болон Буриадын сүсэгтэн олны ачаар дацанд Цзонхавын 390 дутуу хийсэн бяцхан хүн хөшөөг гүйцээн дүүргэсэн.




Өнгөрөгч оны хавар Цуголын дацанд өвчин зовлон, ад чөтгөр, саад тотгороос ангижруулах мөн буян арвижуулах Жинсриг буддын ёслол болсон. Түүнийг Иволгын дацангийн Джуд дуганы лам нар уншсан.

Читийн дацан

Забайкальскийн нутгийн нийслэлийн баруун өмнө орчим Ингода болон Чит голын зүүнд байрлах Титовын толгод дах бунханы равнайг Дамба Брайбулин Читийн дацангийн лам нар хийсэн. Ширээт лам Б.Цымпиловын хэлснээр шашны барилга нь байгалтай холбоотой байгаад мөн ард түмний найрамдал эв нэгдлийн бататгал болдог гэжээ.

Забайкальскийн нутгийн Дид Хамба лам Ц.Дондукбаевын удирдсан Чита, Угдан, Агинскийн дацангийн лам нар оролцсон Читийн ивээгч эхэд зориулсан Титовын толгодын уламжлалт обоо нь Читийн болон ойролцоох хүн ам ихтэй газрын оршин суугчдын хувьд жил бүрийн онцлох үйл явдал байдаг. Зуу зуун мөргөлчид гороо хийж Читийн ивээгч эхэд бэлэг бэлэглэдэг. Энэ өдөр буриадын үндэсний бөхийн барилдааны уламжлалт тэмцээн зохиогддог.

Забайкалийн бурхан шашинтнуудын хувьд дурсгалт үйл явдлын нэг нь Читийн дацанд Мандал Бодхисаттва Авалокитешварын нигүүлсэн энэрэл. Түүнийг хийхийн өмнө хүмүүсийн нүгэлийг шатаах галан мандалын ёслол хийдэг



2010 онд ариусгагдсан Читийн дацанд нь зөвхөн Забайкалийн иргэдээр огсохгүй, хуралд нэг ч удаа оролцож байгаагүй Түвдийн лам нар хүртэл ирдэг. Чита дах буддын цогцолбор нь буддын архитектурын уламжлалт үлгэр жишээ мөн Забайкалд ирэх Москвагийн түшмэд, зураач болон жуулчдын заавал очдог газар болсон.

Зугалайн дацан

Дэчин Чойхорлин: Зугалайн дацан 1826 онд Агинскийн талд баригдсан ба хурдацтай сэргээн босгогдсон байдаг. Забайкальскийн нутаг Буриадын Агинскийн орчмын Могойтуйскийн районд байрлах Зугалайн дацанг улсын соёл, түүхийн дурсгалын жагсаалтанд оруулсан баялаг.

Хэдийгээр Могойтуйскийн районд байрлах Цуголийн дацангаас дөнгөж дараахан баригдсан боловч 80 гаруй жил уг дацан ямар ч баримт бичигт бичигдэж тэмдэглэгдээгүй байсан. Яг энд 1913 онд Романов хааны байшингийн 300 жилийн ойд зориулан Дуйнхор сүм баригдсан.



Зугалайн дацан 1991 онд өөрийн хуучин байсан газраасаа холгүйхэн шинэ түүхийг эхлүүлсэн. Мөн энэ онд анхны хурал хурсан. Могойтуй- Первомайскийн автозамын ойролцоох Зугалай тосгоны дацангийн цогцолборт цогчин, Сахиусан дуган, лам нарын байшин болон аж ахуйн бариулгууд ордог.

2012 онд ирээдүйн Цагаан дарь эхийн ордоны ариун шав тавигдсан. Оросын ерөнхийлөгчийн захиргааны төсвийн тусламжтай түүний 1-р давхарыг дахин сэргээсэн.

Зугалайн дацангийн хурал ёслолд зөвхөн эндхийн бус Забайкалийн нутгийн Буриад Агинскийн орчим Могойтуйскийн хойт ,суурингийн оршин суугчид , Забайкалийн Карым, Шилкин, Чернысгевск, Нерченскийн иргэд оролцдог. Тэд жил бүрийн хурал Дасанай обоо-д хандив өргөдөг .

Угданийн дацан



1991 оноос Забайкальскийн нутгаас 19 км зайд орших Угдан тосгоны дацан Содном Даржалин хуучин уламжлалаа сэргээн баригдсанаар сүсэгтэн олныг татах болсон. Түүний цогцолборт Цогчин дуган, Сахиусан болон Маанин сүм, суваргууд, лам

нарын байшин, номын сан болон зочид буудал байдаг. Угданийн дацангийн 20 жилийн ойг тохиолдуулан 2011 онд хамгийн том сүмийг сэргээсэн. Одоо хурал номнууд шинэчлэгдсэн 2 давхар шавраар гадарлагдсан Цогчин дуганд хурдаг.

Угданын дацангийн анхны ламаар М.Жамсаранов, С.Цыренов, Б.Цыдыпов нар байсан. Одоо ширээт лам Т.Ринчинов. энд мэргэшлэн лам болон эмч лам нар ажилладаг.

Чита болон Угданын хөрш тосгоны оршин суугчид зөвхөн хурал номын зан үйлийн үеэр бус зөвлөмж тусламж хүсэхээр мөн ирдэг.


Цогчин дуганы тахилын ширээнд Ганжурын 108 боть хадгалагддаг. Хурлын хүрд нь дацан болон суваргыг тойрон байх нь тэнд онцгой орчин бүрдүүлдэг. Өнгөрсөн хавар угданы иргэд Буддагийн төрсөн өдрийг тэмдэглэн наадам зохиосон. Зуны улиралд Читийн болон ойролцоох нутгийнханы уламжлалт ёслол болсон. Түүнийг жил бүр Титовын толгодын баруун бэлд Оросын уламжлалт бурхан шашны Забайкальскийин Дид Хамба лам Ц.Дондукбаевын удирдлаган дор Чити, Агинск, Угданын лам нар хурдаг.

Баргузины дацан

Буддын шашны ойн жилд олон нийтийн хандиваар босгосон Баргузины дацангийн Цогчин дуганг равнайлсан. Энэ үйл явдал нь Ярикто отог аймгийн ойролцоох Униганы нутагт Янжима бурханы дүр төрх үүссэний 9 жилийн ойд зориулагдсан. Их бясалгач Цэдэн Соодоевын бясалгадаг байсан энэ газарт 1930-аад онд устгагдсан Баргузины дацангийн шүтээнүүдийг нуусан гэж таамагладаг.

Жил бүрийн луу сарын 24-нд энд Янжима-Сарасвати бурханы бишрэл хүндлэлийн баяр ёслол болдог.


Түүнийг үүссэний 8 дах жилд Буриадын болон Улан-Удийн олон тооны



мөргөлчид цугласан. Янжимын дүртэй ариун чулууны дэргэд хурлыг хурсан ба агуу бурханд Мандал бэлэглэх ёслолыг ширээт лам удирдсан. Дараа нь Сахиусан дуганд сэржим болон даллаг ёслол болсон.

Баргузины районы соёлын хэлтсийн бэлтгэсэн концертонд төрсөн нутгийн цэцэгс, эхийн тухай дуулдаг Лудуб Очиров оролцсон.

Курумканийн дацан



Цогчин дуганы доторх найман баганыг ороон эзэлсэн лууг суурилуулсан нь Оросын Сангхи уламжлалт бурхан шашны хойт зүгийн дацангуудаас онцгой мэдэгдэхүйц ялгаатай чимэг болсон юм. Нагарджуны хувилсан төрх, Агуу Соодой ламын 48 рашаан устай районы хувьд энэхүү луунууд дахин давтагдашгүй маш онцгой утга агуулдаг.

19-р зуунаас Баргузины хөндийд болдог жил ба сар бүрийн томоохон хурлууд одоо ч гэсэн мөн Гандан ШеДувлин Курунканы дацанд болдог. 2006 оноос XXIV Бандид хамба лам Дамба Аюшеевын удирдлаган дор Бархан Тахилган нэмж хурдаг болсон.

Усть-Ордын дацан

Усть-Ордынын дацан Тубдэн Даржалин нь 1919 онд Эрхүү мужид баригдсан 6 дацангийн нэг юм. Мужийн тойргийн ард иргэдийн дэмжлэг тусламжаар 2011 оноос түүнийг сэргээж эхэлсэн. А.А.Дмитриевийн тэргүүлсэн тэтгэмж нь хамгийн анхны том тусламж байсан.



Өнгөрсөн гурван жилд Усть-Ордынын дацан зөвхөн тойргийн оршин суугчдын дунд бус хүндлэл алдартай болсон. Энд Ангарск, Шелехов, Братск болон Эрхүүгийн сүсэгтэн олон хуралд цугладаг. Ялангуяа эртний буддын ёслол Ардын Убгэд эсвэл 13 бурханы мөргөлд олон хүнтэй байдаг. Домогт энэ 13 бурхан уг газрыг хамгаалдаг гэдэг. 100 жилийн дараа буюу 2012 онд шинэ Усть-Ордынын дацангийн тэргүүн С.Гунтупов хуучны ёслолыг сэргээсэн.

Өнгөрсөн оноос хүссэн хүн бүр Усть-Ордынын дацанг чимж буй 1000 буддагаас өөрийн буддаг олж авч болдог болсон. Бурханыг олж авснаар долоо хоногийн тодорхой нэг өдөр

тусламж хүсэх боломжтой. Ням гаригийн будда нь хувийн амжилтыг өөд гарахад харин лхагва гаригт худалдаа наймаанд тусалдаг. Буддагийн гаригийг олох бичиг нь дацанд хадгалагдаж байдаг. Одоо Усть-Ордынын дацангийн 100 гаруй итгэгчид ажил төрөл, сурлага, хүүхэд төрүүлэх, амжилтанд хүрэх болон бизнесд оюуны дэмжлэгийг авдаг.

Якутын дацан

Якутын оршин суугчдын хувьд Буддын сүм баригдсан газарт уламжлалт бурхан шашны мөргөл нь дасал болсон. Түүнийг равнайлах нь Оросын бурхан шашинтнуудын хувьд ойн жил болсон.



Якутын засаг захиргаа нь дацан барихаар газрыг сонгосон буддын шашинтнуудын эсрэг байлаа. Дацан ард иргэдийн тусламж мөн Якутад алдартай одоо Буриадын Ардын хурлын гишүүн В.П.Доржиевын санхүүгийн дэмжлэгтэйгээр баригдаж байгаа.



Хамгийн хойт зүгийн Цогчен дуган бараг бэлэн болсон. Түүний гол шүтээн нь ХХIҮ далай ламын өгсөн алтан будда юм. Якутын дацанд хурал нь сүсэгтэн олны хүсэлтээр хурдаг. Түүний нэг нь өнгөрсөн намраас хурдаг болсон ариун Ногоон дарь эх бурханы хурал юм. Буддын нийгэмлэгийн тэргүүн Еши Дандар лам ертөнцийн хамгийн хойт зүгийн дацан Шакямуни бурханы мэргээр өргөмжлөгдөнө гэж тооцдог. Багш түүний сургаал хойт зүгт тархах болно гэдгийг урьдаас мэдсэн.



Гайхамшигт Занданзуу бурхан



Эхний директор Ленинский медицинского колледжа Чимэд-доржиев Владимир Цамхатович болгож байсан.

Ленинские медицинские колледжи болж Ленинский Заочный медицинского колледж

Ангийн анд Бабу ламын байгуулсан сургууль



Итгэлт хамбын ордон

Лам Ц.Отгонбаярын Итгэл хамбын олон улсын хуралд тавьсан илтгэл:***Орчлон хорвоод, мөнхийн лагшингаараа гайхагдах, Очирваанийн хувилгаан Итгэл хамбад бие сэтгэлээрээ мөргөн тахин номинчилмүү.***

Хаа холоос биеийн алжаал умартан морилон ирсэн хүндэт зочид төлөөлөгчид болон энэхүү хуралыг зохион байгуулж байгаа Бандида хамба лам Д. Аюшеев тэргүүтэй ОХУ ын Бурхан шашинтны төв Санghi Иволгийн дацангийн лам хуваргуудад энэхүү өдрийн түмэн амгаланг айлгая .Итгэл хамбын мөнхийн лагшин энэхүү дэлхий дээр гайхагдан шагшагдаж,олны шүтээн болж олон хүмүүсийн аврал болж байгаа жишээ олон болж байгааг хэлэхэд таатай байна.Хүмүүс ертөнцийн долоон гайхамшигийн нэгэн адил сонирхохоор ирдэг бус мөргөж даатгал хийхээр ирэх хүмүүс болж хувираад байгааг бэлэнхээ төрийн тэргүүд хүртэл ирж даатгал хийж байгаагаар харж болно . Мөнхийн лагшин гүнгэрваандаа залагдсанаас хойш өнөөдөрийг хүртэл энэхэн хэдэн жилийг хугацаанд лагшин дотоод сэтгэлгээний асуудал хөндлөнгөөс харахад машид өөрчлөгдөж байгааг анзаарахаар болжээ 1-рт Залагдаж байгаа эхэн үедээ :Залсан хүмүүс нь эргэлзэж босоод хөдөлбөл яахав ,цаашдаа ингээдэл залаад байхуу гэхчилэн бодож айдас болгоомжлолтой ханддаг байсан бол,эсрэг байр сууринд байсан хүмүүс чөтгөр мэт үзэж,халдварт өвчин гарна буцааж газарт зална гэж ярьцгааж байсан нь худлаа биш байсан шүү нөхдөө эхэн үеийн байдал иймэрхүү байсныг бүгд мэднэ.

2-рт Эргэлзээтэй энэхэн үед хүмүүсийн айдас жаахан дарагдаж энд тэндээс нь эрдэмтэн гэх нөхдүүд үс арьсны дээж авч шинжлэх ухаан гэгч бурханы сургаалиас илүүд үзэх шинжэлгээгээрээ хариу нь гаралгүй хэл үг ч олдохгүй байх тэрхэн үед хүмүүс сониучхан зандаа хөтлөгдөн ирж үзмэр үзэж

буй мэт, зарим нь сүжиг орж буй нэгийгээ хориг тавих зэргээр олонхи шоохорхолын журмаар байсныг дунд үе гэмээр байна

3-р үед Залсан хүмүүсийн эргэлзээ гарч дасаж ямар нэг мэдрэхүйгээр холбогдон Мөнхийн лагшинтай өөр өөрийн мэдрэхүйгээр ихэнхи нь холбогдож харьцдаг болж итгэлийг аван, нэгд эргэлзээгүй болсон хоёрт Эргэлзээгүй болсны үндсэн дээр бусдад зоригтой тайлбар хийдэг болсон, Гуравт Зоригтой тайлбар хийж түүнд дулдуйдан ирж мөргөх сүсэгтэн хүмүүсэд Итгэл хамбын мөнхийн лагшингийн зүгээс ямар нэгэн нөлөө үзүүлж заримд жаахан биетэй болж, нүдний шилтэй болж, мэлмийгээрээ болгоож, заримд нь Бямба ламаар дамжуулан зурвас илгээж байгааг бид хараад мэдрээд байгаа мөртлөө хэвийн бус мэдрэлтэй гэж дуудуулахаасаа имээж дуугүй байсаар байгаа нь үнэн гэдгийг нотлох хүн олон . Ихэнхи хүмүүсийн хандлага ажилаа бүтээлгэхээр аврал айлтгахаар ирдэг болсныг бид бас л мэдсээр байгаа нь бодит үнэн бөгөөд нэг ажилаа авралаар бүтээлгээд дахин дахин ирж дараагийн авралаа даатгаж байгаа нь Ламаар бол сайн лам Шүтээнээр бол дээдийн дээд шүтээн гэдгийг үүнээс өөр яаж нотлох вэ . Бид нар чин харин ухаантай дүр эсгэж улаантаны шашингүй үзэлээр харанхуй хэвээрээ хандаад байна Иймээс нүдний шилтэй болгож хараад байгаа хүмүүс биднээс илүү билгийн нүдтэй харин шүүмжлээд байгаа бид нар чин харин жинхэнэ не нормалны хүмүүс байна шүү гэдгээ мэдэж үзмэр харагч биш шүтээн гэдэг утгаар нь хандах нь зүйтэй боловуу Үүгээр би Итгэл хамбын мөнхийн лагшинд сэтгэлийн тахил өргөж буй оршил хэсэг болой .Одоо илтгэлийнхээ үндсэн сэдэвийг эхлэе

Урьд эрдэм шинжилгээний хуралд Итгэл хамбад дээдийн номын увидас заан сургасан буяны садан багш нар болон нэгэн үед хамт буян номд зүтгэж байсан номын нөхдийн намтарын баялаг далайгаас оочийн төдий өгүүлснийг та бүхэн санаж байгаа байхаа .энэ удаа би тэгүүний үргэлжлэл болох монголд суралцаж эрдэм ухааны оргилд хүрсэн олон лам нарын алдарыг

зухас төдий өөрийн молхи оюунаар гаргахыг оролдлоо.
Алагшаа Дандар лхаарамба:

Насаараа ном үзээд нэгийг ч өвлүүлэж чадахгүй бол ямар
номтой хүн гэхэв

Нэгд нэггүй оношийг нь хэлж чаддаг ч өгөх эмгүй хүнийг ямар
эмч гэхэв

Гэж айлдсанчилэн агуу орос оронд бурханы шашиныг
дэлгэрүүлэгч Итгэл хамбын үйл хэргийг нэр төртэй замгамжлагч
лам нарын намтар цадигийг зухас дурьдбаас энэ буйзаа .

Буриад Жамсрангийн Цэвээн:Соён гэгээрүүлэгч,Эрдэмтэн энэ
хүн 1881онд агийн тал нутагт төрж өсөн багадаа хийдэд шавилан
сууж монгол түвд бичиг үсэг сурч боловсорчээ.1905оноос
Буриадын тухай олон өгүүллэг бичиж өвөрлөгч нутаг,монголоор
хөндлөн гулд явж зохих мэдлэгтэй болсноор Азийн газарзүйн
ном гарган хэвлүүлжээ. Олноо өргөгдсөний хоёрдугаар он буюу
1912 оны 3-рсарын 24ний өдөр монгол улсын гадаад яамны
дэргэд төрийн анхны бага сургуулийг нээв.Багш нар нь
Ж.Цэвээн,Эрдэнэ,Батхаан,Даш Абашеев, Гарма Ванфилова гэх
буряад багш нар, Уйтик хэмээх англи хэлний багш нар ажиллаж
байв .гэж Богд хааны он дараалалын бичигт бичсэнийг үзэхэд
Цэвээн гэх хувраг байсан тэр буряад хөвүүн монголд хамгийн
анхны гадаад хэлийн сургуулийг нээж ,1913оны 3-рсарын бнд
“шинэ толь “хэмээх анхны сэтгүүлийг нээж,Ерөнхий сайд
Намнансүрэн,Өндөр Гонгор нарын төлөөлөгчидтэй оросод очиж
Николай 2-р хаантай Петербурга хотын Царской селоод
уулзахад орчуулагч түшмэлээр оролцож хэлэлцээрийг
амжилттай болгож Богдын засагийн газарт олон тооны зэвсэг авч
ирсэн зэрэг гавъяаг үнэлж Богд хаан гадаад болон орос багш
нартай хамт 1915оны намар Эрдэнийн очир одонгоор шагнажээ.
Түүний дараа монолын судар бичгийн хүрээлэнд эрдэмтэн
нарийн бичгийн даргаар олон жил ажилж байгаад 1937 оны 8-
рсард баримчлагдан 1940 оны 11-рсарын 10 нд оросын шоронд

нас барсныг 1962- 11-бнд цагаатгасан байна . 1915 оны намар оросуудыг эсэргүүцэн дийлдсэн Ач минж, Чикой,Туглуп, Хялга,тосгоны олон мянган хорь болон агийн буряадууд монголд нэгдэж нүүн суурьшнаас халх нөмрөг уулын буриад хошуу,Улз голын буриад хошуу,Онон голын буриад хошуу,Хэрлэн голын буриад хошуу,Ерөө голын Буриад хошуу,ЭГ-үр голын сэлэнгийн буриад хошуу хэмээн хошууны зохион байгуулалтан орж олон буряад лам нар их хүрээнд ирж ном үзэж сайжирсан байдаг.Хүрээний гурван их сургууль болох сира игжатай едгачойлин,ванчин игжатай гунгаачойлин,гүнчин игжатай дашичоймпэл хэмээх дацангуудаас Гүнчин игжааны Дашичоймпэл дацанд ихэнхи нь суралцдаг тэнд гэвш, гавж болдог ба цааш түвдийн брайвүн гоманд очиж суралцаж Буриад эрдэмтэн лам нар Далай ламын номын багш,Гоман дацангийн хамба хүртэл болж номын оргилд хүрч байсаныг би хоёр жилийн өмнөх хуралд жишээгээр дурдсан тул энд ахин хэлэх нь илүүц гэж бодоод орхилоо .

Зая хамба лам Дамбадаржаа: 1726онд 15насандaa ДА хүрээнд ирж Чойрын ном хаялцаж буй монгол гэвш нарыг харж бишрэн шүтэж авъяас багчаг нь сэргэж, агуу үйлсийнхээ гарааг Монголын дашичоймпэл дацангаас гараагаа эхэлсэн байдаг

Цаншив Агваан Доржиев:1913оны2-р сарын 4 нд Түвдийн засгийн газрын төлөөлөгчид монголд ирж Түвдийн засгийн газрын эрх олгосноор төлөөлөгчидийн тэргүүн гүжир цаншив Агваанлуvsан,Богдын засгийн газрын эрх олгосноор гадаад яамыг хамаарсан даа лам нягт билигт Равдан,Дэд сайд бээл манлай баатар Дамдинсүрэн нар Монгол-Түвдийн 9 зүйлт гэрээнд гарын үсэг зурж харилцан биенээ хүлээн зөвшөөрөв,энэхүү гэрээг амжилттай болгоход Буряадын эрдэмт хуврага Агваан Доржеев оролцож гавъяа байгуулсан гэж богдын засгийн газар үнэлэж байв.

Буриад С.Шадүв:Богд хаан ертөнцийн мөнх бусыг үзүүлсний дараа 1925онд шашины хэргийн яам байгуулагдсан ба хоёр ёсыг мэдэх боловсролтой лам нараар бүрдүүлсний нэг нь С.Шадүв лам байлаа.Тэрээр Хамба лам С.Гомбожавтай хамт хүрээнд сууж гэвш болсон номтой гэвш нарын нэг байжээ.1944 онд Гандангийн хурал зуны эхэн сарын шинийн найманд эхлэн бүрээ үлээж цогчин сэргэгдэх үед сайн дураараа буриадууд дагуулан ирж хог цэвэрлэж өгч няравын ажил хийж байгаад аж ахуй эрхэлсэн даамал болжээ.Тэр үед хойноос ирж суурьшсан дээр дурьдсан зургаан буриад хошууны сүсэгтэнгүүд Шадүв ламаар дамжин гандан ирж номоо уншуулдаг байжээ. Энэхүү сүсэгтэй гартаа уртай буряядуудыг цуглуулан гандангийн хашаан дотор хоёр давхар дүнзэн зочид буудал барьж хүлээлгэн өгөв .Гэвч тэр үед тийм гоё дотороо бүрэн зүмбэрэн сийлбэртэй буудал хотод байгаагүй тул улс булаан авч Цаг-уурын газар дараа нь замын цагдаагийн газар оруулж байгаад бүүр хуйчирсан хойно 1970 онд Шашины сургууль нээгдэн орж байжээ.Ламтан хойноос орж ирсэн элгэн садан буриадуудаа эхийн ёсоор хардаг удирдагч хүн байжээ.Тэрбээр гандангийн ёслолын ажилгааг зохион байгуулдаг байв. Улс хувьсгалын 25 жилийн ойгоор маршал Х.Чойбалсанд алтан аягатай сүү их баранзад хадаг,улсын бага хуралын дарга Г.Бумцэндэд мөнгөн аягатай сүү аюуш хадагтай,бусад дагалдан ирсэн 30 гаруй хүнд бага гарын мөнгөн мөнгөн аяга сүү барьж өргөн ёслолыг зохион байгуулдаг байв.Мөн хөдөөгийн хийдүүдэд томиллолтоор очиж аж ахуй эрхлэхийг зааж өгдөг санхүүгийн тайлан хөтлүүлэхэд сургажээ.

Дарсун хэмээх Жинба хамба: Буриадын аг нутагт мэндэлж улмаар лам болон Да хүрээнд ирж Дашичойнпэл дацанд хадагийн зиндаанаас дом тавьталаа арваад жил сурч гэвшийн дамжаа барьсан номтой хуварга билээ. Тэрбээр 1924оны Дархан эмчийн аймагийн Балдан жорвонтой жиндааны 8дугаарт бүртгэгджээ. “Дашичоймпэл дацангийн цантай буюу дом тавьсан лам нарын нэрийн жагсаалтаас” Орос улсад бурханы шашин

дэлгэрүүлэхэд оруулсан гавъяаг та бүхэн мэдэж буй учраас энд дурьдах шаардлаггүй гэж үзэв.

Буриад Бямбын Ренчин: Оросын холбооны улсын хорь буриадаас гарвалтай Эгүр голын сэлэнгийн буриад хошуунд 1905онд төрсөн Их эрдэмтэн,соён гийгүүрүүлэгч,Зохиолч,гүн ухаантан,хэл судлаач,энэ хүний намтарыг мэдэхгүй хүн үгүй учир олныг нуршилгүй Итгэл хамбад инээд өргөх зорилгоор гэрийн жавар үргээж үлгэрийн далай хэмээх сударыг уншуулдаг уламжлалаа бодон эрдэмтний инээдийн далайгаас зах төдий дэлгэвээсүү,

Ренчин гуай Бал даргатай төрийн дуулал сонсоод би явлаа гээд гарах гэтэл дарга яаасныг асуухад чи бид хоёр энэ дуунд алга гэсэн гэнэ яаж байна гэсэн чинь халх монгол гэж дуулаад байна гэж хариулсан гэдэг дараа нь үгийг бүхий монгол гэж зассан гэдэг .

Төрийн сүлдэнд соёмбыг үлдээх анхны тайлбар хийж хоёр талын хаалт хятад оросоос хамгаалж байгаа багана гэж тайлбар өгсөн гэдэг.

Том охин нь эмч болоод дипломоо үзүүлэхээр ирэхэд хүн алах эрхтэй болоо шив дээ гээд орос хэл хир сурсныг асуухад онцсайнаар дүүргэсэн гэхэд атга гурил чимх будаа гээд оросоор хэл гээд чадахгүй болохоор нь болоогүй л байна даа гэсэн гэдэг,

Нэгэн удаа 1000 –н дугуйгаа алдаад хүүхдүүд аваад явсныг нь өөхнөөс айдаг нөхдүүдэд мэдсэн бол сүүл уяаад орхидог байж гээд амаа барьсан гэдэг

Гудамжаар явахдаа хятад шаахай монгол өмд орос цамц өмсөөд явдаг байж таарсан хүн асуухаар найрамдал гэж хариулсан гэдэг

Чеход очоод дайлаганд орж суутал өөрийг нь чадахаар нэгэн чех Та манай сэрээгээрүү,оросын халбагааруу,хятадын савхаар

идэхүү гэхэд хонины хавиргаар иднэ гэж гэнэ,Өнөөх эр давах гэсэн биш хонь муулж хавирга чанах их ажилтай болсон гэдэг.

Эхнэрээ дандаа ёжлож байдаг байжээ тэгээд За хө хөгшөөн чи нэг ганц сайн үстэй дээл хийгээдэх гэж гэнэ . эхнэр нь давахаар шийдэж хөвөнтэй дээл хийгээд өгтөл Ренчин гуай үс нь хаачаав гэтэл энгэрт нь нэг ширхэг үс байгаа нүднийхээ шилээр хараарай гэж нэг удаа Ренчин гуайг давсан гэдэг ,

Цагаан сараар хоёр өрөө засаад сайн байнуу орос хувцастай мэндэлвэл европ засалтай өрөөнд монгол дээлтэй амар асууж золговол ууц шүүстэй өрөөндөө оруулдаг байжээ, за ингээд Буриад их эрдэмтэнийхээ намтарыг өндөрлөө

Буриад Чойнзэн лам: Цорж Диваасамбуу гуайн хэлснээр Аг гарвалтай байж магадгүй 1949 онд намайг ганданд ороход хуралд хурдаг байсан,гэр нь одоогоор Туулын 7-р гудамжинд Цэрмаа ламын зүүнтэйхэн байдаг,том улаан хамартай хурц хараатай шавьнар олонтой лам байдагсан Түвд үсгээр шууд ном бичдэг мундаг номтой С.Гомбожав гуай уул усны савдагын солчид олныг бичүүлдэг нян агтай хүн байсан гэж хуучилдаг юм. Дашичойнпэл дацангийн домын нэрийн жагсаалтаас харахад 97-р зиндаа,Жорвон нь сэцэн тойны Саяннянбуу гээд 5-р ангилагдан Чойнзэн гэж бичэгджээ.Ганданд Шүнлайв Давгажамц багшийг даган орсон гэдэг

Буриад Шийрав ламтан:Цорж Диваасамбуу гуайн хэлснээр Чойнзэн ламын найз ганданд хуралд хурдаг Заримдаа бүсэндээ тонгорог хутаг хавчуулаад явж байдаг хүн сүрдмээр хэрвээ хар сахалтай буриад хүн ийм байдаг боловуу гэхээр лам байдагсан .Сүүлд соносохноо Эрдэнэ зуугийнЛувсаншарав ламтаны зиндаа Дашичоймпэлийн их гэвш гэнэлээ Дашчоймпэлийн домийн жагсаалтаас харахад 92-р домын зиндаа анги Долгороос эхлээд хоёрт Шийрав 5-рт Лувсанширав гэж бичигдсэн байна

Буриад Дондог,Самдан ламтан нар: 1945онд ганданд Дашичойнпэлийн Шүнлайв Дагважамц багшийн зиндаанд дом тавьж багшийн айлдсаны дагуу ганданд орсон номтой гэвш нар бөгөөд гавжийн дамжаанд нийлэхийнхээ өмнөхөн хурал хаагдсан гэдэг юм.

Буриад Галсанжамц,Чойдогжац дооромбо нар: 1950 онд лавранд хамгийн сүүлийн дөрвөн буриад лам номоо үзэж дооромбын дамжаа бариад нутагтаа харихаар бээжинд ирсэн боловч виз нь бүтэлгүй тэндээ жил шахуу болоод манай эндээс Хэнтийн дадал суманд Чойдог дооромбын хамаатангууд ганданд батлан даалт бичэг хийж,шашины зөвлөлөөр дамжуулан хөөцөлдөж байж,Чойдогжамц,Галсанжамц хоёр дооромбо нарыг ганданд хуруулахаар авч ирсэн гэдэг Сонинбаяр багшийн хэлснээр голын арын гавж нарын эгнээг тэргүүлэн суудаг номтой гэвш нар байсан гэдэг Чойдагжамц дооромбо 70-аад оны эхээр төрсөн нутаг агдаа хариад буцаж ирж Хэнтийн дадалд байж байгаад таалал барьсан бол Галсанжамц дооромбо 80-аад оны сүүлээр нутаг явах зөвшөөрөл нь бүтэж аг нутагтаа очиж тэндээ шашин амьтаны тус хийж байгаад ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ.

1970 оноос өнөөг хүртэл Шашины дээд сургуулиар буриад лам нар сургагдан бэлтгэгдэж хуучин өв уламжлал болсон бурханыхаа шашиныг бүрэн залгамжлан авсан хойд үеийн боловсон хүчнийг жагсаавал:

Анхны зиндаа:

1. Бадамгарав-Жамъяаннагнай
2. Б.Алдар –Жамъяандүйдэн
3. Ц.Цэрэн-Жамъяаннямбуу
4. Г.Дашням-Жамъяанталанба
5. Д.Чимэддорж –Жамъяантуваан
6. Ц.Дорж –Жамъяанянлаг
7. М.Доржжав-Жамъяандаажан

8. Ж.Данпэл-Жамъянсэрэв

Хоёрдугаар зиндаа: Д.Гэнэндармаа, Л.Базарсад,
Р.Ганжуурцэрэн, П.Дашцэрэн, Ц.Очир, Т.Пүрэв

Гуравдугаар зиндаа: Ц.Туваандорж, Г.Дашдорж, Ч.Мөнхжаргал,
З.Содов, Г.Санжайжав, Ц.Эрдэм, Ц.Баяр

Дөрөвдүгээр зиндаа: Н.Дорж, Д.Золт, Д.Пүрэвцэрэн, В.Цэвээн,
Л.Цэрэн Р.Чимэддорж, Ц.Шаравжамц,

Тавдугаар зиндаа: И.Нямжав

Зургаадугаар зиндаа: Дамба Аюшеев, Цэрэнпилов
Булат,Базаров Балдан, Баву лам тэргүүтэй олон хуваргууд
монгол нутгаас бэлтгэгдэн боловсорч орос холбооны улсын
бурханы шашиныг өнгөлөн хөгжүүлэж Итгэл хамбынхаа үйл
ажлыг итгэлтэйгээр залгамжилж байна

Иволгийн дацан төвлөн удирдах

Их Оросод олон дацантай

Итгэл хамбын мөнхийн лагшингаар

Ирээдүй цагтаа мөнхрөх нутаг

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа

Ц.Отгонбаярын Итгэл хамбын хуралд тавьсан илтгэл - III

Энэ танхимд бид 3 дах удаагаа хуран чуулж, гадаад дотоодод таныг шинжлэн сорьж эгэп бус гэдгийг нь мэдсээр байж итгэж ядан буй энгийн ард зонхоо өмнөөс Итгэл хамба танаас уучлал хүсэн бие хэл сэтгэлээрээ мөргөн тахин номончилон запбарнам хүлээн авч соёрхнуу.

Эрхэм хүндэт номын нөхөд, энд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид та бүгдийн энэ өдрийн түмэн амгаланг айлтгая.

Монгол ардийн цэцэн үгэнд: нутагийн сайханыг усыг нь амталж мэд,хүний сайныг нехрөөснь асууж мэд гэдэгчилэн өнөөдөр би Итгэл хамбын эргэн тойронд,урьд хойно нь амьдарч, цаст төвдийн оронд тэр тусмаа алдарт брайван гомон дацанд суралцаж эрдэмийн оргилд хүрсэн эрдэмтэд олон бий. Тэд бүгдээрээ п энэ их гомломба бясалгаач Итгэлт хамба хэмээх ёгүзорыг төрүүлэх уг сурвалж болох тул, Буряад нутаг дээр бурханы шашин залж ирсэн, номч мэргэн эрдэмт хуврага лам нар дээдэсийг төвд эх сурвалжаас зухас дурдваас:

Заяа хамба Дамбадаржаагийн намтарын далайгаас өчүүхэн төдий өгүүлэхүй дор анхлан лагшин мэндэлсэн, бага насны амьдрал, Үзэж соносон суралцахын үеэс.Шашин амьтаны тусыг ямар мэт зохиосон ёс,Итгэлт шавь нараа номонд дагуулсан хэмээн дөрөв хуваажээ.

Их монгол орны хоймор талд орших буряад орны цаху хэмээх гол, мөрний зүүнээс баруун тийш урсах их боргионы захад Оцонхан гэх өндөр сүртэй злдэв ургамал модтой хөвд ногоон ойтой уулын ойролцоо цонгоол язгуурын асгат овгийн аав Заяа нь, чухаг дээдийг шүтэгч,сүжиг төгөлдөр, нүгэлийг тэвчигч, буянд шамдагч, Ээжий Дэжид хоёрт эртний ерөөлийн хувиар хөвүүн хэвлийд оршиж, арван сараа гүйцээн 1711 он буюу 12-р жарны.

төмөр эм туулай жил лагшин мэндэлжээ. Нялх балчиртаа ид шидийг үзүүлэн гайхагдаж, Бурханы оронд очиж ном суръя хэмээн эцэг эхээсээ гуйжээ гэвч эцэг эх нь нүдэндээ үзэж чихэндээ сонсоогүй газар явуулахаас татгалцахад гэртээ ч оролгүй идэж уухгүй болсонд арга барагдсан эцэг эх зөвшөөрсөнд Үүл ярагдан тэнгэр цэлмэх шиг, Өчүүхэн хөвүүн ихээр баярлав. Үнзхээр 15 насандаа Үзүүр тегсгөлгүй номын далайд эргэлт буцалтгүй чин зориг гарган сэлж алс замд таарах аюул хулгайнаас хулчийлгүй, ариун номыг үзэхээр алс замд гарчээ.

Ийнхүү төрсөн нутгаас гарч Да хүрээнд очиж, тэндээ хэд хонож, төвд явах мөргөлчидийг даган бээжин хүрчээ. Түүтээр үл барам Зандан зуу тэргүүтэй хосгүй шүтээнд мөргөн си ан дамжин гурван сар явж Богд ламын мэндэлсэн гүмбүм жанбаалин хийдэд очиж шарын шашины 2-р бурхан цолыг олсон Богдламын үлдээсэн хосгүй адистэдтэй золгон мөргөв. Тэгээд хөх нуураар дамжин 3н сар явж, нагчү хэмээх газар хүрэв. Нагчүгээс 10 хоногийн газар лхаданд очлоо. Мөн л тэндэхийн шүтээн зошага тэргүүтэй шүтээнд мөргөв.Тэндээсээ алдарт их номын газар болох брайбүнд ирлээ. Тэндэхийн 3н игчаатай долоон дацангийн Өлзий хутаг төгөлдөр даши гомон дацанд номын хурыг ундаалахаар суурьшив. Мэргэн багш нар олныг шүтэн номын их далайгаас суваг татан өөрийн оюун ухаандаа цутган Санпү, ярчой, жангүн чойд очиж ном хаялцаж алдар нэрээ дурсгаж дээдэсийн таалалд нийцэн ойрын шавь болж чадав. Дээдийн номын увидасыг ихэд сонсож, ялангуяа Ташилхүнбэд очиж, Наваан таяа бурханы хувилгаан Ванчин лувсан иш богдоос Гэцүлийн санваар залж, 20 насандаа Жанрайсиг бурханы хувилгаан 7-р Далай лам Галсанжамцаас гэлэнгийн сахил хайрлаж, түүнийгээ нүдний цөцгий мэт хайрлав. 25 насандаа Винайн ёсыг баригч оройн дээд Ёнзон агваан чойдонгоос Дүлба хамбын зөвшөөрөл олгов. Таван ботийг үндэс гол номлолтой нь эцэст хүргэсэн учир 10н бэрхийн орны тайлахуй ам авах дамжаанд сууж арван бэрхийг тайлахуй гавж хэмээх цолыг авлаа. Нутагтаа буцаж шашин амьтаны тусыг

бүтээхийг сонссон дээрхийн гэгээнтэн Галсанжамц тэргүүнээс Номуун хаан хэмээх алдар цолоор шагнуулав. Чингэж эрдэм номыг үзэж ундаалаад харанхуй, хязгаар нутагтаа очиж ховор нандин Богд ламын шашиныг гэрлийг түгээхээр алс газраас арлын толгой эргүүлэв. /Энэ тухай дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл 7-р далай лам Галсанжамцын намтарт бий\ Тэр ч бүү хэл буряад зон Номын хаан цолтонтойгоороо бусадаас онцлогтой. Сүүлд брайван хийдээ бариад равнай хийж байхдаа баярлан дээрх зүйлийг дурдсан төдий билээ, Тэрнээс биш өөрийгөө мамсаа сүгнэн /даруу зангаар доорд барин/ эрдэмгүй нэгэн гэх мэт хэлдэг байлаа.

Төвдөд очсоны сүүлээр 1728 оны шороон мич жил орос хятадын хоорондын үймээнээс болж нааш цааш явах хүмүүсэд хил нэвтрэх маш хэцүү үе байлаа Тэр цагт хил нэвтрэх хүмүүс төвдийн засгийн газрын Гаршагийн зөвшөөрөлөөр нэвтрүүлдэг байжээ. 1731 оны усан хулгана жил өөрийн тоонот нутагтаа ирж, Элгэн садантайгаа уулзан .нутгийн зондоо хэрэгтэй тустай гэж бурханы шашины дэлгэрүүлэж, тэр жилдээ хамт ирсэн төвд монгол лам хуварга шавь нартайгаа хамтран эсгий гэр дуган барьж эхэлжээ. Энэхүү гэр дугана нь эхлээд оцон ханы ойролцоо байсан ба мохороос цухи годаль хүртэлх зонд хамрагдах дугана гэж айлджээ. Зүг зүгээс лам болох хүмүүс ирж нийт лам нарын тоо 150 аас хол илүү давжээ. 1742 оны их хэнгэрэг хэмээх усан эр нохой жил дээдсийн зөвшөөрөлөөр хомпэлэйд хэмээх газар урд өмнө бурханы шашины улбаагүй нутагт хурал хурах зөвшөөрөлийн дагуу хурал хурав. Тэндэхийн ноёд түшмэл сүсэглэх аргаа олохгүй байгаач тус ихээр хүргэж байв. 1746 оны гал эр бар жил цуухийн захад модон дугана барив. Тэгээд өөрийг нь тива болгох гэсэн боловч Төвд Зонива агваан пунцагийг тива болгов. 1753 он 13-р жарны усан тахиа жил буряад зоноос дээрхийн гэгээнтэнд Заяа хамбийг ширээт болгох хүсэлт уламжилсанд зөвшөөрөл олгосоны дагуу ард зоны итгэлийг бодон сэлэнгийн бойбойд /баабайд/ анхлан тива хэмээх үгийг ширээт

хэмээн ширээтийн алба хүлээн авсан ба хоорондоо адилгүй урсгалуудыг нэгтгэж нэгдсэн удирдлагатай болгосонд нутгийн зон дээрхийн соёрхлоор 1755 оны модон гахай жил орон хийдийн эзэн\зову тива\ тэргүүн ширээт хэмээн зарлигаар алба томилов. Энэ нь бас анхных байлаа. 1759 оны шороон эм туулай жил хэнтийн их ноён тайш Баатар, түшмэл Лувсан жанцан тэргүүтэй сүсэгтэн олноос Сугандуй буюу төвдөөр цогандуй /пам нар ард зоны нэгдсэн хурал/ хуралдаан дээр төвд монгол орны лам хуврага нарын эв нэгдэлийн тулд хуврагийн цэцэрлэгт хүрээлэн лхан барья хэмээн санал оруулж их бага бүгдээр сүсэгийн хүчин дор нэгэн дуу хоолойгоор ам авч, ялангуяа түшмэл Лувсанжанцан өөрийн хөрөнгөөр бариулана хэрвээ чадахгүй бол олон түмэн минь туслаарай хэмээсэнд бүгд баярлав. Ажил зхлэх болсонч том цогцолборыг орос оронд барьж байсан туршлага байхгүй тул Дээдэсээс тусламж хүсэхээр болж айлтгал илгээж бн сарын дараа хариу зөвшөөрсөн бичиг холбогдох журам зургийн хамт илгээсэнийг хүлээн авлаа. Ингээд одоогийн нэр хялгант тосгоны ойролцоо 1760 оны тийн дарагч хэмээх эр төмөр луу жил шав тавьж эхлэв. Үүнтэй зэрэгцэн ванчин эрдэнээс цол шагнал ирүүлж байв. Тавин зургаан сүүдэр тохиосон гал нохой жил дуган баригдаж гүйцэн Балдан брэйван хэмээх нэрийг хайрлав. Эндэхийн зон идэвхитэй оролцов. Равнай уншлагийг төвд монголоор хавсарган айлдсанд олонд таалалтай байв. Энэ үед буряад лам хуварга ширээтүүд сэлэнгийн ямаар дамжуулан буряадын шашины эзэн бандида хаадба цолыг өргөмжилж Дээрхийн гэгээнээр батлуулав. Байгаль нуурыг тойрон их бага 13 хийдийг байгуулан босгов. Яг энэ үед оросын хатан хаан Екатерина 2 олон ястан гууд шашин өөр өөр байгааг харгалзан үзэж олон ястануудын төлөөлийг сэлэнгийн яаманд цуглуулаж. сугандуй хуралдуулаж тогтсон зарчимд хүрэв. 1767 оны номхон хэмээх эм гал гахай жилийн намрын адаг сард орчуулагч намжилдоржийн хамт эрхүү хотыг зорж, тэр сарынхаа 18нд тэндхийн ноёд сайнаар хүлээн авлаа. Тэндээс цаашлан 1768 оны 1-р сарын 11нд оросын нийслэл Петербургад очиж, эх хатантай

элэн далангүй уулзалт бараалхал хийж .Буряадын шашин төрийг амар байлгах 22 зүйлтэй айлтгал өргөж, зөвшөөрсөн хариуг баяртайгаар гардуулахын ялдамд газар газраас ирсэн 60 гаруй хүмүүсийг цуглуулан хүлээн авалт хийж түүн дээр Заяа хамбыг Буряадын шашин төрийн эзэн хэмээн зарлаж эрдэнийн 1-р зэргийн одонгоор шагнав. Тэндээ 10 сар байгаад, 1769 оны шороон үхэр жилийн хаврын дунд сарын 20 ны нар хур тэгширсэн сайхан өдөр Балдан брайбан хийд төрсөн нутагтаа санасан хэргээ бүтээгээд ирэв. Түүний дараа шавь нартаа Ван лүн авшигийг хайрлалгүй өгч номын увидасыг дамжуулах, сахил санваарыг сахиулах талаар чухалчилж иржээ. Ялангуяа 1775 оны модон хонь жил намрын адаг сарын шинийн 18 нд сугандуй хуралдуулаж лам нарын дэглэм жаягийг батлан танилцуулсан байдаг. 1776 оны гал мичин жил 66 сүүдэртэйдээ ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн байдаг. Түүний байгуулсан гавъяа зүтгэл оросын хатан хаан төдийгүй монгол туургатан бурханы шашинд хүндтэй байр суурийг эзэлдэг.

Цаншив /Дээрхийн гэгээн Далай ламын багш/ Лувсан агваан доржиев балсанбуу тэргүүн ануу

Буряад нутгийн хар шивэр хэмээх газар эцэг Дорж, эх Долгор нарын хөвүүн болон 14-р жарны модон бар жил 1854 онд мэндэлжээ. Бага насандаа эцэг эхийн халамжинд өсөж торнисон сэргэлэн цовоо хөвүүн байжээ. 19 насандаа аянчин дагаж төвдөд ном үзэхээр гарсан боловч тэндээ очоод удалгүй /суух зөвшөөрөл авч чадаагүй улмаас/ буцан ирж, Доржчан балдан чойнпэлийг багшаар шүтэн гэцүл гэлэнгийн санваарыг залж ном үзэнгээ засаг ламын туслах хийж байгаад, 26 насандаа хоёр дах удаагаа төвд очиж тэнд брайбун гомон дацанд орж ном үзээд лхаарамба цол хүртжээ. Улмаар нэр алдар нь цуурайтаж 13-р Далай лам түвдэнжамцын цанид багшаар 10 жил байв. 45 насандаа энэтхэг бээжин, лхадан зэрэг газар орноор Дээрхийн гэгээнтний шашин төрийн зөвлөх болж явж байлаа. Төрсөн нутагтаа ирж шашин амьтаны тус хийж хуучин оросын нийслэлд сүм дуган барьж яруу

алдар нь түгжээ. Европоос заллага олон удаа ирсэн боловч очоогүй. Гэвч удалгүй улаан хувьсгал болж шоронд хорин бие нь муудсаар 1938 онд жанч халжээ

69-р гомон хамба Галсан лигдэн балсанбуу ануу

Буряад нутгийн баруун хойд тал орших их Саяаны нурууны өвөр бэл тунка хэмээх аглаг газар лагшин мэндэлж, бага насандаа Цаншив Агваан доржийн дэмжлэгээр төвд газар очиж даши гомон дацанд шавилан сууж таван ботийг тарчигнан лхарамбийн дамжаа барьж мэргэдийн эгнээнд жагсаж олны хүндлэл хүлээн хамбын сэнтийд заларсан нэгэн билээ..

72-р гомон хамба Агваан нямаа балсанбуу тэргүүн ануу

Буряад улан -үдэ хотын баруун хойно байх асгатын хийдийн ойролцоо лагшин мэндэлж, Цаншив агваан доржиевийн дэмжлэгтэйгээр 1922 онд 9 хөвүүн ном үзэхээр төвд одогсодын нэг нь байлаа. Улмаар ном үзэн сайжирч анги дамбийн лхарамба болон мэргэдийн эгнээнд орж. Дээрхийн гэгээнтэн Далай ламаас дүлба хамба хэмээх алдар хүртжээ. Далай багшийг Энэтхэгт дүрвэхэд хамт гарч варнасийн их сургуульд цанид багшаар хичээл зааж байгаад 1960 онд гомон хамбаар томилогдож байжээ. Тэрбээр төрөлх нутгаа санагалзан монголын түүх хорчой нжин бичиж, монгол буряад лам нарыг гомон дацангийн түүхэнд оруулах их ажлыг хийж гүйцээсэн гавъяатай хамба билээ.

Ганжуурваа гэгээн дэнзэн норбуев ренбучи ануу

Буряадын Дашичойнпэл хийдийн ойролцоо 1888 онд лагшин мэндэлжээ. 1895 онд төвдөд очиж гомон дацанд ном үзэн алдарыг олоод, 1910 онд нутагтаа ирж шашин амьтаны тусыг хийж хижинга нутагт жаран хаширын суварга гүйцээн бүтээж равнай өргөжээ. 1935 онд баригдан хоригдож цаазлуулж жанч халжээ.

Эрдэнэ хайзүн галашаев агваан лэгшид ануу

Буряад хижингагийн даши лүнбэ хийдийн харъяа доод тохой хэмээх газар 1856 оны гал могой жил лагшин мэндэлжээ. Улмаар гомон дацанд таван ботийн шүн гол номлолыг онцгой эзэмшиж дооромбо хэмээх алдарыг хүртжээ. 1897 онд нутагтаа буцаж хижингийн хийдийн цанид ламын алба хашжээ. Хоёр ёсыг авч орхихыг өгүүлэхүй бэлгийн толь хэмээх сайтар номлолоороо олонд алдаршжээ.

Халх мэцангийн гэвш данба пэлжээ буюу ёндог гэвш дамба

Буряад нутагг лагшин мэндэлж, гомон дацангийн халх хамцанд орж ном үзэж, анги дамбийн лхараамба хэмээн чойнпэрэл ерөөлийн үеэр цоглом босгон нийтэд зарлаж байжээ. Ном үзэж буй шавь нарт үлгэр үзүүлэж тэр нь шиг ном үзэх хэрэгтэй хэмээн багш нар дээдэс хэлдэг байжээ. Гэвхийг дамжаа барих, цоглом босох үед лам нар чимээгүй болж анхааран авдаг байжээ. 1924 оны модон хулгана жил оросын засгийн газраас томилогдон очсон төлөөлөгчидийг Далай ламтай уулзах үед орчуулагч гэвш Жигмэддоржтой хамтран оросын байр суурь хамтын ажилгааг өргөжүүлэхэд хувь нэмэр ихтэй байсаныг төвдүүд зохон тэмдэглэсэн байдаг.

Гэвш Түвдэн нянбуу

Буряад нутагт лагшин мэндэлж, гомон дацанд төвдийн алдарт жавжий тэчин, гандан тива, ренбуучи нартай хамт ном үзэн сайжирч 1919 онд анги дамбийн гэвш болж байжээ.

Гэвши даши ануу

Буряад нутагт лагшин мэндэлж. Брайбун даши гомон дацанд суралцаж мэргэшин лхарамба болжээ. Нутагтаа буцаж ирэлгүй тэндээ жанч халжээ.

Гэвши шиваан лха ануу

Буряад нутгийн сүүгүүл Дашичойнпэл хийдийн харъяа хүйтэн хэмээх газар мэндэлжээ. Долоон насандаа сүүгүүл дацандаа

шавилан сууж, улмаар Даши гомон дацанд ловнэр хийж анги дамбийн лхарамба алдарыг хүртжээ. Жадамбийн дэлбэ тайлбар сэлтийг цээжээр уншдаг байв. Отог түшмэл хэмээх өглөгийн эзний дэмжлэгтэйгээр тэндээ байж байгаад жанч халжээ.

Мөн намтар бичэгдээгүйч номт мэргэн буряад гэвш нар олон төржээ. Тэдгээрийн заримаас дурдвал

Гэвш Түвдэн дондүв

Цаншив ренбүүчийн намтарыг бичсэн асгатын лхарамба

Намнан багш буюу жанчив лам /буряадын мялараба/

Гэвш Жигмэддорж

Гэвш Жамцо

Ханба Ширавжамц

Дүйнхорва Чойжи нянбу

Дүйнхорва Даши дондүв

Гэх мэт цаст тевдийн оройн чимэг болсон лам нар олон байжээ.

Эдгээр лам нар маань Итгэлт хамбыг мөнхийн лагшинг олох иш онолыг заан сургасан, увидасыг дамжуулсан багш нар номын нөхөд билээ.

ЭЗЭН ЧИНГИС БОГДЫН ТАХИЛГА

ИТГЭЛ- Бурхан ном хийгээд чугуулганы дэгээд дор бодийн хутагийг олохуй хүртэл би бээр итгэмой.

Миний өглөг тэргүүтэн эдгээр еээр хамаг амьтаны тусын тулд бурхан бүтэх болтугай..

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай.Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаан лугаа хагацах болтугай.Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай.Хамаг амьтан ойр хол уурлах дурлахаас хагацаж тэгш дор орших болтугай.

ГАНДАНЛХАВЖАА - Буюу төгсбаясгалант зуун тэнгэр

Намо Гүрү Манзугохаяа

Төгсбаясгалантын зуун тэнгэрийн итгэлийн зүрхнээс

Маш цагаан шинэ тараг овоолсон мэт үүлийн үзүүрт

Номын хаан Бүхнийг айлдагч Сумадигирди

Хөвгүүд лугаа сэлт энэ орноо залран соёрхоо

Өмнийн огторгуйд арслант ширээ,лянхуа,сарны дээр

Гэтэлгэгч лам баясгалангуй цагаан мишээлтэй

Миний оюун сүсгийн буяны дээд орноо

Шашныг дэлгэрүүлэхийн тулд зуун галавт оршин соёрх

Мэдэгдэхүүний эн бүхнийг мэдэгч оюун таалалтай

Сайн хувьтын чихний чимэг болсон сайн номлол зарлигтай

Алдаршлын цогоор үлэмж үзэсгэлэнт лагшинтай

Үзэн,сонсох,дурдахуйн хэргийг төгсгөсөнд мөргөмүй

Сэтгэлд зохистой элдэв тахилын усан, цэцэг хийгээд

Анхилуун үнэрт хүж, зул, үнэрт усан тэргүүтэн

Бодитой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан тахилын үүлэн далай үүнийг

Буяны орны дээд тан дор тахил болгон өргөө.

Алин бээр тэргүүлэш үгүй цагаас хураасан
Бие,хэл,сэтгэл нүгэл юун үйлдсэн хийгээд
Ялангуяа гурван санваарын үл зохилдохуйн зүгүүдийг
Зүрхнээс хатуу гэмшлээр тус тус наманчилъя
Цөвүүн цаг үүнээ олонтаа сонсоод бүтээл дор хичээн
Найман номыг тэвчихээр чөлөө учралын хэргийг хийсэн
Итгэл таны ахуй их зохионгуй дор
Ба бүрэн саналын угаас даган баясмуй.
Гэтэлгэгч лам дээдэс та нугуудын
Номын биеийн огторгуйд айлдал энэрлийн үүлний үзүүрт
Ямар мэт зохистой номхотгогдохууны газар дэлхийд
Аяндаа бүтсэн номын хурыг буулган соёрх.
Би бээр хэдий чинээ хураасан буян үүгээр
Шашин амьтан бүхнээ алин туслах хийгээд
Ялангуяа Гэтэлгэгч Сумади гирдийн
Шашны зүрхэн өнөд гийгүүлэх болтугай

МАНДАЛ ӨРГӨХҮЙ

*Орон дэлхийг өргөн айлтгомой. Ум базар бүмэ-а-хум
Их эрхэт алтан дэлхий. Ум базар рэ-хэ а-хум*

Гадуур төмөр уулаар эргэн тойрон хүрээлсний төвд, Уулсын хаан Сүмбэр уул, Дорноо үлэмжийн биет, Өмнөө Замбуу тив, Өрнөө Үхэр эдлэгч тив, Умараа Муу Дуут тив болон Биет хийгээд Үлэмж биет завсрын тив, Дохиурт хийгээд Бус дохих завсрын тив, Хэлбэрэлт хийгээд Дээд мөрт зорчигч завсрын тив, Муу дуут хийгээд муу дуутын нөхөр завсрын тив, Эрдэнийн уул, Галбарагча мод, Гаминдини үнээ..Эс тарьсан тутарга, Хүрд эрдэнэ, Чандмань эрдэнэ,Хатан эрдэнэ, Түшмэл эрдэнэ, Заан эрдэнэ, Морь эрдэнэ, Баатар эрдэнэ, Их сангийн хумх, Үзэсгэлэнт эх, Эрхич эх, Дууч эх, Бүжигч эх, Цэцгэн эх, Хүжич эх, Үнэртэн эх, Наран, Саран, Эрдэнийн шүхэр, Хамаг зүгээс сайтар ялагч ялгуусны тэмдэг, Төв дунд тэнгэр хүмүүний хотол төгс цог учрал бүрдсэн эдгээрийг ачит ёзоорын ба дамжлага сэлтийн цог төгс лам дээдэс хийгээд, Итгэлт нигүүлсэнгүй Арьяабал нөхөр лүгээ сэлтэд өргөмүй. Их нигүүлсэнгүйгээр амьтаны тусад таалан соёрхоо.Таалан соёрхоод би тэргүүтэн хамаг амьтаныг адистэдлэн соёрхоо.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд
Сүмбэр уул,дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг
Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр
Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр
Шашиныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч
Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон
Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай

Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад
Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба
Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг
Зүүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай

Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд
Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд
Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад
Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай

Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санасанаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистлэн соёрхоо.

Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
Эс төрсөн нь төрөх болтугай
Эрт төрсөн нь доройтолгүй
Дээш дээш арвижих болтугай

Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай

Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтаны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин,ад,хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ

Эцэг,Эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод
Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршсоноор
Эндүүрэлгүйгээр тэдний ерөөл бүтэх болтугай

Өглөгийн эзэн нөхөр сэлт нүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай

Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай

Бишрэнгүйгээр мөргөж, тахиж, наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой

Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт аврижиж
Хориг гэм үгүй язгуурын явдал үргэлжид тасралтгүй
Хоног өдөр бүхэнд Зонхабын шашны номын дуу дуурсаж
Хотол чуулганы цогоор цэнгэхийн өлзий хутаг орштугай

Умаа сарваан дата гада раднаа мандала хам ниряа даряами

ЭЗЭН ЧИНГИС ХААНД ЗАЛБИРАЛ ТАХИЛ ӨРГӨХ ЁС

Намо гүрү базар Бирвааяа

Үүн дор эзэн Чингис хаан дор залбирал тахил үйлдэхийг хүсэгч нэгэн бээр тахил балин тангарагийн эд нүдний гайхал тэргүүтэн ямар мэт хэрэгтэй эд нугуудыг бүрэн гүйцэд ер гол лугаа зохилдуулан бэлдээд адистидэл Бодит ануу:

Аяа цагийн эцсийн галын өмөг бадарсны голд
Ахуй их цусан далай тосон давалгаа эрчилсний төвд
Аймшигт арсланг эрдэнийн эмээл хазаар тэргүүтэн
Асар их үнэт эрдэнэсийн чимгээр чимэсний дээр

Цагаан өнгийн Хум үсэгнээс сарны гэрэл цацран
Чандын дайсан тотгорыг таслаж гурван ертөнцийг хурааж
Янагш хураагдан Хум үсгэнд огоот шингэх болсноор
Ялгуусан Чингис хаан гурван ертөнцийг эрхээр болгогчийн

Лагшингийн өнгө нь цагаан буман сарны гэрлээр хүрээлсэн
Лавтай нэгэн нүүр хоёр мутарт гурван мэлмий хилэгнэн
эргэлдсэн
Баруун мутартаа цагаан жадыг огторгуйн төвд далайсан
Басхүү зүүн мутар дахь тэвшний амсараас эрдэнэ бялхасныг

Зүрхэндээ барьснаар сансар нирвааны үгээгүйг арилгагч
Цээжиндээ цагаан торгон өмсгөлийг элбэг дэлбэг асаасан
Доод биедээ таван өнгийн банзалигаан хормогч дор ч
Тодорхойяа индранила тэргүүтэн эрдэнийн чимэглэсэн

Үснирийн титэм сонорын чимэг хоолойн зүүлт мутар өлмийдөө
Үлэмж сайн эрдэнийн бугуйвчит чандмань сугавчлуурыг
унжуулсан
Үнэт манжлагат титэм гайхамшигтай есөн эрдэнэсийн

Үзэсгэлэнт оройтыг тэргүүндээ өмссөнөөр илэрхий жавхлантай

Эрдэнийн сөөхий гутлыг өмссөний таван хоншоортын дээр
Эрхэмсэг хаан тэр цэнгэлийн дүр байдлаар ямбалж
Эргэн тойрон тэнгэр лус ягчис албин шулмас хийгээд
Эрхэт дагинас айсхит дээрэнгүйт найман аймаг тэргүүтэн

Тангарагтны далайн цэргийн чуулганаар хүрээлүүлсэн
Тансаг гурван орныг гурван очироор бэлгэдэх боллоо
Аяа номын төвийн их амгалангийн тийн цэнгэлээр
Алимад хувилгаан бүжиглэлийг зохиогч тэнгэрийн дээд хаан

Чингис хэмээгдэхийг буман нөхдийн чуулган сэлттэйгээр
Чанх өмнийн огторгуй дор айлтгал залан ирүүллээ
Хэмээн мэдэхүй зоригдол лугаа сэлтэйгээр зуун үсэгтийг
гурвантаа өгүүлтэндээс наманчлал нь

Аяа хамаг ном туурвилын хязгаар лугаа хагацсан боловч
Аюулт нисваанисын эрхээр тангараг харшилсан нугуудыг
Их хаан нөхөд сэлт дор айлтган наманчилваас
Илт уналт доройтлыг засаад хоцроолгүй шидийг хайрлагтун
Тэндээс хангалын эдүүдийг ер мэт адистэдлаад

БОГД ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ САН

Мөнх тэнгэрийн заяагаар
Ертөнцийн сахиус болсон
Суут богд Чингис хаан, дотоод нөхдийн хамтаар
Жаргалант Сухабадын орд харшаасаа

Заяат түшмэд ба нөхөр сэлт бүгдээрээ
Ямар бас алин энд оршсон тэнгэр лус
Ягч рагча газар усны эзэд, догшид бүгдээрээ
Үйлс хүслийг хангахаар залран соёрхоо.

Хэмжээлшгүй эрдэнээр чимсэн арслан ширээ
Найман дэлбээт лянхуат суудлын дээр
Төгс хүчит сахиус эзэн богд Чингис хаан
Хамаг нөхөд, дотоод түшмэд ба тэнгэр лус
Бүгдээрээ баясаад залран суун соёрхоо

Сэтгэл лүгээ зохилдох ариун тахил
Зуун амт бүрдсэн идээний дээж
Сүүний амт төгссөн рашааны шимээр
Суут богд Чингис хаан, нөхөр сэлтийг тахимуй

Бадрангуй галын цог машид бадарсан дөл
Бадрангуйн зул хийгээд зулын гэрлээр тахимуй
Зандан, гүгэл, арц, хүжисийн анхилуун үнэрээр
Сангийн их үлэмжит өнөөдөр тахимуй

Заа, Суут богд Чингис хаан нөхөд лүгээ нэгнээ
Бүгдээр ариусах тахилаан зоогло
Хамаг түйтгэр амирлахуйн шидийг өгөн соёрх
Эмгэг ад амирлахуйн шидийг өгөн соёрх

Буруу тэмцэл амирлахуйн шидийг өгөн соёрх
Буян хишиг дэлгэрэхүйн шидийг өгөн соёрх
Оюун билиг нэмүүлэхүйн шидийг өгөн соёрх
Омог хүчин бадрахуйн шидийг өгөн соёрх

Тэнгэрийн хааны зарлигаар эдийг барин тэтгэгч
Төгс хүчин үйлдэгч түргэн рид хувилгааны хүчнээр
Тэрс номт хаадын дайныг талхан товрог болгоод
Таван өнгө дөрвөн харийн улсаа товчлон

Найман түмэн дөрвөн мянган хаадын эрхэм болсон
Номын хүрдэн хаан мэт их аугаа хүчнээр

Тэрс номт, догшин, тотгорлон хорлогчийг чадагч
Төгс хүчин сахиулсан таныг магтан мөргөмүй

Эзэн юүгээн тахин магтан шүтсэний хүчээр,
Ая мину нөхөд хийгээд эдлэл малыг арвитга
Урт насан амар жаргал эрхшээлийг бататга
Онц хүслийг бүтээхүйн үйлсүүдийг зохио

Заа, хүн хийгээд хүн бусын хорлолыг хариул
Цэрэг аян догшин тотгор хорлолыг хариул
Чуулганд хорлол хийгч өст дайныг хариул
Бурхан багшийн шажин лугаа харшлагч дайсныг
Бат очирт мэснээр нэвт нэвт мэслэ

Амин голын судлыг тас тас огтчин
Очир дарын шажиныг арван зүгт дэлгэрүүл
Тангараглан буцагсдыг хүлэн хүлэн эцүлгэ

Богд Чингис Эзний Даллага Оршив.

Хум, төгс цогт Очирваань тодорхойяа
Хувилгаан амьтаны тусын тулд
Ертөнцийг тэтгэгч эзэн
Чингис хаан хэмээн алдаршсан

Тэнгэр хаан хатад нөхөд сэлт
Энд ирэн соёрх
Эрхэм тансаг Бор тохой оронд орш
Шажин хийгээд шажины богд ир

Сахигч дөрвөн зүйлсийн үйл бүтээгч
Хүчит номын хаан Увш
Энд ирэн соёрх
Зээ, Мах цусан зоог хийгээд цай ба сархад

Ундаа тэргүүт Чакравардын зоог
Их хуримыг Чингис хаан
Танд өргөмүй
Очирдар Далай лам Наваанжамцийн гэгээн ба

Бус бас хувилгаан Саянжамц тэргүүтэн
Язгуурын үндсэн лам нарын зарлигийг
Алмайдаж давалгүй тангаргийг дуртган
Егүзөр бид нарын үйлсүүдийг зохио

Хүн эд малыг улам дэргэрүүл
Ялангуяа үлэмж төгс их хөлгийн сүмийн зүг
Харьяат лам шавь хийдийн хэргийг мандуул
Аймаг хүн ач үрийг дэлгэрүүл

Хүн мал эмнүүлэхийн үйлсүүдийг зохио
Зээ, Лам ядам гурван чухаг
Дээдсийн адистэдийн их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишиг авмуй

Хурай, хурай, хурай
Дээд зүгийн тэнгэр нарын
Хотол төгссөн их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Хурай, хурай, хурай
Дунд зүгийн Чакравард хааны
Хаан язгуурын их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Хурай, хурай, хурай
Богд эзэн Чингис хааны

Хүрдэн эргүүлсэн их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Товчилруун сансар нирваан сайн
Дөрвөн чуулган бүхий их хишгийг
Энэ өдөр өлзий буян хишигт авмуй

Хурай, хурай, хурай
Лам бурхдын өлзий хутаг орш
Ядам бурхдын өлзий хутаг орш

***Эзэн Чингис Богдод сэржим өргөх ёс хийгээд үйлсээ
захируулж санасан зүйлийг түргэн бүтээх сэлт оршвой.***

Гурван оронгийн номын хаан Зонхова бурханд мөргөмөй Үүнд:
эзэн Чингис хаанд сэржим өргөхийг хүсэгч бээр өөрийгөө Ядам
бурханд тодруулснаар нанчод мэт адистлаад

Сэржимийн ариун дээжист тахил үүнийг
Гурван ертөнцийн итгэлт Содномжамц хийгээд
Чингисийн язгуурт мэндэлсэн Ёндонцамц
Бүхнийг айлдагч V Лувсанжамц тэргүүтэн
Эзэн богдын бодит удам залгамжилсан
Багш бурхадыг айлтган тахияа

Санасан бүхнийг зөнд нь бүтээн зохио
Ариун сэржимийн дээжист тахил үүнийг
Номын сахиус нийт хийгээд ялангуяа
Огторгуйн тэнгэр эзэн богд Чингист
Залбирьяа санасан тусыг аяанд нь бүтээж зохио

Ариун сэржимийн дээжийн тахил үүнийг
Эзэн Богдын зарлиг магтаалаар хувилсан хатан
Гадна дотны түшмэд нөхрийн чуулган хоцроолгүйд
Залбирч тахия Санасан тусыг зөнд нь бүтээн зохио

Намо гүрү Базар Бира ваая

Дэвсгэр дээр улаан шар наран арслангийн дээр
Цагаан өнгөнд тунгалаг улаан өнгө тогтсон Богд
Хаана саатавч шашныг сахин санасан горилыг хангаад
Миний сэтгэсэн тус бүгдийг үтэр түргэн бүтээ

Цуугиан цурхираант эгшиг дэлгэрсэн шамдах сэтгэлээр их тэнгэр
таны нас

Дүр байдал магад рид хувилгааны хүч чадлаар торох үгүйеэ
залар

Цай архи ундаа эм цусан далай цагаан балин амтат рашааны
далай

Арван тавны сар дэлгэрсэн мэт гэгээний хот мандалыг мишээж
таал

Бурханы шашны сахиус урьд цагт Охин тэнгэр цагт орших

Сүүлийн цаг үүнд Далай лам Содномжамц бээр

Эдүгээс эхлээд Богд Зонховын шашныг аривжуулна хэмээн
очирын зарлиг

Өвдөх өтлөх үхэх үгүйн рашааны цогийг санах цаг боллоо

Баасан гараг мэт маш цагаан сэтгэлээр зургаан зүйлийн эцэг
эхийг тэтгэ

Хоосон чанарын агаараас амирлах дэлгэрэх эрхшээх догшноор
бүжиглэх

Шар үст тэр ч гурван мянган ертөнцийн орныг сүрээр дарах
хүчит өмөгт

Хоцроолгүй хааны сүр жавхланг үүсгэж хар зүгийн шулмасыг
дарж

Үндэс хийгээд навч цэцгийн үр дэлгэрч чандманын өмгийг
арвитгаад

Халуун хүйтэн тэгшрэх зун цагийн хур ямар мэт хүссэнчлэн
буугтүн

Ялгуулсан Сидхи хаан эцэгт хүн эдийн хувь дэлгэрээд
Залиас төрсөн мэт номын бус зүгийн язгуур сэлтэсээс гэтлээд
Шар малгайтны шашны сахиусаас бүү алгасраг
Идэж үйлдэх бадарсан нөхрөөр хүрээлсэн их Тэнгэр таныг хүсэх
цагт
Оволзож бадарсан цагийн адгийн галаар хар зүг бүхнийг өвс мэт
шатаа
Гайхамшигт тонилох зам арван буяны ёс цаазыг арвижуулж
асрахаар тэтгэ

Хашаа хүрээ бүгдийг эдээр дүүргэж хүн малыг арвижуулан зохио
Бурханы арван таалал Зонховын шашныг дэлгэрүүлэн зохио
Бүхнийг арван буяны цааз зарчимаар амар жаргахыг арвижуулан
зохио
Хаан хатан хүү түшмэд харьяат албат сэлтийг
Хари унаж оршсон хувилгаан сахиус тэнгэрийн увш та
Усан тахил тэргүүтэн тахилыг таалж надтай нөхөрлүүлэн
зохиогтүн

Үг найруулга төдий далдыг орхисон бөгөөд тусын зэндмэнэ
эрдэнийг барьж
Энэрэх санаагаар хөлбөрөлт үгүй багш бурханы таалал
Нигүүлсэнгүйн чандманын далайд мөнхөд оршин үйлдэж
Очир номын сахиустай нөхөрлөн заларсан үүгээр
Алины дотроо хүссэн тусыг айлтгасан цагт номын ёсоор бүтээн
зохио

ГАНСНЫ ТАХИЛГА ҮЙЛДЭХҮЙ

Аяа аяндаа бүтсэн их амгалан номын бие уужмын төвөөс
Алимад гадаад дотоод нууц тангарагийн эд нүдний гайхал
тэргүүтэн
Илэрхийеэ газар лугаа гэгээн завсрын энг дүүргэснээр
Их хаан нөхөд сэлтийг баясган жаргуулах болтугай

Дайсан тотгорын зүрхний цусан тахилын ус далай мэт бялхсан
Тангараг доройтсоны эрхтэний цэцэг жигд дэлгэрсэн
Мах өөхийг шатаасны утаан үйл огторгуйд түгсэн
Маш их хайлмал зул гурван ертөнцийг гэрэлтүүлсэн үүгээр

Махаадва ранза хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн тааллыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг засаж
Магадгүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Тэгш гавар зандангийн үнэрт усан ганга мөрөн мэт урссан
Тэнгэр хийгээд хүмүүний амны идээ Сүмбэр уул мэт цогцолсон
Элбэг шимийн архи хурсны сэржим нь далай мэт бялхсан
Элдэв хөгжмийн яруу эгшиг луугийн дуу мэт дуурссан үүгээр

Махаадэва ранзаа хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн тааллыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг үнэхээр засаж
Магадгүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Түргэнээ одогч барлаг зарц хар хонь цагаан чоно хийгээд
Түүнчлэн зүрх цагаан хар нохой өтөг мэт харайн дүүлэгч ба
Арслан бар ирвэс шилүүс цөөвөр тэргүүтэн

Араа соёогоо ярзайлган хилэгнэсэн элдэв араатан үүгээр

Махаадэва ранзаа хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн таалалыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг магад засаж
Магадгүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Ирт цагаан болор жад чандмань тэвш хийгээд
Эрдэнэсийн чимэгт тэнгэрсийн хувцас ба
Элдэв зургаан зүйл чагжаа баатрын хэц чимэг тэргүүтэн
Илт дөрвөн үйлс бүтээхүйг сануулсан үгээр

Махаадэва ранзаа хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн таалалыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг үнэхээр засаж
Магадгүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Үлэмж хүслийн таван эрдэм хийгээд хаан төрийн долоон эрдэнэ
Өлзийт найман тэмдэг дөрвөн тив өчүүхэн бага тивүүд лугаа
Үнэхээр бодотой бэлтгэсэн сэтгэлээр хувилсан тахилын үүл
үүгээр

Махаадэва ранзаа хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн таалалыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг үнэхээр засаж
Магадгүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Ялангуяа гурван мянган лугаа сацуут савны дотор
Ямарваа цувирал үгүй их улаан балин Эсүрэгийн орноо тулсан
Ямагт сэтгэл итгэмжлэн залбирах дээргүй дээд шүтээн үүгээр

Махаадэвэ ранзаа хааны сэтгэлийн тааллыг хангая
Маш тангарагт нөхдийн чуулганы далайн тааллыг хангая
Магад таалал нь ханаад унал доройтлыг үнэхээр засаж
Мадаггүйеэ садаа тотгорыг арилган хоцроолгүй шидийг
хайрлагтун

Энэ үед балинг өргө Тэндээс сануулан дурдатгах нь
Аяа би бээр ялж төгс нөгчсөн Ямандаг бурхан
Асар нигүүлсэхүйгээр хилэгнэсний дүр байдалтан
Эдүгээ эрхэт тэнгэрийн хаан чамайг

Итгэлээр дурдан сануулан дуудья эрэмгий хүчит минээ
Алимад шашны дайсан тангараг доройтсон хилэнцэт энэ бээр
Ачит ламыг муушаан шашныг будангуйруулсан
Амьтан дор хорлоод басхүү надад уурласан

Агуу тэнгэр чамайг хүчгүй хэмээн доромжилсон
Хилэнцэт эдгээрийг гэтэлгэхийн цаг ирлээ
Хэтэрхий муу цагийн хэрцгий амьтаныг
Хатуу гэсгээлээр үл гэтэлгэвээс

Шашин амьтаны амар амгаланг хоослохын тул
Шантаршгүй ид хаваа үзүүлэн эрэмшигтүн самаяа

Хэмээн хатуу сануул Тэндээс ер буцаалга үйлдээд урилга унших
нь
Хаан зүрхэнд Хум үсгийг тойрон тарнийн эрхэс эргэлдсэнээс
гэрэл цацраад дайсан тотгор хорлолтон бүгдийг гэсгээлээ
Дөрвөн зүйл үйлсийн шид бүтээлийг түрвэл үгүй соёрхмой

Ом Махаа дэва ранзаа сарва сиди заа

Хэмээн аль олон тоол Зуун үсэгтээр илүү дутууг нөх Балинг
өөрөөн аль ядам үйлддэгийн гол мэтээр адистидла

Тэнгэрийн хаан нөхөд сэлтийн хэл гэрлийн нүхээр балингийн шим бүгдийг болгоогоод зоогломуй

Махаа дэва ранзаа савара вара удам балимда ха ха хаа хи

Хэмээн гурвантаа өгүүлэн балин өргө Тарни түүнд зүүсэн
Аргам-аас Шавда хүртэлхээр тахь Дээрхи тарни дээр гурван үр
үсгийг зүүснээр нанчид өргө Тэндээс балин илгээх нь
Хоо Тэнгэрийн хаан нөхөд сэлт дор
Тийнхүү би бээр тахил балин өргөснөөр
Чухаг дээдийн суу залиг муушаасан хийгээд
Чухамхүү энэ хөлгөнийг сөхөөсөн ба

Ялгуусны шашныг эвдсэн хийгээд хутгасан ба
Ялангуяа ламын лагшинг доромжилсон хийгээд
Ёогүзэри надад уурласан тэдгээр нугуудыг
Ямагт тэнгэрийн хаан бээр гэтэлгэгтүн

Дайсан тотгор маараяа пад
Хэмээн өгүүл Газрын эзэнд балин өргө Тэндээс магтаал нь
Аяа ертөнцийн өвгийн тааллын рид хувилгаанаас
Асар элдвээр хувилан гурван ертөнцөд огоот түгсэн
Алимад дөрвөн зүйл үйлсийг түрвэл үгүй бүтээн Зохиогч
Ачит тэнгэрийн их хаан дор би магтмуй

Заримдаа догшин ширүүн хатуу хилэнт хааны есыг
Зарим заримдаа маш амарлингуйн дүр байдлыг үзүүлэгч
Алиныг алинаар номхотгон авч орхихын орныг үзүүлэгч
Аливаа тэнгэр огоотын дайны тэнгэр дор би магтмуй

Нийт нийт бусын рид хувилгааны чуулган
Нэн өгүүлхүйеэ бэрх тоолохуй орноос хэтэрснээр

Нэлэнхүй гурван ертөнцийн төрөлхтөн амьтаныг гэсгээн
дагуулан баригч
Нөхдийн чуулган сэлт тангарагтны далайн тэнгэр дор би магтмуй

Эзэн тан дор тахиж магтан биширсний адистидаар
Эдүүгээгээс эхлээд бодийн зүрхэнд хэзээ хүртлээ
Эгнэгт тан лугаа үл хагацваас харшлах нөхцөл бүхнийг арилгаад
Эерэг зохистой нөхцлийн сайн чуулганыг хоцроолгүй сэтгэлчлэн
бүтээ

Орон дор өлзий хутаг урт нас номын барилдлагыг арвитган
Огоот газар нутгийг аюул тотгороос гэтэлгэх хийгээд
Ахуй үе эцэстээ тулсны хүссэн хэргүүдийг
Аяндаа бүтээхийн буян хишиг дэлгэрэх болтугай

Сүүлийн зан үйлийг бусад ер лугаа зохилдуулан үйлдээд
эрхшээхийн залбирал зохихуй ерөөлөөр хязгаарыг чимэглэн бат
оршил заллагыг аль ёстойгоор үйлдээд өлзий хутаг өгүүлэхүйн
хурыг буулган үйлдээрэй

Хэмээсэн үүнийг Ордос отог Дамила Содномравжаагэндэн
бээр сануулан дор Шагжаан гэлэн
Лувсанбалдандамбийнямчоглойнамжилсамбуу бээр найрууллаа
Эм гал үхэр жилийн дөрвөн сарын арван зургааны өдөр гэлэн
Гэндэнсамбуу бичлээ

Өлзий хутгийн цог Замбутивийг чимэглэх болтугай

БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРЭХИЙН ЕРӨӨЛ

Баатар долоон бурханд мөргөмү

Амьтны тусд урьд би

Аль бэрх хатуужлыг эдлээд

Амар жаргалаа зориулсны хүчинд

Ариун шашин өнөд бадартугай

Өвчтөний тусд урьд би

Өөрийн амь амьдралын зольж

Үгээгүү амьтныг эмнэсний тулд

Үнэн шашин өнөд бадартугай

Эхнэр хийгээд хөвгүүд охид

Эд эрдэнэ, хөлөг хэрэгслээ ч

Эгнэгт гэгээрлийн төлөө зольсноор

Эрхэм шашин өнөд бадартугай

Эцэг, эх, ширвага, брадига

Энэрэлт бурхан, арш дээдэст

Эндэлгүй би вээр тахил өргөснөөр

Эрдэнэ шашин өнөд бадартугай

Олон сая галавт би

Онц элдэв зовлонг амсч

Оюун гэгээрүүлэх номыг эрснээр

Онол шашин өнөд бадартугай

Асар нарийн ёс журам

Аливаа хатуужлыг үргэлж сахин

Арван зүгийн бурхадыг тахиснаар

Аврал шашин өнөд бадартугай

Эргэж буцахгүй хичээл зүтгэлээр
Эсрэг хүчин бүхнийг ялж
Эндүүрч төөрөгсдийг аварсан тул
Эрдэмт шашин өнөд бадартугай

Хүлцэл тэвчээрийг үргэлж эрхэмлэн
Хөнөөлт сэтгэлийн өвчинд баригдсан
Хөөрхий дордсыг уучлан хайрласнаар
Хүндэт шашин өнөд бадартугай

Ганга мөрний хумхийн тоо шиг
Дээд түвшний дияан бясалгалыг
Гаргууд сайн эзэмшсэн тул
Гайхамшигт шашин өнөд бадартугай

Билиг ухаан нээхийн тулд
Бэрх хатуужлаар аглагт сууж
Бичиг шаштир судалсны хүчинд
Бишрэлт шашин өнөд бадартугай

Өршөөлт энэрлээр мах цус
Өнө амьдрлаа ч огоот зориулж
Үе мөчөө харамгүй өгснөөр
Үнэн ном машид дэлгэртүгэй

Алдас нүгэлтнийг урьд би
Агуу хайраар асран сэнхрүүлж
Аль зохих замд нь оруулснаар
Алдаршгүй номын өглөг арвижтүгэй

Арга билгийн хүчээр би
Атхаг үзлээс бусдыг чөлөөлж
Ариун үнэнд залуурдсаны тулд
Авралт ном үлэмж дэлгэртүгэй

Хураах дөрвөн үйлсээр би
Хорсол тачаалын галаас аварч
Хор хилэнцийн хүчийг ялснаар
Хувьт шавь нар минь өнөд орштугай

Буруу зөрүү номтныг би
Буртагт үзлийн уснаас гэтэлгэж
Буцалтгүй үнэн үзэлд оруулснаар
Буянт нөхөд минь өнөд бишэртүгэй

Бурхан шашин үүрд бадартугай

МЭГЗЭМ

**Мэгмид зэвий дэрчин жанрайсиг
Дэмид чинбу банбу жамбиян
Дүдгүн малуй зомзад санвуйндаг
Ганжин хайвий зүгжан зонхава
Лувсан дагби шавла солбаандэв**

НЯЛХСЫН ДОЛООН АВШИГ БУЮУ ХҮҮХЭД УГААХ ЗАН ҮЙЛ

Анхны авшиг цагийн хүрдний номлолоор
Ариун рашаанаар биеээ угааж үйлдмой

УМАА САРВААН ДАТА ГАДА АВЭХИ ГАДА САМАЯ ШРИ А ХУМ

Өглөгийн чанарт энэ усаар
Өөдгүй харамын хирийг угааж
Өгөгдэхүүн болсон цэвэр усаар
Өөр бусдад угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Шагшаабодийн чанарт усаар
Шантрах муу гэмээ ариулаад
Сахилын цэвэр энэ усаар
Сахиагүй бүгдэд угаал өргөмү

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Тэсвэрийн чанарт энэ усаар
Тэсэшгүй уурын гэмээ ариулаад
Асралын чанарт энэ усаар
Амьтан бүхэнд угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Хичээлийн чанарт энэ усаар
Хойшлуулахын залхууг арилгаад
Хичээнгүйн цэвэр рашаанаар
Хотлыг шамдуулах угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Самадийн чанарт энэ усаар
Саад алгасрал гэмийг арилгаад
Бясалгалын үнэрт энэ усаар
Бясалгаагүй түмэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Ухааны чанарт энэ усаар
Ухаараагүйн гэмийг арилгаж
Увидаст энэ рашаанаар
Ухааны хур буулган өргөмөй

Дараагийн авшигаар титэм буюу малгай өргөж
Дээшлэх амьралыг нялхсад бэлгэдмөй
Удаагаар нь унжуураг чихний чимгийг
Увидас уламжлан нялхасд өргөмөй

Дөтгөөр авшигаар хонх очир өргөж
Дүнгэнэх дуугаар нь багчиг бүхнийг сэргээмой
Тавдугаар авшиг бээр очирт бөгж өргөж
Таван язгуурын бурхадын төрлийг сануулмой

Зургаадугаар авшигаар бугуйвч зүүж
Зөн мэдрэхүй сайныг сэргээмой
Эцсийн долдугаар авшигаар
Эцэг дээдэс алдар өргөмой

Энэхүү нялхсын долоон авшигаар
Эрдэмт хүмүүний биеийг олсон сайн хувийг
Энд цугларсан ах эгчид нь зарламой
Эрдэмт хүмүүний заяа буян дэлгэртүгэй

ЦАГААН САРЫН ШИНИЙН 13-НЫ ЕРӨӨЛД ДАГАН БАЯСАХУЙ.

ИТГЭЛ

Багш дор итгэмой

Бурхан дор итгэмой

Ном дор итгэмой

Бурсан хуварга дор итгэмой

(3 дахин).

Бурхан ном хийгээд чугуулганы дэгээд дор

Бодийн хутгыг олохыг хүртэл би бээр итгэмой

Миний өглөг тэргүүтэн эдгээр еээр

Хамаг амьтны тусын тулд бурхан бүтэх болтугай

(3 удаа уншина).

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай.

Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийнг шалтгаан лугаа хагацах болтугай.

Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай.

Хамаг амьтан ойр хол уурлах дурлахаас хагацаж тэгш дор орших болтугай.

БУРХАН БАГШ ШИНИЙН 1-15 ДУУСТАЛ ТЭРСҮҮДИЙГ ХУВИЛГААНААР ЯЛАН ЗОХИОСОН НАМТАРЫГ ДАГАН БАЯСАХУЙ

Ялж төгс нөхгчсөн бээр **шинийн нэгний өдөр**: гэгээн ялгуусан хаан бээр ялж төгс нөгцсөнийг тахихийн тулд хэрэглэл хийгээд идээг бэлдэж хүндлэл үйлдэв. тэр цагт яв ж нөхцсөн цав идээг зооглоод шүдний чигчилүүрийг газарт хатгасан мөнхүү даруй өсч урган долоон зүйл эрднээс бүтсэн, өндөр хийгээд мөчир салааний өргөн нь энэ тэгш 500 н бээрийн найлзуур модон болов. Цэцэг нь тэрэгний булын төдий үр жимс нь таван суллга багтах хумхын төдий сайн үнэр анхилсан түүнээс номын дуу дуурссан гэрэл цацарсан нарны гэрэлыгч сүрээр дарах тийм гайхамшигт болвой. үүнээс эхлээд хагас сар болтол өдөр бүр нижгээд өөр зүйлын нирийг хувилгааны үзүүлэхүйд тэр гайхамшигт ирид хувилгааныг үзсэн төдий тоолшгүй олон бүгд үлэмж сүсэглэсэн бөгөөд тэдгээр олон ардад номыг номлсноор гурван зүйл бодь хутгийг мөрд тус тусд магадтай болгон зохиолоо.

Шинийн хоёрны өдөр:

Удраяна хаан өргөлөл хүндлэл үйлдэв. Тэр цагт ялж төгссөн нөгцсөний биеийн баруун, зүүн хоёр этгээдэд маш өндөр болоод үлэмжит 5 өнгөөр гялтгансан 2 эрдэнийн уулнаа цэцэг жимс нь үлэмж дэлгэрэн, элдэв зүйлийн модод ургасны баруун уулнаа зуун амтат тутрага ургасныг хүмүүс таалан хүссэнээр ханатлаа эдлэн, зүүн уулнаа маш амтат өвс ургасныг адгуус ханатал идэн бүхий тийм рид хувилгааныг үзүүлэв.

Шинийн гуравны өдөр:

Өглөгийн эзэн Шүнээ бээр дали хэмээх ногоо гүнцэг өргөж хүндлэл үйлдэв. Түүний ялж төгс нөгцсөн бээр амаа зайлсан усыг газарт асгаснаас эрдэмийн цөөрөм гарлаа. Тэр цөөрөм нь

200 бээрийн төдий бөгөөд 7 зүйл эрдэсээр хээлэн элдэв өнгийн лянх цэцэгс дүүрсэн тэдгээрээс лянхсын өнгө лүгээ зохилдсон гэрэл цацран огторгуй газар бүхнийг гийгүүлэн үйлдсэн тэдгээрийг үзсэн бүхэн бишрэн магтах тийм рид хувилгааныг үзүүлэв

Шинийн дөрөвний өдөр:

Индраварми хаан өргөл хүндлэл үзүүлэв. Түүнээ урьд өдрийн тэр цөөрмийн 4 талд 8, их суваг гараад түүгээр их ус урссансс номын дуу дуурч тэр урсгал нь эргээд мөнхөд тэр цөөрөмдөө буух тийм хувилгааныг үзүүлэв.

Шинийн тавны өдөр:

Ариун өглөгт хаан өргөл хүндлэл үзүүлэв. Түүнээ ялж төгс нөгцсэн бээр Амнаасаа алтан гэрэл цацруулж их мянган ертөнцийн орныг гийгүүлэн тэр гэрлээр хүрэлцсэн амьтан бүхэн гурван зовлон хийгээд таван түүтгэрээс хагацаж бие, сэтгэл нь маш амгалан болвой.

Шинийн зургааны өдөр:

Өглөгийн эзэн Лицави нар өргөл хүндлэл үзүүлэн гүнцэг өргөв. Түүнээ ялж төгс нөгцсөн бээр тэдгээр олон нөхдийг нааш цааш нэг нэгнийхээ санааг мэдэлцэх хийгээд тус тусын буян нүгэлийн үйлээч онож мэдэх болгон зохиосонд бүгд баясан магтвай.

Шинийн долооны өдөр:

Шагжаа язгуурын өглөгийн эзэн бээр Бурхан багшид өргөл хүндлэл үзүүлэн гүнцэг өргөв. Түүний дараа тэдгээр олон нөхөд бүгдээр тус тусдаа хүрдэн орчуулагч их хаан болоод 7 эрдэнэ ба мянган хөвгүүд төгс болоод өчүүхэн хаад, түшмэдүүд өргөн хүнлэж байх болгон үзүүлснээр олон ард машид баясан дуршил төрлөө.

Шинийн наймны өдөр:

Хурмаст бээр өргөл хүндлэл үйлдэхийн тулд залваас ялж төгс нөгцсөн бээр баруун өлмийгөө ариун үнэрт сүмийн дотор гишгэнгүүт газар дэлхий хөдөлсөн хийгээд дэвсгэр дээрээ үзэгдэхгүй болон 4 зүгийн огторгуйд заларч явах ба босоо зогсох суух, хауулдан нойрсох лугаа 4 зүйлийн явдал мөрийг зохион элдэв зүйлийн гэрлийг цацруулан биеийн дотороос гал бадруулж дээд биесээ ус урсгах ба доод биеэсээ ус урсган дээд биесээ гал бадруулахыг зохиогоод эдгээрүүдэд нь ширвааган нугуудад ч байх ерийн рид хувилгаан болой хэмээн зарлиг болоод арслант ширээндээ суусанд Эсэрва, хурмаст 2 баруун зүүн 2 этгээдээс тахиж хүндлэл үйлдэв. Ялж төгс нөхцсөн бээр дахин зарлиг болруун

- Их хаан минь ээ, Түүнчлэн ирснийг рид хувилгаан үзүүлэхийг өчин айлтгасанд хэн бэ хэмээсэнд гэгээн ялгуулсан хаан

- Би өчин балбирсан бөлгөө хэмээвээс ялж төгс нөхцсөн бээр мутараа газарт хүргэсэнд лусууд бээр тэргэний булын төдий мянган навчид очир тоорцогт лянх цэцгийг өргөсөнд газрыг нэвтлэн гарч ирсэнд ялж төгс нөхцсөн бээр тэр лянхуаны хүйсэнд суулаа. Мөн тэр мэт лянхуа маш олон гарч ирсэний дээр нижгээд хувилгаан бурхад суун, тэр мэт маш олон бурхад доор үгүй орон хүртэл дүүрсний дээр зарим бурхад нь гал бадруулмуй зарим нь тодорхой гялбааны гэрлээр гийгүүлнэ. Зарим нь хур оруулах хийгээд гялбаанд гялбуулах хотлыг мэдүүлэн ном номлох, гүн нарийн номын утга асуун өчих, түүний хариу номлох, огторгуйд нааш цааш эргэцэх ба суух, зогсох, орших, идээ зооглох зэрэг рид хувилгааныг ямар мэт өчүүхнээрч халхалдаггүй бурханы биеийг илэрхий үзэх тэр мэт болгон адислав. Түүнээ тэдгээр өөр орноос ирсэн хаад нөхөд сэлт ба олон буман тоотон тэнгэр хүмүүний нөхөд бурхад ч туувилыг хичээтүгэй хэмээх тэргүүтэн шүлгүдийг зарлиг болгон амой. Түүнээс ялж төгс нөхцсөн бээр: - Аяга тахилгуудаа эдүүгээ энэ их

рид хувилгаан нь үл үзэгдэх болмуй. Та нар рид хувилгааны бэлэгсийг сэтгэлдээ сайтар тогтоон авах тугай хэмээн зарлиг болохуйц сац тэдгээр бүгд үл үзэгдэх болсонд гэгээн ялгуусан хаан бээр тэрсүүдийн 6 багшид - Аяа ялж төгс нөхцсөн бээр рид хувилгааныг үзүүлэн дуусгав. Эдүүгээ та нар үзүүлэх түн гэвээс тэлгээр багш нарын ахмад төгсөгч бээр огт юм үл үгүйлэн өөрийн дараа суусан багш үхрийн хорооны хөвгүүнийг тохойгоороо нудрав. Тэрч өөрийн дараа суусан үнэхээр ялгуулсныг тохойгоороо нудраваас тэрч хажууд нь суугч үл мятагчийг нудрав. Тэрбээр бас дараах Гадягийн хөвгүүн Шилтийг түлхэн тэрээр нүцгэн явагч Уяны хөвгүүнийг түлхсэнд тэрч тэргүүлэгч багш төгсөлтийг тохойгоороо түлхэв. Гэгээн ялгуулсан хаан бээр тийн хэмээн гурвантай үгүйлэвээс тэдгээр огт юухыг ч үгүйлэн үл чадаад нэг нэгнээ тохойгоороо түлхэлцэн димий арга аашаа баран сандарч шантрав. Толгойгоо бөхийж доош харан самбаа ухаанаа алдаад айх ичихээр сэтгэл нь зовнин чичрэн суулаа. Тэндээс ялж төгс нөхцсөн бээр өөрийн суусан арслант ширээгээ мутраараа дарсанд түүнээс зааны дуу мэт сүрхий их дуу гарсан даруй 5 эх ягшас, мангас хувилж гараад, тэдгээр тэрсүүдийн 6 багшийн суусан ширээг эвдэв. Мутартаа очирт бээр гал бадарсан очироо тэдгээрийн толгой дээр далайж, улаан салхит догшин хур тавьсанд тэдгээр 6 н бапл нар машид айн эмээн зүг зүгт босон зугтааснаас үхрийн хорооны хөвгүүн багш нь нэгэн их уулын хонгилд шургаж оров. Үнэхээр их ялгуулсант нь их өвсний дотор үл мяташ үсэн дээлт нь ширэнгэнд гяндангийн хөвгүүн шилт нь нэгэн чулуун байшинд нүцгэн явагч усны хөвгүүн нь нэгэн сүмд шургаж орцгоов. төгсөгч гэрэл сахигч нь хүзүүнз элс дүүргэсэн хумх зүүгээд буруу номын ёсоор цөөрмийн усанд амиа хорлож живж үхээд их тамд одлоо. Түүний шавь нар нь төгсөгч гэрэл сахигч лугаа адил нэртэй түүний шавь нарын дотороос эрхэм нэгнийг багшийнхаа ор болгон тавиад түүнлүгээ нөгөө 5 багш нар учралдан бярманы балгадад зугтаан одвоос тэдгээр тэрсүүдийн 9 түмэн нөхөд сүсэглэн гэрээс сайтар гарч тойн болоод дайснаа дарсны утгыг олов. Тэндээс ялж төгс нөхцсөн

бээр 8 түмэн шавь үснийхээ нүхнээс гэрэл цацруулан тэдгээр гэрэл бүгдэд лянхан дээр сууж нэжгээд хувилгаан бурхад ном номлон бүхүйг үзүүлэв.

Шинийн есний өдөр:

Эсэруа тэнгэр өргөл хүнлэл үйлдэв. Тэр цагт ялж төгс нөхцсөн бээр Эсэруагийн язгуурт тэнгэрийн орон хүртэл их болгон гэрлээрээ огторгуй газар бүхнийг гийгүүлэн зохиож номыг номлон үзүүлэв.

Шинийн аравны өдөр:

Дөрвөн их хаад өргөл хүндлэл үйлдэв. Түүнээ ялж төгс нөхцсөн бээр биеэ сансарын үзүүрт тулах хүртэл их болгон биеэсээ гэрэл бадруулан үйлдэв.

Шинийн арван нэгний өдөр:

Гомид сажон хэмээх өглөгийн эзэн өргөл хүндлэл үйлдэв.. Түүнээ ялж төгс нөхцсөн бээр арслант ширээнд заларч лагшингаа үл үзэгдэх болгон гэрэл цацруулж ном номлов.

Шинийн арван хоёрны өдөр:

Мрашан цэцэрлэгийн гэрийн эзэн тэргүүн дагуул бээр өргөл хүндлэл үйлдэв. Түүнээ ялж төгс нөхцсөн бээр алтан гэрэл цацруулан тэр гэрлээр хүрээлсэн амьтан бүгд асрахуйн сэтгэлд оршив.

Шинийн арван гуравны өдөр:

Өглөгийн эзэн Шүнзи бээр дахин өргөл хүндлэл үйлдэв. Түүнээ ялж төгс нөхцсөн арслант ширээнээ суун ахуйд хүйснээс нь 2 гэрэл гарч биеэс нь дээш 7 алд хэртэй огторгуйд дэгдээд тэр 2 гэрлийн дээр 2 лянхуа гарсанаас бас 2 хувилгаан бурхан гарав. Тэр 2 бурханы хүйснээс бас 2, хоёр гэрэл гараад тэр мэт ёсоор дамжин үлэмж хувилснаар энэ их мянган ертөнцийн орон бүгдийг дүүргэн хувилгалаа.

Шинийн арван дөрөвний өдөр:

Ударяна хаан дахин өргөл хүндлэл үйлдэв. Түүнээ тэр хаан бээр цэцэг цацсанд тэдгээр цэцгүүд нь алт мэт бадарсан бөгөөд Эсэруагийн ертөнцөд хүрэх тийм их чандмань эрдэнээр чимсэн нэг мянга хоёр зуун тавин эрдэнийн дээр нэжгээд хувилгаан бурхад сууж гэрлээрээ энэ гурван мянган ертөнцийн орон бүгдийг үзүгдүүлэх болгон зохиов.

Шинийн арван тавны өдөр:

Сүгжиннямаа хаан өргөл хүндлэл үйлдэв. Түүнээ ялж төгс нөхцсөн бээр хамаг сав бүгдийг 100 амтад идээгээр дүүргэн хувилгаад, тэдгээр рид хувилгааныг үзэхээр чуулсан олон нөхөд бүгдийг тэр идээгээр хангав. Бас ялж төгс нөхцсөн бээр мутраа газарт хүргэснээр 18 тамын орон дахь амьтад маш аймшигт галын дотор түлэгдэх ба хэсэг хэсэг огтлогдох тэргүүтэн элдэв зүйлийн тэсэсгүй зовлонг эдлэн, - Аяа бид ийм их зовлонг идлэв зээ хэмээн энэлэн шаналан өчих энэлэхүй дууг сонсгосонд хурсан олон бүгд маш их айн эмээн нэгүүлсэнгүй сэтгэл төрөв. Тэдгээр тамын амьтад ч бурханы гэгээнийг элт үзэн ном сонсоод даруй егүүдэн тэнгэр, хүмүүний өндөр язгуурт төрлөө бас өнгөтний зүрхэн хаан өчсөнөөр өлмийн толион дахь хүрдний тэмдэгээ үзүүлэв. тэр цагт мөнхүү рид хувилгаан үзүүлсэн тэр оронд нэгэн суварга байгуулсан нь рид хувилгааны суварга хэмээн дурслаа.

Эдгээр арван тав хоногийн Бурхан багшийн рид хувилгаан үзүүлсэн гайхамшигийг дурдан даган баяссаны хотол олны амны хишиг дэлгэртүгэй.

НИНЖИН СЭТГЭЛ ДОР МАГТМУ

Их төрөлхтөний замын үүд
Их хөлөгний мутрын тамга
Их бодийн хөрөнгө онгоц
Их нигүүлсэх сэтгэлд мөргөө

Бурхан бүгдийн игүүсгэгч эх
Бодьсадва бүгдийн зүрхний эд
Бүхийл амьтны тэгш багш
Бат нинжин сэтгэл та намайг авар

Аль бээр гагцаар мөргөхөд
Авралт бодьсадва бүхэнд
Алга хавсран тахихийн түлхүүр
Ашдийн нинж таныг магтая

Эрмэг бодьсадбаа архад бээр
Ээжээс төрөх уг шалтгаан
Эцийн ханацашгүй язгуур
Энэрэнгүй сэтгэлийг магтая

Бурхадын цэцгийн чугуулган
Бусад хөрөнгө услаж боловсрох шиг
Эх адаг дунд хаа ч чухал
Энгүй нинж таныг магтая

Эх болсон амьтан бүгдийг
Эвдрэх орчлонгийн нэрийн бүдүүн үйлээс
Энэрэн таалах мөн чанарт
Энэрэнгүй сэтгэл таныг магтая

Олон амьтан мунхрахийн эрхэнд
Орчлонгийн худагт унасан бүгдийг
Огоот зовлонгоос гаргагч
Олны амьтан төлөөх нинжийг магтая

Эргээ халих усны давалгаа шиг амьтад
Эгшин зуур төдий амгалантгүй
Эвдрэх мөнх бусыг тийн болгоогч
Эрхэм номын төлөөх нинжийг магтая

Сарны дүр усанд буух шиг амьтан бүгдийг
Сайтар болгоох мөн чанар
Аль мэт хоосон шинж төрхтэй
Албадлаггүй төрөх нинжийг магтая

Их нинжийг бясалгаснаар
Ирмэг хүч төгсөхийн цагт
Илт туулсан бурхан болохын
Илбэ шид нь та билээ

Ховор нинжийг дэлгэвээс
Хорлол хэзээч оршихгүй
Хотол дээдийн номондоо
Харин ч эрхэм эрдэнэ та

Үзүүлэгч бурханы шавь нь
Үнэхээр нинжийг хамгаалагч
Үнэн буяны номыг бүтээхийг
Үүргэлэн хуврагийн хань та

Бурхан багш Шаарийбуу
Булт олон дээдэс бүгд

Таныг дамжуулж авалгүй

Тааваараа дээшлэх замгүй

Аюул бүгдээс гэтэлгэгч
Асрангуй сэтгэл та бээр
Асар тэнгэр ертөнцийн
Авралын орон та билээ

Ялж төгссөн бурхан бээр
Ялгамжтай төрөлхтөн болсон нь
Энэрэнгүй таныг бүтээж
Эцсийн замдаа тулсан

Иймийн тулд бурхан бээр
Эцэс нярваан бол шашин
Ирэх үүдийн дээдийг магад олох
Энэрэнгүй сэтгэл гэж сайшаав

Чухаг дээд гурван бурхан
Чухам авралын учир
Зарим нь аврал одуулахгүй ч
Зөвхөн та тэдэнд эрхэм

Уг үүгээр ном хуврага ч
Аврал зохистой бүтээхийн тухайд
Урагнах захилахын эрх ялгамжтай ч
Аврал аврахгүй гэх ялгаа танд үгүй

Архад шарбагаан бясалгалын хүчээр
Арвин их галавт сууж чаддаг ч
Аяа таныг эрхэмлэн залахгүйгээр
Ахиж дэвшиж үл чадна

Туулсан бурхад бодьсадба нар
Тун их эрх мэдэлтэй ч

Таньдаа мөргөн тахихгүйгээр
Төгсөх орчлонгийн тусыг бусдын бусдад үйлдэж чадахгүй

Мулгуу над адил нь санаагаараа тахиж
Мэргэн танд толгойгоо даатгая
Цаагуур одон өнгөрөх зовлонг
Цохлон өөртөө даллан авч

Бусдад амгалан нэгийг ч өгөөд
Буцлам зовлонгоос нь өөртөө ирүүлж
Хойшид гарах зовлон бүгдийг хөөгч
Хаашил танаас өөр хэн байх вэ

Аль нь нэгнийг хүлээн авснаар
Алимад зовлон барагдахын шалтгаан
Хувирах зовлон алийг ирсэн ч
Хаач чадахгүй оруулах гайхамшиг нь та

Аньс тодорхой итгэлт та бээр
Аль өөрийн зовлон үүсгэх нь
Саранд дэлгэх цэцэг бодьсадбал шиг
Сааталгүй төрөлхтөнг амьчилан сахиж

Там хилэнцэд унагалгүй
Төрөлхтөн бүгдийг сахиж
Бусад аньсны суурь болох
Бурхан нинж та болой

Бусдын төлөө зовч адах
Бадам цэцэг шиг уснаас төрөгч
Бие сэтгэлийн баясал амгалант
Бахтай нинж та мэргэн

Та амьтан бүгдийг гэтэлгэж

Тагаалал нь баясалын далайг хөөж
Өөрийн чухалчилах зүйл
Өрөвдөхийн мөрөн гол шиг та

Асрал энэрэл баясгалан
Ашдийн нөхөр баатар
Алив үйл ерөөлийн хүч
Амьтан зургаан язгуурт төрсөн ч

Буяны хүчээр бие амгалан
Бас мэргэн ухаанаар сэтгэл амгалан
Бусдын тусд орчлонгийн эцэс хүртэл
Буцахгүй оршиж уйсал төрөхгүй

Бүх энэрэлийг төвлөрүүлэгч
Бусдад туслах нь гайхамшиг
Хариу үр дүн горлохгүй
Харин ч чөлөөгүй зүтгэгч та

Амьтан бүгдийг зовлонгоос
Аврах хүсэл авир ёст
Зовсон хөвүүнд ухаант ээж шиг
Зүтгэх үлгэр харуулагч та

Хүү олонтой ч өвдсөн хүүдээ
Хайрлан зовох эх шиг
Хамаг амьтан олон ч
Харин та бүгдийг энэрнэ

Өчүүхэн төрөлхтөн над мэтэд
Өөрөөсөө илүү энэрэл өгч
Магад та амьтан бүгдэд
Маш их энэрэх тушаалтан

Зовлон үйлээс айдаг ч
Хилинц нүгэлээс айдаггүй бид
Хилинц нүгэлийн үйлийн үр зантай
Хязгааргүй ихдэхээс айдаг та

Нисва нисаар бугуйлдуулсан
Нилэнхүй орчлонгоор хүлэгдсэнийг
Нээрээн таныг дээдэлсэн бурхад
Нинжид мөргөн ертөнцөд залардаг

Тэр юуны тул бурхад бээр
Тэргүүлэшгүйгээс эхлэн энэ орчлонд
Тэтим болгон танд мөргөдөг нь
Тэртээх энэтхэг мэргэдийн журам

Энх амгалангийн далайгаас
Эргэлдэн гарах булаг шиг
Эх бурхад лусын хаад ч
Энэлэх шавь нараа гаргах үл чадна

Эрхэм таньтай адил боловч
Ид шидтэй тарнийн хүч алин бээр
Эзлэн амирлуулж үл чадна
Эгнэгт болгоон сүрэнд дарагдана

Бурханы хүч мөнхөд төгөлдөр
Бүхий мэдэгдэхүүнийг мэддэгч
Үрээд барахгүй хашын чулуу шиг
Үлгэрлэж таныг жишиж мэддэг
Зовлонгийн их үхлийг зайлуулж
Зайлуулсны сүүлээр тусах заримд
Заавал өөртөө авах таалалтай
Зоригтон танаас өөр хэн ч үгүй

Бусдын бүх зовлон ч өрөвдөн
Өөрийнхөө амгалангаар солих тань
Бурхан мэт таалал тань
Өлөг буян далай мэт

Бусад бээр өөртөө тустайг л хийдэг ч
Буцаад хорлол болох нь олон байдаг
Хор танд хүргэж үйлдсэн нэгнийг ч
Хосгүй тус бүтээснээр тооцдог та

Амьтан бүгд бээр тань доор
Атаархах дайсагнах урагнах бүгдийг
Өөлөх нэгэн зүйл өчүүхэн ч үгүй
Өгөөмөр ээжийн сэтгэлийг харуулдаг

Хөгшин ээжийгээ адаар галзуурахад
Хүндлэл байвч болгоомжтой ханддаг
Хамаг амьтанг ачит эх хэмээн бодож өөрийгөө
Хэнд ч өчүүхэн боломэгүй энэрнэ
Ээжий хүн үрээ хайрлах мэт

Бурхан бүгд энэхүү ертөнцийг
Бүхэл өдөр шөнө амралгүй тольдсоор
Нярвааний замыг заан өгч орших нь
Нигүүлсэнгүй сэтгэл таны их ач

Алин бээр би итгэл үгүй ч
Амьтан бүхнийг аврах нь зөв хэмээн
Арслангийн хүрхэлтийг дуурсагдаг
Агуу нинж таны ач гавъяа билээ

Хүмүүн бус нугууд бээр амьтанг
Хомроглон устгах шидийн тарнийг ч
Хувирган эрдэм болгосон ач

Хувьтай таны адистэд мөн

Алимад шулмасын цэрэг
Аймшигт мэсэн хорыг буулгавч
Алаг цэцэг дэлбээлэн ургах нь
Агуу нинж таны хуяг

Алин бээр амьтан бүгдийг
Амь алдахын жам ёс таарахад
Атган тэврэх хүчит мутраар
Авран нигүүлсэх нь ямагт та

Дээд удирдагч хамаг амьтанг
Дэлхийн аймшигт хүлээс аюулаас
Дээш нь татан гаргах мутарлагаар
Дэгээдэн татах нь таны таалал

Тиймийн тул та бээр амьтан бүгдийг
Татах буурах алинд нь ч тааруулалгүй
Орчлонгийн хотол чуулганыг
Онцгой тагш мэдээ чинь та билээ

Өчүүхэн дотортойм бид бүгд
Өөрийг газрыг бусдад нялзааж
Хотол чуулган сайн бүгдийг
Хувийнхаа төлөө залбиран хүсдэг бол

Бурхан нинж та бээр
Буян сайхныг бусдад нялзааж
Бусдын зовлонг өөртөө татаж
Бүгдийг бурхан болгохыг хүсдэг

Ертөнцийн жаргал зовлон бүгд
Ер өөр бусдыг энхрийлэн барьдаг

Гэм буруу эрдэм тусыг
Гэтэлгэн ялгаж танд итгэмжилдэг

Бусад бүгд ихээр бишрэвч
Буруугаар зарим нь уригнан үйлддэгч
Тэрхүү гэрцгий ард олныг ч
Тэгш сэтгэлээр тахиж үйлддэг

Ялгуусан хутгийг бүтээхүй доор
Ямагт бурхан амьтан хоёр
Ачийн их багыг адилтгах ёсыг
Арга ухаанаар оношлон болгоогч

Хамгийг болгоогч амьтан нугуудын
Хилэнцийг усаар үл угаамой
Зовлонг мутраар үл арилгамой хэмээн
Зарлиг шашдирт айлдсайд байдаг

Нийгүүлсэнгүй бясалгагч бясалгагсан бээр
Нохойн биеэс хавдар өвчин
Хүний биеэс бөөсний өвчин
Халдааж авсан энэ юу нэгэн буй

Гэвч өөр бусдын жаргал зовлонг
Гээх авахыг бясалгасан сүгээрийн
Оюуны чадал сэтгэшгүй бөгөөд
Олныг тольдогч ямагт бээр болгоосон

Тэгш багш лугаа нэгэн үндэст
Тамын тэргийг татагч хийгээд
Таарсан хувь зохиолоор
Тэнд ёроолд нь оршдог

Өдгөө тэр бүх бурхан болсон боловч

Өвөр бидний авир ёсыг
Санах цагт их нигүүлсэнгүй сэтгэл
Саадгүй төрж ялган тодолмой

Омогт нигүүлсэнгүй тань дор
Ойр холын ялгаа юу байх вэ
Өөр болон бусдын тус ямагтыг
Өчүүхэн ч үл мартаx эрдэм амуй

Тамад олон галав суух үйлтэй
Тэд ч мөнхүү таныг олоод
Тэрхүү агшинд үйл нь барагдаад
Тэнгэрийн оронд төрснийг номлодог

Зовлонгийн галыг амгийг сөнөөх үед
Зуны хур адил даган орох бөгөөд
Хилэнцийн цогцосыг шатахуй дор
Хэнээн ч асуулгүй тэмцэлд одмуй

Амьтан заримын толгойны өвчин төдийг
Арилгахыг хүсэгч нигүүлсэнгүй төрмөгц
Янагхан шувуухай тэр тамын
Янагш хүрднээс гэтэлсэн бөгөөс

Огторгуйн сац хамаг амьтаны
Олон арван зүйлийн зовлон арилгахыг
Бясалгал нигүүлсэхүйн дээдийг хүсэгч
Буяны цогцосыг юугаар хэмжих вэ

Таван цэвүүн дэлгэрсэн муу цагийн
Та мэт зуу наст амьтан нугууд
Сайн цагийн бусад бодьсатваа нугууд бээр
Саадыг номхотгон болгоон орхидог

Тэр цагт бяромон далай тоос хэмээх нь
Тэнцэшгүй баатар нигүүлсэхүйн залиар
Таван зуун ерөөлийг сайтан толбиж
Тэгш хувьт дээд шавь нарт мутраар адисласан

Сайваар одогсон эрдэнийн зүрхэн тэргүүтэн
сайх арван зүгийн бурхан шавь нар сэлт
Сайтар эрдэнийн цагаан лянхуай цэцэг шиг
Сайшаалаар дэлбээгээ нээн дэлгэсэн мэт

Тэр бүгд их нинжин сэтгэлийн ачаар
Тэнгэрлэг эрдэмийн цадиг ёсоор
Аа ану гурван цагийн бурханы
Тэргүүн их багш хэмээн магтагдмой

Алин түүгээр итгэлт майдараас
Ахин дөчинхоёр их галавын сүүлд
Агуу бодьсадын сэтгэлийг үүсгэвч
Аяа их урд бурхан болой хэмээн номлосон

Тэр мэт нинжин сэтгэлт та бээр
Тэнгэрлэг багшийн үйлсийг үүрээд
Төгсгөх боловруулах арилгах гуравт
Түвшин хичээл шамдалын ач амуй

Бусдын тусыг үүрэглэн авч
Бүхий л шавь нарын их адал явдал нь
Энгүй шавь нарын багтахуй бэрх бөлгөө
Эглийн оюунд багтахуй бэрх бөлгөө

Төглийн ганц найлзуур модны дэргэд
Тэргүүнээ мянга дахин өгөх ёсыг
Үзэх байтугай сонссон ч зүйл үгүй

Үлгэрлэн бодвоос зүрхэнд шимшрэл төрнө

Сайваар одогсон номын хааны
Сайн язгуурт төрсөн дээд шавь нь
Нинжийн цэцэг мэт дэлбээлэн ургасны
Нижгээд бойжуулсан эх нь нинж та

Магад гарахын тийн ариун санаач
Машид нигүүлсэнгүйгээр бүтэхгүй
Нүүр нь нааш цааш харсан байв ч
Нийлбэр ялгавар адилыг номлосон

Бодь сэтгэлийн галбарваас мод
Буй хийгээд төрөх арвидах бүхэн
Хос долоон шалтгаан үр барилдсан
Ховон нинжин язгуурт дулдуйдмой

Удам хоосон чанарын их далайд
Уран аргат ухаан сүмбэр уулаар
Дахин давтан найруулсны охь
Дамай нинжийн рашаан та ямагт гарсан

Бусад эрдэмүүд бүтсэний шинжийг
Бултыг үзүүлэгч шөнийн одчилон
Их нинжин сэтгэл бүтсэний шинжийг
Ингэж үзүүлэгч нь өдрийн одноос ховор

Тиймийн тулд гурван мянган ертөнцөд
Дээд нинжин сэтгэл эрдэнийг
Төрөлхтөн буй нь олон төдий мөний
Дээд ёсыг барамидийн сударт номлов

Өөрийн махыг таслаад өсөхдөөч
Өлөгчин бард тусалсан гэж баярлаж

Мэдэрхүйеэ бэрх энэхүү нинжин сэтгэлийг
Мэргэн мунхаг хэн бээрч жишиж чадмой

Алин бээрээс ч гуйхын дуу сонордвоос
Амгалант шарваан барадагуудын
Амгалан нирваанд ч үл тэнцэх тул
Ашдын нинж таны цаг заль гайхамшиг

Бодьсадваа баатар тогосын их чуулган
Бодол эрдэмийн хурыг хэдий чинээ идсэн ч
Төдий чинээ эрдэмийн өдөнд уригнах
Төгөлдөр сүр жавхлан таных амуй

Ховор нандин зэндмэн эрдэнүүд
Хэрэг тус төдийг нижгээд бүтээдэг ч
Эрдэнийн хаан оргил нинжийн зэндмэн
Эрсэн хүссэн бүгдийг шамдалгүй бүтээдэг

Өлөг тэргүүтэн зургаан барамид нь
Өгөх авахын нэгэн талыг бүтээдэг
Өгөөмөр их нинжин сэтгэл та бээр
Өөр бусдын тус бүгдийг бүтээдэг

Гайхамшигт нинжин сэтгэлийн эрдэнэ
Гарын алганд буй болвоос
Бурхан нам бүгдийн үйл нь
Буцалтгүй бээр гарт нь хурдаг

Туулсан их бурхан хэмээгч нь
Тунгалаг солонго эргэлдэх гэрлэн хүрээнээс
Найман зүйлийн рид хувилгааныг үзүүлэгч
Нэгийг бодон нь хаанаас байхав

Тэнгэрлэг нинжин сэтгэл таны

Таалсан хэрэг нь амьтан ертөнц
Үргэлжид болгоох нь зовлонгоос
Үнэхээр аврагч таныг тавьмуй

Туулсан их бурхан бээр
Таван мянган жил шашинаа оршоохын угт
Тэнгэрлэг нинжин сэтгэл таныг
Тавьж орлуулан нирваанд заларсан

Бид мэт молхи нугуудад нэн ихээр
Болгоолт энэрэл хэтэрсний тул
Агуу нинжин сэтгэл таны
Ачийг нь бид яаж хариулахав

Өвөг итгэлт хоншин бодьсад бээр
Өөрийн алдарыг адистэдлэж
Алива сонссон аюулыг гэтэлгэдэг нь
Аяа нинжин сэтгэлийн оньс мөн

Асангийн зөөлөн итгэлт
Аглагт арван хоёр жил бясалгаад
Авъяас билэг тодорсонгүй ч
Адгийн гөлгөнд туслаж

Агуу хүчит нинжийг
Агшин дор бүтээсэн буй
Олон зуун бурханыг бүтээснээс
Онцлон нинжин сэтгэлийг бүтээ

Ханьцашгүй богд адиша бээр
Хэмжээт нас арван ёс үйлдсэн ч
Цагт төвдийн оронд заларч
Цаглашгүй нинжийг номлож

Шашин амьтаны журмыг сэргээж
Сайран дэвжихийн үйлийг таалж
Шинэ цаг ирэхгүй болсон ч
Сайтан нинжийг шүтэхийг захив

Хаан хөвүүн самбууцаг бээр
Хамгаас нинжийг онцолсны хүчээр
Хажууд нь байх хулгана чоно ч
Хавьталгүй тэвчив улаан идээ махыг

Төгөлдөр итгэлт бодь лам зонхава бээр
Таван зуун жилийн эцэс нэн цэвүүн цагт
Тунгалаг шагшаабадын хэргүй номлолоор
Төгс үзэсгэлэнт замбуу тивийг болгоосон ч
Урдын баатар эрхэтийн өмнө
Увидист төгөлдөр нинжийн хүч
Дээдийн номыг барихын ерөөл
Дэлгэрэх сайн цагтаа боловсрохыг мэдвэй

Товчилвоос орчлонгийн их далай доор
Там бага их мөрөн сайн чуулган бүгд
Торохгүй урсах нь эхэнд байх цаснаас болдог шиг
Төв сэтгэл болох нинжээс хамаарна

Энэрэнгүй сэтгэл нь огторуйнгаар дүүрч
Эрдэм мэдлэг нь уудам хязгааргүй
Бүхнийг болгоох мэлмий төгөлдөр учир
Бяцхан батгана минь мэт яаж хэмжих вэ

Хурын үүлний тусал зарим өчүүхнээр
Хараацай шувууг амаржуулдагчилан
Энэрэнгүй сэтгэлийн зарим эрдмийг
Энд өгүүлсэндээ сэтгэл минь баясмуй

Нялх балчир цагаасаа эхлэн
Нүгэл мэлмий уналыг үйлдсэн ч
Миний хэлээр хэлсний дээд үг
Магтах нинжин сэтгэлийн өдөр болой

Алин бээр нэгэн үндсэнд төрсөн буй
Адуу мал лугаа харших бодол үгүй мэт
Эр хүний нэр цог залиг мандаагч
Энэрэнгүй сэтгэл танд аврал одуулмой

Зүрхнээс бурханыг олохыг хүсвээс
Нинжин сэтгэлт ламын өмнө оч
Зүрхнээс ажил үйлсээ бүтээж үйлдэхийн тухайд
Нинжин сэтгэлийг бясалгаж үйлд

Тэгүүнчилэн хэлсэн магтаал буян үүгээр
Миний сэтгэлд нинжин их сэтгэл
Түргэн төрөх тэр цагт дор
Мандан дэвштүгэй төрөлхтөн бүгд

Огторгуйн энтэй их болсон тус цохилдох чуулганыг
Онц энэрэнгүй сэтгэлийн их онгоц бээр
Бодлын их далайд залахуй их мэргэн
Богд их сартваах нь би болох болтугай

Цөвүүн цагийг аврахын орон болсон их нинжээр
Цанган энэлсэн амьтан бүгдийг
Цаглашгүй нинжийн рашаанаар чийгшүүлж
Цаг үргэлж бурхан тэнгэрийн адистэд орших болтугай.

*“Wherever the Buddha’s teachings have flourished,
either in cities or countrysides,
people would gain inconceivable benefits.
The land and people would be enveloped in peace.
The sun and moon will shine clear and bright.
Wind and rain would appear accordingly,
and there will be no disasters.
Nations would be prosperous
and there would be no use for soldiers or weapons.
People would abide by morality and accord with laws.
They would be courteous and humble,
and everyone would be content without injustices.
There would be no thefts or violence.
The strong would not dominate the weak
and everyone would get their fair share.”*

*** THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL***

Taking Refuge with a mind of Bodhichitta

**In the Buddha, the Dharma and the Sangha,
I shall always take refuge
Until the attainment of full awakening.**

**Through the merit of practicing generosity
and other perfections,
May I swiftly accomplish Buddhahood,
And benefit of all sentient beings.**

The Prayers of the Bodhisattvas

**With a wish to awaken all beings,
I shall always go for refuge
To the Buddha, Dharma, and Sangha,
Until I attain full enlightenment.**

**Possessing compassion and wisdom,
Today, in the Buddha's presence,
I sincerely generate
the supreme mind of Bodhichitta
For the benefit of all sentient beings.**

**"As long as space endures,
As long as sentient beings dwell,
Until then, may I too remain
To dispel the miseries of all sentient beings."**

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

*** The Vows of Samantabhadra ***

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

*** The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ***

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：布萊底雅 (Buryatia) 地區佛教傳佈史蹟》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГ ЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO037 - 16015